



ДОРНОГОВЬ АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 03 өдөр

Дугаар 02/02

Сайншанд сум

Дорноговь аймгийн хөгжлийн 2024 оны
төлөвлөгөөний биелэлтийг үнэлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1, 35 дугаар зүйлийн 35.1.6, 35.1.15, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь заалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10.3, 21 дүгээр зүйлийн 21.6 дахь заалт, Засгийн газрын 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” 206 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Дорноговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 15/09 дүгээр тогтоолоор батлагдсан “Дорноговь аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилт, түүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хэлэлцэн биелэлтийг 86 хувьтай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлсүгэй.

2. Тайланг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлэн, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн гаргасан санал, дүгнэлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Батжаргал)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нутгийн удирдлагын хөгжлийн хорооны ахлагч (С.Одбаяр), аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Ц.Батсугир) нарт тус тус даалгасугай.

ДАРГА



НАЛДАРБАЯР

442240089

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

№	Түвшин	Хөтөлбөрийн нэр	Үр дүн, үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Үнэлгээ
						он	түвшин			
Салбарын үр дүн 1.1. Бага насны хүүхдийн хөгжлийн үнэлгээг 4.4 хувиар нэмэгдүүлнэ.										
1	Ерөнхий боловсролын сургуульд элсэгчдийн бэлтгэгдсэн байдлын үнэлгээг 4 хувиар нэмэгдүүлнэ	Сургуулийн өмнөх боловсрол	Сургуулийн өмнөх боловсрол олгох	Сургуулийн өмнөх боловсролын хамрагдалт	хувь	2022	87.5	88	Аймгийн хэмжээнд бүртгэлтэй хүн амын тоогоор 2-5 насны 5888 хүүхэд байгаагаас 2024-2025 оны хичээлийн жилд төрийн өмчийн 34 цэцэрлэгийн 176 бүлэгт 5075 хүүхэд, төмөр замын 6 цэцэрлэгийн 26 бүлэгт 651 хүүхэд, нийт 5726 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын бохир жин 97,2 хувьд хүрч өмнөх оноос 4 хувиар өссөн.	100%
2			Сайншанд, Замын-Үүд, Хөвсгөл сумдын цэцэрлэгийн барилгуудыг засварлах	Засварын ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Орон нутгийн төвийн 498.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 12 дугаар цэцэрлэгийн дотор, гадна фасадны засварын ажлыг "Дэнжийн цамхаг" ХХК гүйцэтгэж 2024.11.01-ний өдөр ашиглалтад хүлээлгэн өгсөн. Орон нутгийн төсвийн 180.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 10-р цэцэрлэгийн гадна фасад, цонх шинэчлэн засварлах ажлыг "Дэлгэрбаян хүлэг" ХХК гүйцэтгэж, комиссын шийдвэр хүлээгдэж байна. Хөвсгөл сумын цэцэрлэгийн барилгын дотор засварын ажлыг орон нутгийн төсвийн 156,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Чонот девелопмент” ХХК гүйцэтгэж 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр хүлээлгэн өгсөн. Замын-Үүд сумын 2 дугаар цэцэрлэгийн гадна фасад, цонх,шалны засварын ажлыг орон нутгийн төсвийн 308,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар, 4 дүгээр цэцэрлэгийн дотор засвар, цэвэр бохир усны шугамын засварын ажлыг орон нутгийн төсвийн 419.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Миний Сайншанд" ХХК" гүйцэтгэж нийт ОНТ-ийн 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд, Замын-Үүд, Хөвсгөл сумын 5 цэцэрлэгийн барилгыг засварлаж ашиглалтад хүлээлгэн өгсөн байна.	100%

3			Хөвсгөл сумын ЕБС-ийн багш, ажилчдын орон сууцны барилгад халаалт, цэвэр, бохир усны шугам шинээр хийх	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Хөвсгөл сумын ЕБС-ийн багш, ажилчдын орон сууцны барилгад халаалт, цэвэр, бохир усны шугам шинээр хийх ажлыг орон нутгийн төсвийн 144,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Дэнжийн цамхаг" ХХК гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өгсөн.	100%
4			Сайншанд суманд 150 ортой цэцэрлэгийн барилгыг шинээр барих	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	50	Улсын төсвийн 3,1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд суманд 150 ортой цэцэрлэгийн барилга шинээр барих ажлыг "Унага трейд" ХХК гүйцэтгэж байна. Барилгын газар шороо, суурь, 1-р давхарын каркасан хийцийн угсралтын ажил дуусч, 2-р давхарын баганын арматурчлалын ажил хийгдэж ажлын гүйцэтгэл 35%-тай явагдаж байна.	70%
5			Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудыг нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	Тоног төхөөрөмжөөр хангасан байгууллага	тоо	2023	10	33	Сургуулийн өмнөх боловсролын 28 байгууллагад нэн шаардлагатай байгаа 350,0 сая төгрөгийн 115 ширхэг тоног төхөөрөмжийн жагсаалт, судалгааг гаргасан. Орон нутгийн төсвөөс шалтгаалан 2025 оны төсөвт оруулахаар төлөвлөсөн. Мөн Боловсролын яам, Боловсролын ерөнхий газар, УИХ-ын гишүүн Б.Дэлгэрсайханд тус тус уламжилсан. Тус жагсаалт, судалгаа болон багш, сурагчдыг хөгжүүлэх кабинет байгуулах 13 төслийг "Дэээрэт" олон улсын байгууллагад уламжлан дэмжлэг хүссэний дагуу гал тогооны тоног төхөөрөмжийн 350.0 сая төгрөгийг "Дэээрэт" олон улсын байгууллагаас 2025 онд шийдвэрлэхээр болсон.	30%
6		Сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөр	Ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг хөгжүүлэх	Сургалтад хамрагдсан багш	тоо	2023	100	120	Боловсролын газраас сургуулийн өмнөх боловсролын байгууллагын менежментийг сайжруулах, сургалтын аргазүй, багшийн хөгжлийг дэмжих болон хувь хүний хөгжлийн 3 төрлийн танхимын сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 390 багш, удирдах ажилтнууд хамрагдан академик мэдлэг чадвараа дээшлүүлсэн. Боловсролын ерөнхий газраас жил бүр зохион	90%

									байгуулдаг багшийн мэргэжил дээшлүүлэх 1, 5, 10 жилийн үндсэн сургалт, төрөлжсөн 35 төрлийн модуль сургалт болон бэлтгэл бүлгийн багш нарыг чадавхжуулах цахим сургалтуудад давхардсан тоогоор 390 удирдах ажилтан, багш нар ажлын байран дээрээ хамрагдсан.	
7			"Чадварлаг багш" арга хэмжээг хэрэгжүүлэх	Зохион байгуулсан арга хэмжээ	тоо	2023	2	3	2023-2024 оны хичээлийн жилд "Чадварлаг багш" арга хэмжээний хүрээнд цэцэрлэгийн менежмент, сургалтын арга зүй, багшийн хөгжлийг дээшлүүлэхээр аймгийн Засаг даргын 2024 оны А/167 дугаар захирамжаар 11,5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, СӨБ-ын багш нарт мэргэшүүлэх үе шаттай сургалт зохион байгуулсан. Сургалтад СӨБ-ын 366 багш бүрэн хамрагдаж мэдлэгээ дээшлүүлсэн. Аймгийн Засаг даргын 2024 оны А/756 дугаар захирамжаар 5,5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, аймгийн хэмжээнд анх удаа бүсийн болон багийн зохион байгуулалтаар "Сайн хичээл" ур чадварын уралдааныг 7 төрлөөр зохион байгуулж, сургалтын байгууллагын болон багшийн гүйцэтгэлийн үнэлгээ, үр дүнд үндэслэн төрийн болон төрийн бус өмчийн нийт 40 цэцэрлэгийг 4 бүсэд хуваан арга туршлагаа түгээн дэлгэрүүлэх, харилцан суралцахад чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангасан. Үүний үр дүнд аймгийн 4 бүсийн цэцэрлэгүүд багаараа мэргэжлийн хөгжлийн бүлгээр цэцэрлэгийн сургалтын хөтөлбөрөө хүүхэд төвтэй идэвхтэй сургалтын арга зүйгээр боловсруулан хэрэгжүүлж байна. Мөн 2024-2025 оны хичээлийн жилд "Сайн хичээл" үйл ажиллагааны 1-р шатыг цэцэрлэгүүд өөрсдийн боломжид тулгуурлан зохион байгуулж, туршлагаа хуваалцсан. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагаас 2 цэцэрлэгийн эрхлэгч Боловсролын сайдын 2024 оны А/90 дүгээр тушаалаар Монгол улсын Зөвлөх багш мэргэжлийн зэрэг авсан.	90%
8			Ур чадвар, илтгэлийн уралдаан,	Зохион байгуулс	тоо	2023	2	3	Аймгийн Засаг даргын 2024 оны А/756 дугаар захирамжаар 5,5 сая төгрөгийн дэмжлэгээр сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын	90%

			хичээл төрлийн олимпиад зохион байгуулах	ан арга хэмжээ					дунд "Ур чадвар-2024" сайн хичээл-үйл ажиллагааг 2 үе шаттай зохион байгуулж, шалгарсан багш, удирдах ажилтнууд мэргэжил онол, арга зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилготой эрхлэгч, арга зүйч, багш нарын бүрэлдэхүүнтэй 7 төрлийн үйл ажиллагаанд мэдлэг, ур чадвараа сорин оролцож, баруун бүсийн цэцэрлэгүүд багаараа шалгарч, арга туршлагаа аймгийн хэмжээнд түгээн дэлгэрүүлсэн. Мөн "Хамтын оролцоонд суурилсан сургалтын байгууллагын менежментийг хөгжүүлэх нь" сэдэвт аймгийн багш нарын эрдэм шинжилгээний хурлыг цахим болон танхим хосолсон хэлбэрээр 2 үе шаттай зохион байгуулсан ба шалгарсан илтгэл улсын эрдэм шинжилгээний хуралд амжилттай оролцсон. Аймгийн Засаг даргын 2024 оны А/755 дугаар захирамжаар 12,6 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, суралцагчдад монгол хэл, бичгийн мэдлэг, чадварыг чанартай эзэмшүүлэх, оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор "Анги нийтийн олимпиад"-ыг 9, 12-р ангийн нийт сурагчдын дунд монгол хэл, 6-7-р ангийн нийт сурагчдын дунд монгол бичгийн хичээлээр зохион байгуулж, нийт 1098 бүлгийн 4580 суралцагчийг хамруулж, ахиц амжилт, үр дүнг тооцон шилдгүүдийг шалгаруулсан. Мөн сурагчдын хоцрогдлыг арилгах, гүйцэтгэлийн үнэлгээнд ахиц гарган, сургалтын чанарыг сайжруулах зорилгоор 1-12-р ангид дизайн технологи, англи хэл, орос хэл, эрүүл мэнд, математик, физик, бага анги монгол хэл, математик, хүн ба байгаль, үндэсний бичиг судлагдахуунаар "Анги хамт олны олимпиад"-ыг 2 үе шаттайгаар зохион байгуулж, давхардсан тоогоор 1098 бүлгийн 57111 сурагч хамрагдаж гүйцэтгэл 3,7 хувийн ахицтай, судлагдахуун бүрийн гүйцэтгэлийн хувь 1.5%-18.9% ахисан үзүүлэлттэй байна.	
9			Орон нутагт нэн шаардлагатай багш бэлтгэхэд	Дэмжлэг үзүүлсэн багш	тоо	2023	0	5	Аймгийн Засаг даргын 2023 оны А/853 дугаар захирамжаар Орон нутагт шаардлагатай дуу хөгжмийн багш мэргэжлээр суралцаж "Сургалтын гэрээ" байгуулсан 5 оюутан тус бүрийн 4 жилийн сургалтын төлбөрт 100% дэмжлэг үзүүлсэн.	100%

			сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэх						Сургуулиа төгссөн 3 суралцагч Сайншанд сумын ЕБ-ын 1-р сургууль, Хатанбулаг сум, Зүүнбаянгийн сургуульд гэрээнд заасны дагуу мэргэжлээрээ ажиллаж, гасан ба 2 оюутан үргэлжлүүлэн суралцаж байна. Мөн Даланжаргалан сумын ЗДТГ-аас дуу хөгжмийн багш мэргэжлээр суралцаж байгаа 1 оюутанд 2,5 сая, Сайхандулаан сумын ЗДТГ-аас 2,0 сая төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэгийг тус тус үзүүлсэн.	
Салбарын үр дүн 1.2: Сурагчдын сурлагын үнэлгээг суурь түвшнээс 5 хувиар ахиулна.										
10	Боловсролын чанарын үзүүлэлтийг 12 хувиар нэмэгдүүлнэ	Ерөнхий боловсрол хөтөлбөр	Ерөнхий боловсрол олгох	ЕБ-олгох үйл ажиллагаанд хамрагдсан хүүхэд	тоо	2022	22000	24000	2023-2024 оны хичээлийн жилд 22 сургууль байснаас Замын-Үүд сумын "Үлэмж тэнгэр" төрийн бус өмчийн сургууль зөвшөөрөл эзэмшигчийн хүсэлтээр үйл ажиллагаагаа зогсоосон. 2024-2025 оны хичээлийн жилд 21 сургуулийн өдрийн 541 бүлэгт нийт 16234 сурагч сурагч ерөнхий боловсрол олгох үйл ажиллагаанд хамрагдаж байгаа нь өмнөх оноос 409 сурагчаар нэмэгдсэн. Өмнөх онтой харьцуулахад бага боловсролын сургалтын хамрагдалт 3.2%-иар, суурь боловсролын сургалтын хамрагдалт 2.1%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.	100%
11			Англи хэлний жишиг кабинет байгуулах	Шинээр байгуулагдсан кабинет	тоо	2023	0	1	Сайншанд сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуульд англи хэлний жишиг кабинет байгуулахаар 60.3 сая төгрөгийн төслийг боловсруулж аймгийн Засаг дарга болон Дээрэт олон улсын байгууллагад тус тус хүргүүлсэн боловч төсөв шийдэгдээгүй байна.	30%
12			Англи хэлний багш нарыг гадаадад мэргэжил дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Хамрагдсан багш	тоо	2023	0	1	Аймгийн засаг даргын 2024 оны А/261 дүгээр захирамжаар Боловсролын газрын удирдлага, гадаад хэл хариуцсан 2 арга зүйчийг Тайвань улсын Тайпэй, Тайчун хотод "Удирдлагын манлайлал" сургалтад хамрагдахад 10,5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Мөн тус улсын "Чаоян" Шинжлэх ухаан технологийн их сургууль, АНУ-ын хөтөлбөртэй "Минг Чуан" их сургуультай тус тус хамтран ажиллах санамж бичиг байгуулан, багш солилцоог хэрэгжүүлэх, оюутнуудыг тэтгэлэгтэй суралцахад нь зөвлөн туслах, ахлах ангийн суралцагчдад зориулсан зуны хөтөлбөр хэрэгжүүлэх, хэрэгцээнд	100%

									тулгуурласан бусад сургалтуудыг зохион байгуулахаар төлөвлөсөн. Мөн Япон Улсын Шизуока мужтай байгуулсан санамж бичиг, хамтын ажиллагааны хүрээнд тус мужид 10 дугаар сарын 23-29-ний хооронд ахлах ангийн 17 сурагч, Боловсролын газрын гадаад хэлний арга зүйч, Сайншанд сумын 1 дүгээр сургуулийн англи хэлний багш, холбогдох албаны төлөөлөгч нийт 20 төлөөллийг 2024 оны “Багш, сурагч солилцооны хөтөлбөр” сургалтад хамруулсан. “Багш, сурагч солилцооны хөтөлбөр”-т хамрагдахад зориулж аймгийн Засаг даргын 2024 оны А/666 дугаар захирамжаар 14,4 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	
13			Англи хэлний зуны вакум сургалтад багш, сурагчдыг хамруулах	Хамрагдсан хүн	тоо	2023	16	60	“Нээлттэй Дорноговь аймаг”, “Түншлэл-хөгжил 2024” зорилтот жилийн хүрээнд аймгийн Засаг даргын 2024 оны А/322 дугаар захирамжаар “Bridge to Dornogobi” олон улсын боловсролын үзэсгэлэнгийн үеэр суралцагчдын гадаад хэлний мэдлэг эзэмших, түвшин ахиудахаар тусгай шаардлага хангасан 8 суралцагчдад ахисан түвшний англи хэлний сургалтад хамрагдах нийт 4.0 сая төгрөгийн эрхийн бичиг, “Англи хэлтэй Дорноговь” зорилтот хөтөлбөрийн хүрээнд англи хэлний хичээл, сургалтын орчныг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор англи хэлний сургалтын ном /IELTS/ 65 ширхэг, сургалтын материал 3000 ширхэгийг худалдан авахад зориулж 6,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, урилгаар гэрээний дагуу ажиллаж байгаа 3 багш ЕБ-ын сургуулийн 9-12 дугаар ангийн 45 суралцагчийг олон улсын онооны /IELTS/, түвшинд хүргэх сургалтыг тогтмол зохион байгуулж байна. “Дэээрэт” олон улсын байгууллага, Энхтайвны корпустай хамтран богино хугацааны гэрээгээр англи хэлний 8 багшийг урьж ирүүлэн “Америкийн соёл мэдээллийн төв”-д болон аймгийн төвийн ЕБ-ын сургуулиудын багш, сурагчдад тогтмол хичээлээс гадуурх сургалт зохион байгуулж байна. Сургалтын үр дүнд англи хэлний улсын олимпиадад ерөнхий боловсролын сургуулийн 2 сурагч медаль хүртэж 2024 оны	100%

									элсэлтийн шалгалтын оноо өмнөх оноос 11,2 хувиар ахиж, нийлбэр дүнгээр 3 байр ахисан үзүүлэлттэй байна. IELTS шалгалтад 9 сурагч өндөр оноо авч, 6 сурагч дараагийн шатны сургуульдаа суралцаж, 3 сурагч сургуулиуд руу суралцах хүсэлтээ илгээсэн.	
14			Сургууль, цэцэрлэгийн сургалтын чанарыг ахиулах	Гүйцэтгэлийн үнэлгээний ахиц	хувь	2023	0	2	Ерөнхий боловсролын 22 сургалтын байгууллага гүйцэтгэлийн үнэлгээнд бүрэн хамрагдаж, 2024 онд 75.2 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн нь өмнөх оныхоос 5.35 хувиар ахисан. Гүйцэтгэлийн үнэлгээгээр амжилттай үнэлэгдсэн 3 сургууль, 139 багш урамшуулалд хамрагдсан. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн үнэлгээгээр төрийн өмчийн 33-33, төмөр замын 6-5, хувийн 1-0, нийт 38 цэцэрлэгийн 147 багш хамрагдсанаас 72 багш урамшуулалд хамрагдаж, өмнөх оноос 23-аар нэмэгдсэн. СӨБ-ын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр 82.26 буюу өмнөх оноос 6.82 хувиар буурсан. Сургалтын орчны үзүүлэлт 90.8 хувь буюу 2.6 хувиар ахисан. Сургалтын чанарыг ахиулахад анхаарч сургууль, цэцэрлэгийн менежментийн 4 удаагийн сургалт, 14 сумын сургууль, цэцэрлэгүүдэд ажлын байран дээр нь зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулж, багш, удирдлагуудад тогтмол мэргэжил аргазүйн зөвлөгөө, үнэлгээ дүгнэлт өгч, 22 сургууль, 40 цэцэрлэгийг 7 бүсэд хуваарилан, хамтын ажиллагааг өргөжүүлэх бүсийн уулзалтууд, ахицтай үнэлэгдсэн сургууль, цэцэрлэгүүд бусдадаа туршлагаа хуваалцах үйл ажиллагаа, 7 хоног бүрийн удирдлагуудын цахим сургалт, уулзалт зэрэг үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж сургалт, үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын захирамжаар нийт 98,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	70%
15			Орон нутгийн онцлогт тохирсон хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт	хувь	2023	0	80	Орон нутгийн онцлогт хөтөлбөрийг ерөнхий боловсролын 21 сургууль 2024 онд хэрэгжүүлэн, эцэг эхчүүд, олон нийтэд тайлагнасан. Нийт сургуулиудаас үр дүнтэй хэрэгжүүлсэн Хөвсгөл сумын ЕБ-ын сургуулийн “Адуучны соёл” хөтөлбөр, Зүүнбаянгийн сургуулийн “Миний нутаг бидний	90%

									бахархал" хөтөлбөр, Замын-Үүд сумын ЕБ-ын 2-р сургуулийн "Шагайн наадгай" хөтөлбөрүүдийг шалгаруулж, туршлагыг аймаг болон улсын хэмжээнд түгээн дэлгэрүүлсэн. Орон нутгийн онцлогт тохирсон хөтөлбөрийг бүх сургууль, цэцэрлэгүүд шинэчлэн боловсруулан, тайлант онд шинжлэх ухаан, инженерчлэл, танин мэдэхүй, түүх соёл, ёс суртахуун зэрэг сурагчдын мэдлэг, төлөвшилд нөлөөлөхүйц хэлбэрээр зохион байгуулж байна. Орон нутгийн онцлогт "Говийн Дорнын айл" өрхийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг боловсруулан танилцуулсан ба уг хөтөлбөрийг 2025 оноос хэрэгжүүлнэ.	
16			"Үдийн хоол" арга хэмжээг хэрэгжүүлэх	Арга хэмжээг хэрэгжүүлж буй сургууль	тоо	2023	22	23	"Үдийн хоол" хөтөлбөрийн хүрээнд 2024-2025 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 16 сургууль хэрэгжүүлж байна. Иххэт, Хөвсгөл сумын сургуулиуд нь 6-9 дүгээр ангийн 112 сурагчдад үдийн хоол хөтөлбөрийг эцэг, эхийн дэмжлэгтэйгээр туршин нэвтрүүлж 1-5-р ангийн 7868 сурагчийг бүрэн хамруулсан. Нийт 21 сургуулиас 4 сургууль нь хоолны үйлчилгээг заалаар, 17 сургууль нь анги танхимаар үйлчилгээ үзүүлж, бие даан ажиллуулж буй сургуулиудад 49 тогооч болон бусад ажилтнууд хоол үйлдвэрлэл үйлчилгээг явуулсан. Аймгийн Тогоочдын холбоо, ХХААГазартай хамтран сургууль, цэцэрлэгийн тогооч нарын түвшин ахиулах сургалт, шалгалтыг зохион байлгуулсан. Уг сургалт, шалгалтад 21 хүн хамрагдаж, V түвшин 2, IV түвшин 6, III түвшин 10, II түвшин 3 хүн өгсөн. Тогооч нарыг чадавхжуулах сургалтыг онол, дадлагын хичээл хосолсон хэлбэрээр зохион байгуулж, харилцан туршлага судлах уулзалт зохион байгуулсан. Уг сургалтад ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 60 хүн хамрагдсан. Аймгийн Засаг даргын 2024 оны А/233 дугаар захирамжаар Сайншанд, Замын-Үүд сумдын хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нийт 32 объектод "Үдийн хоол", дотуур байр, цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний чанар, аюулгүй байдал, стандартын хэрэгжилт, сургууль орчмын хүнсний бүтээгдэхүүний	90%

									худалдаа үйлчилгээний 6 объектод стандартын хэрэгжилтэд хяналт шалгалтыг зохион байгуулж, зөвлөмж өгч ажилласан.	
17			ЕБС-д ажиллаж буй сэтгэл зүйчийг нэмэгдүүлэх	Сургуулийн сэтгэл зүйч	тоо	2023	6	9	Ерөнхий боловсролын 21 сургууль сэтгэл зүйчийн орон тоотой. Улс, аймгийн хэмжээнд сэтгэл зүйч мэргэжлийн боловсон хүчин дутмаг байгаагаас Сайншанд сумын 1, 2, 5-р сургууль, Замын-Үүд сумын 2, 3-р сургууль, Зүүнбаянгийн сургууль, Иххэт суманд нийт 7 мэргэжлийн сэтгэл зүйч ажиллаж байгаа нь өмнөх оноос 2-оор өссөн. Бусад бүх сургуулийн суралцагчдад сэтгэл зүйн үйлчилгээг хүргэх зорилгоор 7 сэтгэл зүйчид 21 сургуулийг хуваарилан хариуцуулан ажиллуулдаг бөгөөд жилийн эцсийн байдлаар 13135 сурагчдад мэргэжлийн сэтгэл заслын болон зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. Мөн Нутгийн зөвлөлийн бүрэн тэтгэлэгт хамрагдсан 1 сэтгэл зүйч 2024-2025 оны хичээлийн жилд Сайншанд сумын ЕБ-ын 5 дугаар сургуульд ажиллаж, 6 дугаар сургуулийн нийгмийн ажилтан нь сэтгэл зүйч мэргэжлээр богино хугацааны мэргэшүүлэх сургалтад хамрагдаж байна. Мөн МУИС-ийн Сэтгэл судлалын ангид суралцаж буй 1 оюутанд аймгийн Засаг даргаас 50 хувь, Эрээн хотоос Замын-Үүд суманд суугаа Ерөнхий консулын газраас 50 хувийн сургалтын төлбөрийн тэтгэлэг олгосон.	100%
18			Яргуй наадам зохион байгуулах	Оролцсон хүүхэд	тоо	2022	100	200	Аймгийн Засаг даргын 2024 оны А/425 дугаар захирамжаар хүүхэд, өсвөр үеийнхний урлагийн авьяас чадварыг хөгжүүлэх, шинэ авьяастан төрүүлэх, урын санг баяжуулах, урлагаар дамжуулан хүүхэд багачуудад гоо зүйн хүмүүжил төлөвшил олгох зорилгоор Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан, Боловсролын тэргүүний ажилтан Эрдэнэжаргалын Баярсайханы нэрэмжит 32 дахь удаагийн аймгийн “Яргуй-2024” хүүхдийн урлагийн их наадмыг 2024 оны 05 дугаар сарын 08-11-ний өдрүүдэд аймгийн Хүүхдийн ордонд гоцлол хөгжим, хамтлаг хөгжим, гоцлол дуу, хамтлаг дуу, гоцлол бүжиг, хамтлаг бүжиг, чөлөөт номер зэрэг 7 төрлөөр ерөнхий боловсролын 9-12 жилийн 20	100%

									сургууль, хүүхэд хөгжлийн 4 сургалтын төвийн нийт 1024 хүүхэд хамруулан зохион байгуулсан. Нийт 47,0 сая төгрөгийн төсөв зарцуулсан.	
19			Сайншанд, Айраг, Дэлгэрэх, Замын- Үүд,Хөвсгөл сумдын ЕБ-ын сургуулиудийн барилгад засвар хийх	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй Сайншанд сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн их засварын ажлыг 4 багцад хувааж нийт 1,8 тэрбум төгрөгийн өртөгөөр гадна фасад, дотор гэрэлтүүлэг, коридор, шатны хонгилын заслал, анги танхимын хаалга шинэчлэх, урлаг заал, спорт заал, гал тогооны засварын ажлыг "Дэнжийн хүү" ХХК, "Цүн түрүү" ХХК, "Дэнжийн цамхаг" ХХК гүйцэтгэхээр гэрээ байгуулсан. Багц 1,2,4-т тусгагдсан ажлууд бүрэн дууссан. 3-р багцад тусгагдсан урлаг заал, спорт заал, гар тогооны хэсгийн засварын ажил 60%-ийн гүйцэтгэлтэй байна. Орон нутгийн төсвийн 792.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн хичээлийн "А" блок, дотуур байрны дотор засал, гэрэлтүүлгийн засварын ажлыг "Эргэл хийц" ХХК гүйцэтгэж, ажлын явц 80%-тай. Айраг сумын Ерөнхий боловсролын сургуулийн засварын ажлыг орон нутгийн төсвийн 790.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Хөх оноо" ХХК гүйцэтгэж ашиглалтад оруулсан. Дэлгэрэх сумын ерөнхий боловсролын сургуулийн засварын ажилд орон нутгийн төсвийн 257,0 сая төгрөг батлагдсан боловч төсвийн тодотголоор хөрөнгө оруулалт татагдаж хэрэгжээгүй. Замын-Үүд сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн гадна фасадын засварын ажлыг "Дэнжийн хүү" ХХК нь орон нутгийн төсвийн 138,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өгсөн. Хөвсгөл сумын ЕБС-ийн хичээлийн байрны өргөтгөл барих, хуучин сургуулийн барилгын гадна фасадын засварын ажлыг улсын төсвийн 2,9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Хөх оноо" ХХК гүйцэтгэж ажлын явц 35%-тай явагдаж байна.	70%

20			Замын-Үүд суманд 640 хүүхдийн сургуулийн барилгыг ашиглалтад оруулах	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	65	100	Улсын төсвийн 9,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Замын-Үүд суманд 640 хүүхдийн сургуулийн барилга угсралтын ажлыг “Билгүүн монгол констракшн” ХХК гүйцэтгэж, барилгын дотор засал, халаалт, салхивч, гэрэлтүүлэг, холбоо дохиоллын ажил хийгдэж тус онд багтаж дуусгахаар ажлын гүйцэтгэл 90%-тай явагдаж байна. Мөн ОНТ-ийн 1,8 тэрбум төгрөгийн өртөгөөр тус сургуулийн гадна шугам сүлжээ, гадна тохижилтын ажлыг “Густокек” ХХК гүйцэтгэж гадна цахилгаан хангамж, зам талбайн тохижилтын ажил хийгдэж явц 90%-тай	100%
21			Сайншанд сумын 8-р цэцэрлэгийн барилгын иж бүрэн засварын ажил	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Орон нутгийн төсвийн 430.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 8 дугаар цэцэрлэгийн их засвар хийх ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах нээлттэй тендер зарласан боловч оролцогч кампани ороогүй тул засварын ажил хийгдээгүй. Мөн аймгийн ИТХ -ын 2024 оны 19/01 дүгээр тогтоолоор хассан.	30%
22			Хатанбулаг суманд 320 хүүхдийн сургуулийн барилгыг ашиглалтад оруулах	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	80	100	Хатанбулаг сумын 320 хүүхдийн сургуулийн барилгын ажлыг 7,8 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөр "Нью констракшн" ХХК гүйцэтгэж, 2023 оны 12 дугаар сарын 30-ны өдөр улсын комисс хүлээлгэн өгсөн. 2023-2024 оны хичээлийн жилд сургалтын үйл ажиллагаа хэвийн явуулж, 17 бүлгийн нийт 370 суралцагч хичээллэж, хичээл сургалын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.	100%
23			Даланжаргала н суманд 320 хүүхдийн сургуулийн барилгыг ашиглалтад оруулах	Ажлын гүйцэтгэл	хувь	2024	0	100	Улсын төсвийн 7,8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Даланжаргалан суманд 320 хүүхдийн сургуулийн барилгыг шинээр барих ажил орон нутагт эрх шилжиж ирээгүй бөгөөд тендер шалгаруулалтад хэд хэдэн удаагийн гомдол гарч тус ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах ажил удаарширсан бөгөөд 2024 оны 10 дугаар сарын 28-нд нээгдсэн тендерт "Ашид буйлдинг" ХХК шалгарч гэрээ байгуулах эрх олгосон.	30%
24			ЕБС-ийг нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	Тоног төхөөрөмжөөр хангасан сургууль	тоо	2023	21	22	Ерөнхий боловсролын 19 сургуульд нэн шаардлагатай 32 төрлийн /гал тогооны тоног төхөөрөмж, сурагчийн ширээ, сандал/ нийт 250,0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн судалгаа гаргасан. Санхүүгийн нөхцөл байдлаас шалтгаалан 2025 оны	30%

									төлөвлөгөө, төсөвт тусгуулахаар төлөвлөсөн. Аймгийн Засаг даргын 2024 оны 01/1258, 01/1259 тоот албан бичгээр Боловсролын сайд, аймгийн Боловсролын газраас 2024 оны 299 тоот албан бичгээр УИХ-ын гишүүн Б.Дэлгэрсайханаас дэмжлэг авах тухай албан бичиг хүргүүлсэн.	
25			Орон нутгийн инновацийн хөгжлийг дэмжих төвийн барилгын зураг төсөв хийх	Ажлын гүйцэтгэл	тоо	2023	0	100	Хүн амын тоог нэмэгдүүлэх, тэдгээрийг таатай нөхцөлөөр хангах зорилгоор орон нутгийн инновацийн хөгжлийг дэмжих төвийн барилгын зураг төсөв хийх, инженер программчлалын цогц хөтөлбөрийг боловсруулах зэрэг ажлуудыг нийт 125,0 сая төгрөгөөр зураг төсөв хийлгэх судалгаа хийж, газрын асуудлыг судлуулахаар аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт чиглэл өгсөн.	30%
26			Сайншанд сумын 2-р сургуульд Кембрижийн хөтөлбөр нэвтрүүлэх	Хөтөлбөр нэвтэрсэн хичээл	тоо	2023	0	5	Сайншанд сумын 6 дугаар сургуульд Кембрижийн хөтөлбөр нэвтрүүлэх үйл ажиллагааны хүрээнд суурь судалгаануудыг авч, мэдээлэл цуглуулан орчноо хэрхэн бүрдүүлэх, хэрхэн үр дүнтэй хэрэгжүүлэх талаар Боловсролын ерөнхий газраас зөвлөгөө, зөвлөмж авч ажилласан. Төсвөөс шалтгаалан 2025 онд эхний шатны сургалтыг зохион байгуулахаар төлөвлөсөн. 2024-2025 оны хичээлийн жилд Кембрижийн хөтөлбөрийг Математик, Англи хэл, Хими, Биологи, Физик зэрэг 5 судлагдахуун хичээлд нэвтрүүлэхээр хүсэлтийг Боловсролын ерөнхий газарт хүргүүлсэн.	30%
27			Замын-Үүд сумын ЕБ-ийн 1-р сургуулийн барилгыг буулгах, шинээр сургууль барих	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	50	Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 13.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Замын-Үүд сумын 1 дүгээр сургуулийг буулгаж шинээр 960 хүүхдийн сургууль барих ажлыг "Голомт констракшн" ХХК гүйцэтгэж явц 35%-тай.	70%
28			Сайншанд сумын ЕБ-ийн 1,2 дугаар сургуулийн биеийн	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Орон нутгийн хөгжлийн сангийн 712.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн баруун талд Нийтийн биеийн тамирын талбай шинээр байгуулах ажлыг "Сутайн жинст" ХХК гүйцэтгэж	70%

			тамирын талбайг тохижуулах, шинээр байгуулах						ажлын явц 40%-тай. Орон нутгийн хөгжлийн сангийн 133.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн биеийн тамирын талбайг шинэчлэх ажлыг “Дорнын далай очир” ХХК гүйцэтгэж дууссан.	
29			Инженер, программчлалын цогц хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Аймгийн "Шинжлэх ухаан технологийн салбар зөвлөл"-ийн 2024 оны "Инженер, программчлалын цогц хөтөлбөр"-ийг боловсруулан, суралцагчдын асуудлыг шийдвэрлэх, бие даан суралцах, бусадтай харилцаа холбоо тогтоох, хамтран ажиллах, бүтээлч, инженер сэтгэлгээний чадварыг нэмэгдүүлэх, судалгааны ажил хэрхэн хийх талаар сургалтыг ЕБ-ын 9-12 дугаар ангийн 450 сурагчдыг хамруулсан. Мөн "Ирээдүйн энтрепренерүүд" судалгааны ажил хийх уралдаанд 4 сургууль шалгарсан. Шинжлэх ухаан, технологи дээр суурилсан төслийн цагийн үйл ажиллагааны хүрээнд өөрийн орон нутаг, сургалтын байгууллага, байгаль орчинд тулгамдсан асуудалд шийдэл олох зорилгоор Иххэт, Айраг, Замын-Үүд, Сайншанд сумын ерөнхий боловсролын сургуулийн суралцагчид “Хоггүй цэвэр орчинд амьдрах шийдэл олцгооё”, “Хог хаягдал ашиглан бүтээл хийх нь”, “Хичээлээр үзсэн онолын мэдлэгээ хэрэглэж, хаягдал материал ашиглан вагон замын зарчмыг харуулсан туршилтат бүтээл урлах нь”, “Усаа хэмнэе” төслүүдийг хэрэгжүүлсэн. Суралцагчид хамтран төсөл хэрэгжүүлснээр багаар ажиллаж, бүтээлч чадварыг нэмэгдүүлэх, асуудлыг олж харах, шийдвэрлэх, судалгааны ажил бичих чадварт суралцсан. Нийт 4 төслийн үйл ажиллагаанд 80 гаруй суралцагч хамрагдсан. Сурагчдын техник сэтгэлгээг хөгжүүлэх, орон нутагтаа роботын боловсролыг түгээн дэлгэрүүлэх, ирээдүйн инженерүүдийг бэлтгэх зорилгоор Монгол-Солонгосын хамтарсан “ДОРНОГОВЬ РОБО-2024” лега роботын олон улсын сургалт, тэмцээнийг амжилттай зохион байгуулж ерөнхий боловсролын сургуулиудын дунд, ахлах ангийн 60 сурагч олон улсын хөтөлбөрийн сургалттай сургуулиудын 30	90%

									сурагч Бүгд Найрамдах Солонгос Улсын ахлах сургуулийн 30 сурагч Монгол, Солонгос зохион байгуулагч багш нар, Сайн дурын сурагчдын 150 гаруй хүн оролцсон. Тус сургалт, тэмцээнд аймгийн Засаг даргын 2024 оны А641 дүгээр захирамжаар 16,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	
30			ЕБС-уудад гадна, дотор камер худалдан авах	Камер	тоо	2023	10	421	Орон нутгийн төсвийн нийт 244.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Ерөнхий боловсролын 16 сургуульд гадна, дотор нийт 421 камер суурилуулах тендер шалгаруулалтад "Би И инженеринг" ХХК ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 100 хувь хийж гүйцэтгэсэн.	100%
31			ЕБС-ийн багш нарыг хөгжүүлэх	Зохион байгуулсан арга хэмжээ	тоо	2023	16	22	Боловсролын ерөнхий газраас зохион байгуулсан 1, 5, 10 дахь жилдээ ажиллаж буй багш нарын үндсэн сургалтад 22 сургуулийн 120 багш, удирдах ажилтан танхим болон цахимаар хамрагдсан. Мөн модуль сургалтад 647 багш удирдах ажилтан, БШУГ-аас зохион байгуулсан чадавхжуулах сургалтад 629 багш, удирдах ажилтан, сургуулийн менежментийг сайжруулах чиглэлээр улсын хэмжээнд сонгогдсон 8 сургуулийн 27 удирдах ажилтан, БШУГ-ын 8 ахлах арга зүйчийг хамруулан академик мэдлэг болон заах арга зүйг дээшлүүлж ажилласан. Ажлын байрандаа тасралтгүй хөгжиж өөрийн мэдлэг ур чадвараа дээшлүүлсэн 187 багш өөрийн арга туршлагаа танхим болон цахимаар түгээсэн. Давхардсан тоогоор 1618 багш удирдах ажилтан чадавхжуулах сургалтад хамрагдсанаар арга зүй, ур чадвар сайжирсан. Мөн "Явцын үнэлгээ ба ялгаатай суралцахуйн арга зүй" цахим сургалтад ерөнхий боловсролын сургуулийн 412 багш хамрагдсан. Бага ангийн сургалт Esurgalt, itpd.mn цахим платформд 1 дүгээр ангийн сурагчидтай ажиллах арга зүйн сургалтад 1 дүгээр ангид орох хөгжим, биеийн тамир, бага ангийн 82 багш хамрагдсан. "Шинэ монгол" сургуулиас зохион байгуулж буй "Сургуульд суурилсан менежмент" төслийн хүрээнд 16 сурууль 7 хоног тутам бүр цахим сургалтад хамрагдсан. Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын мэргэшүүлэх, хөгжүүлэх сургалт, үйл ажиллагаанд	90%

									аймгийн Засаг даргын захирамжаар 88,2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	
32			"Чадварлаг багш" арга хэмжээг хэрэгжүүлэх	Зохион байгуулсан арга хэмжээ	тоо	2023	10	20	“Чадварлаг багш” арга хэмжээний хүрээнд сургуулийн менежмент, сургалтын арга зүй, багшийн хөгжлийг дэмжих зорилгоор аймгийн Засаг даргын 2024 оны А/164 дугаар захирамжаар ЕБС-ын багш нарт мэргэшүүлэх үе шаттай сургалт зохион байгуулахад зориулж нийт 38,2 сая төгрөгийг дэмжлэг үзүүлсэн. Сургалтад ЕБС-ын 722 багш бүрэн хамрагдаж мэдлэгээ дээшлүүлсэн. Аймгийн хэмжээнд бага ангийн 21 ментор багш сургуулиудад 5 хоногийн хугацаатай ажиллаж, өөрийн арга зүй болон сургуулийн арга туршлагаа түгээн дэлгэрүүлсэн. Medle.mn цахим сургуульд 6 багш хичээл зааж, 9 сургуулийн 230 сурагч хамрагдсан. Хичээл төрлийн олимпиадын хоёрын даваанд амжилттай оролцож шалгарсан 11 судлагдахууны 16 багш, 46 сурагч улсын олимпиадад оролцож, 3 багш, бэлтгэсэн шавь нараас нь 9 сурагч шагналт байруудад шалгарсан. Аймгийн Засаг даргын 2024 оны А/259 захирамжаар 11,4 сая төгрөгийг шийдвэрлэн, “Зорилгын хүч-5” сургалт, үйл ажиллагааг зорилгын хуудас бөглүүлэх, танхимын сургалт зохион байгуулах, анги хамт олны бүтээлч ажил өрнүүлэх, дэвжээ тэмцээн зэрэг шинэлэг байдлаар зохион байгуулж, 10 сургуулийн элсэлтийн шалгалт өгөх 12-р ангийн 711 сурагчдыг хамруулсан. “Зорилгын-Хүч-5” үйл ажиллагааны хүрээнд 10 судлагдахуунаар мэргэжлийн зэрэгтэй 35 багш удирдан 278 цагийн сургалт хийж, давхардсан тоогоор 3128 суралцагчийг хамруулсан. Дээрх олон талт үйл ажиллагааг зохион байгуулснаар 2024 оны элсэлтийн шалгалтын хэмжээст оноо өмнөх оноос 0.1-ээр ахисан.	90%
33			ЕБС-ийн багш нарын ур чадварын болон илтгэлийн	Зохион байгуулсан арга хэмжээний төрөл	тоо	2023	10	15	Аймгийн Засаг даргын 2024 оны А/259 захирамжаар 11,4 сая төгрөгийг шийдвэрлэн, “Зорилгын хүч-5” сургалт, үйл ажиллагааг зорилгын хуудас бөглүүлэх, танхимын сургалт зохион байгуулах, анги хамт олны бүтээлч ажил өрнүүлэх,	90%

			уралдаан, зорилгын хүч, хичээл төрлийн олимпиад зохион байгуулах						дэвжээ тэмцээн зэрэг шинэлэг байдлаар зохион байгуулж, 10 сургуулийн элсэлтийн шалгалт өгөх 12-р ангийн 711 суралцагчийг хамруулсан. “Зорилгын-Хүч-5” үйл ажиллагааны хүрээнд 10 судлагдахуунаар мэргэжлийн зэрэгтэй 35 багш удирдан 278 цагийн сургалт хийж, давхардсан тоогоор 3128 суралцагчийг хамруулсан. Шилдэг илтгэл шалгаруулах “Хамтын оролцоонд суурилсан сургалтын байгууллагын менежментийг хөгжүүлэх нь” сэдэвт аймгийн багш нарын эрдэм шинжилгээний хурлыг цахим болон танхим хосолсон хэлбэрээр 2 үе шаттай зохион байгуулж 24 сургууль, цэцэрлэгийн багш, заах аргын нэгдэл, багш нарын хамтарсан багууд оролцож, СӨБ-ын байгууллага болон ЕБ-ын сургууль тус тус шилдгүүдээ шалгаруулсан. Үүнд: Сайншанд сумын ЕБ-ын 3-р сургууль, Замын-Үүд сумын 2-р сургууль, Алтанширээ сумын сургуулийн багш нарын эрдэм шинжилгээний ажил эхний 3 байрт шалгарсан. Шалгарсан багш нараас улсын шилдэг илтгэл шалгаруулах уралдаанд “Ментор эцэг эхээр дамжуулан сургалтын байгууллагын менежментийг хөгжүүлэх боломж” сэдэвт илтгэлийг “Дорноговь аймгийн баг” тавьж амжилттай оролцсон. Зорилгын хүч-5 уралдаан 6 төрлийн арга хэмжээг зохион байгуулсан. Сурагчдын хоцрогдлыг арилгах, гүйцэтгэлийн үнэлгээнд ахиц гарган, сургалтын чанарыг сайжруулах зорилгоор 1-12-р ангид дизайн технологи, англи хэл, орос хэл, эрүүл мэнд, математик, физик, бага анги /монгол хэл, математик, хүн ба байгаль/, үндэсний бичиг судлагдахуунаар “Анги хамт олны олимпиад”-ыг 2 үе шаттайгаар зохион байгуулж, давхардсан тоогоор 1098 бүлгийн 57111 сурагч хамрагдаж гүйцэтгэл 3,7 хувийн ахицтай, судлагдахуун бүрийн гүйцэтгэлийн хувь 1.5%-18.9% -иар ахисан байна.	
34			Багш спорт арга хэмжээ зохион байгуулах	Хамрагдсан багш нар	тоо	2023	0	250	Аймгийн Засаг даргын 2024 оны А692 дугаар захирамжаар 15,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, “Багш спорт 2024” спортын наадмыг 10 дугаар сарын 03-05-ны өдрүүдэд зохион байгуулж, ЕБ-ын 21 сургууль, АШУҮИС-ийн салбар Анагаах ухааны	100%

									сургууль, Польштехникийн коллеж, 33 цэцэрлэгийн 500 гаруй багш, ажилтнууд спортын 5 төрлөөр оролцсон. Багийн нийлбэр дүнгээр Сайншанд сумын 5 дугаар сургууль, Замын-Үүд сумын 1 дүгээр сургууль, Сайншанд сумын 6 дугаар сургуулийн баг эхний 3 байрт шалгарсан. Дархан-Уул аймагт 2024 оны 10 дугаар сарын 25-27-ны хооронд зохион байгуулагдсан "Багш спорт-2024" 21 аймгийн багш нарын спортын наадамд 50 хүний бүрэлдэхүүнтэй баг, тамирчид оролцож, аймгийн Засаг даргын 2024 оны А/754 дүгээр захирамжаар 11,8 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	
35			Орон нутагт нэн шаардлагатай багш бэлтгэхэд сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэх	Сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлсэн багш	тоо	2023	5	8	Орон нутагт нэн шаардлагатай дуу хөгжмийн багш мэргэжлээр суралцаж байгаа 5 оюутантай "Сургалтын гэрээ" байгуулан, жил бүр сургалтын төлбөрийн 100%-ийн дэмжлэг үзүүлсэн. 2023-2024 оны хичээлийн жилд гэрээний дагуу 20.0 сая төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлсэн. Аймгийн Засаг даргаас болон Эрээн хотоос Замын-үүд суманд суугаа Ерөнхий консулын газартай хамтран, 12 оюутанд нийт 28,5 сая төгрөгийн сургалтын төлбөрийн тэтгэлэг олгосон. "Гүүр" төсөл, хөтөлбөрийн хүрээнд Бүгд Найрамдах Солонгос Улсын Чонжу хотын Чонжу Их Сургуульд Бизнесийн удирдлага, Архитектур, Зочид буудлын менежмент, Кино зураглаач, Солонгос хэлний чиглэлээр 30 хүүхэд, залуучуудыг тэтгэлгээр сургахаар тэтгэлэгт хөтөлбөрийг зарлан, 13 хүүхдийн хүсэлт материалыг хүлээн аваад байна. Шалгаруулалтыг 11 сард зохион байгуулна. Мөн ОХУ-ын Томскийн Польштехникийн Их Сургуульд Технологийн үйл ажиллагаа ба үйлдвэрийн автоматжуулалт, Газрын тос, байгалын хий, Цахилгаан эрчим хүч болон цахилгааны инженерчлэл зэрэг мэргэжлээр бүрэн тэтгэлэгт хөтөлбөр зарлаад байна.	90%
36			Сургуулийн менежментээр дамжуулан цахим технологийг	Нэвтрүүлсэн сургалтын технологи	тоо	2023	0	6	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны "Цахим системд суурилсан англи хэлний хөтөлбөр хэрэгжүүлэх, төлөвлөгөө батлах тухай" А/353 дугаар тушаал, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны "Сургалтын цахим систем нэвтрүүлэх, зардал	100%

			нэмэгдүүлэх, сайжруулах						батлах тухай" А/312 дугаар тушаалаар 2023-2024 оны хичээлийн жилээс ЕБС-ийн 3-4 дүгээр ангид Эдүтэн цахим системд аймгийн 21 сургуулийн 3200 суралцагч, Англи хэлний Pearson хөтөлбөрт 3758 суралцагч хамрагдсан. 2024-2025 оны хичээлийн жил Eduten цахим системд Дорноговь аймгийн төрийн өмчийн 21 сургуулийн 1-5 дугаар ангийн 7900 суралцагч, Англи хэлний Pearson хөтөлбөрт 19 сургуулийн 5-7, туршилтаар Сайншанд сумын 1 дүгээр сургуулийн 3-10, Сайншанд сумын 2 дугаар сургуулийн 3-7 дугаар ангийн 6059 сурагчид хамрагдаж математик, гадаад хэл, технологийн ур чадвараа хөгжүүлж байна. Ерөнхий боловсролын сургуулийн математикийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, чанарыг сайжруулах зорилгоор цахим системийн хэрэгжилтэд мониторинг хийн, сургуулийн үйл ажиллагаа, багшийн арга зүйд дэмжлэг үзүүлэх зорилгоор, БЕГ-ын мониторингийн баг, Боловсролын газартай хамтран 2024оны 10 сарын 08-22нд Сайншанд, Дэлгэрэх, Алтанширээ, Өргөн, Эрдэнэ сумдын сургуульд ажиллалаа. Үйл ажиллагааны явцад сургууль бүр дотоод сүлжээ, интернэт орчин бүхий цахим ангийг байгуулж, кабинетийн системээр хичээллэх орчин нөхцөлийг хангасан байдалтай танилцлаа. Тус үйл ажиллагаанд 9 сургуулийн 30 удирдах ажилтан, 80 багш хамрагдлаа. Аймгийн 21 сургуулиас цахим кабинет байгуулсан 13, интернэтийн дотоод сүлжээг сайжруулсан 21 сургууль байна. Цахим системд хамрагдсан хүүхдийн тоо өмнөх онд 6778 байсан бол 13959 болж 2 дахин нэмэгдсэн байна. Боловсролын ерөнхий газраас хэрэгжүүлж буй сургуулийн менементийн хөтөлбөрт 8 сургууль, Шинэ Монгол сургуулиас хэрэгжүүлж буй "Сургуулийн менежмнет"-ийн хөтөлбөрт 16 сургууль цахимаар хамрагдсан.	
37			Олон улсын боловсролын үзэсгэлэн	Оролцсон улс, сургууль	тоо	2023	0/0	8 20	"Нээлттэй Дорноговь аймаг", "Түншлэл-хөгжил 2024" зорилтот жилийн хүрээнд аймгийн Засаг даргын 2024 оны А/322 дугаар захирамжаар "Bridge to Dornogobi" олон улсын боловсролын үзэсгэлэнг	100%

			зохион байгуулах						2024 оны 04 дүгээр сарын 05, 06-ны өдөр зохион байгуулсан. “Bridge to Dornogobi” олон улсын боловсролын үзэсгэлэнд 2400 гаруй суралцагч, оюутан, залуучууд, эцэг эхчүүд, төрийн албан хаагчдыг хамруулан, дэлхийн 11 улс, орны 17 их дээд, сургуулиудын сургалтын хөтөлбөр, оюутан элсүүлэх журам, тэтгэлэгт хөтөлбөрүүд, боловсролын өнөөгийн тогтолцоо, цаашдын хөгжил, суралцах боломж зэрэг сонирхсон бүхий л чиглэлийн мэдээ, мэдээллийг хүргэсэн. Боловсролын үзэсгэлэнд Унгар улс, Чех улсын Элчин сайдын Яамд, олон Улсын байгууллагын төлөөлөл болох Солонгос-Монголын Хөгжлийн төв, Япон-Монгол төв, Оросын соёл шинжлэх ухааны төв, Монгол Францын Соёлын төв, Америкийн нэгдсэн улсын Сиатл хотын Их Сургууль, Санхүү Эдийн Засгийн Дээд Сургууль зэрэг томоохон их дээд сургуулиудын төлөөллүүд хүрэлцэн ирж, оролцогчдод 2 өдрийн турш илтгэл, хэлэлцүүлэг өрнүүлэх, сургуулиудын танилцуулгыг хүргэх зэрэг өргөн цар хүрээтэй хүртээмжтэй байдлаар олон талын мэдээ, мэдээллийг өглөө. Тус үйл ажиллагааны үеэр суралцагчдын гадаад хэлний мэдлэг эзэмших, түвшин ахиулах боломжийг олгох зорилгоор тусгай шаардлагыг хангасан 8 суралцагчдад ахисан түвшний англи хэлний сургалтад хамрагдах нийт 4.0 сая төгрөгийн эрхийн бичгийг гардуулж, сургалтад хамруулсан. Төсөл, хөтөлбөрийн үр дүнд Дорноговь аймгийн 30 ЕБС төгсөгч, оюутан, залуусыг БНСУ-ын Чонжү хотын Чонжү Их сургуульд Бизнесийн удирдлага, Архитектурын инженерчлэл, Зочид буудлын менежмент, Кино зураглаач, Солонгос хэлний чиглэлээр тэтгэлгээр суралцуулахаар сонгон шалгаруулах үйл ажиллагаа зохион байгуулагдаж байна.	
38			Насан туршийн боловсрол олгох үйл	Хамрагдс ан хүүхэд	тоо	2023	24000	2500 0	Аймгийн Засаг даргын 2024 оны А/166 дугаар захирамжаар аймгийн хэмжээний насан туршийн боловсролын нэгжийн багш нарыг чадавхжуулах, гэр бүлийн боловсролын үндэсний сургагч багш бэлтгэх	100%

			ажиллагааны чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх						зорилгоор модуль сургалтыг зохион байгуулахад зориулж 7,6 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, нийт 20 багшийг сургагч багшаар бэлтгэсэн. Гар урлалын сургалтыг 7 төрлөөр зохион байгуулж, нийт 208 иргэн, иргэний боловсролын сургалтыг 5 төрлөөр нийт 603 иргэн хамрагдсан. Үндэсний бичгийн анхан болон ахисан шатны сургалтыг 7 байгууллагын 115 албан хаагч, 71 иргэнд, цахим бичвэрийн сургалтыг 4 байгууллагын 29 албан хаагч, 8 иргэнд, 22 төрийн байгууллагын 22 архив бичиг хэргийн ажилтныг хамруулж мөн 7000 гаруй дагагчтай үндэсний бичиг түгээн дэлгэрүүлэх зорилготой Босоо бичиг бидний бахархал цахим хаягаар цахим хичээл, уралдааныг тогтмол зохион байгуулж 38000 хүнд түгээсэн. "Тунгаамал" үндэсний бичгийн аварга шалгаруулах хамт олны уралдааныг насанд хүрэгчдэд 5 удаа, ЕБС-ийн хүүхдүүдэд 5 удаа зохион байгуулж, 25 байгууллагын 180 албан хаагч, 12 жилийн 11 ЕБС-ийн 180 сурагчдыг оролцуулсан. Аймгийн ИТХ-тай хамтран Зочинтой уулзалт арга хэмжээг 4 удаа зохион байгуулж, нийт 810 иргэн, 720 ахлах болон дунд ангийн суралцагч оролцсон. Энэ хичээлийн жилд Боловсрол нөхөн олгох хөтөлбөрөөр 1-12 ангийн нийт 59 сурагч суралцаж байна. Тусгай хэрэгцээт боловсролын тэгш хамруулах сургалтыг явуулж танхимаар 13 хүүхэд, эрүүлжин хөгжих төвд 11, гэрийн тойролт, эргэлтээр 12 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байна. Тус байгууллагын багш ажилчид өмнөх онтой харьцуулахад 70 хувь шинэчлэгдсэн тул багш чадавхжуулах хөтөлбөр дээр түлхүү анхаарч ажиллан 9 удаагийн сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулсан. Насан туршийн боловсролыг иргэд олон нийтэд хүргэдэг багш ажилчдын чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор 4 байгууллагатай хамтран 7 төрлийн сургалтад багш нарын 90.4 хувийг хамруулсан. Аймгийн Засаг даргын захирамжаар 2,4 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, Боловсролын ерөнхий газраас Хэнтий аймагт зохион байгуулсан говийн болон зүүн бүсийн 7	
--	--	--	---	--	--	--	--	--	--	--

									аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн багш, удирдах ажилтныг чадавхжуулах сургалт, зөвлөгөөнд 14 сумын багш нарыг хамруулсан. Насан туршийн боловсролыг тэгш хүртээмжтэй хүргэх, иргэд олон нийтэд таниулах зорилгоор 25 төрлийн арга хэмжээг танхим болон цахим хэлбэрийн хосолсон аргаар зохион байгуулж, нийт 34584 иргэнд хүрч ажилласан.	
Салбарын үр дүн 1.3: Олон улсын хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөхүйц мэргэжлийн болон техникийн боловсролтой төгсөгчдийг 3 дахин нэмэгдүүлнэ.										
39	Политехникийн Коллежи төгсөгчдөөс мэргэжлээрээ ажиллагчдыг 2 хувиар нэмэгдүүлнэ.	Мэргэжлийн болон техникийн боловсрол хөтөлбөр	Мэргэжлийн ур чадварын уралдаануудад оролцоход дэмжлэг үзүүлэх	Ур чадварын уралдаан	тоо	2023	1	2	Монгол Солонгосын политехник коллежид зохион байгуулагдсан “Монгол ур чадвар” мэргэжлийн ур чадварын уралдаанд Политехникийн коллежийн авто машин засварчин мэргэжлийн 2 багш, авто машин засварчин мэргэжлийн 5 суралцагчийн хамт амжилттай оролцсон. Политехник коллежийн захирлын нэрэмжит мэргэжлийн ур чадварын уралдааныг жил бүр уламжлал болгон зохион байгуулж, 7 төрлийн тэмцээнд 1-2 дугаар курсын нийт 120 суралцагч хамрагдсан. Мэргэжлийн ур чадварын тэмцээн зохион байгуулж, оролцсоноор суралцагчдын сурах идэвх оролцоо нэмэгдэж, цаашид дэвшин суралцах хүсэл тэмүүлэлтэй болсон.	90%
40			Бүс нутгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн КООСЕН сургалтын хөтөлбөрийг мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтад нэвтрүүлэх	Нэвтрүүлсэн чиглэл	тоо	2023	0	2	Тус хөтөлбөр нь Улсын хэмжээнд туршилтаар анх удаа нэвтэрж байгаа бөгөөд орон нутгийн орчин нөхцөлөөс шалтгаалан хэрэгжих боломжгүй байна.	30%
41			Дорноговь аймаг дахь Политехникийн коллежийн	Ашиглалтад орсон сургууль	хувь	2023	0	100	Барилгын зураг төсөв хийлгэх төсвийг 2024 оны төсвийн тодотголд оруулах саналыг Боловсрол шинжлэх ухааны яам болон Боловсролын ерөнхий газарт удаа дараа хүргүүлсэн боловч хариу ирээгүй.	30%

			цогцолборын барилгын зураг төсөв боловсруулах							
Салбарын үр дүн 1.4: Халдварт болон халдварт бус өвчлөлийг 20 хувиар бууруулна.										
42	Амьдралын зөв дадал хэвшилтэй иргэдийн тоог 5 хувиар нэмэгдүүлнэ.	Нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөр	НЭМ-ийн сургалт, сурталчилгаа зохион байгуулах	Сургалтад хамрагдсан иргэд	тоо	2022	12000	14000	ЭМЯ-аас 2024 оныг “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулж аймгийн хэмжээнд “Нийгмийн эрүүл мэндийг - Өрх бүрд” зорилтыг тавьж, дэмжих жилийн нээлтийн үйл ажиллагааг нийт 30 байгууллага, спорт клубүүдтэй хамтран зохион байгуулж, 13 төрлийн цэгээр 600 гаруй иргэдэд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлсэн. ЭМБ-ууд нийгмийн эрүүл мэндийн чиглэлээрх 12 төрлийн арга хэмжээг хувь хүн, гэр бүлд түшиглэн иргэдэд эрүүл зан үйл төлөвшүүлэх, хамт олонд эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх ажлыг тасралтгүй хүргэсээр байна. Тайлант хугацаанд 18 удаагийн аян, өдөрлөг, 2154 удаагийн цахим ба танхимын сургалт, сурталчилгаа, хэлэлцүүлэг, 4 удаагийн тэмцээн уралдаан зохион байгуулж, давхардсан тоогоор 24054 хүнийг хамруулсан нь өмнөх оны мөн үеэс 321 удаагийн сургалт 5641 хүнээр нэмэгджээ. Цахимд 2005 төрлийн мэдээлэл, зөвлөмж байршуулсан нь 113201 хандалтыг авч, орон нутгийн телевиз, “Дорноговь сайт”-тай хамтран “Эмчийн зөвлөгөө”, “Охид хөвгүүдийн цаг”, “Зочны цаг” зэрэг 97 нэвтрүүлэг, цаг үеийн мэдээ, мэдээллийг бэлтгэн хүргэснээр иргэдийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл идэвхтэй амьдралын хэв маяг өөрчлөгдөж мэдлэг мэдээлэл нэмэгдэн эрүүл аж төрөх дадал хэвшилтэй өрх гишүүдийн хувь нэмэгдсэн.	100%
43			"Эрүүл, идэвхитэй хүн" арга хэмжээг хэрэгжүүлэх	Арга хэмжээнд хамрагдсан иргэд	тоо	2022	94254	10000	"Эрүүл идэвхтэй амьдрал" арга хэмжээний хүрээнд иргэдийн эрүүл идэвхтэй амьдралыг нэмэгдүүлэх зорилгоор тайлант онд 3375 удаагийн сургалт, сурталчилгаа, тэмдэглэлт өдөр, уралдаан тэмцээн зэрэг олон нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 171 байгууллагын 16571 ажилтан, иргэдийг хамруулсан	100%

								нь өмнөх оны мөн үеэс 14 байгууллага 952 хүнээр нэмэгджээ. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх 1993 төрлийн мэдээлэл, зөвлөмжийг цахимд байршуулсан нь 102547 хандалт авсан байна. “Нийгмийн эрүүл мэндийг- Өрх бүрт” зорилтыг 2024 онд дэвшүүлж, аймгийн хэмжээний хүрээнд 24 ЭМБ-ын 296 эмч, сувилагч нар 7423 өрхийн 23406 иргэнд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэж, өрхийн эрүүл мэндийн эрсдэлийг үнэлэхэд эрүүл мэндийн эрсдэлгүй-8%, эрсдэл бага-29%, дунд зэргийн эрсдэлтэй-40.8%, өндөр эрсдэлтэй-22.2% үнэлэгдсэн нь иргэд өглөөний цай ууж хэвшээгүй, өдөрт уух ус, жимс, цагаан идээний хэрэглээ маш бага, идэвхтэй дасгал хөдөлгөөн хийж хэвшээгүй зэрэг нь нөлөөлж байна. Арга хэмжээний хүрээнд “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жилийн нээлт”, “Хийн дасгалын сургагч багш бэлтгэх сургалт”, “Эмч спорт”, “Flash mob” тэмцээн, “Энэ жилдээ - Эрүүл жиндээ-2 аян”, “Осол гэмтлээс сэргийлэх”, Хүүхдийн аюулгүй байдал-Таны хариуцлагаас”, “Эрт илрүүлэг үзлэгийг эрчимжүүлэх” аян зэрэг томоохон арга хэмжээнүүдийг зохион байгуулснаар төлөвлөгөө 94.1% -тай хэрэгжиж, өмнөх оноос 2.3%-иар нэмэгдэж, иргэдийн эрүүл мэндийг дэмжих, дасгал хөдөлгөөнөөр хичээллэх иргэд байгууллагын тоо өмнөх оноос 10%-иар нэмэгдсэн сайн талтай байна.	
44		"Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээг хэрэгжүүлэх	Арга хэмжээнд хамрагдсан охид эмэгтэйчүүд	тоо	2022	14860	16000	"Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээг 5 зорилтын хүрээнд 33 үйл ажиллагааг төлөвлөж, 84.8-тай хэрэгжсэн байна. Үүнд: Өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор “Үе тэнгийн сургагч багш чадавхжуулах” сургалтыг зохион байгуулснаар Сайншанд сумын ЕБ-ын 5 сургуулийн 31 хүүхэд, Политехник коллежийн 14 өсвөрийн эмчийг хамруулж, 22 хүүхдийг шинээр бэлтгэв. Сургалтын үр дүнд үе тэнгийн нийт 3005 хүүхдэд ЭМБ олгосноос охид 1482 байна. Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран “Охид хөвгүүдийн цаг” нэвтрүүлэг–8, подкаст бичлэг 4 удаа бэлтгэн хүргэснээр 8647	100%

									хүний хандалт авчээ. "Хүүхдийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх" зорилгоор Цагдаагийн газартай хамтран "Өсвөр үеийнхнийг эрсдэлт хүчин зүйлсээс хамгаалах", Эрүүл зөв дадал хэвшүүлэх 17 удаагийн сургалтаар 1184 охидыг хамруулсан. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд жирэмсэн эхчүүд болон тэдний гэр бүлд зориулсан 87 удаагийн сургалтад 610 хүнийг хамруулж, 21 төрлийн 227 ширхэг сурталчилгааны материал тарааж, 96 удаагийн мэдээлэл цахимд байршуулснаар 6492 хүний хандалтыг авсан байна. ЕБС-ийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан өсвөр насны 1157 охидод гэр бүл төлөвлөлт, охидын эрүүл ахуйн талаар зөвлөгөө мэдээлэл өгч, НЭ-ийн эх барих эмэгтэйчүүдийн эмч нар DTV телевизээр Жирэмсний эрт үеийн хяналт, Жирэмсэн үед анхаарах асуудлын талаар 2 удаа зөвлөгөө хүргэж, эрсдэлт хүчин зүйлээс сэргийлснээр жирэмснээс сэргийлэх арга хэрэглээний хувь 80.3%-д хүрэв. Жирэмсний хяналтад 1176 эмэгтэйчүүд орж, эрт үеийн хяналт 87.1%-д хүрч, 2024 оны 10 сарын байдлаар 1055 жирэмсэн эхийг 4 халдвар илрүүлэх шинжилгээнд 100% хамруулж, өвчлөл илэрсэн жирэмсэн эмэгтэйг 100% эрүүлжүүлснээр төрөлхийн тэмбүү бүртгэгдээгүй. Жирэмсний хяналтын чанарыг нэмэгдүүлэх зорилгоор ЭМГ, анхан шатны эрүүл мэндийн төвийн дарга нарын дунд 7 хоног бүр жирэмсний хяналтын эргэн мэдээллийг хийж, эмнэлэг хоорондын уялдаа холбоог сайжруулж, Эх нярайн тусламжийг чадавхжуулах 6 удаагийн цахим ба танхимын сургалтыг давхардсан тоогоор 112 эмч мэргэжилтнүүдийг чадавхжуулснаар эхийн ноцтой хүндрэл 2 бүртгэгдсэнд шуурхай арга хэмжээг авч, тайлант хугацаанд эхийн эндэгдэлгүй ажиллаж байна.	
45			"Эрүүл чийрэг эр хүн" арга хэмжээг хэрэгжүүлэх	Арга хэмжээнд хамрагдсан	тоо	2022	4447	5000	"Эрүүл чийрэг эр хүн" арга хэмжээг 4 зорилтын хүрээнд 18 ажлыг төлөвлөснөөр хэрэгжилт 83.3%-тай байна. "Дэээрэт" ОУ-ын Энэрлийн байгууллагын 136 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгтэйгээр АНЭ-ийн амбулаторийн тасагт "Эрэгтэйчүүдийн кабинет"-	100%

				эрэгтэйчү үд				ийг ЭМС-ын А/449 дүгээр тушаалын дагуу 2024 оны 2-р сард шинээр нээж, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй орон нутагтаа авах боломжийг бүрдүүлэв. Тус кабинет нээснээр Урологийн эмчийн үзлэгт 264 хүн хамрагдаж, үүнээс мэс засал шаардлагатай 19 хүнд хагалгаа хийж, тусламж үйлчилгээг үзүүлсэн. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр 151 удаагийн сургалт, сурталчилгааг зохион байгуулж 4800 эрэгтэйчүүдийг хамруулж 93 төрлийн 1232 зөвлөмж тараан, цахимд 107 төрлийн мэдээлэл, зөвлөмж байршуулснаар 37994 хандалт авсан нь өмнөх оноос 21 удаагийн сургалт, 17009 хандалтаар нэмэгдсэн. Дээрх үйл ажиллагаануудын үр дүнд эрэгтэйчүүдийн эрүүл мэнддээ тавих анхаарал хандлага өөрчлөгдөж, урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгт 2024 оны 10 сарын байдлаар 5310 хүнийг хамруулснаас 46.1% нь эрэгтэйчүүд байгаа нь өмнөх оноос 0.6%-иар нэмэгдсэн. Дорноговь аймгийн Засаг даргын 2024 оны А/308, А/350 дугаар захирамжаар 2024 оны 1-р ээлжийн цэрэг татлагын үзлэгт нийт 14 сумын 767 залуучууд хамрагдсан нь өмнөх оноос 296 залуучуудаар нэмэгдсэн. Үзлэгт эрүүл мэндээр тэнцсэн 537, тэнцээгүй 230 хүн байгаагаас эрүүлжүүлэх төлөвлөгөө гаргаж, эмчилгээ хяналтыг хийснээр эрүүлжүүлэлт 70%-тай явагдсан нь өмнөх оноос 1.2%-аар өссөн үзүүлэлттэй байна.	
46		"Эрүүл насжилт" арга хэмжээг хэрэгжүүлэх	Сургалт, эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан ахмад	тоо	2023	3500	4500	ЭМС-ын 2024 оны "Заавар батлах тухай" А/22 дугаар тушаалын дагуу "Ахмад настны хам шинжийг илрүүлэх ICOPE үнэлгээ, сорил"-ыг хэрхэн авах тухай заавар зөвлөмжийг СЭМТ, ӨЭМТ-ийн 20 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд танилцуулах сургалт хийсэн. ICOPE үнэлгээний хараа, сонсголын бэрхшээл илрүүлэн оношлохоор 35 хүнд үнэлгээг хийж зөвлөгөө өгсөн. Ахмадын кабинетаар давхардсан тоогоор 17968 ахмад настанд эмнэлгийн тусламж үйлчилгээг шуурхай үзүүлж, 2401 ахмадыг хэвтүүлэн эмчилсэн. Тайлант онд давхардсан тоогоор 46924 ахмад настан эмнэлгийн тусламж	100%

								үйлчилгээ авснаас хөнгөвчлөх тусламжид 379, сэргээн засах тусламжид 2965, сувилахуйн тусламжид 11604, гэрээр сувилахуйн тусламжид 1104 ахмад тус тус хамрагдаж өмнөх оноос 5240 ахмадаар нэмэгдсэн. Мөн ЭМБ-ууд ахмадын эрүүл мэндтэй холбоотой 25 удаагийн сургалт сурталчилгаанд 1469 ахмадыг хамруулж, цахимд 56 төрлийн мэдээллийг байршуулан 1594 хандалт авч, шинээр 15 төрлийн зөвлөмж хэвлэн 579 хүнд тараасан нь өмнөх оноос 8 удаагийн сургалт, 748 ахмадаар нэмэгджээ. “Төвшин сайхан” ахмадын амралтын газар 2024 оны 5 сарын 1-ээс шинээр үйл ажиллагаагаа эхлүүлж, АНЭ, Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нар 7 хоног бүр үзлэг хийж, 352 ахмадыг үзлэгт хамруулсан. Мөн “Томуу, томуу төст өвчин, цэгэн массаж хийх”, “Эрүүл зөв хооллолт”, Цусны даралт ихсэлт зэрэг сэдвээр 254 хүнд сургалт хийж, эрүүл мэндийн дасгал зааж өгсөн байна. Аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 585 ахмад настан байгаагаас 5-р бүлгийн 120 ахмад байна. Гэрийн идэвхтэй хяналтад давхардсан тоогоор 5954 ахмад настан хамрагдсан нь өмнөх оноос 110 хяналтаар нэмэгдүүлж, гэрийн идэвхтэй хяналтыг сайжруулаад байна. 2022 оны 05 сараас эхэлсэн “Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг шинжилгээ оношилгоо”-нд аймгийн хэмжээнд өссөн дүнгээр 34349 иргэн хамрагдсанаас 27%-ийг ахмад настан эзэлж байна.	
47		"Элэг бүтэн-Монгол" арга хэмжээг зохион байгуулах	Элэгний вирус халдвараас сэргийлэх сургалтад хамрагдсан хүн	тоо	2022	4152	4500	“Элэг бүтэн Монгол” арга хэмжээг 4 зорилтын хүрээнд 18 заалтыг төлөвлөж, арга хэмжээг эрчимжүүлснээр хэрэгилт 80,0%-тай байна. Арга хэмжээний хүрээнд ЭМЯ-ны 18,7 сая төгрөгийн санхүүжилтээр В,С вирус илрүүлэх 8800 оношлуурыг татан авч, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилж, эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулав. В,С вирусийн илрүүлэг шинжилгээнд эхний 9 сарын байдлаар 10381 хүн хамрагдаж, үүнээс С вирусийн архаг халдвартай 48, В вирусийн халдвартай 84 хүнийг тус тус илрүүлж,	100%

								эмчилгээ хяналтад авчээ. Молекул биологийн лабораторид хэрэглэх 48 сая төгрөгийн В,С,D вирусийн ачаалал тоолох 576 оношлуур, дагалдах хэрэгслийг татан авч, АНЭ-ийн лабораториор ачаалал тоолох шинжилгээнд 217 хүнийг хамруулснаар вирусийн идэвхижилтэй 50 хүнийг эрт илрүүлж, эмчилгээнд хамруулаад байна. Тархвар судлалын заалтаар элэгний В вирустэй эхээс төрсөн 5 нярайд В гепатитын иммуноглобулин эмчилгээг хийж, халдвараас сэргийлсэн. ЭМЯ-ны 3.3 сая төгрөгийн санхүүжилтээр Халдварт өвчин судлалын үндэсний төвтэй хамтран 19 байгууллагын 40 эмч лаборант нарт танхимын сургалт хийж, чадавхжуулав. Тайлант хугацаанд ЭМБ-ууд иргэдэд 25 удаагийн сургалт зохион байгуулж, 1165 хүнийг хамруулан 60 төрлийн 834 ширхэг зөвлөмж тарааж, цахимд 78 удаагийн мэдээлэл байршуулснаар 4101 хандалт авсан.	
48		Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах	Сургалт, сурталчилгааны арга хэмжээ	тоо	2022	15	20	Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан “Эмийн зохистой хэрэглээг хамтдаа төлөвшүүлье” уриан дор ЭМБ-уудын дунд 7 хоногийн аянг 09 сарын 16-27 өдрүүдэд зохион байгуулав. Аяны хүрээнд эмийн зохистой хэрэглээ, шинэ эмийн мэдээллийн талаар цахим, танхимын 2 сургалтыг нийт 100 эм найруулагч, эм зүйч, эмч мэргэжилтнүүдэд, дотоодын сургалтыг 51 эмийн сан, 4 ЭХНБ, төрийн 20 эрүүл мэндийн байгууллагын 406 эмч мэргэжилтнүүдэд тус тус зохион байгуулж, мэдлэгийг дээшлүүлсэн. “Эмийн зохистой хэрэглээг хамтдаа төлөвшүүлье” уриан дор “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг 16 эмийн сан, 9 эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгүүдтэй хамтран зохион байгуулж, иргэдэд эмийн зохистой хэрэглээний сургалт сурталчилгаа, эрүүл мэндийн үзлэг, хөнгөлөлттэй жор бичих, түргэвчилсэн оношлуураар сахар, холестерол үзэх зэрэг эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж, эмийн зохистой хэрэглээний талаар иргэдэд мэдээлэл өгч, нийт 787 хүнийг хамруулж, зохистой хэрэглээний талаарх мэдлэгийг дээшлүүлсэн. Мөн эмийн зохистой хэрэглээг	100%

									төлөвшүүлэх мэдээлэл, сургалтыг 16 албан байгууллагуудад хийж, 606 иргэдийг хамруулснаар эмийн тухай ойлголт мэдээлэл сайжирсан.	
49			Явуулын үзлэг зохион байгуулах	Үзлэгт хамрагдсан хүн	тоо	2022	27.5	30	Аймгийн Засаг даргын 2024 оны “Явуулын үзлэг зохион байгуулах тухай” А/394 дугаар захирамжаар 11.7 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлж, Явуулын амбулаторийн үзлэгийг АНЭ, ЗҮНЭ-ийн Дотор, Хүүхэд, Мэдрэл, ЭХО, ЧХХ, Эмэгтэйчүүд, Шүд, УАУ-ны эмч нарын бүрэлдэхүүнтэй багийг 12 сумдад ажиллуулсан. Явуулын тусламж үйлчилгээгээр нийт 6105 хүн, давхардсан тоогоор 11280 хүн үзүүлсэн нь үзлэгт хамрагдсан хүний тоо өмнөх оноос 3836-р нэмэгдсэн. Үзлэгээс шинээр 182 өвчлөл илрүүлж, лавлагаа шатлалд 70 хүнийг илгээж, 1048 хүнд эмчилгээ зааж сумын эмчийн хяналтад байна. ЭМС-ын 2024 оны А/150 дугаар тушаалаар Улсын Нэгдүгээр төв эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын бүрэлдэхүүнтэй нүүдлийн эмнэлэг 2024 оны 05 сард бүх сумдад 15 хоногийн турш ажиллаж, 13 сумын 1017 иргэдийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээнд хамруулснаас хавдрын сэжигтэй 6 тохиолдлыг эрт илрүүлж, дээд шатлалын эмнэлэг рүү илгээх зэргээр асуудлыг шийдвэрлэсэн нь хөдөөгийн хүн амын 49,1% нь орон нутагтаа төрөлжсөн төв эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлсэн үр дүнтэй арга хэмжээ болсон.	100%
50			"Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх" арга хэмжээг зохион байгуулах	Өвчлөлийн бууралт	промиль	2023	10	15	"Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх" арга хэмжээг 7 зорилт 38 заалтын хүрээнд хэрэгжүүлж, үүнээс 101 удаагийн сургалт, сурталчилгаагаар 3489 хүнийг хамруулж, цахимд 236 төрлийн мэдээлэл түгээснээр 16429 хандалтыг авчээ. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, болзошгүй цартахлын үед хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах зорилгоор ХӨСҮТ, ДЭМБ-ийн 24,3 сая төгрөгийн дэмжлэгтэйгээр бүсийн сургалтыг ширээний дасгал сургуулилттайгаар зохион байгуулж, 9 аймгийн 45 мэргэжилтэнг чадавхжуулах салбар хоорондын	100%

									хамтын ажиллагаа сайжирсан. Сүрьеэгийн эрт илрүүлэг, идэвхтэй тандалтыг халдварт ба халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгтэй хамтатган хийж, 416 хүнийг хамруулснаас шинэ сүрьеэ бүртгэгдээгүй байна. Сүрьеэгийн сорьц тээвэрлэлтийг эрчимжүүлж 13 сумдаас 124 цэрний сорьцыг тээвэрлэснээс 2 шинэ сүрьеэг илрүүлж, эмчилгээ хяналтад авсан. Тайлант онд БЗДХ-ын кабинетаар нийт 3797 хүн үйлчлүүлснээс 2825 хүн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдан, 229 өвчлөлийг илрүүлж, үүнээс БЗДХ-тай 21 жирэмсэн эмэгтэйг эрт илрүүлсэнг 100% эрүүлжүүлж, төрөлхийн тэмбүү бүртгэгдээгүй байна. 2024 оны 3-р улирлын байдлаар 10000 хүн амд ногдох БЗДХ 32.0 болж, өмнөх оны мөн үеэс 1.1-ээр буурч, 10000 хүн амд ногдох сүрьеэ 4,5 болж, өмнөх оны мөн үеэс 2,6 промилоор буурсан үр дүнтэй байна. Нийт халдварт өвчлөлийн 805 тохиолдол бүртгэгдсэн нь 10000 хүн амд 99.0 болж өмнөх оноос 83.2-оор буурч, арга хэмжээ 96%-тай хэрэгжсэн.	
51			“Хавдрын эсрэг” арга хэмжээг зохион байгуулах	Үзлэгт хамрагдсан хүн	тоо	2022	1100	1500	“Хавдрын эсрэг” арга хэмжээг 5 зорилтын хүрээнд 33 заалтыг төлөвлөж, хэрэгжилт 3-р улирлын байдлаар 95.1%-тай байна. “Хавдрын эсрэг анхаарал хандуулах дэлхийн өдөр” уриатай 14 хоногийн аяныг нийт ЭМБ-ууд зохион байгуулж, аяны хүрээнд ХСҮТ-ийн сэтгэл зүйчтэй хамтран “Үйлчлүүлэгчийн сэтгэл зүй” сэдвээр ЭМ-ийн 20 байгууллагын 34 эмч, мэргэжилтнүүдийг 6 удаагийн цахим сургалтад хамруулж, цаашид сургалтыг лавлагаа шатлалын хавдрын эмч, мэргэжилтнүүдэд зохион байгуулж чадавхжуулсан. Хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт жил бүр орохын ач холбогдол чиглэлээр ЭМБ-ууд нийт 120 удаагийн сургалт сурталчилгаанд 3394 хүнийг хамруулж 20 төрлийн 1173 гарын авлага тарааж, 72 төрлийн мэдээллийг цахимаар түгээснээр 12625 хандалт авч, өмнөх оноос сургалтад хамрагдсан хүний тоо 126-р нэмэгдэж, иргэдийн мэдлэг, хандлага нэмэгдсэн. ЭМС-ын 2024 оны А/150 дугаар тушаалын хүрээнд УНТЭ-ийн эмчээр удирдуулсан	100%

								13 хүний бүрэлдэхүүнтэй баг Дорноговь аймагт 15 хоног ажиллаж, 13 сумын 1017 хүнийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулан хавдрын сэжигтэй 6 тохиолдлыг эрт илрүүлэн дээд шатлалын эмнэлэг рүү илгээж, асуудлыг шуурхай шийдвэрлэсэн. Дээрх арга хэмжээний үр дүнд хавдрын 3 төрлийн эрт илрүүлэг үзлэгт нийт 23980 хүн хамрагдаж, дундаж хамралт 47.9%-д хүрсэн нь өмнөх оноос 6432 хүнээр, үзлэгийн хувь 10.7%-иар тус тус өсөж, шинээр умайн хүзүүний хорт хавдар 2-ыг эрт үед нь илрүүлж дараагийн шатлалд илгээсэн байна. Тайлант онд шинээр 133 хавдар илэрч, 91 нас баралт бүртгэгдэж, үүнээс 33.9% нь эрт үедээ оношлогдож, хавдрын эмчийн хяналтад 555 хүн байгаагаас 40.0% нь 5-аас дээш жил амьдарч байгаа нь хавдар эрт шатандаа оношлогдсоноор амьдрах чадвар тодорхой хэмжээгээр уртасч байгаа үр дүн гарч байна. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Хавдрын тасгийг 2 их эмчтэй, 10 ортойгоор өргөжүүлж, полихими эмчилгээг нэвтрүүлэн, 10 сарын байдлаар хөнгөвчлөх эмчилгээнд-133, хими эмчилгээнд 46 хүнийг хамруулж, тусламж үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй үзүүлж, УБ хот явах урсгалыг бууруулж байна.	
52		“Эрүүл шүд” арга хэмжээг зохион байгуулах	Шүдний өвчлөл эрүүлжсэн хүн	тоо	2022	80.7	82	"Эрүүл шүд" арга хэмжээний 2024-2027 оны 4 жилийн төлөвлөгөөг батлуулж, ЭМБ-уудад хүргүүлэн, хэрэгжилтэд мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж байна. Төр хувийн хэвшлийн нийт 12 шүдний кабинетаар 11666 хүүхэд үйлчлүүлснээс 9686 өвчлөл илрүүлж, 8632 (89.1%)-ийг эрүүлжүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 0.2%-р өссөн байна. Арга хэмжээний хүрээнд бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд “Амны хөндийн эрүүл ахуйн зөв мэдлэг дадал төлөвшүүлэх” 32 удаагийн сургалт, сурталчилгаанд 1761 хүүхэд, эцэг эхчүүдийг хамруулан, 8 төрлийн 234 зөвлөмж, гарын авлагыг тарааж, эрүүл мэндийн боловсрол олгов. Сайншанд сумын ерөнхий боловсролын 3 сургуульд урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж, 2544 хүүхэд	100%

									хамрагдахаас 2284 буюу 89.8%-ийг хамруулан 1639 өвчлөлийг илрүүлж, 20.7% эрүүлжүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 19.5%-аар өсчээ. БШУГ-тай хамтран сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудыг анги бүрд "Шүд угаах цаг"-тай болгох ажлыг туршилтаар Сайншанд сумын 6-р сургууль, Улаанбадрах, Даланжаргалан, Хөвсгөл сумы зэрэг нийт 4 сургуулийн бага ангийн хүүхдүүдэд хэрэгжүүлж, 855 хүүхдийг хамруулж эхлээд байна. Хүүхдийн шүдний өвчлөлийн тархалтыг бууруулах зорилгоор "Эрүүл шүдтэй хүүхдийн байгууллага, анги хамт олон" шалгаруулах болзолт уралдааныг идэвхжүүлснээр ЕБСургууль, цэцэрлэгийн 13 байгууллага, 66 анги хамт олон төлөвлөгөөгөө ирүүлсэн нь хүүхдийн байгууллагын тоо 1-ээр, анги хамт олны тоо 18-аар тус тус нэмэгдэж, амны хөндийн эрүүл мэндийг сайжруулах үйл ажиллагаа идэвхэжсэн.	
53			Хүн амын урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийг эрчимжүүлэх	Үзлэгт хамрагдсан иргэд	хувь	2023	15	70	МУЗГ-ын санаачилгаар 2022 оны 05 сараас эхэлсэн "Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг оношилгоо"-нд аймгийн хэмжээнд 2024 оны 10 сарын байдлаар 5310 хүн, өссөн дүнгээр 34425 иргэн хамрагдсан нь хамрагдвал зохих хүн амын 48.0%-ийг эзэлж байна. Үзлэгт 63.7% (21913)-ийг 0-17 насны хүүхэд, 36.3% (12512)-ийг 18-аас дээш насны хүн ам байгаа нь үзлэгийн дүнгээр улсын хэмжээнд 5-р байрт, улсын дүнгээс 3.3%-иар, аймгуудын дүнгээс 5.8%-р тус тус өндөр хамралттай, 0-17 насны хүүхдийн үзлэгийн хувиар улсад 1 дүгээрт эрэмбэлэгдэж байна. Үзлэгт хамрагдсан нийт 34394 хүний 45.0% нь эрэгтэй, 55.0% нь эмэгтэйчүүд эзэлж, тайлант онд хавдрын 7 тохиолдлыг илрүүлж, дээд шатлалд илгээн эмчилгээний асуудлыг шийдсэн. Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг, үзлэг шинжилгээг сум, өрхийн 17 эрүүл мэндийн төв, 2 нэгдсэн эмнэлэг нийт 19 эмнэлгүүд зохион байгуулж, үзлэгээр 631 өвчлөлийг шинээр илрүүлсний 425 нь хүүхдийн өвчлөл байна. Хүүхдийн өвчлөлийн 87.3% шүдний өвчлөл бүртгэгдсэний 283 хүүхдийг	100%

									эмчилгээнд хамруулж, эрүүлжүүллээ. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийг эрчимжүүлэх зорилгоор 2024 онд 2 удаагийн аяныг зохион байгуулснаар 1121 хүнийг үзлэгт хамруулав. ЭМС-ын 2024 оны А/150 дугаар тушаалаар Улсын Нэгдүгээр төв эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын бүрэлдэхүүнтэй нүүдлийн эмнэлэг 2024 оны 05 сард бүх сумдад 15 хоногийн турш ажиллаж, 13 сумын 1017 иргэдийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээнд хамруулснаас хавдрын сэжигтэй 6 тохиолдлыг эрт илрүүлж, дээд шатлалын эмнэлэг рүү илгээх зэргээр асуудлыг шийдвэрлэсэн нь хөдөөгийн хүн амын 49,1% нь орон нутагтаа төрөлжсөн төв эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлсэн үр дүнтэй арга хэмжээ болсон.	
54			Товлолт дархлаажуулалтын үйл ажиллагааг зохион байгуулах	Хамрагдсан хүн	тоо	2022	94.3	96.2	Үндэсний товллын дархлаажуулалтад “Хүний папилома вирусийн халдварын эсрэг вакцин” нэмэгдэж орсонтой холбогдуулж, ЭМБ-уудын бэлтгэл ажлыг хангуулахаар 8 байгууллагад дэмжлэгт хяналт хийж, зөвлөмжийн хэрэгжилт 85%-тай байна. “Хүний папилома вирусийн эсрэг вакцин”-ийг товллод нэвтрүүлэх танилцуулга сургалтыг орон нутагт зохион байгуулж, 19 эрүүл мэндийн байгууллагын дарга, вакцинолог 38 хүнийг хамруулж, арга зүйгээр хангасан. ЭМБ-ууд дархлаажуулалтын ач холбогдол, товллын, сайн дурын дархлаажуулалтын талаар зөвлөгөө мэдээллийг танхим болон цахимаар 1249 хүнд өгч, цахимд 59 төрлийн мэдээлэл байршуулсан нь 2347 хүний хандалт авчээ. Товллын дархлаажуулалтын 1 насны бүрэн тунгийн хамралт 88.6%, 2 насны бүрэн тунгийн хамралт 88.2% байна. В вирусийн эсрэг сайн дурын дархлаажуулалтад шинээр 567 хүн, бүрэн тунд /3 тун/ 183 хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 386 хүн буюу 1 дахин нэмэгдэж, халдварт өвчлөл бүртгэгдээгүй байна.	100%
55			Улирлын томуугийн эсрэг	Дархлаажуулалтад хамрагдсан хүн	тоо	2022	500	600	Эрүүл мэндийн сайдын 2024 оны "Улирлын томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулах тухай" А/359 дүгээр тушаалын дагуу ХӨСҮТ-өөс хуваарилагдсан томуугийн эсрэг "GCFLU" 4320 хүн	90%

			дархлаажуулалт хийх						тун вакцин, дагалдах хэрэгслийг хамт татан авч, Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны А/104 дугаар тушаалаар 19 эрүүл мэндийн байгууллагад хуваарилсан. Улирлын томуугийн эсрэг вакцинаар 6 сартайгаас 5 настай, 65-аас дээш насны, архаг хууч өвчтэй, жирэмсэн, эрүүл мэндийн салбарын ажилтан нийт 3502 хүнийг дархлаажуулж, хамралт 81.1%-тай байна. Томуу, томуу төст өвчний халдварын дэгдэлт, бага насны хүүхдийн томуугийн халдвар, уушгины хатгалгаанаас сэргийлэх зорилгоор жил бүр 0-12 насны хүүхдүүдийн дунд томуугийн эсрэг дархлаажуулалтыг уламжлал болгон хийснээр томуугийн шалтгаанаар эндэх, хүндрэх тохиолдлын тоо 25,6%-иар буурч, уушгины хатгалгаар эндсэн тохиолдлын тоо 36,1%-иар буурсан үр дүнтэй байна.	
56		Эмнэлгийн тусламж үйлчилгээ хөтөлбөр	Хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх	Эрүүл мэндийн байгууллага	тоо	2022	101	110	Аймгийн хэмжээнд төрийн эмнэлэг 20, хувийн эмнэлэг 32, ЭХНБ 4, эмийн сан 52, лаборатори 1, сувилал 1, цэргийн эмнэлэг 3, АШМУХ 4, нийтдээ 116 байгууллага эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг орон нутгийн хүн амд үзүүлж байна. 2023-2024 онд 7 эмнэлэг, 8 эмийн санд шинээр тусгай зөвшөөрөл олгож, эрүүл мэндийн байгууллагын тоог 12.9%-иар нэмэгдүүлсэн. Төмөр замын хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээг ойртуулах, нэгдсэн эмнэлгийн төв хэсгийн төвлөрлийг бууруулах зорилгоор 2024 онд “Нэгдсэн эмнэлгийн салбар амбулатори-2” – ийг Сайншанд сумын төмөр замын хэсэгт нээж, ачаалал ихтэй шүд, мэдрэл, хүүхдийн кабинетуудыг ажиллуулахаас гадна “Дэээрэт” ОУ-ын Энэргийн байгууллагын 136 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгтэйгээр “Эрэгтэйчүүдийн кабинет”-ийг шинээр нээн, тусламж үйлчилгээг цаг алдалгүй орон нутагтаа авах боломжийг бүрдүүлсэн нь иргэдийн хүлээгдэл чирэгдлийг 16,9%-иар буурчээ. Орон нутгийн төсвийн 1,9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2023 онд Ханги хилийн боомтод эмнэлгийн 5 ортой барилга шинээр барьж, 2024 оноос үйл ажиллагааг эхлүүлснээр хилийн боомтын албан хаагч, аж ахуй нэгжийн ажилчид, бүс нутгийн	100%

									малчин иргэд, хөдөлгөөнт хүн ам зэрэг нийт 1000 гаруй хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээг шуурхай үзүүлэх боломж бүрдсэн Тайлант онд ЗҮНЭ-т ОНХС-ийн 250,0 сая төгрөгөөр “Цусны төв”, улсын төсвийн 500,0 сая төгрөгөөр “Эмгэг судлалын төв”-ийг байгуулж, АНЭ-ийн хавдрын тасагт моно, полихими эмчилгээ, хэвлийн диализ эмчилгээг нэвтрүүлж, нэгдсэн эмнэлгүүдэд молекул биологийн лаборатори байгуулснаар лавлагаа шатлалын тусламжийн чанарт ахиц гарсан. Мөн анхан шатлалд 100% мобайл технологи нэвтэрч, 76,9% нь цус, шээс, биохимийн анализаторын аппараттай болж анхан шатлалын оношилгооны чадавх сайжирснаар хөдөөгийн иргэд орон нутагтаа шинжилгээ, оношилгоонд орж, дээд шатлал руу урсах урсгал буурлаа. Хувийн хэвшлийн клиник эмнэлгүүдийн тоо 12,9%-иар нэмэгдэж, орон нутагт хийгддэггүй оношилгоо, шинжилгээ эмчилгээг хийдэг болсноор иргэдийн УБ хотруу явах чирэгдэл буурч байна.	
57			Аймгийн Нэгдсэн эмнэлгүүдийн үйл ажиллагааг хэвийн явуулах боломжоор хангах	Зарцуулсан зардал	хэмжээ	2023	0	2,255.70	Аймгийн хэмжээний лавлагаа шатлалын 3 эмнэлэг(аймгийн ба Замын-Үүд нэгдсэн эмнэлэг, Уламжлалт анагаах ухаан рашаан сувиллын төв) - ийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангах зорилгоор Монгол Улсын засаг захиргааны нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.18 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.1.16 дахь заалтуудын дагуу 2024 онд тогтмол зардлыг орон нутгаас хариуцахаар 2323.7 сая төгрөгийн төсвийг батлуулснаас сарын хуваарийн дагуу эхний 10 сард 16,9 тэрбум төгрөгийг зарцуулжээ. Тайлант онд АНЭ-ийн гадна фасадын засварт орон нутгийн төсвөөс 3,3 тэрбум, ЗҮНЭ-т “Эмгэг судлалын эмнэлэг”-ийн шинэ барилгын ажлын 300,0 сая, тоног төхөөрөмжид 488,6 сая төгрөг, Цусны салбар төвд шаардлагатай 17 нэр төрлийн тоног төхөөрөмж худалдан авахад 218,0 сая төгрөг, Нэгдсэн эмнэлгүүдийн автомашины парк шинэчлэлтэд улсын төсвийн 538,9 сая төгрөгийн бүрэн тоноглогдсон MAN TGE-3.180 маркийн	100%

									автомашиныг нийлүүлж, 110,4 сая төгрөгийн 6 төрлийн тоног төхөөрөмж зэргийг тус тус нийлүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлснээр тоног төхөөрөмжийн хангалт хувь болж, өмнөх оноос хувир нэмэгдэж, оношилгооны чадавх сайжирсан. Үүний дүнд лавлагаа шатны 2024 оны эхний 10 сарын байдлаар 218954 хүнд амбулаторийн, 10651 хүнд хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээг тус тус үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс үйлчилгээний нэр төрөл нэмэгдэж, тусламжийн чанарт ахиц гарсан. ЭМГ-ын ажлын хэсэгт тайлант онд Нэгдсэн эмнэлгүүдийн үйл ажиллагаанд нийт 4 удаагийн дэмжлэгт хяналт хийж, арга зүйн заавар чиглэл өгч, гарч буй алдаа дутагдлыг тасаг нэгжийн дарга, удирдлагын багт танилцуулж, цаашид үйл ажиллагааг чадавхжуулах чиглэл, үүрэг даалгавар өгч, зөвлөмжийн биелэлт 86,1%-тай байна.	
58			Нарийн мэргэжлийн эмчийн тоог нэмэгдүүлэх чиглэлээр багц арга хэмжээ хэрэгжүүлэх	Зохион байгуулсан арга хэмжээ	тоо	2022	1	3	Аймгийн болон Замын-Үүд Нэгдсэн эмнэлгүүдийн тусламж үйлчилгээний нэр төрөл, нарийн мэргэжлийн эмч нарын тоо, төрөлжсөн мэргэжлийн тусламжийг нэмэгдүүлэх зорилгоор эмч мэргэжилтнүүдийг төгсөлтийн дараах мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтуудад үе шаттайгаар тасралтгүй хамруулж байна. Үүнд: эх барих эмэгтэйчүүд, хүүхэд, нярайн эмч, сэтгэц, эмнэл зүйн эмгэг судлал, дотор судлал, гэмтэл судлал, уламжлалт анагаах ухааны их эмч, мэрдэлийн эмч-2, дүрс оношилгооны эмч-2, Уламжлалт анагаан ухаан рашаан сувиллын төвд зүү судлалын эмч зэрэг нийт 13 нарийн мэргэжлийн эмчийг 2022-2024 онуудад гэрээ байгуулан сургаж, ажлын байраар ханган, эмч мэргэжилтнүүдээ чадавхжуулаад байна. Мөн анхан шатлалд эх барих, хүүхэд, дотор, дүрс оношилгооны чиглэлээр 6 эмч мэргэжилтэнг гэрээ байгуулан сургаж байна. Үүний үр дүнд анхан шатлалд нарийн мэргэжлийн эмч нарын тоо нэмэгдсэнээр хөдөөгөөс аймгийн төврүү ирэх урсгал буурах юм. Эрүүл мэндийн байгууллагуудын эмч, мэргэжилтнүүдийн мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтад 22, танхим болон цахим 1770, дотоод	100%

									сургалтад 1127 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулж мэдлэг чадварыг дээшлүүлснээр нарийн мэргэжилтний эзлэх хувийг анхан шатлалд-44,0%, лавлагаа шатлалд-86,5% болгосон.	
59			Дорноговь аймгийн эрүүл мэндийн салбарын Хүний нөөцийн сургалт хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Төлөвлөг өөний хэрэгжилт	хувь	2022	55	100	Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийн нэгдсэн төлөвлөгөөг 4 бүлэг 11 заалтын хүрээнд 95.2%-тай хэрэгжүүлсэн. Үүнд: тайлант онд эрүүл мэндийн байгууллагуудын эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулж, мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтад 22, танхимын болон цахим сургалтад давхардсан тоогоор 1770, ЭМБ-ын дотоодын сургалтад давхардсан тоогоор 1127 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулж мэдлэг чадварыг дээшлүүлсэн. Хөрш зэргэлдээ, өндөр хөгжилтэй гадаадын улс оронд 2024 онд нийт 24 эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг мэргэжлийн чиглэлээр суралцуулж, дадлага туршлага эзэмшүүлэх сургалтад хамруулсан нь өмнөх оноос 14 хүнээр нэмэгджээ. ЭМБ-уудын хүний нөөцийн хангалт анхан шатанд-90,2%, лавлагаа шатлалд-89,6%, салбарын хэмжээнд дунджаар-89,9%-тай болж өмнөх оноос 3,3%-аар өссөн байна.	90%
60			Аймгийн Нэгдсэн эмнэлэгт эмэгтэйчүүдийн хавдрын оношилгооний орчин үеийн тоног төхөөрөмж нэвтрүүлэх	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн төрөх тасгийн 2 эмчийг “Эмэгтэйчүүдийн хавдар судлал”-аар мэргэшүүлж, тоног төхөөрөмжийн хангалтыг 80%-тай болгосноор тусламж үйлчилгээний чадамжийг нэмэгдүүлэхэд анхааран ажиллаж байна. Хиймэл оюун ухаанд суурилсан умайн хүзүүний хавдрын оношилгооны системийг нэвтрүүлэхээр Эй Ай Меди Монголиа ХХК-ыг урьж, "Cervicare AI" систем танилцуулах сургалтыг аймгийн Нэгдсэн эмнэлгийн “Төрөх, эмэгтэйчүүд, эмгэг нярайн тасаг” - ийн эмч нарт хийж, "Cervicare AI" аппаратаар 21 хүнийг оношилгоонд хамруулах замаар ажлын байрны сургалтад хамруулав. Төсөв хөрөнгө, санхүүжилтийн асуудал шийдэгдээгүйгээс уг аппаратыг авч чадаагүй, донор байгууллагуудад төслийг хүргүүлээд байна. Харин аймгийн хэмжээнд Эх барих эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээг явуулдаг хувийн 2 эмнэлэг уг "Cervicare AI"	100%

									аппаратыг авч, сургалтад хамрагдаж, албан ёсны гэрчилгээг авсанаар орон нутгийн эмэгтэйчүүдэд умайн хүзүүний хавдрын оношилгоог 380 эмэгтэйд хийж, 29 өөрчлөлт илэрсэнг хавдрын эмчрүү илгээж, эмчилгээнд хамруулжээ. Аймгийн хэмжээнд 2024 оны 10 сарын байдлаар нийт умайн хүзүүний эрт илрүүлэгт 1355 (27.1%), хөхний хавдар илрүүлэгт 11198 (64.1%) эмэгтэйчүүд хамрагдсанаас эсийн шинжилгээний өөрчлөлт 17 гарч, үүнээс орон нутагт 13 эмэгтэйг эмчилж, лавлагаа шатлалд 4 эмэгтэйг илгээж, эмчилгээ хяналтад авсан.	
61			АШУУИС-ийн Дорноговь аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн цогцолбор барих	Барилгын гүйцэтгэл	хувь	2022	0	100	Энэ оны улсын төсөвт Дорноговь аймгийн Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургуулийн цогцолборын барилга шинээр барих ажилд 25,101.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт батлагдсан. Зураг төслийг "ТГТ" ХХК боловсруулсан бөгөөд Монгол Улсын Боловсролын сайдын 2024 А/02 дугаартай эрх шилжүүлэх тушаалын дагуу тус ажил орон нутаг эрх шилжиж ирсэн аймгийн Худалдан авах ажиллагааны газраас гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах нээлттэй тендерийг 08 дугаар сард зарлахад оролцогч хүсэлт ирүүлээгүй тул тендер шалгаруулалтыг ахин 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр зарласан тус тендерт "Солармед монгол" ХХК болон "Эн ар" ХХК оролцох хүсэлт ирүүлсэн боловч тендерт ирүүлсэн баримт бичиг шаардлага хангаагүй тул шалгаруулалт амжилтгүй болсон.	30%
62			Зарим эмнэлгүүдэд автомашины парк шинэчлэлийг хийх	Шинэчлэл хийсэн машин	тоо	2022	2	2	ЭМС-ын 2024 оны А/104, А/264 тоот тушаалаар Дэлгэрэх сумын эрүүл мэндийн төвд улсын төсвийн 160,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар яаралтай тусламжийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон туулах чадвар сайтай Land-78, аймгийн болон Замын-Үүд Нэгдсэн эмнэлгүүдэд 538,9 сая төгрөгийн бүрэн тоноглогдсон MAN TGE-3.180 маркийн автомашиныг тус бүр нийлүүлснээр түргэн тусламжийн шуурхай бэлэн байдлыг нэмэгдүүлсэн.	100%
63			Аймгийн Нэгдсэн эмнэлгийн	Засварын ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн гадна фасад засварлах ажлыг орон нутгийн төсвийн 3,3 тэрбум төгрөгийн өртөгөөр "Энержи парагон" ХХК гүйцэтгэж	70%

			барилгад их засвар хийх						байна. Барилгын гадна фасадны металл рам угсрах, шилэн хөвөн дулаалга, цонх шинэчилж засварлах ажил хийгдэж, явц 60 хувьтай.	
64			Айраг, Мандах сумын Эрүүл мэндийн төвүүдийн барилгад засвар хийх	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Айраг сумын ЭМТ-ийн 1-р байрны засвар хийх ажлыг 339.7 сая төгрөгийн өртөгөөр "Мунара констракшн" ХХК, Мандах сумын Эрүүл мэндийн төвийн гадна фасадны засварын ажлыг 255.1 сая төгрөгийн өртөгөөр "Эргэл хийц" ХХК тус тус гүйцэтгэж ашиглалтад оруулсан.	100%
65			Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн барилгын гадна дулааны ажил хийх	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Тус эмнэлгийн барилгын гадна шугам сүлжээ, цахилгаан хангамж, холбоо дохиоллын ажлыг орон нутгийн төсвийн 496.0 сая төгрөгийн өртөгөөр "Жи Би Ти Эм Би констракшн" ХХК гүйцэтгэж байна. Гадна дулаан, цэвэр усны шугамын өргөтгөл шинэчлэлтийн ажил хийгдэж байна. Ажлын явц 50%-тай.	50%
66			Хатанбулаг сумын Эрүүл мэндийн төвийн барилгад өргөтгөлийн ажил хийх	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Орон нутгийн төсвийн 1,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хатанбулаг сумын эрүүл мэндийн төвийн "Халдвартын тасаг"-ийн өргөтгөлийн ажлын тендерт "Энержи парагон" ХХК шалгарч, ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. Ажлын гүйцэтгэл 100 хувь.	100%
67			Өргөн сумын ЭМТ-ийн барилгыг шинээр барих	Барилгын шинэчлэл	хувь	2022	0	100	ОНТ-ийн 860,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт батлагдаж Өргөн суманд Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга барих ажлын зураг төсвийг Сант номун ХХК боловсруулсан. Аймгийн худалдан авах ажиллагааны газраас гүйцэтгэгчийн сонгон шалгаруулахаар нээлттэй тендер шалгаруулалтыг 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр зарлахад оролцогч хүсэлт ирүүлээгүй тул хүчингүй болгож, хөрөнгө оруулалтыг 2025 оны төсөвт суулгасан.	30%
68			Замын-Үүдийн Нэгдсэн эмнэлэгт тоног төхөөрөмж худалдан авах	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Улсын төсвийн 499.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Замын-Үүд Нэгдсэн эмнэлэгт "Эмгэг судлалын тоног төхөөрөмж" худалдан авах тендерийг зарлаж, "Сетунари" ХХК ажил гүйцэтгэгчээр шалгарч гэрээ байгуулж, тоног төхөөрөмж хүлээлгэн өгсөн. Ажлын гүйцэтгэл 100%	100%

69			Зарим сумдын ЭМТ-ийг зайлшгүй шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах	Нэмэгдсэн тоног төхөөрөмж	тоо	2022	80	85	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сумын эрүүл мэндийн төвүүд тайлант онд тусламж үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай 124,5 сая төгрөгийн 24 нэр төрлийн 75 ширхэг тоног төхөөрөмж, орон нутгийн хөрөнгө оруулалт, хандив тусламжаар нийт 69.3 сая төгрөгийн авсанаар тоног төхөөрөмжийн хангалт 85.1%-д хүрч, өмнөх оноос 0.9%-иар нэмэгдсэн. МЭХ-оос санаачилсан “ХАВДАРГҮЙ МОНГОЛ ЭМЭГТЭЙ” нийгмийн зорилтод төслийн хүрээнд БНХАУ-ын Бүх Хятадын Эмэгтэйчүүдийн холбооноос сүүлийн үеийн олон үйлдэлт эмэгтэйчүүдийн төрөх ор-9, үзлэгийн ор 3-ыг сумын эрүүл мэндийн төвүүдэд өгсөнөөр эх, нярайг эсэн мэнд амаржих ээлтэй, ая тухтай орчинг бүрдүүлсэн.	100%
70		Эмнэлгийн тусламж үйлчилгээ хөтөлбөр	Аймгийн Нэгдсэн эмнэлэгт суурин Рентген аппарат худалдан авах	Худалдан авсан суурин рентген аппарат	тоо	2022	1	2	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн “Суурин рентген аппарат” нь 2012 онд ашиглалт орсноос хойш тасралтгүй 11 жил ажиллаж, 2023 онд ашиглах боломжгүй болсон. Орон нутгийн төсвийн 84.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2023 онд зөөврийн рентген аппарат авснаар тусламж үйлчилгээг тасалдуулахгүй байх зохицуулалт хийгдэж байгаа ба шинээр рентген суурин аппарат авах төслийн саналыг донор байгууллагууд, Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн.	30%
71			"Эрүүл шүд" хөтөлбөрийн хүрээнд Шүдний кабинетын тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх	Худалдан авсан шүдний дэлгэмэл рентген аппарат	тоо	2022	0	1	Замын-Үүдийн Нэгдсэн эмнэлгийн шүдний кабинетад улсын төсвийн 12,9 сая төгрөгөөр, аймгийн Нэгдсэн эмнэлэгт 21,3 сая төгрөгөөр шүдний эмчилгээний иж бүрдэл авч, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийгдсэн. Мөн аймгийн Нэгдсэн эмнэлэгт Улсын төсвийн 35.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар шүдний иж бүрэн тоног төхөөрөмж худалдан авах эрх шилжин ирснээр худалдан авах ажиллагааг зохион байгуулах шатандаа явж байна. Шүдний дэлгэмэл рентген аппаратын засвар, шинэчлэлийн төслийг ЭМЯ-д хүргүүлсэн. Айраг, Зүүнбаян, Хатанбулаг, Мандах сумын эрүүл мэндийн төвүүд шинээр шүдний кабинеттай болж, иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангагдсан. Гэвч орон нутагт ажиллах хүний нөөцийн	90%

									дутагдалтайгаас хувийн хэвшлийн 3 шүдний эмнэлэгтэй гэрээ байгуулж, “Явуулын шүдний эмчийн үзлэг”-ийг тус кабинетуудад зохион байгуулж, нийт 254 хүнд үзлэг хийж, 296 шүдний өвчлөл илрүүлснээс 87.7%-г эрүүлжүүлсэн.	
72			Аймгийн Нэгдсэн эмнэлэгт Комьпютер томографийн аппарат худалдан авах	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Улсын төсвийн 1,4 тэрбум төгрөг, орон нутгийн төсвийн 350.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн Нэгдсэн эмнэлэгт Компьютер томографын аппарат худалдан авах тендерт 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр Сетунари ХХК шалгарч, гэрээ байгуулах эрх олгосон.	30%
73			Цахим жорын программыг өргөжүүлж, эрүүл мэндийн даатгалын сангийн үнийн хөнгөлөлттэй эмийн хүртээмжийг нэмэгдүүлэх	–	тоо	2022	86	100	Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2022 оны 11-р тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн сангийн тоог 39 болгож өмнөх оноос 3-аар нэмэгдүүлсэн. Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх 151 ерөнхий нэршлийн, 651 эмийн жагсаалтын дагуу www.Health.gov.mn прораграммаар төрийн өмчийн 19 эрүүл мэндийн байгууллагын 218 эмч хөнгөлөлттэй эм бичих эрхийн дагуу 41731 иргэнд цахим жор бичиж, эрх бүхий 39 эмийн сан 1,4 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй эмээр үйлчилсэн. Тайлант хугацаанд тусламж үйлчилгээ авсан хүний тоо 8362 иргэнээр, санхүүжилт 500.4 сая төгрөг буюу 64.8%-иар тус тус нэмэгдсэн. Мөн 2024 онд 12 эмчид цахим жор бичих эрхийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар руу саналыг хүргүүлснээр, хөнгөлөлттэй жор бичих эмчийн тоо нэмэгдсэн.	100%
Салбарын үр дүн 1.5: “Хэвийн” биеийн жинтэй иргэдийн тоог 5.6 хувиар нэмэгдүүлнэ.										
74	Өдөрт 30 минут дасгал хөдөлгөөн хийдэг иргэдийн тоог 10 хувиар	Нийтийн биеийн тамир хөтөлбөр	Биеийн тамир, спортыг бүх нийтэд түгээн дэлгэрүүлэх	Биеийн тамир, спортоор хичээллэгчид	тоо	2022	10562	11000	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 24 холбоод, клубүүдтэй хамтран ажиллах гэрээний дагуу спортын 12 дугуйланд өсвөрийн болон насанд хүрэгчдийг 676 иргэдийг хичээллүүлж, 43 байгууллагатай заалаар үйлчлэх гэрээ байгуулан, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хамтран үйл ажиллагаа зохион байгууллаа. “Илүүдэл жингүй-Эртэч Монгол” хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны	100%

	нэмэгдүүл нэ.								хөтөлбөрийг хэрэгжүүлэх, нийтийн биеийн тамирыг дэмжих зорилтын хүрээнд нийтийн шугаман бүжгийн спортын дугуйлан, алхалт, гүйлт, гар дээр сунналт, дасгал хөдөлгөөн, дугуй спортын чиглэлээр 5 удаагийн тэмцээнд 2100 тамирчдыг хамруулан, спортын үйл ажиллагаанд 25772 иргэн оролцож Нийтийн биеийн тамирын ач холбогдлын талаар зөв мэдлэгтэй болсон. Биеийн тамир, спортоор тогтмол хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх, спортын төрлийг нэмэгдүүлэх, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, эрүүл бие бялдрыг хөгжүүлэх зорилгоор орон нутагтаа 12 удаагийн тэмцээнийг зохион байгуулж давхардсан тоогоор 38165 иргэн оролцсон.	
75			"Эрүүл Монгол хүн" үндэсний хөдөлгөөнийг зохион байгуулах	Эрүүл Монгол хүн арга хэмжээнд хамрагдсан иргэд	тоо	2022	0	1200 0	"Эрүүл монгол хүн" арга хэмжээний хүрээнд "Эрүүл орчин-Эрүүл хүүхэд", "Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх", "Орчиндоо мод тарих аян", "Харшилгүй монгол хүн" зэрэг үйл ажиллагаануудыг зохион байгуулж, 532 удаагийн сургалтаар 15548 хүн хамруулж, "Нийгмийн эрүүл мэндийг- Өрх бүрт" зорилтыг дэвшүүлж, эрүүл мэндийн 24 байгууллагын 296 эмч, сувилагч нар аймгийн хэмжээний 7423 өрхийн 23406 иргэнд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэж ажиллалаа. Мөн шугаман бүжгээр давхардсан байдлаар 5,314 иргэн хамрагдсан. "Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жилийн нээлт", "Хийн дасгалын сургагч багш бэлтгэх сургалт", "Эмч спорт", бүх нийтийн гүйлт арга хэмжээ, "Хутагтын нутаг-Шамбалын орноор" явган алхалт, "Сайншанд марафон-2024", "Энэ жилдээ - Эрүүл жиндээ-2 аян", "Осол гэмтлээс сэргийлэх", Хүүхдийн аюулгүй байдал-Таны хариуцлагаас", "Эрт илрүүлэг үзлэгийг эрчимжүүлэх" аян зэрэг томоохон арга хэмжээнүүдийг зохион байгуулснаар төлөвлөгөө 94.1% -тай хэрэгжиж, өмнөх оноос 2.3%-иар нэмэгдэж, иргэдийн эрүүл мэндийг дэмжих, дасгал хөдөлгөөнөөр хичээллэх иргэд байгууллагын тоо нэмэгдсэн сайн талтай байна.	100%

76			“Унадаг дугуй” арга хэмжээг хэрэгжүүлэх	Унадаг дугуйгаар хичээллэг сэд	тоо	2022	300	400	"Аймгийн дугуйн спортын, аяллын "Хулан" клубээс санаачлан унадаг дугуйг нийтийн хэрэглээ болгохоор аймгийн хэмжээнд судалгаа хийж, судалгааны дүнд үндэслэн ойрын дугуйн аялал, зугаалгыг жил бүр явуулж хэвшсэн. Аймгийн хэмжээнд нийт 233 хүн унадаг дугуйг хэрэглээний болон спортын зориулалтаар тогтмол хэрэглэж дугуйн спортоор хичээллэгсдийн тоо 20-30 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 2024 оны байдлаар аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан "Сайншандын цом"-ын өсвөрийн дугуйчдын аварга шалгаруулах тэмцээнд 70, Уулын дугуйн өсвөрийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 48 тамирчид оролцсон. Монголын дугуйн холбооноос Сэлэнгэ аймагт зохион байгуулсан Улсын өсвөр үе, Залуучуудын уулын дугуйн аварга шалгаруулах тэмцээнд аймгаас 13 хүний бүрэлдэхүүнтэй 12 тамирчин оролцож унадаг дугуйгаар хичээллэгсдийн тоо өмнөх оноос 70, сонирхогчдын тоо 233 болж өссөн.	90%
77			Спортын төрлүүдийг хөгжүүлэхэд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх	Хамтран ажилласа н спортын холбоо, клубын тоо	тоо	2022	22	24	Аймгийн хэмжээнд 24 холбоод, клубүүдтэй хамтран ажиллах гэрээний дагуу спортын 12 дугуйланд 676 өсвөрийн болон насанд хүрэгчдийг хичээллэж, 43 байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан. Аймгийн спортын холбоодуудтай хамтран бокс, сагсанбөмбөг, гарбөмбөг, шатар, даам зэрэг аймгийн аварга шалгарах тэмцээнүүд, Жюү жицүгийн “Дорноговь опен” дэлхийн чансааны 800 оноо олгох бүсийн зэрэглэлийн олон улсын тэмцээнийг зохион байгууллаа. Бөхийн спортыг хөгжүүлэхэд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Их говийн хүчтэн" бөхийн нэгдсэн холбооны анхдугаар зөвлөгөөнийг үндэсний болон сонгомол бөхийн холбоо, клуб, дэвжээ, бөхийн зүтгэлтнүүдээс бүрдсэн 80 гаруй төлөөлөгчдийг хамруулан зохион байгуулж, их спортын хөгжил, анхаарах асуудал, Үндэсний бөхийн холбоо, дэвжээнүүдийн сайн туршлага, анхаарах асуудал сэдвүүдээр санал	100%

									солилцсон.Үүний үр дүнд бөхийн холбоодын үйл ажиллагааг идэвхжүүлэх, аймаг орон нутгийнхаа нэрийг гаргах алдартан, цолтны тоог нэмэгдүүлэх хөтөлбөр боловсруулан батлуулахаар болсон. Зөвлөгөөнд 7,8 сая төгрөг зарцуулсан. Тайлант онд спортын холбоотой хамтран 81 удаагийн тэмцээнийг /аймгийн төвд 33, сумдад 48/ зохион байгуулж 9514 тамирчин оролцуулж, спортоор хичээллэгсдийн тоо 10-15 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 2020 онд 40 спортын холбоод болон ААН-тэй хамтран ажиллаж байсан бол энэ онд 67 болж өсөөд байна. Аймгийн Засаг даргаас дэмжлэг хүссэн 13 холбоод, клубд /сумо, чөлөөт, хийн дасгал, бильярд, шатар, хөлбөмбөг/ 109,7 сая төгрөгний дэмжлэг үзүүлэн тамирчдаа дэмжин ажиллалаа.	
78			Алтанширээ суманд спорт зал шинээр барих	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Алтанширээ суманд Спорт заал барих ажлыг орон нутгийн төсвийн 1,9 тэрбум төгрөгийн өртөгөөр "ЭИБОЛ" ХХК гүйцэтгэж байна. Барилгын газар шороо, суурь, гадна ханын өрөг, гадна шугам сүлжээний ажил хийгдсэн. Багана, бүс бетоны төмөр бетон хийцийн цутгалтын ажил хийгдэж байна. Ажлын явц 50%-тай.	50%
79			Усан спорт сургалтын төвд дээвэр, дотор засал, агаар сэлгэлтийн засвар хийх	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Орон нутгийн төсвийн 449.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Усан спорт сургалтын төвд дээвэр, дотор засал, агаар сэлгэлтийн засвар хийх ажлыг "Цүн түрүү" ХХК ажил гүйцэтгэн ашиглалтад бүрэн хүлээлгэн өгсөн.	100%
80			Сумдын соёл, спортын ордны засварыг үе шаттай хийх	хувийн биржийн тоо	тоо	2022	5	6	Нийтийн биеийн тамирын зориулалтын барилга, цогцолборын үйл ажиллагааг хэвийн явуулж, орчин нөхцөлийг сайжруулах ажлын хүрээнд орон нутгийн төсвөөс 70,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Улаанбадрах сумын Соёл, спортын төвд бүрэн засвар, Зүүнбаян багийн Соёл, спортын төвд гадна засварын ажлыг тус тус хийж гүйцэтгэсэн. Мөн Айраг сумын Соёл спортын төвд шал, дээврийн засварын ажлыг байгууллагын албан хаагчид 1,7 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.	90%

81		Мэргэжлийн спортын хөгжил хөтөлбөр	Өсвөрийн шигшээ багийг төрлийн нэмэгдүүлж, багш дасгалжуулагчдыг урьж хамтран ажиллах	Уригдан ажилласан багш дасгалжуулагч	тоо	2022	0	3	Хүүхдийн хөгжлийг дэмжих, оролцоог хангах, өсвөр үеийн шигшээ багийг шинэчлэн байгуулах, нэгдсэн зохион байгуулалтаар хангах, улс, бүсийн чанартай уралдаан тэмцээнд шигшээ багийг бэлтгэн оролцуулах чиглэлээр "Монголын сагсан бөмбөг"-ийн холбоотой хамтран ажиллах санамж бичиг байгуулж, аймгийн сагсан бөмбөгийн шигшээ багийг бүрдүүлэх, "Хүүхдийн лиг" зохион байгуулах орон нутагтаа улсын чанартай тэмцээн зохион байгуулах зэрэг чиглэлээр хамтран ажиллахаар төлөвлөлөө. Монгол Улсын сайд, Олимп, Нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга, Дорноговь аймгийн Засаг даргатай байгуулсан 2024 онд хамтран ажиллах гэрээний дагуу спортын холбоодуудтай хамтран өсвөр үеийн шигшээ багийг 12 төрлөөр хөгжүүлэн, үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна. Аймгийн өсвөр үеийн шигшээ багт 670 гаруй тамирчид хичээллэж, Боксын төрлөөр тив, дэлхийн аваргаас нийтдээ 13 алт, 10 мөнгө, 10 хүрэл медаль хүртсэн. Даамны төрлөөр улсын аварга шалгаруулах тэмцээнээс 1 алт, 6 хүрэл, шатарын тэмцээнд улсын аварга, улсын чанартай тэмцээнээс алт 5, мөнгө 5, хүрэл 14, чөлөөт бөхөөс алт 1 хүрэл 1, Жүдо, жюү жи цүгийн төрлөөс алт 57, Мөнгө 49, Хүрэл 33, Үндэсний бөх өсвөрийн аваргын 14 насанд алт 1 тус тус хүртэж, өсвөрийн тамирчид нийтдээ алтан медаль 81, мөнгөн медаль 63, хүрэл медаль 65 буюу 209 медалийн эзэд болсон. Монгол улсын Волейболын спортын мастер Г.Хандсүрэн, Д.Эрдэнэбулган нарыг урьж волейболын олон улсын дүрэм, техникийн талаар практик сургалт зохион байгуулж, волейбол сонирхогч 80 гаруй эмэгтэйчүүд оролцлоо. Өсвөрийн шигшээ багийн төрлийг нэмэгдүүлэх аймгийн аварга шалгаруулах гарбөмбөгийн тэмцээн, "Шинэ эхлэл" хүүхдийн лиг, шагайн харваа, 3*3 сагсан бөмбөгийн тэмцээн зэрэг 13 төрлийн тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулж 3514 өсвөрийн тамирчдыг хамрууллаа. Тайлант онд өсвөрийн тамирчдын медалийн чанар	100%
----	--	------------------------------------	---	--------------------------------------	-----	------	---	---	---	------

									өмнө оноос 24%-аар, хичээллэгсдийн тоо 6%-аар өссөн байна.	
82			Их спортын төрөл, шигшээ багийг нэмэгдүүлж, олон улс, улс, бүсийн тэмцээнийг орон нутагт зохион байгуулах	Зохион байгуулах тэмцээний тоо	тоо	2022	1	2	“Dornogobi open-2024” бүсийн зэрэглэлтэй олон улсын нээлттэй тэмцээн Сайншанд хотноо зохион байгуулагдаж, Дорноговь аймгийн Жюү жицүгийн холбоо Арабын нэгдсэн эмират улсын AJP Tour байгууллагатай хамтран аймгийн Засаг даргын ивээл дор Оросын холбоот улс, Бүгд найрамдах Хятад ард улс, Казакстан, Монгол улсын нийт 30-аад байгууллагын 600 орчим тамирчид оролцлоо. Зүүн бүсийн аварга шалгаруулах “Зүүн бүс-2024” шатрын тэмцээнийг 8 аймаг 2 дүүргийн 360 гаруй тамирчид дунд 6 насны ангилаллаар өрсөлдөж шилдгүүдээ тодрууллаа.Өсвөрийн тамирчид, залууст зориулан "Хөгжлийн лиг-2024", "Шинэ эхлэл" хүүхдийн лиг, "Gobi guys" Сагсан бөмбөгийн лигийн тэмцээнийг зохион байгуулж 1500 гаруй тамирчид өрсөлдөж, 8000 гаруй хүн үзсэн. Аймгийн хэмжээнд шагайн харваа, дугуйн тэмцээн, чөлөөт бөх, жүдо бөх, даам, шатар, боксын аймгийн аварга шалгаруулах Олон улс, бүс, орон нутгийн чанартай 13 тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулж, амжилтын чанараа өмнө оныхоос 100%-иар ахиулан 33,9 сая төгрөг зарцуулсан.	100%
83			Жиү жи цү олон улсын нээлттэй тэмцээнийг зохион байгуулах	Оролцсон тамирчид	тоо	2023	185	250	“Дорноговь open” Дэлхийн чансааны 800 оноо олгох бүсийн зэрэглэлийн Олон улсын тэмцээн 2024 оны 05 дугаар сарын 15, 16-нд Спортын ордонд зохион байгуулагдаж БНХАУ, ОХУ, Казакстан, Монгол улсын 30-аад клубийн 600 орчим тамирчин оролцсон.	100%
84			Бага олимпыг зохион байгуулах	Оролцсон тамирчид	тоо	2021	1500	2000	"Бага олимп" спортын наадмыг зохион байгуулах удирдамжийг боловсруулсан боловч төсвөөс шалтгаалан 2025 онд зохион байгуулахаар төлөвлөсөн.	30%
85	Өдөрт 30 минут дасгал хөдөлгөөн хийдэг иргэдийн	Мэргэжлийн спортын хөгжил хөтөлбөр	Тив, дэлхий, олимп, улс, бүсийн чанартай тэмцээнд оролцох	Амжилт гарган урамшуулал авсан тамирчдын тоо	тоо	2022	75	80	Дорноговь аймгийн Засаг даргын 2021 оны А/171 дүгээр захирамжаар “Өсвөр үе, залуучуудын шигшээ баг”-ийн журмыг 2024 онд шинэчлэн нэмэлт санал, арга хэмжээг тусгаж, тамирчид, дасгалжуулагчдыг урамшуулах, шагнах мөнгөн дүнг нэмэгдүүлэн батлуулсан. Тайлант онд тив, дэлхий,	90%

	тоог 10 хувиар нэмэгдүүл нэ.		тамирчид, дасгалжуулагч дад дэмжлэг, урамшуулал олгох						олон улсын тэмцээнд оролцохоор дэмжлэг хүссэн аймгийн харьяат 44 тамирчинд 35.9 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, 11 сарын байдлаар баг тамирчид 60 гаруй тэмцээнд амжилттай оролцож нийтдээ 298 медалийн эзэд боллоо. 2024 онд тив, дэлхий, олон улс, бүс, улсын чанартай тэмцээнд амжилт гаргасан тамирчид, дасгалжуулагчдийг 12 сард шагнаж, урамшуулна.	
86		Үндэсний уламжлалт спортын хөгжил хөтөлбөр	Үндэсний спортын дугуйлан, секцийн тоог нэмэгдүүлэх	Хичээллэгсдийн тоо	тоо	2022	560	750	Үндэсний спортын төрлүүдийн нэг шагайн тэмцээнийг өвлөн уламжлуулах, сурталчлан, таниулах зорилгоор шагайн харвааны 3 тэмцээн, МУ-ын Даян мэргэн, спортын мастер Лүндэгийн Цэнгэл агсны нэрэмжит сурын харвааны "ДАЯН КАП-2024" тэмцээн, Хатансайханы нэрэмжит 128 бөхийн барилдаан зэрэг тэмцээнүүдийг зохион байгуулж, 800 гаруй тамирчид оролцлоо. Орон нутгаас сурын харвааны тэмцээнд оролцох 40 тамирчинд 4,6 сая төгрөг, сурын харвааны тэмцээн орон нутагт зохион байгуулахад 26,4 сая төгрөг, шагайн холбоонд тэмцээнд оролцоход 1,3 сая төгрөг, үндэсний бөхийн холбоод тэмцээн зохион байгуулахад 10,0 сая төгрөгийг тус тус олгож, Үндэсний спортын хөгжлийг дэмжин ажиллалаа. Мөн аймгийн шагайн холбоод өсвөр, залуу үе болон ахмад тамирчдад зориулан шагай харвааны өрөө бэлдэж өгч, бэлтгэл сургуулилт явуулах таатай орчныг бүрдүүлсэн. Аймгийн хэмжээнд үндэсний спортын 6 дугуйланд бөхийн төрлөөр 112, шагай харваагаар 108, сурын харваагаар 31 суралцагч тогтмол хичээллэж байна. Тайлант оны байдлаар үндэсний спортын дугуйланд тогтмол 251 тамирчин хичээллэж, 10 удаагийн тэмцээн, уралдааныг зохион байгуулсан.	90%
87			Бүсийн хурдан морин уралдаан зохион байгуулах	Оролцсон уралдаанч хүүхэд	тоо	2023	0	500	"Хутагтын хурд 2024" хурдан морины уралдаанд 102 хүүхэд, 159 морь бүртгэгдсэнээс 92 хүүхэд, 150 морь уралдаанд гарч хөнгөн бэртэл авсан 2 хүүхдэд эрүүл мэндийн үйлчилгээ шуурхай үзүүлсэн. Аймгийн болон 14 сумын баяр наадмаар 1017 хүүхэд, 2097 морьд гараанд гарч хөнгөн бэртэл авсан 5, хүнд бэртэл авсан 2 хүүхдийн эрүүл	100%

									мэндийн үйлчилгээнд шуурхай холбон зуучилж үйлчилгээ үзүүлсэн. Унаач хүүхдийн бүртгэл, даатгал, гэрээ, хувцаслалтад бүрэн хяналт тавьж, стандартыг бүрэн хэрэгжүүлсэн.	
88			Үндэсний спортоор амжилт гаргасан баг тамирчдыг урамшуулах, дэмжлэг үзүүлэх	Медаль, Дэмжлэгт зарцуулсан хөрөнгө	тоо төгрөг	2022	7 5.0	15 10.0	Сэлэнгэ аймагт зохион байгуулагдсан “Үндэсний сурын багийн Улсын аварга” шалгаруулах тэмцээнд аймаг орон нутгаа төлөөлөн оролцсон аймгийн Үндэсний сурын холбоонд 4,6 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо сурталчлах, Үндэсний бөхийг орон нутагт хөгжүүлэх зорилгоор “Улс аймгийн цолтой 128 бөхийн барилдаан”-ыг зохион байгуулж, хүндэтгэл үзүүлэх, арга хэмжээнд 10,0 сая төгрөг зарцуулсан. Үндэсний спортын төрлүүдийн нэг шагайн тэмцээнийг өвлөн уламжлуулах, сурталчлан, таниулах зорилгоор аймгийн Шагайн холбоотой хамтран "Говийн бүсийн сар шинийн харваа-2024", цолгүй харваачдын аймгийн аварга шалгаруулах тэмцээн, аймгийн аварга шалгаруулах Үндэсний шагайн харвааны тэмцээн, ахмадын аймгийн аварга шалгаруулах шагайн тэмцээнийг тус тус зохион байгуулсан. Монголын үндэсний сурын харвааг олон нийтэд сурталчлах, хөгжүүлэх, шинэ залуу цолтон төрүүлэх зорилгоор Монгол Улсын Даян мэргэн Лүндэгийн Цэнгэл агсны нэрэмжит “А” зэрэглэлийн спортын цол, зэрэг олгох тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулж 26,4 сая төгрөг зарцуулсан. Уг тэмцээнд 240 харваач цэц мэргэнээ сорьсноос аймаг, сумын цолтон, 19 залуу харваачид өрсөлдсөн. Аймаг орон нутгаас үндэсний спортын төрлөөр хичээллэгсдийн тоог нэмэгдүүлэх, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах зорилгоор 6 арга хэмжээг зохион байгуулж 41,0 сая төгрөгөөр дэмжин ажиллалаа.	100%
Салбарын үр дүн 2.1: Зохистой хөдөлмөр эрхэлж буй хүний тоог 5 хувиар нэмэгдүүлнэ.										
89	Ажилгүйдлийн түвшинг бууруулна	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Орон нутгийн хэмжээнд шинээр бий болсон ажлын байранд	Зуучлагдсан иргэд	тоо	2022	1013	1100	Хөдөлмөр эрхлэлтийн цахим бүртгэлийн систем ejob платформд орон нутгийн хэмжээнд шинээр бий болсон 1452 шинэ ажлын байрыг бүртгэсэн бөгөөд байнгын 886, улирлын 75, түр 491 байна. Тайлант онд шинээр бий болсон ажлын	90%

			ажиллагсдыг зуучлах						байранд 328 иргэнийг зуучилж хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүллээ. Өмнөх онтой харьцуулахад шинээр бий болсон ажлыг байрны бүртгэл 34,5%-иар, зуучлагдсан иргэдийн тоо 169-өөр нэмэгдсэн үзүүлэлттэй.	
90			Шинээр ажлын байр бий болгох иргэн, ААН- үүдэд дэмжлэг үзүүлэх	Дэмжлэг үзүүлсэн ААН	тоо	2022	2	5	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 4 иргэнд ажлын байрны түрээсийн хөнгөлөлтийн 4.8 сая төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгосон. Дэмжлэгт хамрагдсан иргэд нийт 6 байнгын ажлын байрыг бий болгосон бөгөөд шатрын сургалт, хувцас угаалга, компьютер засвар, өөрөө өөртөө үйлчлэх зургийн студи гэсэн чиглэлээр үйл ажиллагаагаа эрхэлж байна.	90%
91			Хувийн хөдөлмөр эрхлэлтийн бирж байгуулахад дэмжлэг үзүүлэх	Хувийн биржийн тоо	тоо	2022	0	1	Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хөдөлмөрийн хувийн бирж байгуулан ажиллах хүсэлтэй иргэн, аж ахуй нэгж байгууллагад мэргэжил арга зүйн зөвлөгөө, мэдээллийг өгч ажилласнаар “Хутагт мөрөн” ХХК-ийн дэргэдэх Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн агент нь 2024.03.01-ний өдрөөс эхлэн “Залуучуудын хөдөлмөр зуучлалын төв” хөдөлмөрийн хувийн бирж байгуулан үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Тус төвд ажил хайгчаар 200 иргэн бүртгүүлж, 33 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, 1 иргэнийг байнгын ажлын байранд зуучилсан	100%
92			EJOB платформын хэрэглээ, ашиглалтыг нэмэгдүүлэх талаар сургалт сурталчилгаа, мэдээлэл хийх	Цахимаар зуучлагдс ан иргэдийн тоо	тоо	2022	1057	1215	Хөдөлмөр эрхлэлтийн нэгдсэн цахим систем “EJOB” платформыг 2023 оны 01 сарын 01-нээс нэвтрүүлж хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамрагдаж буй иргэдийн нэгдсэн санг бий болгон ажиллаж байна. Тус платформыг танилцуулах, ашиглалтыг нэмэгдүүлэх зорилгоор бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх зорилтын хүрээнд зохион байгуулагдсан DIGITAL-FIRST-D1 арга хэмжээ болон Хөгжлийн Шийдэл ТББ-н хэрэгжүүлж буй BEST хөтөлбөрөөс зохион байгуулсан ЭНТРЕПРЕНЕР ЭМЭГТЭЙЧҮҮД IV ФОРУМ-д оролцогч 100 гаруй эмэгтэйчүүдэд мөн “ХАЛАМЖААС ХӨДӨЛМӨРТ-222” арга хэмжээгээр	100%

									7 сумын 234 иргэн болон 5 сумын 58 байгууллагын 116 ажилтан, албан хаагчдад танилцуулахаас гадна тус системд бүртгүүлэх зааварчилгааг бэлтгэн байгууллагын цахим хаягт байршуулж, 1482 ажил хайгч иргэд, 116 ажил олгогч байгууллагад 2 төрлийн гарын авлагыг түгээн мэргэжил, арга зүйгээр ханган ажиллалаа. 2024 оны 11 сарын 28-ны өдрийн байдлаар Ejob платформд 1729 ажлын байрны захиалга, шинээр 981 ажил хайгч иргэн бүртгэгдэж, 916 иргэн ажилд зуучлагдсан. Өмнөх оноос тус системд бүртгэгдсэн ажлын байрны захиалга 405-аар буюу 30,6%-аар нэмэгдэж, ажил зуучлал 253-аар буюу 21,6%-аар, бүртгүүлсэн ажил хайгч иргэдийн тоо 446 иргэнээр буюу 31,2%-аар тус тус буурсан үзүүлэлттэй байна.	
93			Хөгжлийн бэрхшээлтэй иргэний Хөгжлийн төвийн барилга барих	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	80	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн "Эрүүлжин хөгжих төв"-ийн үйл ажиллагаанд гарч байгаа ахиц дэвшил, иргэдийн сэтгэл ханамж, хүлээлтэд үндэслэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв"-ийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр барихаар шийдвэрлэсэн. Үүний дагуу аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 15/08 тоот тогтоолоор "Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв"-ийн барилгад 3,5 тэрбум төгрөгийн төсөв баталсан боловч үнийн нэмэгдлээс шалтгаалан зураг төсөв батлагдаж ирээгүй учир барилгын ажил эхлээгүй байна.	30%
94			Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн талаарх сургалтыг зохион байгуулах	Сургалтад хамрагдсан байгууллага, иргэдийн тоо	тоо	2022	190, 1500	150, 1000	Аймгийн ХАБЭА-н зөвлөл ХАБЭА сарын аяны хүрээнд АҮЭХ, АОЭХ-той хамтран аж ахуй нэгж байгууллагын дарга, ХАБЭА-н ажилтнууд, төрийн албан хаагчид, агентлагийн удирдлагуудад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон хөдөлмөрийн тухай хуулийг сурталчлан таниулах зорилгоор 6 удаагийн сургалтыг зохион байгуулж 306 төрийн албан хаагч, 121 аж ахуй нэгж байгууллагын 935 ажилтныг чадавхжуулсан. Мөн сарын аяны хүрээнд орон нутгийн төсвийн 2.4 төгрөгийг төсөвлөн МҮЭХ-ны сургагч багш	100%

									Д.Энхтайвныг урьж орон нутагт барилгын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 28 ААНБ-ын төлөөллүүд, 73 төрийн албан хаагчийг хамруулан "Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Аймгийн ХАБЭА-н зөвлөл 2021-2024 онуудад “Хөдөлмөрийн харилцаанд хамтын гэрээ, хэлэлцээрийн гүйцэтгэх үүрэг, хэрэгжилт, Хөдөлмөрийн аюулгүй байдлын зохицуулалт”, “ХАБЭА-н удирдлагын тогтолцоо, стандартын талаарх ойлголт, чадамжийг гүнзгийрүүлэх, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад тус стандартыг нэвтрүүлж эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх”, “ХАБЭА-н тухай хууль, салбар зөвлөлийн чиг үүрэг, тулгарч буй асуудал” зэрэг нийт 100 гаруй сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж давхардсан тоогоор 8000 гаруй хүнийг хамруулсан.	
95			Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн хяналт шалгалтыг зохион байгуулах	Хяналт шалгалтын тоо	тоо	2022	2	4	Гэр бүл хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны харьяа салбарын хяналтын газрын даргын баталсан төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай удирдамжуудын дагуу 62 аж ахуйн нэгж байгууллагыг хамруулан байгууллага тус бүрт хяналт шалгалтыг удирдамж боловсруулан хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгөх үйл ажиллагааг хэрэгжүүлснээр 682 зөрчил илрүүлсэн бөгөөд 180 зөрчлийг газар дээр нь шийдвэрлэн, үлдсэн 502 зөрчилд 205 заалт бүхий 62 албан шаардлагыг хүргүүлэн ажилласан. Мөн зөрчлийн тухай хуулийн дагуу 8 аж ахуйн нэгж, байгууллагад 9,6 сая төгрөгийн торгууль ногдуулж, улсын төсөвт төвлөрүүлсэн.	100%
Салбарын үр дүн 3.1: Үндэсний соёлын дархлааг 66 хувьд хүргэнэ.										
96	Үндэсний соёлын өв тээгчдийн тоог 10 хувиар	Нийгмийн соён гэгээрэл хөтөлбөр	Соёлын өвийг хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, иргэдэд соёл, урлагийн	Соёлын байгууллагаар үйлчлүүлсэн хүн	тоо	2022	25809	30889	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 13-р тогтоолоор батлагдсан "Улсын хамгаалалтад байх түүх соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт"-д Дорноговь аймгаас бүртгэгдсэн 6 үл хөдлөх дурсгал, аймгийн хамгаалалтад байдаг 14 дурсгалыг иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулан хариуцуулан	90%

	нэмэгдүүл нэ		үйлчилгээг үзүүлэх						ажиллалаа. Соёлын өвийн үндэсний төвтэй хамтран мэргэжлийн багаар чулуун арслан, хүн чулуу хөшөөг сэргээн засварлуулж, хадгалалт хамгаалалтыг сайжруулсан. Гадаад орчны хүчин зүйлээс үүдэн эрсдэлд өртөж буй түүх соёлын үл хөдлөх 10 дурсгалыг ангилан учирч буй нөхцөл байдлын тайлбарлан гэрэл зургийн хамтаар баримтжуулж Соёлын өвийн үндэсний төвийн Авран хамгаалах, эрсдлийн судалгааны газарт хүргүүлсэн. Замын-Үүд сумын гаальд хураагдсан 35 ширхэг баримтат өвийг Замын-Үүд сумын Сум дундын шүүхийн шийтгэврээр музейн сан хөмрөгт хүлээн авч, бүртгэсэн. Соёлын сайдын 2024 оны А/255 дугаар тушаалаар батлагдсан Археологийн эрдэм шинжилгээний хайгуул, малтлага судалгааны ажил хийх зөвшөөрлийн дагуу Монгол Улсын Их Сургуулийн Археологийн судалгааны төвтэй хамтран Хатанбулаг сумын нутаг Хасар уул орчим малтлага судалгааны ажлыг зохион байгуулж, судалгааны ажилд 5.0 сая төгрөг зарцуулсан. Иргэдэд соёлын үйлчилгээг хүртээмжтэй, хэрэгцээ шаардлагад нийцсэн байдлаар хүргэх зорилгоор аймгийн Музейн сургалт судалгааны төвөөс Сайншанд сумын ЗДТГ-тай хамтран Сайншанд хот дахь түүхэн дурсгалт хөшөө дурсгалын тухай дэлгэрэнгүй тайлбарт "Сити тур" аялалыг зохион байгуулж ЕБС-ийн 81 сурагчийг хамруулснаас гадна тэмдэглэлт ойн өдрүүдэд зориулсан 12 удаагийн үзэсгэлэнг 24216 иргэн, тус музейгээс хэрэгжүүлдэг 7 боловсролын хөтөлбөрт 2245 хүүхэд багачуудыг хамруулж ажилласан.Тайлант онд музейн танхимаар аймгийн хэмжээнд 8539 үзэгч үйлчлүүлсэн бол соёлын үйлчилгээг нийтдээ 26461 хүүхэд, иргэнд хүргэн ажиллалаа.	
97			Соёлын биет бус өв тээгчийн тоог нэмэгдүүлэхэд чиглэсэн арга	Арга хэмжээ	тоо	2022	76	89	Соёлын биет бус өвлөн уламжлагчдийн тоог нэмэгдүүлэх чиглэлээр Музей сургалт судалгааны төв дэргэдээ “Эвийн эгшиг” уртын дууны дугуйлан, “Увидаст ятга” ятгын дугуйланг тогтмол хичээллүүлэн орчин цагийн музей үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан ардын язгуур	90%

			хэмжээг хэрэгжүүлэх						урлагийн тоглолт зохион байгуулж 350 гаруй үзэгчдэд толилууллаа. "Эвийн эгшиг" уртын дууны дугуйлан 2014 оноос эхлэн шавь сургалтын үйл ажиллагаагаа явуулан, 10 жилийн хугацаанд 300 гаруй шавь төрүүлсэн. ЮНЕСКО, СӨҮТ-өөс хамтран хэрэгжүүлсэн соёлын биет бус өвийн сургагч багш бэлтгэх сургалтын хүрээнд өвлөн уламжлагчдыг бүртгэх, баримтжуулалтын арга зүйн талаар сумдын музейн ажилтан, МССТ-ын эрдэм шинжилгээний ажилтанд албан хаагчдад сургалт арга хэмжээг зохион байгууллаа. Улсын хэмжээнд өрнөсөн "Монгол гэр" үзэсгэлэн, "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестиваль, орчин цагийн музей үүсэж хөгжсөний 100 жилийн арга хэмжээнд аймаг орон нутгаа төлөөлөн оролцсон өвлөн уламжлагчдаа дэмжин 23,5 сая төгрөг зарцуулсан. Тайлант оны хугацаанд соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдын тоог нэмэгдүүлэх, сурталчлан алдаршуулахад чиглэсэн 7 арга хэмжээг зохион байгуулж, 40 өвлөн уламжлагчид мөнгөн урамшуулал олгож, 10 өвлөн уламжлагчид "Тэргүүний ардын авьяастан" цол тэмдгийг гардууллаа.	
98			Дэлгэрэх,Эрдэ нэ сумдад шинээр Соёлын төвийн барилга барих	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Эрдэнэ суманд соёл спортын цогцолбор шинээр барих ажлыг улсын төсвийн 3,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Өгөөмөрөн шанд" ХХК ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, ажлын явц 20%-тай. Дэлгэрэх суманд Соёлын төвийн барилга барих ажлыг улсын төсвийн 4,1 тэрбум төгрөгийн өртөгөөр "Элит конкрет" ХХК ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, ажлын явц 20%-тай байна.	30%
99			Даланжаргала н, Хатанбулаг,М андах сумын Соёлын төвүүдийг шаардлагатай тоног	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	ОНТ-ийн хөрөнгө оруулалтаар Даланжаргалан, Хатанбулаг сумын Соёлын төвүүдэд тус бүр 80,0 сая төгрөгийн ЛЕД дэлгэц 2 ширхэг, Мандах сумын соёлын төвд ОНТ-ийн 120,0 сая төгрөгөөр тайзны гэрэлтүүлэг, сандлыг тус тус худалдан авч, шаардлагатай төхөөрөмжөөр 100% ханган үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн.	100%

			төхөөрөмжөөр хангах							
100			Музейн үйлчилгээг цахимжуулах VR төхөөрөмж нэвтрүүлэх	VR төхөөрөмж	тоо	2023	0	5	Музейгээр үйлчлүүлэгч хүүхэд багачуудад зориулан Digital Solution компанитай хамтран монгол орны байгаль түүх соёлын талаарх танин мэдэхүйн 23 контент агуулсан 1 ширхэг VR төхөөрөмжийг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас олгосон үр дүнд суурилсан санхүүжилтийн зардлаас 2,3 сая төгрөгийг шийдвэрлэн худалдан авсан.	90%
101			Иххэт, Сайхандулаан, Алтанширээ сумдын Соёлын төвүүдийг засварлах	Ажлын гүйцэтгэл	хувь	2022	0	100	ОНТ-ийн хөрөнгө оруулалтаар Иххэт сумын Соёлын төвийн бүжгийн заалны засварын ажлыг 124,4 сая төгрөгийн өртгөөр, Иххэт сумын Соёлын төвийн дотор халаалт гэрэлтүүлэг, цэвэр, бохир усны шугам сүлжээний засварын ажлыг 264.4 сая төгрөгийн өртгөөр "Чандмань тайж" ХХК, Алтанширээ сумын Соёлын төвийн барилгын их засварын ажлыг 441,9 сая төгрөгийн өртгөөр "Мунара констракшн" ХХК, Сайхандулаан сумын Соёлын төвийн засварын ажлыг 208,9 сая төгрөгийн өртгөөр "Илч дулаан өсөх" ХХК-ууд тус тус гүйцэтгэж 8 дугаар сард ашиглалтад оруулсан.	100%
102			Саранхөхөө театрын барилга барих, шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах, тохижуулах	Ажлын гүйцэтгэл	хувь	2021	0	100	Саранхөхөө театрын барилгын ажлыг "Болор аграмба" ХХК гүйцэтгэж театрын барилгын суурь, зоорь, 1,2,3-р давхрын рам, хучилтын хийцүүдийн угсралт хийгдсэн. Гадна дотор ханын дүүргэлтийн тоосго, блокон ханын өрлөгийн ажил, цонх суулгах ажлууд хийгдэж байна. Барилга угсралтын ажил 65%-тай. Шинээр ашиглалтад орох 700 хүний суудалтай Саран хөхөө театрт орон нутгийн төсвөөс 1,1 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авах тендерийг зарлаж "Киберком" ХХК шалгарч 2024 оны 11 дүгээр сарын 27-нд гэрээ байгуулах эрх олгосон.	70%
103			Замын-Үүд сумын Соёл, урлагийн ордон, Өргөн сумын соёлын төвд шаардлагатай	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Замын-Үүд сумын Соёлын ордонд шаардлагатай тоног төхөөрөмжийг "Содон сод оюу" ХХК 1,0 тэрбум төгрөгөөр 87 төрлийн тоног төхөөрөмж худалдан авч хүлээлгэн өгсөн. Үүнд гэрэл техник тоног төхөөрөмж 131.2 сая, Хөгжим, микрофон, техник тоног төхөөрөмж 164.4 сая, гадна, дотор талд байрлуулах лед дэлгэц 156.6 сая, тайзны	100%

			тоног төхөөрөмж худалдан авах						хэрэглэл гал, салют,мульт, кабель, 48,5 сая, зөөврийн тайз 44,0 сая, Компьютер принтер, студи төхөөрөмж 59,1 сая, Үндэсний хөгжим болон цахилгаан хөгжим 70,0 сая, Тайзны хөшиг 42,0 сая, Тавилга эд хогшил 84,0 сая, Сандал 130,0 сая, автобус 86,0 сая, тог баригч 16,0 сая төгрөгөөр худалдан авсан. Өргөн сумын соёлын төвд 114.2 сая төгрөгөөр тоног төхөөрөмж худалдан авах тендер шалгаруулалтыг зарлаж "Сити лед" ХХК 99.9 сая төгрөгөөр нийлүүлэхээр гэрээ байгуулж тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн.	
104			Хамарын хийдэд ноён хутагт Д.Данзанравж аагийн нэрэмжит соёл-аялал жуулчлалын төв, гэр театрын барилга барих	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Хамарын хийдийн 3 замын уулзварт "Өв соёлын өргөө-гэр театрыг"-ыг барихад шаардлагатай газар олголтын асуудлыг шийдвэрлэн соёл аялал жуулчлалын төв гэр театр барихаар төлөвлөсөн. Барилгын ажил цахилгааны хүчдэл хүрэлцэхгүй гэсэн шалтгаанаар түр хойшлогдсон боловч аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 19/01 дүгээр тогтоолоор хэлэлцэж уг ажлыг цуцлах шийдвэр гаргасан.	30%
105			Аймгийн Төв номын сангийн барилгын дотор халаалтын системийн засварын ажил хийх	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Аймгийн Төв номын сангийн барилгын дотор халаалтын системийн засварын ажлыг орон нутгийн төсвийн 122.6 сая төгрөгийн өртгөөр "Миний Сайншанд" ХХК гүйцэтгэж 7-р сард хүлээлгэн өгсөн.	100%
106			Үзэгчдэд зориулсан зөөврийн 4 давхар сандал худалдан авах	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Үзэгчдэд зориулсан зөөврийн 4 давхар сандал орон нутгийн 150,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар худалдан авах тендер шалгаруулалтыг зарласан боловч шаардлагад нийцсэн материал орж ирээгүй учраас 2024 оны 09 сарын 26-ны төсвийн тодотголоор нэр, эх үүсвэр өөрчлөгдөж, хөгжлийн сангийн эх үүсвэрээс шийдвэрлэсэн. Тус ажлыг "Энержи парагон" ХХК 106,0 сая төгрөгөөр аймгийн төв цэнгэлдэх хүрээлэнгийн засварын	100%

									нэмэлт ажлын хүрээнд үзэгчдэд зориулсан зөөврийн 4 давхар сандал нийлүүлсэн.	
107			Аймгийн төв Гандантэгчинлэн хийдийн орчны тохижилтийг хийх	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Орон нутгийн төсвийн 600,0 сая төгрөгөөр аймгийн Төв Гандантэгчилэн хийдийн орчны тохижилтыг гүйцэтгэхээр төлөвлөсөн боловч аймгийн ИТХ-ын 2024 оны 19/01 дүгээр тогтоолоор үр ашиггүй хөрөнгө оруулалт гэж шийдвэрлэн хүчингүй болгосон	30%
108	Нийгмийн соён гэгээрлийн түвшинг нэмэгдүүлнэ.	Нийгмийн соён гэгээрэл хөтөлбөр	"Торгон хил" арга хэмжээг зохион байгуулах	Хамрагдсан хүүхэд	тоо	2022	20	25	2023-2024 оны хичээлийн жилд "Орон нутгийн онцлогт хөтөлбөр"-өөр Замын-Үүд сумын 1-р сургууль, "Үлэмж тэнгэр" болон Зүүнбаянгийн сургуулиуд "Торгон хил-Эх орон" сэдвийн хүрээнд 658 сурагч, 110 багш, ажилчид болон 56 эцэг эх, иргэд нийт 824 хүнийг хамруулан зохион байгуулсан. Мөн өсвөр үе, залуучуудад эх орноо хайрлан хамгаалах, эх оронч үзлийг төлөвшүүлэх, нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Зэвсэгт хүчний 336 дугаар ангитай хамтран "Хутагтын нутгаар-Торгон хил" арга хэмжээг 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдөр зохион байгууллаа. Тус арга хэмжээгээр цэргийн ангийн үйл ажиллагаа болон Монгол цэргийн түүх, соёл, үнэт зүйлсийг танилцуулж, хугацаат цэргийн алба хаагчдын дунд сургалт, ярилцлага зохион байгуулж, 245 хүүхэд, залуучуудыг хамруулсан.	100%
109			Олон улсын соёлын танилцуулга, хамтын ажиллагааны экспо зохион байгуулах	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Монгол Улс, Бүгд найрамдах Хятад ард улстай дипломат харилцаа тогтоосны 75 жилийн ойг тэмдэглэн 2 орны соёлын харилцааг бэхжүүлэх, хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хамтарсан урлагийн тоглолт зохион байгуулж, БНХАУ-н Эрээн хотын орлогч дарга, Консулын газартай аймгийн удирдлагууд уулзаж цаашид хамтран хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, арга хэмжээний талаар зөвшилцлөө. Уг арга хэмжээнд 2 улсын 80 албан хаагч, уран бүтээлчид оролцож 350 иргэдэд соёлын үйлчилгээ үзүүллээ. МУЗГ-ын тогтоолын дагуу "Монголд зочлох жил"-ийн хүрээнд зохион байгуулсан "Монгол гэр" үзэсгэлэнд соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхэлдэг 2 иргэний бүтээлийг, "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивальд 3 иргэний	70%

									бүтээлээр үзэсгэлэн гаргаж, олон нийтэд худалдаалан аймгийн бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдээ дэмжин ажиллалаа. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн арга хэмжээнд орон нутгаа төлөөлөн оролцсон байгууллага, хувь хүнийг дэмжин 16,0 сая төгрөг зарцуулсан. Жил бүр Улаанбаатар хотноо уламжлал болон зохион байгуулагддаг "Ай Ти Эм" аялал жуулчлалын үзэсгэлэнд орон нутгийн "Тансаг цагаан" ингэний хоормог, эврэн урлал, эко саван,суран эдлэл, эсгий ширмэл эдлэл зэрэг бүтээлүүдийг гадаад дотоодын жуулчид, аялал жуулчлал сонирхогч олон нийтэд түгээн, сурталчиллаа.	
110			Өв уламжлал, хүмүүжлийн агуулгатай хүүхдэд зориулсан уран бүтээл туурвих	Уран бүтээл	тоо	2022	2	2	Хүүхдийн уран бүтээлийн нэр төрлийг нэмэгдүүлж, насны онцлогт тохирсон уран бүтээлийг толилуулах, соёл, урлагаар дамжуулан хүүхэд багачуудын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэн, төлөвшүүлж, соён гэгээрүүлэх зорилготой шинээр “Эвт Мэргэн Өвгөн Эх Чоно хоёрын домог” хүүхдийн жүжгийг сургуулийн өмнөх боловсролын хүүхдүүдэд, “Чандмань Эрдэнэ” хүүхдийн жүжгийг тус тус найруулан толилуулсан. Тус хүүхдийн жүжгийг нийт 21 удаа тоглож 4329 хүүхэд үзсэн. Мөн Замын-Үүд сумын Соёл, спортын ордны “Мини-Отголдой” хүүхдийн театр үе тэнгийн дээрэлхэлт, зан байдал, харьцаа хандлага, хорт зуршлуудаас урьдчилан сэргийлэх сургамжит жүжгийг тайлант онд Айраг, Даланжаргалан, Өргөн, Эрдэнэ сумын 1200 хүүхдүүдэд толилуулж, соён гэгээрүүллээ. Хүүхдэд зориулсан уран бүтээл туурвихад 24,0 сая төгрөг зарцууллаа.	90%
111	Эв нэгдлийн нягтралыг 20 хувиар нэмэгдүүл нэ.	Үндэсний эв нэгдэл хөтөлбөр	Соёлын төвүүдэд үндэсний бичгийн булан байгуулах	Үндэсний бичгийн булантай байгууллага	тоо	2022	0	5	Соёлын төвүүдэд үндэсний бичгийн булан байгуулах ажил 100 хувьтай хэрэгжлээ. Тайлант онд шинээр 8-н соёлын байгууллага Үндэсний бичгийн булан байгуулж, нийтдээ 12 соёлын байгууллага Үндэсний бичгийн булантай болсон.Үндэсний бичгийг сурталчилсан, түгээн дэлгэрүүлсэн 6 ажлыг зохион байгуулж 36 сурагч,20 байгууллагын 78 албан хаагч, 150 иргэн оролцож, үндэсний бичгийн мэдлэг чадвараа дээшлүүлэн, хэрэглээгээ	100%

									нэмэгдүүлж, цаашид монгол бичигт бүрэн шилжих бэлтгэл ажлыг эхлүүллээ. Үндэсний бичиг соёлоо сурталчлах арга хэмжээнд 1,6 сая төгрөг зарцуулсан.	
112			“Миний монгол хэл, бичиг-2025” арга хэмжээг хэрэгжүүлэх	Арга хэмжээнд хамрагдсан иргэн	тоо	2022	358	655	Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд 2021 оноос ерөнхий боловсролын сургууль, Насан туршийн суралцахуйн төвийн монгол хэл, бичгийн багш нар иргэд, төрийн албан байгууллагуудад монгол бичгийн анхан болон дунд шатны сургалтыг 5000 гаруй албан хаагч, иргэдэд зохион байгуулсан. Суралцагчдад монгол хэл, бичгийн мэдлэг, чадварыг чанартай эзэмшүүлэхийн тулд 2023-2024 оны хичээлийн жилд 9, 12-р ангийн 1835 сурагчдын дунд монгол хэл, 6-7-р ангийн 2745 сурагчдын дунд үндэсний бичгийн хичээлээр анги хамт олны олимпиадыг зохион байгуулж, ахиц амжилтыг тооцон шилдгүүдийг шалгаруулсан. 2024 оны 9 сард Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн хүрээнд “Эх хэлний өдөр” болон “Үндэсний бичиг соёл, номын өдөр”-ийг хамтатган зохион байгуулсан. Эх хэлний өдрөөр эх хэл, түүхээрээ бахархах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор монгол хэл, бичиг, түүхийн сэдвээр хичээл бэлтгэн зааж, 541 бүлгийн 16160 суралцагчийг хамруулсан. Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд 2021 оноос ерөнхий боловсролын сургууль, Насан туршийн суралцахуйн төвийн монгол хэл, бичгийн багш нар иргэд, төрийн албан байгууллагуудад монгол бичгийн анхан болон дунд шатны сургалтыг 5000 гаруй албан хаагч, иргэдэд зохион байгуулсан. Суралцагчдад монгол хэл, бичгийн мэдлэг, чадварыг чанартай эзэмшүүлэхийн тулд 2023-2024 оны хичээлийн жилд 9, 12-р ангийн 1835 сурагчдын дунд монгол хэл, 6-7-р ангийн 2745 сурагчдын дунд үндэсний бичгийн хичээлээр анги хамт олны олимпиадыг зохион байгуулж, ахиц амжилтыг тооцон шилдгүүдийг шалгаруулсан. 2024 оны 9 сард Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн хүрээнд “Эх хэлний өдөр” болон “Үндэсний бичиг соёл,	90%

									номын өдөр"-ийг хамтатган зохион байгуулсан. Эх хэлний өдрөөр эх хэл, түүхээрээ бахархах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор монгол хэл, бичиг, түүхийн сэдвээр хичээл бэлтгэн зааж, 541 бүлгийн 16160 суралцагчийг хамруулсан. Мөн Үндэсний бичиг соёл, номын өдрөөр "Номын хишиг-Эрдмийн түшиг" номын хэлэлцүүлэг, АХА тэмцээн, "Сайхан бичигтэн", "Түргэн уншигч" зэрэг нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулсан. Мөн сумын сургуулиуд төрийн байгууллага, иргэдийн дунд монгол бичгээр нэрээ бичих, бичил эх унших, "Алтан хонх", номын үзэсгэлэн дэлгэх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж 150 гаруй албан хаагч, иргэдийг хамруулсан.	
Салбарын үр дүн 3.2: Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг 1 хувиар нэмэгдүүлнэ.										
113	Соёлын үйлдвэрлэл эрхлэгч, иргэн, хуулийн этгээдийн тоог 10 хувиар нэмэгдүүлнэ	Соёлын бүтээлч үйлдвэрлэл хөтөлбөр	Соёлын бүтээлч үйлдвэрлэгчдийн үзэсгэлэн зохион байгуулах	Үзэсгэлэн	тоо	2022	2	26	МУЗГ-ын 2022 оны 264-р тогтоолоор 2023-2025 оныг "Монголд зочлох жил" болгон зарласантай холбогдуулан "Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл"-ийг сурталчлан таниулах "Монгол гэр" үзэсгэлэн, "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестиваль зэрэг арга хэмжээ улсын хэмжээнд өрнөсөн. Аймаг орон нутгаас "Монгол гэр" үзэсгэлэнд соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхэлдэг 2 иргэний бүтээлийг "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивальд 3 иргэний бүтээлээр үзэсгэлэн гаргаж, олон нийтэд худалдаалан аймгийн бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдээ дэмжин ажиллалаа. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн арга хэмжээнд орон нутгаа төлөөлөн оролцсон байгууллага, хувь хүнийг дэмжин 16,0 сая төгрөг зарцуулсан. Иргэдийг бүтээлч авьяасаа нээн хөгжүүлэх, бараа үйлчилгээгээ борлуулан, үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах боломжийг бүрдүүлэн орон нутагтаа "Монгол гэр-Соёлын орон зай" арга хэмжээний хүрээнд 4 бүтээлч үйлдвэрлэгчдийг оролцуулан, бүтээлүүдийг олон нийтэд сурталчлан, хамтран ажиллалаа. Уг арга хэмжээнд 1000 гаруй иргэн оролцсон. Мөн уламжлалт сар шинийн баярыг тохиолдуулан "Ардын уламжлалт гар урлалын ай сав" цахим үзэсгэлэнг зохион байгууллаа. Цахим үзэсгэлэнд	100%

								ардын уламжлалт гар урлалын ай савын 8 өвлөн уламжлагч оролцсон ба цахим үзэсгэлэнг 7662 хүн цахимаар үзэж сонирхлоо. Жил бүр Улаанбаатар хотноо уламжлал болон зохион байгуулагддаг "Ай Ти Эм" аялал жуулчлалын үзэсгэлэнд орон нутгийн "Тансаг цагаан" ингэний хоормог, эврэн урлал, эко саван,суран эдлэл, эсгий ширмэл эдлэл зэрэг бүтээлүүдийг гадаад дотоодын жуулчид, аялал жуулчлал сонирхогч олон нийтэд түгээн, сурталчиллаа. Тайлант хугацаанд соёлын бүтээлч үйлдвэрлэгчдийн 5 үзэсгэлэнд оролцож бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдээ дэмжин ажиллалаа.	
114		Улсын чанартай арга хэмжээнд орон нутгийн үйлдвэрлэгчдийг оролцуулах	Улсын чанартай арга хэмжээнд оролцсон орон нутгийн үйлдвэрлэгч	тоо	2022	5	10	Өмнөговь аймгийн Даланзадгад хотноо зохион байгуулагдсан А.Цэрэнхүү агсны нэрэмжит уран хамтгалчдын улсын уралдаан , "Эсгий туургатан 2024" гар урлалын ур чадварын уралдаанд уламжлалт гар урлалын өвлөн уламжлагч, уран хатгамалч Г.Урантогос нь шүүгчдийн нэрэмжит шагналаар шалгаран амжилттай оролцлоо. Жил бүр Улаанбаатар хотноо уламжлал болон зохион байгуулагддаг "Ай Ти Эм" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд аймгийн Засаг даргын А/730 дугаар захирамжийн дагуу 6,0 сая төгрөгийн дэмжлэгтэйгээр оролцож орон нутгийн 3 иргэн, 10 аж ахуй нэгжийг дэмжин оролцлоо. Казакстан улсын Астана хотод зохион байгуулагдсан дэлхийн нүүдэлчдийн 5-р их наадамд Монгол Улсаа төлөөлөн Дорноговь аймгийн өвлөн уламжлагчдын Зээ хамтлагийг оролцуулсан бөгөөд тус хамтлаг нь ерөөл, магтаал, халх тууль, аялгуут үлгэр, домог, уртын дуу, хөөмэй зэрэг язгуур урлагийн тоглолтын үзүүлбэр үзүүлдэг 5 гишүүний бүрэлдэхүүнтэй эх хэл, аман уламжлал язгуур урлагийн хамтлаг юм. МУЗГ-ын 2022 оны 264-р тогтоолоор 2023-2025 оныг "Монголд зочлох жил" болгон зарласантай холбогдуулан “Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл”-ийг сурталчлан таниулах "Монгол гэр" үзэсгэлэн, "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивальд орон нутгаа төлөөлөн оролцсон байгууллага, хувь хүнийг дэмжин 16.0 сая төгрөг зарцуулсан. Улсын	90%

									чанартай 6-н арга хэмжээнд орон нутгийн 13 иргэн, 10 аж ахуй нэгжийн үйлдвэрлэгчдийг оролцуулж, 21,0 сая төгрөгөөр дэмжин ажиллалаа.	
115			"Тэнгэрийн хутагт" фестивалийг зохион байгуулах	Хамрагдсан иргэд	тоо	2023	0	3000	Аймгийн Засаг даргын А/492 дугаартай захирамжаар соёлын салбарын албан хаагчдыг чадавхжуулах, шинэлэг санал санаачилга өгөх, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор Улаанбаатар хотноо тоглогдсон Говийн ноён хутагтын амьдрал уран бүтээлийг харуулсан түүхэн "Тэнгэрийн хутагт" бүжгэн жүжгийг үзүүлж, орон нутгийн төсвөөс 3,6 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Оны шилдэг уран бүтээлчийг шалгаруулах "Мөнгөн мод 2023" наадамд "Тэнгэрийн хутагт" бүжгэн жүжгийн зохиолч нутгийн яруу найрагч Л. Эрдэнэбат, зураач Д.Ганпүрэв, хөгжмийн зохиолч УГЗ Ш.Өлзийбаяр, бүжиг дэглээч Х.Хашхүү нарын материалыг хүргүүлж, "Мөнгөн мод-2023" оны шилдэг хөгжмийн зохиолч тэнгэрийн хутагт бүжгэн жүжгийн хөгжмийн зохиолч УГЗ Ш.Өлзийбаяр, шилдэг бүжиг дэглээчээр Х.Хашхүү нар шалгарлаа.Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгөнөөс шалтгаалан "Тэнгэрийн хутагт" фестивалийг 2025 онд хувийн хэвшилтэй хамтран зохион байгуулахаар болсон.	50%
116			"Их говийн тэмээ"фестивалийг зохион байгуулах	Хамрагдсан иргэд	тоо	2023	0	4500	Дорноговь аймгийн соёлын салбар соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, орон нутгийн брэнд онцлог бүхий "Их говийн тэмээ" фестивалийг цаг агаарын нөхцөл байдал /зуд/-аас шалтгаалан цуцалсан. Тэмээн сүргийн үүлдэр угсааг сайжруулах, тоо толгойг өсгөх, тэмээчид, малчдыг туршлага солилцуулах, алдаршуулах, гадаад дотоодын жуулчдыг татах зорилгоор Баянхонгор аймагт зохион байгуулагдсан "Монголын тэмээн соёл" улсын зөвлөгөөн, баяр наадамд оролцож туршлага судалсан.	30%
Салбарын үр дүн 4.1: Гэр бүлийн эрүүл, тогтвортой байдлыг хангана.										
117	Хүүхдийн эрхийн баталгааг 1 хувиар	Нийгмийн хөгжил хөтөлбөр	Хүүхдийн эсрэг үйлдэгдсэн	Арга хэмжээ	тоо	2022	30	45	"Намайг хамгаал", "Хайр хязгааргүй ялгаагүй", "Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй", "Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг өдөр" "Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ-2024", "Гэр бүлийн	90%

	сайжруулн а.		гэмт хэрэгтэй тэмцэх						хүчирхийллийн гэрч хохирогч хүүхдүүдийн эрх ашгийг хамгаалах, хуулийн хүрээнд үйлчилгээ үзүүлэх" чиг үүргийн хүрээнд хууль зүйн хорооны хяналтад 17 хүүхэд авснаас, бэлгийн хүчирхийллийн 2, Үл хайхрах хүчирхийллийн 4, Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан 11 хүүхдийн асуудлыг шийдвэрлэж, хариу арга хэмжээг авч, харьяа байгууллагуудад холбон зуучилсан. 2024 онд бэлгийн хүчирхийллийн 1 дуудлага мэдээлэл хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэнийг бүртгэн, хэргийг шалган шийдвэрлүүлэхээр Цагдаагийн газарт хүргүүлсэн. Насанд хүрээгүй хүүхэд холбогдсон зөрчил шалган шийдвэрлэх 39, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх 9 хэргийн нийт 48 хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр ажиллаж, эрх ашгийг хамгаалан ажилласнаар өмнөх онтой харьцуулахад гэмт хэрэг, зөрчилд холбогдсон хүүхдийн тоо 22 хувиар буурсан үзүүлэлттэй байна.	
118			Хүүхэд хамгааллын үйл ажиллагаа явуулах	Хамгааллын үйлчилгээнд хамрагдсан хүүхэд	тоо	2022	56	60	Хүүхэд хамгааллын чиглэлээр "Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй", "Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг өдөр", "Үе тэнгийн дээрэлхэлт", "Гэр бүлдээ цаг гаргая", "Хүүхдийн аюулгүй байдал-биднээс" зэрэг 20 гаруй арга хэмжээг зохион байгуулж 25700 гаруй иргэнд сургалт, нөлөөллийн арга хэмжээг хүргэсэн. Сайншанд сумын Түр хамгаалах байраар том хүн 1, хүүхэд 10, Замын-Үүд суман дахь Түр хамгаалах байраар том хүн 2, хүүхэд 9, нийт 3 том хүн 19 хүүхдэд хоол хүнс, хувцас, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээг үзүүлсэн. Хамгааллын үйлчилгээний чиг хүрээнд хүүхдийн асрамжийн төвд 1, хүүхдийг үрчлүүлэн асралт гэр бүлд 2, хууль зүйн зөвлөгөөг 5, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах төвд аутизм болон сэтгэцийн өөрчлөлттэй 1, сэтгэл санааны хохирлыг тогтоох үйлчилгээг 2 хүүхдэд тус тус үзүүлэн, шаардагдах ахуйн болон ариун цэврийн хэрэгсэл, хувцас, хичээлийн хэрэглэлийг бэлтгэж өгсөн. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн судалгааг нэгтгэн гаргах, нөхцөл байдлын үнэлгээг хийх, хариу үйлчилгээг үзүүлэх зэрэг арга зүйн сургалтыг 2024 онд 3 удаа Хамтарсан багийн зөвлөх багштай	100%

								хамтран зохион байгуулж, хамтарсан багийн 119 гишүүдийг хамруулан арга зүйгээр хангасан. Хүүхдийн тусламжийн 108 утсанд тайлант хугацаанд 78 дуудлага мэдээллийг хүлээн авч, 89,7%-ийг шийдвэрлэн, 8 дуудлагын зөрчлийг шалган ажиллаж байна. 2023-2024 оны өвөлжилт хүндрэн, цас зудад боогдсон Сайншанд, Алтанширээ, Иххэт, Айраг, Даланжаргалан, Дэлгэрэх, Мандах сумын нийт 215 малчин өрхийн 319 хүүхдэд 17,2 сая төгрөгийн хариу үйлчилгээг үзүүлж, хүнс тэжээлийн болон ахуйн хувцас хэрэглэлийг хүргэж, 32 хүүхдэд амин дэмийн багц олгож хүүхдийн эрхийг хамгаалан, эрсдэлийг бууруулан, хяналт тавьж ажилласнаар хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулснаар өмнөх оноос 28 хувиар өссөн.		
119			Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа болон эрх нь зөрчигдсөн хүүхэд, гэр бүлд хамгаалах, нөхөн сэргээх хариу үйлчилгээ үзүүлэх	Хамгаалах ,нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдсан хүүхэд	тоо	2022	96	100	Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа бүтэн, хагас өнчин хүүхэдтэй 150 өрхийн цахилгааны болон галын аюулгүй байдал, бохирын нүх зэрэгт нөхцөл байдлын үнэлгээг хийн, эрсдэлтэй гарсан 33 өрхөд хүнсний болон бусад дэмжлэг хариу үйлчилгээг, зудын эрсдэл өндөртэй байсан Сайншанд, Айраг, Алтанширээ, Мандах, Даланжаргалан сумын 32 хүүхдэд тус бүр 50,0 мянган төгрөгийн үнэтэй 1,6 сая төгрөгийн амин дэмийн багцын дэмжлэгийг тус тус үзүүлсэн. Түр хамгаалах байраар үйлчлүүлсэн 11 хүүхдэд 10,4 сая төгрөгийн хувцас, хичээлийн ахуйн хэрэглэлийг бэлтгэн өгч, хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээг хүргэсэн. Аймгийн хэмжээний эрсдэлт нөхцөлд байгаа 492 хүүхдийн судалгааг нэгтгэн гаргаж, нөхцөл байдлын үнэлгээг хийх, хариу үйлчилгээг үзүүлэх зэрэг арга зүйн сургалтыг 2 удаа Хамтарсан багийн зөвлөх багш Дуламсүрэнтэй хамтран зохион байгуулсан. 2024 оны байдлаар давхардсан тоогоор 685 хүүхдэд хүүхэд хамгааллын нөхөн сэргээн үйлчилгээг үзүүлж, 48 өрхөд хамтарсан багийн шийдвэрийн дагуу хүнс, хичээл бичиг хэргийн хэрэгсэл, хувцас, түлээ, нүүрсний дэмжлэг үзүүлсэн. Бэлгийн хүчирхийллийн 2, зөрчлийн хэргийн 66 хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр ажиллахын зэрэгцээ 21 хүүхдийн	100%

									мөнгөн тэтгэмжийг хадгаламжийн дансанд барилт хийн, үүргээ биелүүлэхгүй байгаа асран хамгаалагчийн дансанд шилжүүлэхгүй байх арга хэмжээг авч ажилласнаар хүүхдийн эрхийг хамгаалан, эрсдэлийг бууруулан, хяналт тавьж, хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулснаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 28 хувиар өссөн.	
120			Хүүхэд хөгжлийн үйлчилгээ үзүүлэх	Хүүхэд хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхэд	тоо	2022	5797	7000	Хүүхдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх орчныг бүрдүүлэх, хүүхдийн авьяас, оюун билгийг нээх зорилгоор Хүүхэд хөгжлийн төвд англи хэлний сургалтад давхардсан тоогоор 62, шатрын дугуйланд давхардсан тоогоор 95, илтгэх урлаг, мэтгэлцээний дугуйланд давхардсан тоогоор 148, уран нугаралтын дугуйланд давхардсан тоогоор 43 хүүхэд тус тус хичээллэж нийт давхардсан тоогоор 348 хүүхдийг хамруулсан. Хүүхэд, өсвөр үеийнхний техник сэтгэлгээ, урлан бүтээх санал санаачилгыг дэмжих, дэлхийн боловсролтой иргэд бэлтгэх зорилгоор “Боломжийг хүн бүрд” уриатай “Unitel Hub” танхимыг засварлан тохижуулж, инженерчлэлийн суурь мэдлэг олгох анхан шатны робокидын сургалтад 12 удаагийн элсэлт авч 8-14 насны 96 хүүхэд, хоёр дахь шатны робокид-2 сургалтад 2 элсэлт авч 14 хүүхдийг хамруулж нийт 110 хүүхдэд код бичилт болон электроникийн суурь ойлголтуудыг өгсөн. “Зуслангийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх” удирдамж ирсэнтэй холбогдуулан эрсдэлт нөхцөлд болон зорилтот бүлгийн хүүхдийг тэгш хамруулах ажлыг зохион байгуулж Өмнөговь аймгийн “Буянт хотхон” хүүхдийн зусланд 2 ээлжээр зорилтот бүлгийн бага ангийн 75, дунд, ахлах ангийн 75, нийт 150 хүүхдийг, аймгийн Хүүхдийн зусланд 6 дугаар сард 2 шөнө 3 өдрийн сургалт хүмүүжлийн арга хэмжээнд 7 ээлжид 700 гаруй хүүхдийг нийт энэ онд 850 хүүхдийг хамруулсан. Дэлхийн сансрын 7 хоногийн 21 аймагт 2024 оны 10 дугаар сарын 04-09-ны өдрүүдэд “Сансар ба Уур амьсгалын өөрчлөлт” сэдэвтэйгээр зохион байгуулж арга хэмжээнд 1,2,3,5,6 дугаар сургууль болон цэцэрлэгийн 7000 гаруй сурагч, хүүхдүүд оролцсон.	100%

									Өмнөх онтой харьцуулахад хүүхдүүд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, авьяасаа нээн хөгжүүлэх, идэвхжүүлэх, төлөвшихөд чиглэсэн дугуйлан секцэд хамрагдсан хүүхдийн тоо 8200 болж өссөн.	
121			Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх	Төлөвлөгөөний хэрэгжилт	хувь	2022	86	100	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 53 дугаар тогтоолоор баталсан “Хүүхдэд ээлтэй орон нутаг” зорилтот хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд тус байгууллагын хяналтад 6 зорилтын 36 арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан. Тус хөтөлбөрийн хүрээнд Хүүхдийн хөгжил, оролцоо, хамгаалал чиглэлээр зохион байгуулагдсан Монгол Улсын төрийн шагналт, ардын жүжигчин, зууны манлай бүжиг дэглээч Ц.Сэвжидийн нэрэмжит “Өсвөрийн бүжигчдийн улсын XVI” наадам, Яргуй урлагийн наадам, Дорноговь робот-2023, “Шинэ эхлэл” хүүхдийн спортын лигийн тэмцээн, Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллийн эсрэг нөлөөллийн арга хэмжээ, Жаргалан хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа, Хүүхдийн ордны дотоод засвар, үйлчилгээ зэрэг 40 гаруй үйл ажиллагаанд 1,1 тэрбум төгрөгийн төсөв санхүүг шийдвэрлэн санхүүжүүлсэн. Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга, аймгийн Засаг даргын 2024 оны А/647 дугаар захирамжийн хэрэгжилтийн хүрээнд “Хайр хязгааргүй-ялгаагүй” нөлөөллийн аяны хүрээнд 30 удаагийн сургалтад 13000 орчим иргэдийг хамруулан, Хүүхэд хамгааллын тухай хууль, хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр 11 төрлийн зөвлөмжийг 14 сум, 35 байгууллагын цахим, орон нутгийн 2 телевиз, 2 сайтад 4 удаагийн ярилцлагаар иргэд олон нийтэд хүргэсэн.	90%
122			Хүүхдийн өмнө үүрэг хүлээгч бүх шатны байгууллага, албан тушаалтнуудыг	Сургалт арга хэмжээний тоо, хамрагдсан албан тушаалтан	тоо	2022	8 / 450	10 / 450	Хүүхдийн өмнө үүрэг хүлээгч байгууллага, албан тушаалтнуудыг чадавхжуулах зорилгоор байгууллагуудын эцэг эхийн зөвлөлийн гишүүдийн сургалт, сумдын хамтарсан багийн сургалтыг зохион байгуулж аймгийн 32 байгууллага, 14 сумын нийт 118 албан тушаалтан хамрагдсан. Сум, багийн хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлтэй ажиллах чиг үүрэг бүхий хамтарсан	90%

			чадавхжуулах сургалтад хамруулах						багийн гишүүдийг мэргэжил, арга зүйн хувьд нарийн мэргэшүүлэх, кейс менежментийн зарчим, алхмын дагуу чанартай хамгааллын үйлчилгээг хүүхэд, гэр бүлд үзүүлж сургах зорилгоор “Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг хүүхэд гэр бүлийн хөгжлийн төлөө “Галт шувуу холбоо” ТББ-ын гүйцэтгэх захирал, Хүүхэд хамгааллын зөвлөх багш Э.Дуламсүрэнтэй хамтран аймгийн 27 хамтарсан багийн 81 гишүүнийг хамруулсан сургалтыг зохион байгуулсан. Сургалтын үр дүнд кейс менежментийн үйлчилгээний үе шатын дагуу хохирогчдод хамгааллын үйлчилгээг үзүүлэх талаар нэгдсэн ойлголттой болж, хамтарсан багийн гишүүд нотлох баримтыг хэрхэн бүрдүүлэх, хүүхдийн эсрэг хүчирхийлэл болон гэр бүлийн хүчирхийлэлтэй ажиллахад шаардлагатай маягт дээр ажиллаж сурсан. “Дэлхийн зөн Монгол” Олон улсын байгууллагаас "Зудын яаралтай хариу арга хэмжээ 2" төслийг хэрэгжүүлж Айраг, Алтанширээ, Иххэт, Даланжаргалан, Дэлгэрэх сумдын хамтарсан багийн 30 гишүүдэд "Гамшгийн үеийн жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэхэд хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалт"-ыг зохион байгуулж гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, орон нутгийн түвшинд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамтарсан багаас үзүүлэх кейс менежментийн үйл явцыг танилцуулснаар гамшиг онцгой үеийн хүүхэд хамгааллын үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд арга зүйг олголоо. Нийт хүүхдийн өмнө үүрэг хүлээгч бүх шатны байгууллага, албан тушаалтнуудыг чадавхжуулах 123 төрлийн сургалт зохион байгуулж 4500 гаруй иргэд хамрагдсан.	
123			"Яргуй-2024" наадмыг зохион байгуулах	Наадамд оролцсон хүүхдийн тоо, зарцуулсан төсөв	тоо	2022	0	1 / 500	Аймгийн Засаг даргын 2024 оны А/425 дугаар захирамжаар хүүхэд, өсвөр үеийнхний урлагийн авьяас чадварыг хөгжүүлэх, шинэ авьяастан төрүүлэх, урын санг баяжуулах, урлагаар дамжуулан хүүхэд багачуудад гоо зүйн хүмүүжил төлөвшил олгох зорилгоор Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан, Боловсролын тэргүүний	100%

									ажилтан Эрдэнэжаргалын Баярсайханы нэрэмжит 32 дахь удаагийн аймгийн “Яргуй-2024” хүүхдийн урлагийн их наадмыг 2024 оны 05 дугаар сарын 08-11-ний өдрүүдэд аймгийн Хүүхдийн ордонд гоцлол хөгжим, хамтлаг хөгжим, гоцлол дуу, хамтлаг дуу, гоцлол бүжиг, хамтлаг бүжиг, чөлөөт номер зэрэг 7 төрлөөр ерөнхий боловсролын 9-12 жилийн 20 сургууль, хүүхэд хөгжлийн 4 сургалтын төвийн нийт 1024 хүүхэд хамруулан зохион байгуулсан. Нийт 47,0 сая төгрөгийн төсөв зарцуулсан.	
124			Аймгийн Хүүхдийн чуулганыг зохион байгуулах	Чуулганд оролцсон хүүхэд	тоо	2022	0	1 / 300	Аймгийн 14 сумын 21 сургуулийн сурагчдад сургуулийн орчинд зөрчигдөж буй хүүхдийн эрх хамгааллын талаар багийн болон өртөөчилсөн сургалтаар дамжуулан шийдлийг олох замаар бодит оролцоог хангаж өөрийн үзэл бодлоо эрхэмлэх, нэр төрөө хамгаалах, бусдын эрхэд хүндэтгэлтэй хандах, нийт сурагчдын өмнөөс дуу хоолой болон үйлдэл хийхэд бэлтгэж хариуцлагатай иргэнийг бэлтгэх зорилгоор сурагчдад хүүхэд хамгаалал нэр төр өөрийн үнэ цэнийг эрхэмлэх талаар мэдлэг, мэдээлэл олгох. Хэлэлцүүлэг болон 3 төрлийн өртөөчилсөн сургалтын аргаар асуудлыг танин мэдүүлж бодитой хэрэгжихүйц шийдэл боловсруулах. Хүүхдийн оролцооны төвлөрсөн сүлжээ байгуулж төлөөлөл сурагчдын оролцоог тогтворжуулах. Хэн ч биш ч и л өөрчилнө” хүүхдийн чуулга уулзалт 2024 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр Сайншанд хотын Хүүхдийн ордонд зохион байгуулж 85 хүүхдийн оролцоотойгоор хийсэн. Сургалтын үр дүнд оролцогч хүүхдүүд багаар ажиллах чадварт суралцаж өөрсдийн оршин суугаа газарт тулгамдаж буй хүүхдийн эрх хамгаалалтай холбоотой асуудлуудыг хэлэлцэж микро түвшинд шийдлийг боловсруулан, хэрэгжүүлэх үе тэнгийн найз нөхдөдөө зөв үлгэр дуурайлал болох ба хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх талаар чиглүүлэг авч үйл ажиллагаа зохион байгуулах зэрэг чадваруудыг эзэмшсэн.	100%
125	Хүүхдийн эрхийн		ААН байгууллагууд	Хяналт шалгалт	тоо	2022	20	67	ХНХЯ-ны харьяа Салбарын хяналтын газрын даргын баталсан төлөвлөгөөт болон урьдчилан	90%

	баталгааг 1 хувиар сайжруулн а.	Нийгмийн хөгжил хөтөлбөр	ад хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах						сэргийлэх шалгалт хийх тухай удирдамжуудын дагуу ААН байгууллагуудад хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хяналт шалгалтын ажлыг аймгийн ХГБХХГ, ХХҮГ, ЭМГ-тай хамтран 23 аж ахуйн нэгж байгууллагад төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн. Шалгалтаар 8 байгууллага 25 ба түүнээс дээш ажилтантай байсан бөгөөд үүнээс 6 аж ахуйн нэгж байгууллага нь хуулийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулж байна. Харин хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй, мөн хуульд заасан төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийн санд төлөөгүй 2 байгууллагад 23,7 сая төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийн санд нөхөн төлүүлэх тухай улсын байцаагчийн 2024 оны 2 удаагийн актыг хүргүүлж улсын орлогод 13,2 сая төгрөг төвлөрүүлсэн байна. Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын Хөдөлмөрийн хяналтын Улсын байцаагчтай хамтарсан хяналт шалгалтыг 2 хүнд үйлдвэрийн газар, 5 уул уурхай, 3 барилга байгууламж, 1 хүүхдийн паркийн үйл ажиллагаанд хийж, ажил олгогчдод Хөдөлмөрийн тухай хууль, Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтын талаар мэдээлэл өгч, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар зөвлөгөө өгсөн. Иргэдээс ирсэн хүүхдээр хөдөлмөр эрхлүүлсэн гэх 1 иргэний гомдлыг Зөрчлийн тухай хуулиар шалган шийдвэрлэж, тухайн иргэнд 500,0 мянган төгрөгийн торгуулийн шийтгэл оногдуулж хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан. Аймгийн Засаг даргын 2024 оны А/799 захирамжийн хүрээнд 13 сумын 72 ААНБ-д улсын үзлэгийг зохион байгуулж, хяналт шалгалтын хүрээнд 72 байгууллагад зөвлөмж хүргүүлсэн. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зөвлөлийн жилийн ажлын төлөвлөгөө 95%, сарын аяны төлөвлөгөө 90%-н хэрэгжилттэй байна.	
126			Уралдаанч хүүхдийн эрх ашгийг	Стандарт ын хэрэгжилт	хувь	2022	99	100	Орон нутаг болон бүсийн хурдан морины уралдаан болон сунгаа, уралдааны бэлтгэлийн үеэр хүүхдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах,	100%

			хамгаалах талаар холбогдох хууль эрх зүйн хэрэгжилтийг хангах						хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 02/1038 тоот албан бичгээр 14 сумын Засаг дарга нарт зөвлөмж, Уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангах үүднээс Хүүхдийн эрхийн Улсын байцаагчийн 1 зөвлөмж, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2024 оны 03/05 тоот чиглэлийг 14 сумын Засаг дарга, Хүүхдийн төлөө зөвлөлд хүргүүлэн хяналт тавьж ажилласан. Сайншанд, Мандах сумын ЗДТГ-аас зохион байгуулсан "Малчдын нэгдсэн зөвлөгөөн-2024" арга хэмжээнд 270 малчин иргэдэд Засгийн газрын 57 дугаар тогтоолыг танилцуулан, хориглосон хугацаанд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээг зохион байгуулахгүй байх, тогтоолыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар мэдээлэл хүргэсэн. Тогтоолыг зөрчиж, насанд хүрээгүй хүүхдээр морь унуулсан гэх гомдол мэдээллийн дагуу Зөрчлийн 2 хэргийг шалган, Хатанбулаг сумын 8 иргэнд Зөрчлийн тухай хуулиар мөнгөн торгуулийн арга хэмжээ авч, хариуцлага хүлээлгэсэн. "Хутагтын хурд 2024" хурдан морины уралдаанд 102 хүүхэд, 159 морь бүртгэгдсэнээс 92 хүүхэд, 150 морь уралдаанд гарч хөнгөн бэртэл авсан 2 хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээнд холбон зуучилсан. Аймгийн болон 14 сумын баяр наадмаар 1017 хүүхэд, 2097 морьд гараанд гарч хөнгөн бэртэл авсан 5 хүнд бэртэл авсан 2 хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээнд шуурхай холбон зуучилж үйлчилгээ үзүүлсэн. Унаач хүүхдийн бүртгэл, даатгал, гэрээ, хувцаслалтад 100% хяналт тавьж, стандартыг бүрэн хэрэгжүүлсэн.	
127	Гэр бүлийн эерэг харилцааг бэхжүүлнэ	Нийгмийн хөгжил хөтөлбөр	Гэр бүлийн боловсролын үйлчилгээ үзүүлэх	Үйлчилгээнд хамрагдсан гэр бүл	тоо	2022	45	79	"Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль"-ийн хүрээнд хүүхдийн эрхийн зөрчил, гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийлэл, "Асран хамгаалагчийн үүрэг, хариуцлага, хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон хүмүүжлийн эерэг арга, угийн бичиг хөтлөхийн ач тусын талаар Сайншанд сумын 1500 гаруй иргэдэд мэдээлэл өгсөн. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын дарга, Хил хамгаалах ерөнхий газрын дарга нарын хамтран	90%

									баталсан 2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу Эрдэнэ сумын Хилийн цэргийн 0129 дүгээр ангийн нийт бие бүрэлдэхүүн, алба хаагч нарт эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэг оролцоо, хүүхдийн хөгжил, оролцоо, гэр бүлийн харилцаа, харилцаанд нөлөөлөх хүчин зүйлс зэрэг сэдвээр сургалт мэдээлэл хүргэж албан хаагчид, хугацаат цэргүүдэд бүлгийн ярилцлага хийн, гэр бүлийн хосуудад хосын карт ажиллуулах арга хэмжээг зохион байгуулсан. Аймгийн Шүүхийн Тамгын газартай хамтран гэр бүлийн эвлэрүүлэн зуучлалын сэтгэл зүйчийн уулзалтыг зохион байгуулан, 12 гэр бүлийг мэргэжлийн сэтгэл зүйчтэй уулзуулсан. Гэр бүлийн асуудлаар маргаантай 6 өрхөд шинжээчийн дүгнэлтийг гарган Шүүхэд хүргүүлэн ажилласан. Гэр бүлийн боловсролын 4 удаагийн 10 төрлийн сургалтад 50 гэр бүлийг хамруулан эцэг эх асран хамгаалагч нарт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, хосын эерэг харилцаа, хүүхэд хүмүүжлийн эерэг аргыг түгээсэн. Энэ онд гэрлэхийн өмнөх боловсрол олгох зорилгоор шинээр гэр бүлээ батлуулсан 14 хосод гэр бүлийн тухай хууль, жендерийн тэгш байдлын талаар зөвлөгөө өгсөн.	
128		Сайншанд сумын 1,7 дугаар багт тоглоомын талбай байгуулах	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Сайншанд сумын 1 дүгээр багт тоглоомын талбай байгуулах ажлыг орон нутгийн төсвийн 74.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Айсуй хөгжил" ХХК гүйцэтгэж 9 дүгээр сард ашиглалтад оруулсан. Сайншанд сумын 7 дугаар багт тоглоомын талбай байгуулах ажлыг орон нутгийн төсвийн 71.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Эгнэгт Өрнөх" ХХК гүйцэтгэж дууссан захиалагч, зохиогчийн хяналт хэрэгжүүлсэн байгууллагаас нэгдсэн дүгнэлт гарсны дараа ашиглалтад оруулах комисс ажиллахаар хүлээгдэж байна.	90%	
129		Үр хүүхдээ эсэн мэнд өсгөн бойжуулсан гэр бүлийн	Сайн туршлага хуваалцсан гэр бүл	тоо	2022	5	14	Дэлхийн гэр бүлийн өдрийг тохиолдуулан Хатанбулаг сумын Соёлын төвөөс нутаг усандаа ажиллаж амьдарч байгаа гэр бүл, ураг удмыг сурталчлан таниулах зорилгоор "Алтан ургийн хэлхээ" спортын нэгдсэн арга хэмжээ, Эрдэнэ	90%	

			туршлагыг нийтэд сурталчлах						суманд "Монгол гэр бүл" спортын тэмцээн зохион байгуулж нийт 27 гэр бүлийн 390 гаруй иргэн хамрагдсан. Сайншанд сумын 10 гэр бүлийн туршлагыг танилцуулах ТВ нэвтрүүлгийг DSB телевизтэй хамтран бэлтгэн олон нийтэд түгээхээр зураг авалтыг эхлүүлсэн.	
130			Залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх	Хөтөлбөр ийн хэрэгжилт	хувь	2023	0	50	Залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөрийг боловсруулахад аймгийн 14 сумын Залуучуудын салбар зөвлөл, аймгийн Залуучуудын холбоонд бичиг хүргүүлж ирүүлсэн саналыг хөтөлбөрийн төсөлд нэгтгэж аймгийн залуучуудын салбар зөвлөлийг хуралдуулан хурлаас гарсан санал, сумдаас ирүүлсэн саналуудыг тусган хэлэлцэж 4 зорилт 16 үйл ажиллагаа бүхий хөтөлбөрийн төслийг боловсруулан заалт арга хэмжээг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны /2024-2028/ оны хөтөлбөрт хэрэгжүүлэхээр төслийн саналд тусгасан.	30%
131			"Говийн дорнын айл" Монгол гэр- ийн онолд суурилсан өрхийн хөгжлийг хувь хүний хөгжлөөр дэмжих хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх	Хөтөлбөр ийн хэрэгжилт	хувь	2023	0	50	"Говийн Дорнын айл" өрхийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулах суурь судалгааг авч хэрэгцээ шаардлагад тулгуурлан хөтөлбөр боловсруулсан. Төсвөөс шалтгаалан 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.	30%
132			Зорилтот 9 гэр бүлийн хуримын ёслолын арга хэмжээг зохион байгуулах	Хуримын ёслолд хамрагдса н зорилтот гэр бүл	тоо	2022	0	9	Аймгийн Соёмбо цогцолборын дэргэдэх Гэрлэх ёслолын ордонд Сайншанд, Даланжаргалан, Хатанбулаг, Алтанширээ сумын нийт 7 хосын хуримын үйл ажиллагааг зохион байгуулсан.	90%
133			Гэр бүлийн хүчирхийлэлтэ	Зохион байгуулса	тоо	2022	45	70	Уламжлал болгон зохион байгуулагддаг Олон улсын гэр бүлийн өдөр, Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг өдөр, Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах	90%

			й тэмцэх, сэргийлэх	н арга хэмжээ					өдөр зэрэг тэмдэглэлт өдрүүдийг Хүүхдийн эрхийг дээдэлъе, гэр бүлийн дундах эерэг харилцааг нэмэгдүүлэх нь, Гэртээ эрт харья уриалгын хүрээнд спортын арга хэмжээ, гар зургийн уралдаан, хүүхдийн чуулган, гэр бүлийн уулзалт ярилцлага, “Гэртээ эрт харья” цахим челленж зэрэг 43 төрлийн нөлөөллийг ажлыг зохион байгуулан давхардсан тоогоор 1500 иргэнийг хамруулсан. Хүүхэд хүмүүжлийн эерэг арга, гэр бүлийн хосуудын харилцан ойлголцол, бат бэх байдлыг дэмжих нь, амьдрах ухааны, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн байгууллагын албан хаагч болон иргэд рүү чиглэсэн 78 удаагийн сургалтад нийт 2900 иргэн, Хүүхдийн эрх, хамгааллын тухай хуулиар хүлээсэн эцэг, эх, асран хамгаалагчийн үүрэг, хариуцлага, гэр бүлийн үнэ цэнэ зэрэг 44 төрлийн гарын авлагыг бэлтгэж 3305 өрхөд хүргэсэн. Нийт 123 төрлийн сургалт, арга хэмжээнд 4500 гаруй иргэнийг хамруулсан. 44 төрлийн гарын авлагыг 3305 иргэнд хүргэсэн. Өмнөх оноос гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээнд хамрагдсан хүний тоо 2.1 хувиар өссөн.	
134			Архины хамааралтай гэр бүлд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээ	тоо	2022	213	202	Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссоос "Гэр бүлийн хүрэн дэх жендер ба хүний эрхийн асуудал" сэдвээр Улсын Их Хуралд 23 дахь илтгэлийг боловсруулж буй ажлын хүрээнд байнгын хүчирхийлэлтэй гэр бүлийн тоо, байнгын архины хамааралтай гэр бүлийн тоо, орон гэргүй хүн (хүйсээр) болон гэр бүлийн тоог сум тус бүрээр гаргаж судалгаанд үндэслэн, “Бүтээлч тархи”, "Говийн хөх салхи" НҮТББ-тэй хамтран Сайншанд, Айраг, Замын-Үүд сумдад 3 удаагийн сэтгэл зүйн зөвлөгөө, 6 удаагийн бүлгийн ярилцлага зохион байгуулж, архины хамааралтай 350 иргэнд ургалт нөлөөллийн арга хэмжээг хүргэсэн. Сайншанд сумын 4 дүгээр багийн архины хамааралтай байнгын бага насны 2 хүүхдээ үл хайхардаг 1 иргэнийг харьяа хамтарсан багтай хамтран ажиллаж, ажлын байранд зуучлан, хүүхдүүдийг боловсролын болон	70%

									зуслангийн үйлчилгээнд хамруулахын зэрэгцээ гэр бүлд нь эргэн нэгтгэн, байнгын эргэлт хяналтыг зохион байгуулан ажилласан.	
135			Хүчирхийллийн хохирогч иргэдэд Түр хамгаалах байраар үйлчилгээ үзүүлэх	Түр хамгаалах байраар үйлчлүүлсэн иргэн	тоо	2022	57.0	65.0	Аймгийн хэмжээнд 2 түр хамгаалах байраар нийт 19 насанд хүрээгүй иргэнийг буюу бэлгийн хүчирхийллийн 3, үл хайхрах хүчирхийллийн 11, бие махбодын хүчирхийллийн улмаас хохирсон 1, насанд хүрсэн 2 хохирогчийг хүлээн авч, хууль эрх зүйн зөвлөгөө, өмгөөлөл, эрүүл мэнд, боловсрол, сэтгэл зүйн үйлчилгээ, харуул хамгаалалт, хоол хүнс, ахуйн хэрэглээг хангахад 87,0 сая төгрөгийг зарцуулсан. Түр хамгаалах байраар хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ авсан нийт хүүхдүүдийн 97.8 хувь нь гэр бүлдээ эргэн нэгтгэгдэж хэвийн орчинд амьдрах нөхцөл бүрдэхийн зэрэгцээ гэр бүлийн орчин дахь эрсдэл буурсан бөгөөд байнгын эргэлт хяналтыг тавьж хэвшсэн. Одоо түр хамгаалах байраар үл хайхрах хэлбэрийн хүчирхийллийн хохирогч 2 хүүхэд үйлчлүүлж байна.	100%
136	Эрүүл, идэвхтэй ахмад настныг 20 хувиар нэмэгдүүлнэ.	Нийгмийн хөгжил хөтөлбөр	Ахмад настуудад эрүүл мэнд (гериатр), сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх	Гериатр эмч, сэтгэл зүйн үйлчилгээнд хамрагдсан ахмад	тоо	2022	1576	2500	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг үзүүлэхээр магадлан итгэмжлэгдсэн 2 байгууллага буюу аймгийн "Ахмадын хороо" ТББ, Улаан загалмайн хороонд тус бүр 1 удаа үйлчилгээний журам болон шалгуурын талаар зөвлөгөө мэдээлэл өгсөн. "Ахмадын өдрийн үйлчилгээ", "Зөвлөгөө өгөх үйлчилгээ"-г Ахмадын хороогоор гэрээлэн гүйцэтгүүлж Замын-Үүд, Өргөн, Эрдэнэ, Сайншанд сумын 111 ахмадыг хамруулан улсын төсвөөс батлагдсан хуваарийн дагуу 11,9 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Үйлчилгээг өмнөх жилүүдэд зөвхөн Сайншанд суманд зохион байгуулж байсан бол энэ удаа бусад сумын ахмадуудыг хамруулж хүртээмжийг нэмэгдүүлсэн давуу талтай байв.	100%
137				Ажиллаж байгаа мэргэжлийн эмч	тоо	2022	0	1	Ахмад настны хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоог дэмжихээр Говийн бүсийн ахмад настны төрөлжсөн асрамжийн газар болон ахмадын "Төвшин сайхан" амралтын газарт өндөр насны тэтгэвэрт гарсан 2 эмчийг үндсэн орон тоогоор ажиллуулж байна.	100%

138			Говийн бүсийн төрөлжсөн асрамжийн үйлчилгээг үзүүлэх	Асрамжийн үйлчилгээнд хамрагдсан ахмад	тоо	2022	20	60	“Говийн бүсийн ахмад настны төрөлжсөн асрамжийн газар”-ыг улсын төсвийн 2,6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар барьж, орон нутгийн төсвийн 108,6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар орчин үеийн шаардлагатай тоног төхөөрөмжөөр ханган 2024 оны 10 дугаар сарын 06-ны өдөр ашиглалтад оруулан, ахмадуудыг хүлээн авсан. Тус асрамжийн газарт 19 асруулагч асруулж байгаа бөгөөд 2024 онд шинээр 8 асруулагчийг холбогдох журмын асрамжийн үйлчилгээнд хамруулсан. Нийт асруулагчдаас оролцооны бүлгийн 5 ахмад, шилжилтийн бүлгийн 6 ахмад, бие даах чадваргүй 8 ахмад байдаг бөгөөд тус бүрд тохирсон хөгжлийн ажлын болон эрүүл мэндийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж чадамжийг бууруулахгүй байхад анхааран ажиллаж байна. Салбар дундын уялдаа холбоог сайжруулах ажлын хүрээнд асруулагч ахмадуудад чиглэсэн үйлчилгээ үзүүлэхэд анхаарч АШУҮИС-ийн Дорноговь дахь салбар, Уламжлалт Анагаах ухааны төв, Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эмнэлэг, Саран хөхөө театр, Ахмадын холбоо, Үсчин гоо сайханчдын холбоо зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран 25 удаагийн үйл ажиллагааг зохион байгуулсан. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад асруулагч ахмадын тоо 4-өөр нэмэгдсэн.	100%
139			Ахмадын сувиллын үйл ажиллагаа явуулах	Сувиллаар үйлчлүүлсэн ахмад	тоо	2022	0	100	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын дэргэдэх "Төвшин сайхан" амралтын газар амрагчдыг 2024 оны 5 дугаар эхлэн 7 хоног бүр хүлээн авч байна. Уг амралтын газрын 7 хоногийн төлбөр иргэнээс 56,0 мянган төгрөг, нийгмийн халамжийн сангаас 245.0 мянган төгрөгийн хөнгөлөлт үзүүлж нийт 301,0 мянган төгрөгийн зардлаар 1 иргэнийг амрааж байгаа бөгөөд үйл ажиллагаагаа тогтмол явуулж эхэлснээс хойш 9 ээлжийн 926 ахмадад үйлчилгээ үзүүлж улсын төсөвт 278,7 сая төгрөгийг төвлөрүүлсэн. Мөн амралтын газрын үйл ажиллагааг сайжруулах, салбар дундын уялдаа холбоог хангаж аймгийн Эрүүл мэндийн газар, Биеийн тамир спортын газар,	100%

									Сайншанд сумын Захирагчийн ажлын албатай хамтран эрүүл мэнд, дасгал хөдөлгөөн, спорт болон автобусаар үйлчлэх зэрэг үйлчилгээг хүргэн ажиллаж байна.	
140			Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг үзүүлэх	Зөвлөх үйлчилгээнд хамрагдсан ахмад	тоо	2022	10	12	Хөдөлмөр эрхлэлтийн "Түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагаа"-ны Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ арга хэмжээнд Айраг, Алтанширээ, Даланжаргалан Замын-Үүд, Сайншанд сумын 6 байгууллагад ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг үзүүлэн 6 ахмадыг түр ажлын байраар хангаж нийт 5,1 сая төгрөгийн санхүүжилт олгохоос 2,0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон бөгөөд 3,1 сая төгрөгийн санхүүжилт хүлээгдэж буй төлөвтэй байна.	90%
141			Ахмадын хөгжлийн үйлчилгээ үзүүлэх	Үйлчилгээнд хамрагдсан ахмад	тоо	2022	3579	4500	Ахмад настны тухай хуульд заасан хөнгөлөлт тусламжийн үйлчилгээнд хамрагдах иргэдийн хүсэлтийг цахим системээр дамжуулан хүлээн авч 6675 иргэний хүсэлтийг шийдвэрлэн 715,8 сая төгрөгийг улсын төсвөөс олгосон. Өмнөх оны мөн үеэс үйлчилгээ авсан ахмадын тоо 64,5%-иар нэмэгдсэн байна. Үйлчилгээний төрлөөр задалбал: харьяалалгүй 3868 ахмад настанд 75,8 сая төгрөг, рашаан сувилал болон амралт сувиллын хөнгөлөлт 1905 ахмадад 428,3 сая төгрөг, ортопед протез тусгай хэрэгслийг 728 ахмадад 165,9 сая төгрөг, оршуулгын тэтгэмж 10 ахмадад 20,0 сая төгрөг тус тус олгосон. Үйлчилгээг журамд заасны дагуу нарийн мэргэжлийн эмчийн тодорхойлолт болон Эмнэлэг хяналтын комиссын шийдвэрийг үндэслэн үзүүлж байна.	100%
142			Хувиараа хөдөлмөр эрхэлдэг ахмадуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх	Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан ахмад	тоо	2022	5	8	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан "Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа"-ны ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгийн зар мэдээг Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын цахим хуудас, орон нутгийн телевиз болон бусад мэдээллийн сувгуудаар 4, 9 сард 2 удаа 21 хоногийн хугацаатай иргэд олон нийтэд хүргэж, тайлант хугацаанд 49 төслийг хүлээн авсан. Нийт ирүүлсэн төслөөс ажлын	100%

									хэсгийн хурлаар 9 сумын 28 ахмадын төслийг дэмжиж 208.8 сая төгрөгийн хүүгүй, барьцаагүй, 24 сарын хугацаатай санхүүгийн дэмжлэг олгож 28 ажлын байр бий болгож өрхийн орлогыг нэмэгдүүлсэн.	
Салбарын үр дүн 4.2: Нийгмийн халамжийн зорилтот бүлгийн иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлнэ.										
143	Зорилтот бүлгийг хэрэгцээнд нийцсэн нийгмийн халамжийн үйлчилгээнд бүрэн хамруулна	Нийгмийн халамж хөтөлбөр	Нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх	Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэд	тоо	2022	22768	22000	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж хөнгөлөлтөд хамрагдах хүсэлт гаргасан 9979 иргэний хүсэлтийг хүлээн авч хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэсэн. Тайланд хугацаанд нийт 26574 хүүхдэд 26,605.9 сая төгрөгийн хүүхдийн мөнгөн тэтгэмж, 25084 иргэнд 13,231.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 44 иргэнд 56,4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс зарцуулж тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт олгосон. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нийт тэтгэвэр, тэтгэмж, тусламж хөнгөлөлтөд хамрагдсан хүний тоо 1775-аар, зарцуулсан мөнгөн дүн 1,9 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.	100%
144			Нийгмийн халамжийн үйлчилгээнд ISO нэвтрүүлэх	Нэвтрүүлсэн үйлчилгээ	тоо	2022	0	60	"Чанарын менежментийн тогтолцоо"-г байгууллагад 2021 оноос хойш үе шаттай нэвтрүүлэн нийгмийн халамжийн үйлчилгээг ISO стандартаар тухай бүрд иргэдэд үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Иргэдийн итгэлийг хүлээсэн үйлчилгээний соёл төлөвшүүлэх хүрээнд аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын угтах үйлчилгээний танхим хэсэгт албан хаагчдын үйлчилгээ үзүүлэх чиглэл, өрөө болон цонхны дугаар бүхий киоск машин байрлуулж 13200 иргэнд үйлчилгээ үзүүлсэн. Мөн иргэдэд үйлчилгээг ойртуулах, хүссэн газраасаа нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, тусламж хөнгөлөлтөд хамрагдах боломжийг бүрдүүлэх цахим системд нийгмийн халамжийн 64 нэр төрлийн үйлчилгээ, emongolia аппликейшнд 11 төрлийн үйлчилгээг шилжүүлсэн. Өмнөх оны эцэстэй харьцуулахад киоск төхөөрөмжөөр дамжуулан үйлчилгээ үзүүлсэн хүний тоо 5757-оор, emongolia аппликейшнд шилжүүлсэн үйлчилгээний тоо 7-оор тус тус нэмэгдсэн.	100%

145			Иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг жилд нэг удаа тогтмол хийх	Судалгаа нд хамрагдсан хүн	тоо	2022	376	1250	Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын үйл ажиллагаа, төрөөс явуулж буй бодлого шийдвэр, үйлчилгээг албан хаагчид иргэдэд хэр хүртээмжтэй, нээлттэй хүргэж байгаа талаар үйлчилгээний чанараа сайжруулах зорилгоор үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг 11 асуумжаар 330 иргэнээс цахим болон цаасаар авч ажилласан. Судалгаанд хамрагдсан иргэдийн 32.6% нь цахим системийг ашиглаж чадахгүй байгаа гэж хариулсантай холбогдуулан байгууллагын вэб сайтад ehalamj.mn, ejob.gov.mn ашиглах зааврыг байршуулж иргэд, олон нийтэд ойлгомжтой байдлаар хүргэн ажиллалаа. Мөн хөдөлмөр, халамжийн салбарт хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, мэдээлэл хэр ил тод, нээлттэй байгаа талаарх асуултад 30.7 хувь нь дунд, 9.0 хувь нь хангалтгүй, мэдэхгүй гэсэн хариултыг өгсөн байна. Байгууллагын үйл ажиллагаа, төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого, шийдвэрийг сурталчлан таниулах, ил тод, иргэдэд нээлттэй ажиллахад анхаарч байгууллагын вэб сайтад төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, сайтыг шинэчлэн, аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар пэйж хуудас нээж мэдээллүүдийг шуурхай хүргэж ажиллаж байна. Мөн DTV хамтран мэдээллийг олон нийтэд хүргэлээ.	90%
146		Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	ХБИ-ийг хөдөлмөр эрхлүүлэх талаар холбогдох хуулийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах	ХБИ шинээр авч ажиллуулсан байгууллага	тоо	2022	3	5	Хөдөлмөрийн тухай хуулийн 144-р заалтад заасан Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулаагүйн төлбөр, төлбөрөөс хөнгөлөгдөх Засгийн газрын 293-р тогтоолыг нийт 42 албан байгууллага, 23 уул уурхайн компани, 30 тээврийн үйлчилгээний аж ахуй нэгжид сурталчлан нөлөөллийн арга хэмжээг аймгийн ХХҮГ, Нийгмийн даатгалын газар, Нэгдсэн эмнэлэг, Авто тээврийн төв, Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв, Зам тээвэр хөгжлийн яамны албан хаагчтай хамтран зохион байгуулсан. Хуулийн хэрэгжилтийг хангуулахын тулд 11 байгууллагаас 170.1 сая	100%

									төгрөгийн төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлсэн.	
147			ХБИ-д сургалт мэдээлэл, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах, хөтөлбөрт хамруулах	Сургалт сурталчилгаанд хамрагдсан иргэдээс ажлын байраар хангагдсан ХБИ	тоо	2022	24	30	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль тогтоомж, шийдвэрийг сурталчлан таниулах зорилгоор “Халамжаас хөдөлмөрт-222” арга хэмжээгээр дамжуулан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх оролцоо” сэдэвт сургалтыг зохион байгуулж 158 хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулсан. Мөн “Эрүүл мэндийн магадлал, хөдөлмөр эрхлэлт, халамжийн үйлчилгээ, эрүүл мэнд” өдөрлөгөөр дамжуулан 450 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг тэгш хамруулан сургах, спортоор дамжуулан хөгжүүлэх, авьяас чадварыг зорилгоор Ерөнхий боловсролын сургууль болон цэцэрлэгийн захирал, эрхлэгч биеийн тамирын багш, нийгмийн ажилтан, эмч, эцэг эх, асран хамгаалагч нарт “Family health forum” сургалтыг зохион байгуулсан. Уг сургалтад эцэг эх, асран хамгаалагч, боловсролын байгууллагын 65 төлөөлөл, 17 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд оролцсон бөгөөд тус сургалтын үеэр Монголын Тусгай Олимпын хорооноос хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдэд хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг хамруулах, спортын тэмцээн уралдаан, арга хэмжээг хамтран зохион байгуулах оюуны бэрхшээлтэй хүүхдүүдийг ердийн хүүхдүүдтэй хамт спортоор хичээллүүлэх, тэдний дэмжин тоглогчийг бэлтгэх, талаар Ерөнхий боловсролын Нэгдүгээр сургуультай “Хамтарсан сургууль”-ийн санамж бичиг байгуулан тусгай олимпын төрөл болох шалны хоккей, боче зэрэг спортоор хичээллэх сонирхолтой хүүхдийг бүртгэсэн. Эдгээр хүүхэдтэй ажиллах багшийг 6 дугаар сард Тусгай олимпын хороонд бэлтгэсэн бөгөөд 4 хүүхдийг бочегийн сургалтад хамруулж байна. Аймгийн хэмжээнд тэргэнцэр шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн судалгааг гарган хүмүүнлэгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын санхүүжилттэй	100%

									байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор “Дезерет” олон улсын байгууллагад 50 иргэн, Австралийн Ротари клубт байнгын асаргаатай 7 хүүхдэд тэргэнцэр шаардлагатай байгаа талаар хүсэлт гаргасны дагуу тус байгууллагуудаас тэргэнцэр олгож нийгмийн амьдралд хэвийн оролцох боломж нөхцөлөөр хангасан. Мөн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа”-нд давхардсан тоогоор 81 иргэнийг хамруулснаас аж ахуй эрхлэлтийн сургалтад 38 иргэн, 50 хувийн эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэгт 16, мэргэжлийн ур чадварыг богино хугацаанд олгох танхимын сургалт болон хоол, унааны хөнгөлөлтөд давхардсан тоогоор 24, борлуулалтын дэмжлэг арга хэмжээнд 3 иргэнийг хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 128,8 сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан.	
148		Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Асран хамгаалагчийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	Дэмжлэгт хамрагдсан хүн	тоо	2022	12	35	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2024 онд хэрэгжүүлж буй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа”-ны хүрээнд байнгын асаргаа шаардлагатай хүнийг асарч буй 7 иргэнийг зээлийн өмнөх аж ахуй эрхлэлтийн сургалтад, 5 иргэн танхимын сургалт, 4 иргэн санхүүгийн дэмжлэгт хамрагдаж 32,0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн. Өмнөх оноос дэмжлэгт хамрагдсан иргэн 2-нэмэгдсэн байна. Нийгмийн халамжийн сангаас байнгын асаргаа шаардлагатай, хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон хүүхэд асарч байгаа 512 иргэнээс 291 иргэн, ажил хөдөлмөр эрхэлж байна. Өмнөх оны мөн үед 240 асрагч хөдөлмөр эрхэлж байсан бол энэ онд 51 иргэнээр нэмэгдсэн.	100%
149			"Эрүүлжин хөгжих" төвийн үйл ажиллагаа явуулах	Үйлчилгээнд хамрагдсан хүүхэд	тоо	2022	12	20	Сургуульд хамрагдаж чадахгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй, байнгын асаргаа шаардлагатай хүүхдүүдэд сэргээн засах, өдөр өнжүүлэх үйлчилгээ үзүүлэх “Эрүүлжин хөгжих төв”-д хүнд хэлбэрийн эмгэгтэй 9 хүүхдийг асаргааны үйлчилгээнд, 6 хүүхдийг бариа заслын үйлчилгээнд	100%

									тус тус хамруулж байна. 2024 онд төвийн үйл ажиллагаа болон цалингийн зардалд орон нутгийн төсвөөс 125 сая төгрөг батлагдсанаас жилийн эцсийн байдлаар 84,4 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан. Тус төвд хамрагдаж байгаа хүүхдүүдэд өдөр тутам сэргээн засах, бариа заслын үйлчилгээг үзүүлж байгаа бөгөөд үйлчилгээний үр дүнд 5 хүүхдийн бие бялдар, үйл хөдлөл, сэтгэхүйн онцлогт эерэг өөрчлөлт гарч байгаагаас гадна ажил хөдөлмөр эрхлэхгүй байсан 7 асран хамгаалагчаас 4 асран хамгаалагч байнгын ажлын байртай болсон давуу талтай байна. Мөн хөдөө сумдаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахаар ирсэн асран хамгаалагчдыг мөн адил боломжоор хангасан. Өрөө танхимын хүртээмжээс шалтгаалан өдрийн турш байрлуулан асрах үйлчилгээнд хүүхэд нэмэгдээгүй бөгөөд бариа заслын үйлчилгээнд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6 хүүхдийг нэмж хамруулсан. Тус төвийг түшиглэн Улаанбаатар хотын “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв”-ийн мэргэжлийн эмч нарын цогц үзлэгийг орон нутгийн хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас 6,5 сая төгрөгөөр санхүүжүүлэн зохион байгуулж 14 сумын 177 хүүхдийг хамруулж, эцэг эх асран хамгаалагчдад сэргээн засах тусламж үйлчилгээ болон тэгш хамруулах, нийгмийн сэргээн засалтын талаар зөвлөгөө өгч хүүхдийн хөгжлийн талаар туслан зөвлөсөн.	
150	Нийгмийн халамжийн үйл ажиллагаанд хамрагдаж буй 5000 иргэнийг хөдөлмөр эрхлэлтэд шилжүүлнэ.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах	Сургалтад хамрагдсан хүн	тоо	2022	115	155	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан Хөдөлмөрт бэлтгэх үйл ажиллагааны зээлийн өмнөх ба дараах аж ахуй эрхлэлтийн сургалтыг 4, 9 дүгээр саруудад Хөгжлийн шийдэл ТББ-ийн Дорноговь аймгийн BEST хөтөлбөртэй хамтран тус тус зохион байгуулж нийт 168 иргэнийг хамруулан чадавхжуулж 3,2 сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан.	100%
151			Санхүүгийн дэмжлэг олгох	Дэмжлэгт хамрагдсан хүн	тоо	2022	97	100	“Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 01 тогтоолоор батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2024 онд хэрэгжүүлэх санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа”-ны	100%

									хүрээнд 28 ахмадад 208.8 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож 28 ажлын байр, иргэн аж ахуй эрхлэгчид санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээгээр 39 иргэнд 388.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгож байнгын 39 ажлын байр, 16 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 128.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож 16 ажлын байр, малчдыг малжуулах арга хэмжээнд 11 сумын 116 өрхийг хамруулан 928.0 сая төгрөгийн 8385 толгой бог малаар малжуулж 232 ажлын байр буюу нийт 315 ажлын байр бий болгосон.	
152			Түр ажлын байраар хангах	Ажлын байраар хангагдсан хүн	тоо	2022	564	650	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 01 тогтоолоор батлагдсан “Түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагаа”-ны мод тарих арга хэмжээнд 8 сумын 10 төсөл, нийтийг хамарсан ажил арга хэмжээнд 5 сумын 5 төслийг хүлээн авч 50 иргэн, нийтийг хамарсан ажил арга хэмжээнд 434 иргэнийг хамруулж түр ажлын байраар хангасан. /ХЭДС-ын зарлагын гүйлгээг 9 дүгээр сарын 25-наас эхлэн тодорхойгүй хугацаагаар зогсоосноос болж, ХЭДС-аас санхүүжилттэй, хийгдэхээр төлөвлөж байсан ажлууд зогссон бөгөөд 10 сарын 28-нд зарцуулалт хийх эрх нээгдсэн болно. Одоо ажлууд хийгдэж эхлээд байна/	70%
153			Суурь ур чадварын сургалтад хамруулах	Сургалтад хамрагдсан хүн	тоо	2022	178	100	Суурь ур чадварын сургалтыг “Дарь овооны эзэд” ХХК-ийн дэргэдэх сургалтын байгууллагатай гэрээлэн гүйцэтгүүлж хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 35, ажилгүй 15 иргэнийг хамруулж 1,5 сая төгрөгийн санхүүжилтийг хийсэн. /ХЭДС-ын зарлагын гүйлгээг 9 дүгээр сарын 25-наас эхлэн тодорхойгүй хугацаагаар зогсоож, ХЭДС-аас санхүүжилттэй, хийгдэхээр төлөвлөж байсан ажлууд зогссон. 10 дугаар сарын 28-нд зарцуулалт хийх эрх нээгдэсэнээр ажил үргэлжилж байна.	90%
154			Богино хугацааны мэргэжил олгох сургалтад хамруулах	Сургалтад хамрагдсан хүн	тоо	2022	61	65	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаа”-ны танхимын сургалтыг “Нярав” мэргэжлээр Баян нэгүл ХХК-ийн дэргэдэх сургалтын төв, Дарь овооны эзэд” ТББ-ын дэргэдэх сургалтын байгууллагаар	90%

									дамжуулан “Нярав”, “Оёдол” мэргэжлээр хамтран зохион байгуулж, ажилгүй болон ажилгүйдэлд өртөж болзошгүй 42 иргэнийг хамруулсан. Эмэгтэйчүүдэд зориулсан богино хугацааны сургалтыг Сонор сургалтын төвтэй хамтран зохион байгуулж “Бичиг хэрэг-Архив” мэргэжлээр, ажилгүй, ажил хайж буй 20 иргэнийг тус тус хамруулан чадавхжуулсан. /ХЭДС-ын зарлагын гүйлгээг 9 дүгээр сарын 25-наас эхлэн тодорхойгүй хугацаагаар зогсоосноос болж, ХЭДС-аас санхүүжилттэй, хийгдэхээр төлөвлөж байсан ажлууд зогссон бөгөөд 10 сарын 28-нд зарцуулалт хийх эрх нээгдсэн болно. Одоо ажлууд хийгдэж эхлээд байна/	
155			Сургалтуудад хамрагдсан иргэдийг ажлын байранд зуучлах	Зуучлагдсан иргэн	тоо	2022	50	55	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаа”-нд хамрагдсан иргэдээс 55 иргэн санхүүгийн дэмжлэгт хамрагдаж 55 ажлын байр, 11 иргэн ажлын байранд зуучлагдаж, 4 иргэн оёдлын чиглэлээр, 1 иргэн бусад чиглэлээр хувиараа хөдөлмөр эрхэлж байна.	100%
Салбарын үр дүн.5.1.Хүнсний аюулгүй байдлыг 7.6 хувиар сайжруулна.										
156	Гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний дотоодын хангамжийг 3 хувиар нэмэгдүүлнэ.	Хүнс хөтөлбөр	Орон нутгийн хүнс, хөдөө аж ахуй эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг улс бүсийн үзэсгэлэн худалдаанд дэмжин оролцуулах, сурталчлах	Үзэсгэлэн худалдаанд оролцогчид	тоо	2022	2	10	Орон нутгийн хүнс, газар тариалан, өрхийн болон жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулах зорилгоор “Цагаан сар-2024”, “Намрын ногоон өдрүүд-2024” үзэсгэлэн худалдааг Сайншанд суманд зохион байгуулж 14 сумын давхардсан тоогоор 302 иргэн, аж ахуйн нэгж оролцож 337,9 сая буюу өнгөрсөн оноос 117.9 сая төгрөгөөр илүү борлуулалт хийсэн. “Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл” улсын нэгдсэн арга хэмжээнд “Далт мөнгөн шанд” ХХК нь ургамлын гаралтай “Загсгал цай”-аар оролцож, “Говийн бүсийн шилдэг аж ахуйн нэгж”-ээр шалгарсан. Монгол Улсын Зэвсэгт хүчин, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Ардын чөлөөлөх армийн Хуурай замын цэргийн хамтарсан “Талын түнш-2024” хээрийн сургууль, Хоёр улсын нутаг дэвсгэрт ээлжлэн зохион байгуулагддаг “Талын түнш-2024” хамтарсан хээрийн сургуулийн үеэр аймаг орон нутагт үйл	100%

									ажиллагаа явуулдаг өрхийн болон бичил, жижиг дунд үйлдвэр эрхлэгч 15 иргэн ААН-ийг оролцуулж бараа бүтээгдэхүүнийг таниулан сурталчилснаар 5.8 сая төгрөгийн борлуулалт хийсэн. “Шинэ-Хоршоо” хөдөлгөөний хүрээнд улс, бүсийн 3 арга хэмжээнд орон нутагт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний үзэсгэлэнг гаргаж “Өөлий урлан”, “Мондо урлан”, “Chimivie fashion”, “Эсгий урлал” зэрэг бичил бизнес эрхлэгчид бараа бүтээгдэхүүнээ сурталчлан оролцож, шинээр байгуулагдсан 9 хоршооны төлөөллийг БНАУ-ын ӨМӨЗО-ны “Шилийн гол” аймгийн мал аж ахуй, хүнсний үйлдвэрлэл эрхлэгч хоршоо, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, шинэ дэвшилтэт техник технологи, үйлдвэрлэлтэй танилцуулсан. Улаанбаатар хот, БНХАУ-д болсон 4 удаагийн томоохон үзэсгэлэн худалдаанд аймгийн өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, хоршоодын төлөөлөл давхардсан тоогоор нийт 33 иргэн, аж ахуйн нэгжийг оролцоход дэмжлэг үзүүлж ажилласнаар иргэн, аж ахуйн нэгжүүд туршлага судлан, бараа бүтээгдэхүүнээ сурталчлан нийт 25,8 сая төгрөгийн борлуулалт хийсэн.	
157			Хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих хөнгөлөлттэй зээл олгох	Дэмжлэгт хамрагдсан иргэн, аж ахуй нэгж	хувь	2022	60.5	62.5	“Хүнсний хангамж-аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 63 дугаар тогтоолын дагуу хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих 5-6 хувийн хүүтэй, хөнгөлөлттэй зээлд газар тариалан, жимс, жимсгэний үйлдвэрлэл эрхлэгч 11 иргэн хамрагдаж, нийт 188,0 сая төгрөгийн санхүүжилт авч, тариалсан талбайн хэмжээг 40 га-аар нэмэгдсэн. “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сан”-гаас хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 6 аж ахуйн нэгж 556,3 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авч, үйлдвэрлэлийн хүчин чадал, цар хүрээг өргөжүүлсэн. Алтанширээ, Хөвсгөл сумдын “Хоршоо хөгжүүлэх сан”-гаас 2 хоршоонд махны үйлдвэрлэлийн чиглэлээр 160,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. “Шинэ хоршоо” хөдөлгөөний хүрээнд хүнсний үйлдвэрлэл, мах, сүү цагаан идээ боловсруулах чиглэлээр 10 хоршоонд нийт 1.1 тэрбум төгрөгийн зээл олгож	100%

									дэмжлэг үзүүлсэн. "Түншлэл ба хөгжил" аймгийн бизнес эрхлэгчдийг дэмжих зорилтот хөтөлбөрийн хүрээнд ОНТ-т 2.0 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдаж, хүнсний болон хөнгөн үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд 3 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатай хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулалтыг зарлаж, 68 төсөл хүлээн авч сонгон шалгаруулалтын шат үргэлжилж байна.	
158	Гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний дотоодын хангамжийг 3 хувиар нэмэгдүүлнэ.	Хүнс хөтөлбөр	Хүнсний хангамж, аюулгүй байдлын талаар төлөвлөгөөт, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн хяналт шалгалт зохион байгуулах	Хяналт шалгалтад хамрагдсан сум, зөрчлийн бууралт	тоо хувь	2022	6, -	14 сум, 50%-аас дээш	Дорноговь аймгийн 14 суманд хүнсний худалдааны чиглэлээр 326, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр 202, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлээр 59, 587 иргэн, аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулдаг. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Салбарын ерөнхий байцаагчдын баталсан удирдамжийн дагуу 14 сумын давхардсан тоогоор 341 аж ахуйн нэгж, 256 иргэн, нийт 597 объектыг хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад хамруулж, шалгалтад хамруулсан объектын тоог 199 буюу 50%-иар нэмэгдүүлсэн. Дээрх хяналт шалгалтын явцад илэрсэн 2349 зөрчлийн 43.33% буюу 1018 арилгуулах, 39.1% -д хамаарах 47 иргэн, аж ахуйн нэгжид улсын байцаагчийн 436 заалт бүхий албан шаардлага хүргүүлэн биелэлтийг 39.1%-иар хангуулж, 17.5%-д хамаарах 54 иргэн, аж ахуйн нэгжид улсын байцаагчийн 574 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлэн хэрэгжилтийг 44.6 %-иар тус тус хангуулж, хүнсний чанар, аюулгүй байдлын шаардлага зөрчсөн 11 аж ахуй нэгжид 33,0 сая, 20 иргэнд 9,1 сая нийт 31 иргэн, аж ахуй нэгжид 42,1 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан. Хаяг шошгийн болон хадгалалтын хугацаа, горим зөрчигдсөн 303 нэр төрлийн 3482 ширхэг, 16,63 кг, 8,269,020 төгрөгийн өртөг бүхий хүнсний бүтээгдэхүүнийг хураан авч, холбогдох хууль, журмын хүрээнд зориулалтын дагуу устгалд оруулсан.	100%
159			Хүнсний гол нэрийн	Дэмжлэг	тоо	2023	0	1	Алтанширээ сумын нутаг дэвсгэрт байрлах "Алтанширээт" үйлдвэрлэл технологийн паркийн	100%

			бүтээгдэхүүн үйлдвэрлэх тохиромжтой байршлуудад ҮТП байгуулах хувийн хэвшлийг инженерийн дэд бүтцээр дэмжих						674.44 га, Хөвсгөл сумын нутаг дэвсгэрт байрлах "Гэрэлт говь" үйлдвэрлэл технологийн паркийн зориулалтаар 264.38 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авах саналыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэсэн. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар 2022-2023 онд Айраг, Даланжаргалан, Мандах, Хатанбулаг, Хөвсгөл сумдын нутаг дэвсгэрт 10 байршилд 3337.38 га газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авч, газар олголтын үйл ажиллагааг зохион байгуулах боломжийг бүрдүүлсэн. Орон нутгаас уул уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд түшиглэн хүнс, хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлж, хөрөнгө оруулагч хувийн хэвшлүүдэд бүхий л талын дэмжлэгийг хуулийн хүрээнд үзүүлэн ажиллаж байна.	
160		Газар тариалан хөтөлбөр	Газар тариалангийн эрхлэгчдийн нэгдсэн сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулах	Зохион байгуулсан сургалт	тоо	2022	1	1	“Газар тариаланг хөгжүүлэхэд өртгийн сүлжээг сайжруулах нь” сэдэвт аймгийн тариалан эрхлэгчдийн нэгдсэн сургалт, зөвлөгөөнийг 2024 оны 04 дүгээр сард Сайншанд суманд зохион байгуулж, 86 тариаланч оролцож салбарын бодлого, орчин үеийн шинэ технологи, тэргүүн туршлагауд, өртгийн сүлжээ зэрэг сэдвүүдийн хүрээнд мэдээлэл авч, цаашид анхаарах асуудлуудын талаар харилцан санал солилцож, зөвлөлдсөн. Сургалт, зөвлөгөөний хөтөлбөрийн хүрээнд Сайншанд сумын 6 дугаар багт байрлах “Хорвоогийн бөмбөлгөн гэрэл” хоршооны тариалангийн талбайд хөрс боловсруулах орчин үеийн дэвшилтэт технологийн үзүүлэх сургалт явуулсан. ХХААХҮЯ, Өмнөговь аймагтай хамтран зохион байгуулсан “Хаврын тариалалт бүсчилсэн хөгжил - 2024” говийн бүсийн анхдугаар зөвлөгөөнд газар тариалан эрхлэгчдийн 45 төлөөлөлийг оролцуулан туршлага судлуудсан.	100%
161			Өрхийн тариалан эрхлэгчдэд хүлэмжийн дэмжлэг үзүүлэх	Нийлүүлсэн хүлэмж, тариалсан талбай	тоо, м2	2022	65 хүлэмж, 10520 м2 талбай	95 хүлэмж, 12320 м2	“Мөрөөдлийн говь” ХХК хувийн 180,0 сая төгрөгийн хөрөнгөөр Сайншанд сумын 7 дугаар багт 0,7 га талбайд 6 ширхэг 3 улирлын нарлаг хүлэмж, 120 м2 хэмжээтэй 50 ширхэг нийлэг хальсан хүлэмж бүхий цогцолбор аж ахуй байгуулж 6000м2, Засгийн газрын хөдөө аж ахуйг дэмжих 5-6 хувийн хүүтэй	100%

								талбай	хөнгөлөлттэй зээлд 2 иргэн хамрагдаж 300 м2 хүлэмжийг шинээр ашиглалтад оруулж, аймгийн хэмжээнд нийт 1500 м2 өвлийн хүлэмж, 36520 м2 зуны хүлэмжинд тариалалт хийж хамгаалагдсан хөрсний тариалалт өмнөх оноос 7600 м2-аар нэмэгдүүлсэн.	
162			Өрхийн тариалан эрхлэгчдийн техникийн шинэчлэлд дэмжлэг үзүүлэх	Техник шинэчлэлтэд хамрагдсан тариалан эрхлэгч	тоо	2022	21	40	Аймгийн хэмжээнд газар тариаланд 421 хүлэмж, 74 трактор, төмсний комбайн 1, төмс ухагч 3, хүнсний ногоо хураагч 4, хадуур тармуур 22, хаман боогч 2 зэрэг 10 гаруй нэр төрлийн техник ашиглагдаж, техникийн шинэчлэлт урьд оноос 17.2%-иар өссөн. "Хүнсний хангамж-аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 63 дугаар тогтоолын дагуу хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих 5-6 хувийн хүүтэй, хөнгөлөлттэй зээлд газар тариалан, жимс, жимсгэний үйлдвэрлэл эрхлэгч 11 иргэн хамрагдаж, 188.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авч, 300 мкв хүлэмж, 2 мотоблок, 9.5 га талбайд дуслын услалтын систем, 85 тонны усны нөөцийн савыг ашиглалтад оруулж техникийн шинэчлэл хийсэн. Дэлхийн зөн ОУБ-ын "Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй орон нутаг" төслийн хүрээнд Иххэт сумын "Өнгөт" малчдын бүлэгт 79,0 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмжийг олгосон. Аймгийн ИТХ-аас тариалан эрхлэгч 21 иргэнд хөрс халаагч, ургамал хамгааллын автомаксыг олгон дэмжлэг үзүүлсэн. "Шинэ хөдөө" төслийн хүрээнд улсын төсвийн 1.8 тэрбум төгрөгийн хөрөнгөөр Сайншанд сумын 7 дугаар багт, орон нутгийн тариаланчдын ногоог хадгалах зориулалт бүхий зоорийг байгуулахаар төлөвлөн, гүйцэтгэгчээр шалгарсан "Хөх оноо" ХХК-тай гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн. Сайншанд сумын 3 дугаар багийн 1 иргэн газар тариалангийн гар багаж үйлдвэрлэх, агропаркийн засвар үйлчилгээ үзүүлэх төвийг шинээр байгуулж, тариалан эрхлэгчид, иргэдэд үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.	100%
163			Ургацын урьдчилан	Хамрагдсан сум	тоо	2022	14	14	Аймгийн хэмжээнд 356 өрх, 30 аж ахуйн нэгж, байгууллага төмс 23 га, хүнсний ногоо 68 га, малын	100%

			баланс тогтоох						тэжээл 116,24 га, жимс, жимсгэнэ 9,6 га, нийт 217 га талбайд тариалалт хийж 588 тн ургац хураан авсан нь өмнөх оноос талбайн хэмжээг 40 га-аар, 1 га-аас авах ургацыг 10 цн-ээр нэмэгдүүлсэн.	
Салбарын үр дүн 5.2: Гэмт хэрэг, зөрчлийг 3 хувиар бууруулна.										
164	Цагдаагийн байгууллагын үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн түвшинг 20 хувиар нэмэгдүүлнэ.	Цагдаа хөтөлбөр	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх	Зохион байгуулсан арга хэмжээ	тоо	2022	35	40	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах зорилгоор бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээнд дүн шинжилгээ хийдэг. 10 дугаар сарын байдлаар нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 26.0 хувь нь согтуугаар үйлдэгдсэн байна. Иймд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 15 ерөнхий арга хэмжээний хүрээнд 40 гаруй арга хэмжээг зохион байгуулж, гарын авлага, зурагт хуудас, санамж, сэрэмжлүүлгийг нийт 33.0 мянга гаруй ширхгийг иргэд олон нийтэд хүргэсэн. Мөн Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д өөрчлөлт орсонтой холбоотойгоор архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хязгаарт өөрчлөлт орж согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг нэмэгдсэн талаар дүн шинжилгээг хийж аймгийн Засаг дарга холбогдох хууль тогтоомжийн дагуу өөрийн эрх хэмжээний хүрээнд 2024 оны А/774 дүгээр захирамжаар согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хязгаарыг шинэчлэн тогтоож, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлээд байна. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг олон төрлөөр зохион байгуулах зорилгоор иргэд олон нийтэд орон нутгийн “DSB”, “DTV” телевизээр болон аймгийн Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн газрын цахим хуудсаар мэдээ, мэдээллийг иргэд олон нийтэд хүргэж байна.	90%
165			Гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлэх	Гэмт хэргийн илрүүлэлт	хувь	2022	66	68	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нэгдсэн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах, илрүүлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээнд дүн шинжилгээ хийж, өссөн гэмт хэрэг, зөрчил, түүнээс урьдчилан	90%

									сэргийлэх чиглэлээр 15 нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсан. Мөн мөрдөгчдийн ур чадварын нэмэгдүүлэх тусгай сургалтыг зохион байгуулж, мэдээ мэдээллээр тогтмол хангаж ажиллаж байна. Гэмт хэргийн илрүүлэлт аймгийн хэмжээнд 54.4 хувь байгаа нь өмнөх оноос 8.9 нэгжээр өссөн эерэг үзүүлэлттэй байна.	
166			Иххэт сумын Цагдаагийн кобаны барилгын их засварын ажил хийх	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Цагдаагийн кобаны их засварын ажлыг орон нутгийн хөгжлийн сангийн 148,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Мунараконстракшн" ХХК гүйцэтгэж дууссан.	100%
167			Аймгийн Цагдаагийн газарт шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хууль зүй, дотоод хэргийн сайдаас аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хүрээнд 330.0 сая төгрөгөөр аймгийн Цагдаагийн газрын их засварын ажлыг хийж гүйцэтгэж байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар зөөврийн хурд хэмжигч, богино долгионы гар станц, зөөврийн компьютер, зөөврийн принтер, согтуурлын зэрэг шалгагч багаж, холын тусгалтай гар чийдэн, GPS байршил тогтоогч төхөөрөмж зэрэг 7 төрлийн нийт 97,5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэгийг үзүүлсэн. Тус онд улс, орон нутгийн төсвөөс нийт 427.5 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн.	100%
168			Мөрдөгчдийн ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээ	тоо	2022	26	40	Мөрдөгчдийн ур чадварыг нэмэгдүүлэх дадлага, ур чадварын "Шилдэг мөрдөгч" тэмцээнийг жил бүр уламжлал болгон зохион байгуулж хэвшсэн. Тайлант онд мөрдөгчийн ур чадварыг дээшлүүлэх, нэмэгдүүлэхээр 23 төрлийн 3 удаагийн сургалт зохион байгуулж аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 200 гаруй мөрдөгчийг хамруулсан. Мөн зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг мөрдөгчдийг тусгай мэдлэг олгох сургалтад хамруулахад дэмжлэг үзүүлж ажилласан. Мөрдөгчдийн ур чадвар нэмэгдэх сургалтыг зохион байгуулсны үр дүнд гэмт хэргийн илрүүлэлт өмнөх	100%

									оны мөн үеийнхээс 8.9 нэгжээр өссөн эерэг үзүүлэлттэй байна.	
169	Гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй эрсдэл бүхий иргэдийн тоог 3 хувиар бууруулна.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулах	Хэсэгчилсэн арга хэмжээ	тоо	2022	6	8	Сар, улирал бүр бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээллийг гаргаж, өссөн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг судалж, дүн шинжилгээ хийдэг. Дүн шинжилгээний үндсэн дээр урьдчилан сэргийлэх чиглэлээр "Цахим гэмт хэрэг", "Хичээл эхэллээ", Харилцан хүндэтгэе", "Хүүхэд хамгаалал-2024", "Илэрц" зэрэг 15 арга хэмжээний хүрээнд 40 гаруй арга хэмжээг зохион байгуулж ажилласан. Онцлох хэсэгчилсэн арга хэмжээг дурдвал 1.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор "За больё- хэмжээ болсон" арга хэмжээг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд иргэдэд согтууруулах ундаанаас татгалзах сэдлийг төрүүлэх зорилгоор хүн ихээр зорчих замын хажуугийн самбар, согтууруулах ундаа худалддаг болон түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгжүүдэд санамж, сэрэмжлүүлгийг байршуулан ажилласан. 2.Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, байгаль цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан алдсан, олсон, уруудсан малыг олж тогтоох, эрлийн ажилд дэмжлэг үзүүлэх мэдээллийг шуурхай солилцох "Дорноговь алдсан болон олдсон малын нэгдсэн зар" цахим хаягийг ажиллуулж 7000 гаруй малчид нэгдсэн. Тус цахим хаягт иргэд алдсан болон олсон малын зарыг шуурхай солилцож байна. 2024 оны 10 дугаар сард мах бэлтгэлийн ажил эхэлсэнтэй холбогдуулан аймгийн цагдаагийн газраас Сайншанд сумын нутаг дэвсгэрт олноор орж ирсэн адуунд хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж, бүртгэлжүүлэн тус цахим хаягаар дамжуулан малчдад мэдээлэл хүргэж ажилласан.	100%

170			Камержуулалтын ажил хийх	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 14/02 тоот тогтоолоор Сайншанд, Замын-Үүд сумдад камерын хяналт, удирдлагын нэгдсэн системийг 101 байршилд 278 камер шинээр нэвтрүүлэхээр 2,1 тэрбум төгрөгийг төсөвт тусган шийдвэрлэсэн. Энэ хүрээнд 1,3 тэрбум төгрөгөөр Сайншанд суманд 63 цэг байршилд 163 камер байршуулж, "Камерын хяналтын дэд төв"-ийг холбогдох хууль тогтоомжийн дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэд байгуулсан. Замын-Үүд суманд 38 байршилд 115 камерыг байршуулж, шилэн кабелин өргөтгөлийн ажлыг хийж гүйцэтгэсэн. 2024 оны байдлаар 102 цэгт 263 чиглэлийн камер ажиллаж байна.	100%
171			Олон нийтийн цагдаагийн урамшуулал олгох	Урамшуулалд хамрагдсан олон нийтийн цагдаа	тоо	2022	18	33	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас нийт 33 олон нийтийн цагдаагийн орон тоо баталснаас 20 олон нийтийн цагдаа аймаг, сум орон нутагт ажиллаж байна. Аймгийн төв дээр 6, Замын-Үүд сумын сум дундын цагдаагийн хэлтэст 4, бусад суманд 10 хүн ажиллаж байна. Цаашид сул орон тоог нөхөн хангах чиглэлээр иргэдийг бүртгэл судалгаанд хамруулж байна. Олон нийтийн цагдаагийн урамшууллыг аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2023 оны №01 дүгээр тогтоолоор 1.0 сая төгрөг байхаар шийдвэрлэсний дагуу олгож байна.	90%
172	Гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй эрсдэл бүхий иргэдийн тоог 3 хувиар бууруулна.		Хууль сахиулах чиг үүргийн байгууллагуудын зөвлөгөөн зохион байгуулах	Зөвлөгөөнд хамрагдсан албан хаагчид	тоо	2022	0	250	2024 оны 05 дугаар сарын 16-ний өдөр төрийн цэргийн болон хууль сахиулах чиг үүргийн байгууллагын албан хаагчдад зориулсан сургалт, лекцийг зохион байгуулж 200 гаруй албан хаагчдыг хамруулсан. Тус сургалтыг төрийн албан хаагчийн харилцаа хандлага, ёс зүй, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, хувь хүний хөгжлийг дэмжих агуулгаар зохион байгуулсан. Мөн 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр хууль сахиулах чиг үүргийн байгууллагуудын уялдааг холбоог нэмэгдүүлэх зорилгоор "Хилийн цэргийн болон хууль сахиулах чиг үүргийн байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөн"-ийг зохион байгуулж 50 гаруй албан хаагч хамрагдсан. Тус зөвлөгөөнөөр "Хүүхдийн эсрэг гэмт хэргийн	90%

									Дорноговь аймаг дахь нөхцөл байдал, цаашид анхаарах асуудал", "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, үр дүн", "Гэмт хэргийн нөхцөл байдал, цаашид анхаарах асуудал", хилийн цэргийн 0129, 0168, 0108 дугаар ангиуд "Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлтэй хамтран 2024 онд хийсэн ажлын товч мэдээлэл, хил орчмын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал, анхаарах зарим асуудал" сэдвээр илтгэл хэлэлцүүлэг хийсэн. Зөвлөгөөний үр дүнд хууль сахиулах чиг үүргийн байгууллагуудын 2025 оны үйл ажиллагааны чиг хандлагыг тодорхойлсон бөгөөд аймгийн жилийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгахаар ажиллаж байна.	
173			АА-н үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах	Дэмжлэг ийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээ	тоо	2022	0	4	Архины хамааралтай иргэдийн тоог бууруулах, тус иргэдэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх, гэмт хэрэг, зөрчилд үйлдэх, өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх зорилгоор архины хамааралтай 75 иргэний судалгааг сум, багтай хамтран гаргаж, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах ажлын хүрээнд албадан эмчилгээнд хамруулахаар ажиллаж байна. Мөн "Архичид аминчлахуй" төрийн бус байгууллагатай хамтран Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийг иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулж, иргэдийг хууль, эрх зүйн мэдээ мэдээллээр хангах ажлыг зохион байгуулсан. Мөн аймгийн Цагдаагийн газраас "Ухаарлын алхам" АА "Найдварын Өргөө" НҮТББ-ын "Бетел" АА-ийн нийгэмлэгүүдтэй хамтран архинаас татгалзах нөлөөллийн арга хэмжээний хүрээнд нэг удаагийн хувцас хэрэгслээр хангах, ариун цэвэр сахиулахаар үсийг нь засуулах ажлыг 7 хоног бүр тогтмол зохион байгуулж байна.	90%
174			"Итгэл" төслийг орон нутагт хэрэгжүүлэх	Төсөлд хамрагдсан иргэд	тоо	2022	0	200	Тус аймгийн хэмжээнд архи согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэдэг иргэдийг албадан эмчлэх, эмчилгээнд хамруулах зорилгоор "Итгэл" төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.	30%

									“Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Цахим-Архи худалдаа” тусгай арга хэмжээг энэ оны 01 дүгээр сарын 09-ний өдрөөс 2 сарын хугацаатай зохион байгуулж холбогдох хууль, журам зөрчиж архи согтууруулах ундаа худалдан борлуулсан, түүгээр үйлчилсэн зөрчлийг илрүүлж 17 иргэн, 16 хуулийн этгээдийг 89,5 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч эргүүл, хяналт шалгалтын ажиллагааг үргэлжлүүлэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг итгэл төслийн хүрээнд шат дараатай зохион байгуулан ажиллаж байна.	
Салбарын үр дүн 5.3: Хүний хүчин зүйлээс хамааралтай осол гэмтлийн гаралтыг 5 хувиар бууруулна.										
175	Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх дадалтай иргэдийн тоог 20 хувиар нэмэгдүүлнэ.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр	Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа зохион байгуулах	Сургалт, сурталчилгаа	тоо	2022	50	60	Улсын болон орон нутгийн чанартай авто замд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, хөдөлгөөнд оролцогчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлж, иргэдийн аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд зам тээврийн осол их гардаг цэгүүдэд санамж сэрэмжлүүлэг байршуулах ажлыг тогтмол зохион байгуулж байна. Тайлант онд Сайншандаас-Замын-Үүд чиглэлийн хатуу хучилттай авто замд “НОЙР СЭРГЭЭГЧ” 3D цагаан шугамыг нийт 180 гаруй сая төгрөгөөр 12 цэгт байрлуулсан. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр нийт 21 байгууллагын 1.200 гаруй албан хаагчдад “Зам тээврийн осол гэмт хэрэг, зөрчлийн статистик тоо мэдээ, осол хэргийн шалтгаан нөхцөл, зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаар”, Аюултай ачаа тээвэрлэх журам, Тусгай дуут дохио хэрэглэх мөн “Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт” зэрэг сэдвээр сургалт зохион байгуулсан. Бага насны хүүхдийг зам тээврийн осол, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрмийн мэдлэг олгох, замын хөдөлгөөнд аюулгүй оролцуулах дадал эзэмшүүлэх зорилгоор давхардсан тоогоор нийт 2,800 гаруй хүүхдэд сургалт, мэдээлэл өгч ажилласан.	70%

176			Чойр - Сайншанд - Замын-Үүд чиглэлийн босоо тэнхлэгийн замд жолоочийн нойр сэргээгч дэржгэнүүр хийх	Шинээр хийсэн дэржгэнү үр	тоо	202 2	16	20	Сайншандаас-Замын-Үүд, Замын-Үүдээс Сайншандын чиглэлийн авто зам дагуу зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж авто осол гарч болзошгүй 2 байршилд нийт 12 ширхэг туузан “Нойр сэргээгч” 3D цагаан шугамыг замын засвар, арчлалтыг хариуцан ажилладаг "Борхойн Зам" ХХК 8,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн.	100%
177			Урьдчилан сэргийлэх санамж, сэрэмжлүүлг ийн самбар байршуулах	Шинээр нэмж байршуу лсан самбар	тоо	202 2	15	15	Улсын болон орон нутгийн чанартай авто замд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, хөдөлгөөнд оролцогчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлж, иргэдийн аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор зам тээврийн осол их гардаг цэгүүдэд АГХУСАЗСЗ-өөс 6,4 сая төгрөгөөр 6 ширхэг санамж сэрэмжлүүлэг бүхий самбар аймгийн Засаг даргын Тамгын газраас 3.7 сая төгрөгийг “Анхаар!!! Хурд хэмжигч ажиллаж байна” 4ш самбарыг тус тус шинээр байрлуулсан.	70%
178			Зөөврийн хурд хэмжигч худалдан авах	Хурд хэмжигч	тоо	202 2	0	3	Аймгийн Цагдаагийн газарт орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар БНСУ-ын Comlaser компанийн ТРСАМ загварын хурд хэмжигч 1, сансрын иридум гар утас 1, богино долгионы гар станц 65, зөөврийн компьютер 3, зөөврийн принтер 3, согтуурлын зэрэг шалгагч багаж 5, холын тусгалтай гар чийдэн 10, GPS байршил тогтоогч төхөөрөмж 2 зэрэг нийт 90 төхөөрөмжийг 97,5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэгийг үзүүлсэн.	70%
179			Ханги хилийн боомтын дагуу авто замд байнгын хяналтын цэг байгуулах	Хяналтын цэг	тоо	202 2	0	1	Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Ханги хилийн боомтоос Өмнөговь аймгийн Цогтцэций сум, Тавантолгой чиглэлийн хатуу хучилттай авто зам дагуу Цагдаагийн байгууллагаас хяналт шалгалт явуулах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, алба хаагчдын ажиллах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор “Тахилт хайрхан транс” ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд Цагдаагийн зөөврийн сууц, чиргүүлийг шийдвэрлэж “Master camp” ХХК нд 2024	70%

									оны 11 дүгээр сарын 20-ны өдөр төсөвт өртөгийн тооцоолол, захиалга хүргүүлсэн бөгөөд 2024 онд багтаан шийдвэрлэгдэхээр болсон. Мөн Хатанбулаг сумын сум дундын цагдаагийн тасгаас Ханги хилийн боомт дээр хяналт шалгалтыг 7 хоног бүр явуулж байна. Тухайн зам дагуу Хатанбулаг сумын сум дундын Цагдаагийн тасаг, Ханги боомтын цагдаагийн хэсэгтэй хамтран 7 хоногт 2-3 удаа нэгдсэн хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулж ажиллаж байгаа бөгөөд 2024 оны эхний 10 сарын байдлаар тухайн авто замд зам тээврийн ослын гэмт хэргийн шинжтэй 5, зөрчлийн шинтэй 18 дуудлага мэдээлэл бүртгэгдэж, 71 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасаж, 14 иргэнийг сум дундын шүүхээр баривчлуулж, зөрчилтэй явсан 208 жолоочийг 13.1 сая төгрөгөөр торгох арга хэмжээ авсан байна.	
Салбарын үр дүн 5.4: Орчны эрсдэлийг суурь түвшнээс 1 хувиар бууруулна.										
180	Гамшгийн эрсдэлийг даван туулах чадавхыг 30 хувиар нэмэгдүүлнэ.	Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх хөтөлбөр	Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх олон нийтийн нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээ	тоо	2022	19	25	Монгол улсын Засгийн газрын 2011 оны 339, 340, 2017 оны 67 дугаар тогтоол, Монгол улсын Шадар сайд, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, аймгийн Засаг даргын баталсан удирдамж, аймгийн Засаг даргын 2024 оны А/263 дугаар тушаал, Онцгой байдлын газрын даргын баталсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу албаны үйл ажиллагааг сурталчлан таниулах, гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, гамшгийн үед өөрийгөө болон бусдыг авран хамгаалах арга ухаанд суралцуулах зорилгоор нийт 26 удаагийн нэгдсэн өдөрлөг, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, 11636 иргэн, гамшгаас урьдчилан сэргийлэх ангиллын сургалтад 11092 иргэн, давхардсан тоогоор нийт 22728 иргэнийг хамруулсан нь аймгийн нийт хүн амын 30 гаруй хувийг эзэлж байна.	100%
181			Гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд	Хамрагдсан хүн	тоо	2022	9500	10000	Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны А/412 дугаар тушаал, Монгол улсын Шадар сайд, аймгийн Засаг даргатай 2024 онд байгуулсан төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ, аймгийн Засаг даргын	100%

			штабын дадлага сургууль зохион байгуулах						2024 оны А/263 дугаар захирамж, Онцгой байдлын газрын даргын баталсан удирдамж, Онцгой байдлын газрын 2024 оны 25/178, 25/179, 25/180 дугаар албан бичгийн дагуу тайлант оны 11 дүгээр сард Замын-Үүд, Эрдэнэ, Дэлгэрэх сумдад гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд сургууль, бэлэн байдлын үзлэг зохион байгууллаа. Дээрх дадлага сургуулиудын үеэр гал түймэр, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, мэдлэг олгох чиглэлээр 20 цагийн багтаамж бүхий танхимын сургалт, 7 цагийн багтаамж бүхий дуурайлган үзүүлэх сургалтыг тус тус зохион байгуулж, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн түвшинд гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийж, дээрх сумдын Онцгой комисс, Ерөнхий зориулалтын мэргэжлийн анги, төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын алба хаагч, иргэдийн төлөөллөөс бүрдсэн нийт 978 хүнийг хамруулсан.	
182			Гамшгаас хамгаалах ангиллын сургалт зохион байгуулах	Сургалт	тоо	2022	300	400	Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны А/133 дугаар тушаалаар батлагдсан график төлөвлөгөө, аймгийн Засаг даргын 2024 оны А/263 дугаар захирамж, Онцгой байдлын газрын даргын баталсан “Гамшгаас хамгаалах ангиллын сургалт зохион байгуулах удирдамж”-ийн дагуу тайлант хугацаанд нийт 207 удаагийн гамшгаас хамгаалах ангиллын сургалтыг 363 цагийн хугацаатай зохион байгуулж, давхардсан тоогоор 11092 иргэнийг хамруулсан. Тодруулбал: Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуй нэгжид 177 удаагийн сургалтыг 444 цагийн багтаамжтай зохион байгуулж, 5285 иргэн, ЕБС-ийн ахлах болон дунд ангийн сурагчдын 41 удаагийн сургалтыг 54 цагийн багтаамжтай зохион байгуулж, 6377 сурагч, сургуульд элсэхийн өмнөх насны хүүхэд, багш нарт 22 удаагийн сургалтыг 23 цагийн багтаамжтай зохион байгуулж, 755 багш, хүүхдийг хамруулан гамшгаас хамгаалах мэдлэг чадвар эзэмшүүлсэн.	100%
183			Асрамжийн газрын үерийн	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Асрамжийн газрын үерийн усны далан хийх ажлыг орон нутгийн төсвийн 101.1 сая төгрөгийн	100%

			усны далан хийх						хөрөнгө оруулалтаар "Сутайн жинст" ХХК гүйцэтгэж бүрэн ашиглалтад орсон.	
184			Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшинд эрсдэлийн үнэлгээ хийх	Үнэлгээ хийгдсэн сум, аж ахуй нэгж	тоо	2022	4 сум 10 ААН	5 сум 11 ААН	Гамшгаас хамгаалах тухай хууль, Монгол улсын Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоол, Монгол улсын Шадар сайдын 2021 оны 68 дугаар тушаал, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны А/255 дугаар тушаал, Монгол улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Улсын Онцгой комиссоос ирүүлсэн үүргийн дагуу тус аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн түвшинд зудын эрсдэлийн үнэлгээ-4, шар усны болон уруйн эрсдэлийн үнэлгээ-1, хээрийн гал түймрийн эрсдэлийн үнэлгээ-1, үерийн эрсдэлийн үнэлгээ-2, гангийн эрсдэлийн үнэлгээ-2, нийт 10 удаа гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийсэн. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны А/412 дугаар тушаал, Монгол улсын Шадар сайд, аймгийн Засаг даргатай 2024 онд байгуулсан төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ, аймгийн Засаг даргын 2024 оны А/263 дугаар захирамжийн хүрээнд Эрдэнэ, Замын- Үүд, Дэлгэрэх сумдын түвшинд гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийсэн. Мөн онц аюултай объектын түвшинд хийгдсэн гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээний 18 тайланд холбогдох журам, зааврын дагуу анхан шатны шинжилгээ хийсэн байна.	50%
185	Цаг уур орчны шинжилгэ эний таамаглал ын таарцыг 1 хувиар нэмэгдүүл нэ.	Ус цаг уур, орчны шинжилгэ э хөтөлбөр	Цаг агаарын төлөв байдал, аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээллийг олон нийтэд хүргэх, болзошгүй эрсдэлийг бууруулах	Иргэдэд хүргэсэн мэдээлэл	тоо	2022	20000	2500 0	Цаг агаарын төлөв байдал болох цасан шуурганы аюултай үзэгдэл 2 удаа, хүчтэй салхины аюултай үзэгдэл 5 удаа, шороон шуурганы аюултай үзэгдэл 4 удаа, нийт 11 удаагийн үзэгдэл ажиглагдаж, байгаль цаг агаарын аюултай үзэгдлээс анхааруулах, сэрэмжлүүлэх мэдээг боловсруулан аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын "Масс мессеж" үйлчилгээгээр аймгийн онцгой комиссын гишүүд болон малчид ард иргэдийн гар утсанд мессеж хэлбэрээр шуурхай дамжуулан 1 удаагийн мессежийг 5400 орчим иргэдэд хүргэж, давхардсан тоогоор нийт 59400 хэрэглэгчдэд цаг агаарын аюултай үзэгдлээс анхааруулах, сэрэмжлүүлэх	100%

									мэдээг хүчтэй салхи, шороон шуурга, цасан шуурганы төрлөөр хүргэн ажилласан.	
186			Айраг сумын харуулын цэгийг цаг уурын станц болгож өргөжүүлэх	Станцын тоо	тоо	2022	72	73	Айраг сумын цаг уурын харуул цэгт автомат багаж, тоног төхөөрөмжийг 2022 онд суурилуулан цаг уурын станц болгох нөхцөлийг бүрдүүлсэн. Тус харуул цэгт 1 техникч ажиллаж улсын сүлжээний цаг уурын үйл ажиллагааг хэвийн явуулж байна. Дээрх харуулын цэгийг цаг уурын станц болгож бүтэц, орон тооны асуудал шийдэх хүсэлтийг Цаг уур, орчны шинжилгээний газарт хүсэлтийг хүргүүлсэн.	30%
187	Инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдардаг өрхийн тоог 21.6 хувиар нэмэгдүүлнэ.	Барилга хөтөлбөр	Барилгын материалыг дотоодын хангамжаар хангах санамж бичгийг төрийн болон төрийн бус байгууллага, үйлдвэрлэгч аж ахуйн нэгжтэй байгуулах	Барилгын үйлдвэрлэлийн материалын тоо	тоо	2022	0	3	2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр Дорноговь аймгийн ЗДТГ, ГХБХБГ, Монголын барилгачдын нэгдсэн холбоо, Дорноговь аймгийн барилгачдын холбооноос хамтран зохион байгуулсан “Барилгачдаа сонсьё” зөвлөгөөнөөр барилга угсралтын компаниуд болон барилгын материал үйлдвэрлэгчдийн санал хүсэлтийг хүлээн авч хэлэлцэн, санамж бичгийг байгуулсан. Барилга үйлдвэрлэлийн үндсэн материалаас цемент болон бетон зуурмагийг дотоодын нөөцөөс хангаж байна.	70%
188		Барилга хөтөлбөр	Барилга захиалагчийн хяналтын үйл ажиллагаа явуулах	Хяналт хийсэн барилга	тоо	2022	50	71	Аймгийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 8 төсөл арга хэмжээ, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 58 төсөл арга хэмжээ, нийт 66 ажлын явцад барилгад аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас гэрээний үндсэн дээр захиалагчийн хяналт хэрэгжүүлж байгаа бөгөөд эдгээр төсөл, арга хэмжээнд барилгын норм ба дүрэм, стандартын шаардлагыг хангуулан ажилласан.	90%
189			Сайншанд сумын суурьшлын хэсгийн 1:1000-ны масштабтай байр зүйн	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Сайншанд сумын суурьшлын хэсгийн 1:1000-ны масштабтай байр зүйн зураг, газар доорх шугам сүлжээний зургийг солбицлын ITRF2020 эринд шилжүүлэх ажил хийх ажлын даалгаврыг Газар зорхион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргаар батлуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг 2024 оны 03 дугаар сард	30%

			зураг, газар доорх шугам сүлжээний зургийг солбицлын ITRF2020 эринд шилжүүлэх ажил хийх						зохион байгуулсан. Энэхүү ажлыг гүйцэтгэхээр тусгай зөвшөөрөл бүхий 8 аж ахуйн нэгж оролцож, хамгийн бага үнийн санал ирүүлсэн "Агар орд" ХХК нь шалгарсан боловч бусад оролцогчоос гомдол гаргасныг хянан үзэж, тендерийг хүчингүй болгосон.	
190			Сайншанд сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Сайншанд сумын Нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөө боловсруулах ажлын даалгаврыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраар батлуулсан. Тендер шалгаруулалтын тодорхойгүй нөхцөл байдлын улмаас гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил удаашралтай байна.	30%
191			Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний тодотгол хийх ажлыг 2024.06.07-ны өдрийн ОНТХО-НТШ-11/2024 дугаартай гэрээг "Лапланд эко" ХХК-нь гэрээг байгуулсан. Гэрээнд тусгагдсан ажлын үе шатны хуваарийн дагуу бэлтгэл ажил болох суурь судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. "Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх" ажлын бэлтгэл судалгааны ажлын үр дүнг үндэслэн хээрийн тодруулалт судалгаа явуулах маршрут, хугацааг тодорхойлон график төлөвлөгөө гаргаж ажлыг 2024 оны 09 дүгээр сарын 15 - ны өдрөөс эхлэн Алтанширээ, Мандах, Сайншанд, Дэлгэрэх сумдын малчдын нэгдсэн өдөрлөг, Иххэт, Сайхандулаан, Хөвсгөл, Хатанбулаг, Улаанбадрах, сумдын Сумдын удирдах албан тушаалтнууд болон ЗДТГ-ын албан хаагчдад аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх ажлыг танилцуулга, сургалт хийж санал асуулга авч, сумдын нийгэм, эдийн засгийн суурь нөхцөлийн судалгаа, хээрийн хэмжилт судалгааг хийж төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай байршлыг солбицол тодорхойлж, холбогдох албан тушаалтнуудтай хамтран сумын нутаг дэвсгэрт	50%

									тулгамдаж байгаа асуудлыг ярилцаж, аймгийн ерөнхий төлөвлөгөөнд тусгах шаардлагатай асуудлыг сумын хил бүхий 1:100000-ны масштабтай байрзүйн зурагт тэмдэглэх ажлыг гүйцэтгэсэн. Ажлын явц: 58.7%	
192			Барилга байгууламжийг паспортжуулах	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	2024 оны орон нутгийн төсөвт барилга байгууламжийг паспортжуулах ажилд 100.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт батлагдаж нийт 9 барилгад паспортжуулалтын дүгнэлт гаргуулахаар ажлын даалгавар, жагсаалтыг гаргасан. Ажлын гүйцэтгэгчээр "Бүүвэй цагаан барс" ХХК шалгарч, ажил гүйцэтгэх гэрээ байгуулаад байна.	50%
193			Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийн тоног төхөөрөмж худалдан авах	Худалдан авсан тоног төхөөрөмжийн өртөг	Сая.төгрөг	2022	0	7.0	Барилгын материалын лабораторийн шинжилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, барилгад ашиглаж буй барилгын материалуудын чанарт тавих хяналтыг сайжруулах зорилгоор 18.2 сая төгрөгийн өртгөөр хатаах шүүгээ, усан ванн, шмидтийн алхыг шинээр худалдан авсан.	100%
194		Хот байгуулалт хөтөлбөр	Сайншанд сумын 2 дугаар багийн Дэнжийн 6 гудамж 618,620-р байранд дээврийн засвар хийх	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Орон нутгийн хөгжлийн сангийн 142.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сайншанд сумын 2 дугаар багийн Дэнжийн 6 гудамж 618, 620-р байрны дээврийн засварын ажлыг "Айсуй хөгжил" ХХК гүйцэтгэж 8 дугаар сард ашиглалтад оруулсан.	100%
195			Замын-Үүд сумын орон сууцнуудын гадна фасадны ажил хийх	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Замын-Үүд сумын 48 айлын орон сууц /130, 131, 134/ гадна фасадын ажлыг орон нутгийн төсвийн 321,0 сая төгрөгийн хөрөнгөөр "ДЭЛГЭР БАЯН ХҮЛЭГ" ХХК, 64 айлын орон сууцны гадна фасадын засварын ажлыг орон нутгийн төсвийн 364,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Баялаг өөдөс" ХХК, 72 айлын орон сууцны гадна фасадын засварын ажлыг орон нутгийн төсвийн 233,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Баялаг өөдөс" ХХК, 136 дугаар байрны гадна фасадын засварын ажлыг орон нутгийн төсвийн 188 сая төгрөгийн хөрөнгө	100%

									оруулалтаар "Дэнжийн хүү" ХХК, 133 дугаар байрны гадна фасадын засварын ажлыг орон нутгийн төсвийн 140,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Аббадон констракшн" ХХК, 135а байрны гадна фасадын засварын ажлыг орон нутгийн төсвийн 189,0 сая төгрөг, 135 б байрны гадна фасадын засварын ажлыг орон нутгийн төсвийн 184,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Дэнжийн хүү" ХХК тус тус гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өгсөн.	
196			Сайншанд, Замын-Үүд сумдын авто зам, авто зогсоол, явган хүний зам, дугуйн зам, гэрэлтүүлэг, тохижилтыг сайжруулах	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Улсын төсвийн 4,7 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Замын-Үүд сумын төвд 2,15 км хатуу хучилттай автозам барих ажлыг "Борхойн зам" ХХК, Сайншанд сумын 2-р багт 1,3 км хатуу хучилттай авто зам, 2 байршилд авто зогсоол, 6-р багт 3.6 км хатуу хучилттай авто зам, 7-р багт 0,38 км хатуу хучилттай авто зам, 1 байршилд авто зогсоол, 8-р багт 1 байршилд авто зогсоол шинээр барих ажлыг нийт 5,6 тэрбум төгрөгийн санхүүжилтээр "Дэлгэр баясах зам" ХХК, "Дорноговь-А33А ТӨХК, "Сутай жинст" ХХК, "Айсуй хөгжил" ХХК тус тус гүйцэтгэж ашиглалтад оруулсан. Сайншанд сумын 8-р багт 94ш гэрэлтүүлэг, 2-р багт 20ш гэрэлтүүлэг, 1, 4, 6, 7-р багт 219ш гэрэлтүүлэг шинээр суурилуулах ажлыг нийт 1,7 тэрбум төгрөгийн санхүүжилтээр "Энержи бөх бөт" ХХК, "Сонголт нар" ХХК, "Уртын-Уул" ХХК, "Насака" ХХК, Алтанзавьяа Ундрага ХХК, Чандманьхонгор групп ХХК тус тус гүйцэтгэж ашиглалтад оруулсан.	100%
197			Аймгийн хэмжээнд ногоон байгууламж нэмэгдүүлэх /14 сум/	Нэмэгдсэн талбайн хэмжээ	га	2022	35	70	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх аймгийн зорилтот хөтөлбөрийн хүрээнд 422 өрх хашаандаа 4 төрлийн 5185 мод, 195 аж ахуйн өөрсдийн эзэмшлийн хашаандаа 7 төрлийн 9699 мод, нийтийн болон тусгай хэрэгцээний 15.69 га талбайд 50,921 мод, авто замын хамгаалалтын ойн зурвас байгуулахад 3.02 га талбайд 15,280 мод, төмөр замын хамгаалалтын ойн зурвас байгуулахад 1 га талбайд 790 мод, өртөө, зөрлөг, боомтын хамгаалалтын ойн зурвасыг 2 га талбайд байгуулж 4,024 мод, нийт 8 төрлийн 20,094 мод, жимсний аж ахуйн 1 га талбайд 120 мод, агро ойн аж ахуйн 1.8 га	90%

									талбайд 2,072 мод, доройтсон ойг нөхөн сэргээж 1 га талбайд 170 мод, заган ойн 10 га талбайд нөхөн сэргээлт хийж 3,200 мод, байгалийн сэргэн ургалтад туслахаар 11.5 га талбайд 22,310 мод, уул уурхайн компаниуд 6 төрлийн 32,999 модыг тус тус тарьснаар аймгийн хэмжээнд нийт 47.01 га талбайд 9 төрлийн 166,074 мод шинээр тарьж, 273,2 сая төгрөгийг тарьж ургуулахад зарцуулж ногоон байгууламжийн хэмжээг 13,8 хувиар нэмэгдүүлсэн. Иргэдэд мод тарих нөлөөллийн арга хэмжээг 4 удаа зохион байгуулж модны тарьц суулгац худалдаалдаг 6 иргэн 5 төрлийн 2000 модыг иргэдэд худалдан борлуулж, заавар зөвлөмж өгч ажилласан. Төв суурин газрын ногоон байгууламжийн өвчин, хортон шавьжтай тэмцэх ажлын хүрээнд Сайншанд сумын ногоон байгууламж дахь модноос дээж авч мэргэжилийн байгууллагад явуулж шинжилгээ хийлгэсэн бөгөөд улиасны өмөн өвчин болон хайлаасны бөөс илэрч 2 удааг ариутгалын ажлыг гүйцэтгэж хортон шавьжийг устгасан. Даланжаргалан, Мандах, Хөвсгөл, Иххэт сумдад иргэдийн иргэдийн ая тухтай амрах нөхцлийг бүрдүүлж ногоон байгууламж бүхий талбайг 5.06 га талбайд байгуулсан байна. Сайншанд сум мод тарьж ургуулсан 6 өрх, 3 аж ахуйн нэгж байгууллагыг урамшуулж, 25 иргэн, 40 аж ахуйн нэгж байгууллагад модны гэрчилгээ олгож бүртгэлжүүлсэн.	
198		Хамарын хийдийн 3 замын уулзвараас Зүүнбаян чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний үе шат, 18.2 км автозам барих	Шинээр бий болсон автозам	км	2022	3.8	5	Сайншанд сумын 2 баг Хамарын хийдийн 3 замын уулзвараас Зүүнбаян баг хүртэлх 20 км хатуу хучилттай автозам барих ажлыг 12,4 тэрбум төгрөгийн санхүүжилтээр "Борхойн зам" ХХК гүйцэтгэж, ажлын гүйцэтгэл 55%-тай байна. Гэрээний хугацаа 2025.11.17-д дуусна	100%	

199	Эдэлбэр газрын өгөөжийг 5 хувиар нэмэгдүүлнэ.	Газрын харилцаа хөтөлбөр	Газрын бүртгэлийн нэгдсэн системд эзэмшил, ашиглалт, өмчлөлд олгосон газруудыг бүртгэх	Олгосон нийт газраас Улсын бүртгэлд бүртгэгдсэн нэгж талбар	эзлэх хувь	2022	100	100	Энэ онд тухайн шатны Засаг даргын шийдвэрээр шинээр газар эзэмших, ашиглах, өмчлөх эрх үүссэн 256, гэр бүлийн 1 гишүүнд өмчлөх эрхээ шилжүүлсэн 18, бусдад бэлэглэх, худалдах, худалдан авах гэрээгээр газар өмчлөх эрхээ шилжүүлсэн 486, газар эзэмших эрхийн гэрчилгээгээ бусдад шилжүүлсэн 622, хугацаа сунгасан 132, газрын зориулалт, байршил, хэмжээ, нэгтгэх, хуваах, оноосон нэр, эрхийн төрөлд өөрчлөлт орсон 79, хамтран өмчлөгч нэмэх, бусдад ашиглуулах 10, эрх сэргээх, дуусгавар болох 20 нэгж талбар нийт 1623 нэгж талбарын мэдээллийг газрын кадастрын системд бүртгэсэн.	100%
200			Устсан геодезийн цэг тэмдэгтийг сэргээн засварлах, хамгаалах	Сэргээн, хамгаалах цэг тэмдэгт	тоо	2022	261	261	Тайлант онд Сайхандулаан сум 7.9 сая төгрөгөөр 5, Хатанбулаг сум 8.5 сая төгрөгөөр 5, Дэлгэрэх сум 6 сая төгрөгөөр 4, Замын-Үүд сум 11, нийт 25 цэг тэмдэгтийг нөхөн сэргээх гэрээг "Талст газар" ХХК-тай тус тус байгуулан цэг тэмдэгтийг сэргээн завсарлаж геодезийн хэмжилт, зураглалыг хийж гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлж ажилласан. Мөн Улаанбадрах сум "Бадрах энерги" ХХК-ны хөрөнгө оруулалтаар 4 цэгийг сэргээн засварлаж нийт 29 цэг тэмдэгтийг сэргээн засварласан.	30%
Салбарын үр дүн 5.5: Агаар, орчны чанарыг стандарт түвшинд хүргэнэ.										
201	Орчныг бохирдуулагчдын тоог 20 хувиар бууруулна.	Орчны бохирдлыг бууруулах хөтөлбөр	Орчин үеийн дэвшилтэд технологи, шинэ шийдлүүдийг иргэд, олон нийтэд танилцуулах, сурталчилах	Сургалт, арга хэмжээ	тоо	2022	2	3	Орчин үеийн дэвшилтэд технологи, шинэ шийдлүүдийг иргэд олон нийтэд таниулж, сурталчилахаар "Нээлттэй хаалга өдөрлөг"-ийг 5 дугаар сард, 09 дүгээр сарын 18-ны өдөр "Ногоон технологи" өдөрлөгүүдийг зохион байгуулсан. Өдөрлөгөөр "Юниват" халаалтын ногоон технологи, Юнилос- Экогранд эко ариун цэврийн байгууламж, монгол гэрийн дулаалгын ЧИП багц зэрэг халаалт, дулаалгын 3 төрлийн 6 иж бүрдлийг иргэдэд танилцуулахаас гадна цахилгаан, ус дулаанаар хангагч байгууллага, байгаль орчны салбарын байгууллагууд, банкны салбарууд оролцон цахилгааны шөнийн тариф, хөнгөлөлт, хог хаягдлын менежмент, "Ногоон зээл"-ийн талаар мэдээлэл өгч 16 төрлийн нийт 1200 ширхэг тараах материалыг иргэдэд тарааж, давхардсан тоогоор 490 орчим	100%

									иргэнд мэдээлэл хүргэсэн. Мөн Дорноговь телевиз, DSB телевизүүдэд мэдээ, ярилцлага бэлтгэн цахимаар болон телевизийн сувгаар цацан олон нийтэд хүргэсэн. Замын-Үүд сум агаарын бохирдлыг бууруулах өрхийн ухаалаг хэрэглээг бий болгох чиглэлээр “Утаагүй зуух” аяныг хэрэгжүүлж айл өрхүүдэд урилга заавар бүхий гарын авлага хүргүүлж, гэр хорооллын гудамжнуудаар дуут мэдээлэл цацаж, сумын ЗДТГ-ын болон Онцгой байдлын хэлтсийн цахим хаягуудаар уриалга хүргүүлж ажилласан. Агаарын бохирдлыг бууруулах өрхийн ухаалаг хэрэглээг бий болгох ажлын хүрээнд тайлант онуудад нийт 6322 өрх, 265 ААН-д зөвлөмж мэдээлэл хүргүүлсэн.	
202			Сайншанд, Замын-Үүд сумын агаарын чанарын бүсэд байгаа айл өрхийн цахилгаан хаалаагуурын хэрэглээг нэмэгдүүлэх	Цахилгаан халаагуур хэрэглэдэг айл өрхийн тоо	тоо	2022	294	324	Сайншанд сумын хэмжээнд 250 айл, Замын-үүд суманд 110 айл өрх цахилгаан халаалтаа шийдсэнээр нийт 360 цахилгаан халаалттай өрх болж 1800 тн нүүрсний хэрэглээг бууруулсан. Сайншанд, Замын-үүд сумын 1398 өрхөд шөнийн цагт хэрэглэсэн 1.1 сая квт цахилгааны 125.2 сая төгрөгийн тарифын хөнгөлөлтөнд хамрагдсан.	100%
203			Сайншанд сумын хог хаягдлын цэгт бүрэн шаталттай зуух суурилуулах	Бүрэн шаталттай зуухны тоо	тоо	2022	0	1	Сайншанд суманд хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийг байгуулж эрчим хүч, дулаан үйлдвэрлэх, мөн дөрвөн улирлын хүлэмж байгуулах, хог хаягдлын менежментийг хэрэгжүүлж байгальд ээлтэй технологийг нэвтрүүлэх чиглэлээр Нидерланд Улсын "RECYCLING MONGOLIA" LLC -тай хамтран ажиллах санамж бичгийг 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр байгуулсан. Дээрх төслийг хэрэгжүүлэх техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулахтай холбогдуулан судалгаа мэдээлэл гаргаж, төслийн үйл ажиллагааг дэмжиж ажиллах ажлын хэсгийг байгуулан шаардлагатай мэдээ, мэдээллийг цуглуулж байна. Тус төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Сайншанд сумын хог	30%

									хаягдлын цэгт бүрэн шаталттай зуух суурилуулах ажил хийгдээгүй, цуцлагдсан болно.	
204			Сумдын хог хаягдлын төвлөрсөн цэгийг хашаажуулах	Хашааж хамгаалсан цэгийн тоо	тоо	2022	2	4	Тайлант онд Улаанбадрах, Хатанбулаг, Хөвсгөл, Даланжаргалан, Эрдэнэ, Замын-Үүд сумууд хувийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 87.2 га талбайд хуримтлагдсан хог хаягдлыг түрж цэвэрлэн орчны бохирдлыг бууруулж 110 га талбай болгосон. Эрдэнэ сум хог хаягдлын салхин доод талд 150метр урттай 4 метр өндөртэй торон хашаа байгуулж, камержуулах ажлыг орон нутгийн төсвийн 11.0 сая төгрөгийн хөрөнгөөр барих ажил үргэлжилж байна. Замын-Үүд сум хог ангилан ялгах үйлдвэр, хог хаягдлыг ландфилийн аргаар устгах 3 шатлал бүхий талбай, хашаажуулах зорилгоор "Сэвхүүлийн тойромд байрлах сумын нэгдсэн хөгийн цэгийг цэгцлэх ажил"-ыг 3 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр нийт 4.0 тэрбум төгрөгийн төсөвтэйгөөр "Элемент" ХХК-тай хамтран ажиллаж байгаа бөгөөд сум орон нутгийн төсвийн 500,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар нийт 72 га талбайд тархсан хог хаягдлыг 10 га талбайд шахах, цэвэрлэсэн газарт биологийн болон техникийн нөхөн сэргээлт хийх, хогийн цэг рүү чиглэсэн 2 км автозамыг сайжруулж хаших ажлууд хийгдсэн.	90%
205			Сайншанд сумын Захирагчийн ажлын албанд хог ачилтын болон цас арилгах автомашин, төхөөрөмж худалдан авах	Худалдан авах авто машин	тоо	2023	0	6	Сайншанд сумын Захирагчийн ажлын албанд хог ачилтын 5 автомашин, авто замын давс цацагч төхөөрөмжийг орон нутгийн төсвийн 302.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан.	90%
Салбарын үр дүн 6.1: Ногоон хөгжлийн сэргэлт										
206	Хог хаягдлын дахин	Орчны бохирдлыг	Орон нутаг дахь дахин боловсруулах	Дахин боловсруулсан	тн	2022	1	2	Орон нутагт дахь дахин боловсруулах "Эко говь" үйлдвэрийн үйл ажиллагааг дэмжин 55.5 сая төгрөгийн үнэ бүхий хуванцар нягтруулан шахах	100%

	боловсруулалтын түвшинг 20 хувиар нэмэгдүүлнэ.	бууруулах хөтөлбөр	үйлдвэрийг бодлогоор дэмжих	хогны хэмжээ					төхөөрөмж, гадна дотор камерын иж бүрдэл, цахилгаан жин, хуванцар хайлуулах төхөөрөмж, 40 тонны контейнер, хуванцар бутлагч төхөөрөмж зэрэг аймгийн Байгаль орчны газарт бүртгэлтэй тоног төхөөрөмжүүдийг гэрээ байгуулан ашиглуулж байна. 2024 онд тус үйлдвэрийн гадна цахилгаан хангамжийг хүчин чадлыг нэмэгдүүлэх АТП дэд өртөө байгуулах, цахилгааны 380 вТ-д холбох ажлыг гүйцэтгүүлж улсын комисст хүлээлгэн өгөхөөр бэлтгэл ажлыг хангасан. Хог хаягдал болон дахивар ангиллын тухай ойлголт мэдээллийг ЕБС-уудын сурагчдад өгөх, сурагчдыг хогоо ангилгах дадалд уриалах, хэвшүүлэх, сургууль бүрийг хогоо ангилдаг, дахивраа тушаадаг эко сургууль болоход чиглүүлэн "Говийн эко сургууль" төслийг амжилттай хэрэгжүүлсэн. Төслийн үр дүнд Сайншанд сумын 6-н сургууль, Алтанширээ, Дэлгэрэх, Сайхандулаан, Улаанбадрах, Даланжаргалан, Эрдэнэ сумдын сургууль цэцэрлэгүүд дахивар цуглуулж хэвшсэни бөгөөд Эко говь үйлдвэрт 11 тн хуванцарыг нийлүүлсэн байна. Тайлант онд лааз 3тн, шил 4.5тн, 11 тн хуванцар хаягдал, 29 тн гялгар уутны хаягдал цуглуулж, 8 тн гялгар уутыг дахин боловсруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна. Мөн Улаанбаатар хот дах "Нью метод ХХК"-ны электрон хаягдал дахин боловсруулах үйлдвэрт "Аюулыг авдарлъя" аяны хүрээнд ЕБС-иудаас цуглуулсан 600кг хаягдал батарей, цахилгааны хог хаягдлыг тээвэрлэн тушаасан.	
207			Ахмадын сувилал, Хүүхдийн зуслан, Иргэдийн цэцэрлэгт хүрээлэнгийн мод услах зориулалтын усалгааны автомашин	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Иргэдийн цэцэрлэгт хүрээлэнгийн мод услах зориулалтын усалгааны автомашин худалдан авах тендерт 52.1 сая төгрөгөөр "Альянстрейд" ХХК шалгарч гэрээ байгуулж, 04 дүгээр сарын 05-ны өдөр ашиглалтад хүлээлгэн өгч мод усалгаанд ашиглаж байна.	90%

			худалдан авах							
208			Иргэдэд хог хаягдлыг ангиалан ялгах дадал хэвшлийг төлөвшүүлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах	Нөлөөл ийн арга хэмжээ	тоо	2022	50	100	Сайншанд сумын Ерөнхий болосвролын сургуулийн сурагчдыг хогоо ангилах дадалд уриалах, хэвшүүлэх, сургууль бүрийг хогоо ангилдаг, дахивраа тушаадаг эко сургууль болоход чиглэсэн "Говийн эко сургууль" төслийг "Эко говь" хог хаягдал дахин боловсруулах үйлдвэртэй хамтран аймгийн агаарын бохирдлыг бууруулах зардлаас 19,9 сая төгрөгөөр санхүүжүүлэн хэрэгжүүлж 41 бүлэг нийт 1277 хүүхдэд хог ангиллын талаарх цогц мэдлэгийг олгох 1640 цагийн сургалт явуулсан. Мөн аймгийн Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний 19,9 сая төгрөгийн санхүүжилтээр "Сайншанд сумын хог хаягдлын менежментийг сайжруулах төсөл-2"-ыг "МЭВХ" НҮТББ-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж төслийн хүрээнд хог хаягдлын талаар соён гэгээрүүлэх 7 удаагийн сургалт таниулах арга хэмжээг хэрэгжүүлж 120 иргэнд мэдээлэл өгч ажилласан. Даланжаргалан сум 10.0 сая төгрөгөөр, Алтанширээ сум 5.6 сая төгрөгөөр хог хаягдал преслэгч төхөөрөмжийг худалдан авч ашиглаж 2 тн дахиварыг цуглуулж преслэсэн. Сайхандулаан сум орон нутгийн хөгжлийн сангийн 11,0 сая төгрөгийн хөрөнгөөр хоёрдогч түүхий эд боож баглах төхөөрөмж, ангиалан ялгах сав худалдан авч сар бүрийн 11, 22 ний өдрүүдийг хоёр дахь түүхийн эд авах өдөр болгон зарлаж "Хог хягдал-Хоёрдагч түүхий эд" дахивар авах нөлөөллийн аяныг хэрэгжүүлж ажилласан. Дээрх төслүүдийн үр дүнд 11 тн хуванцар сав, 29 тн гялгар уутны хаягдлыг цуглуулан түүхий эдийн нөөц бүрдүүлж, үүнээс 8 тн гялгар уутыг дахин боловсруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэснээр байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулсан.	100%
Салбарын үр дүн 6.2: Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн үр ашгийг 5 хувиар нэмэгдүүлнэ.										
209	Улсын тусгай хамгаалал ттай газар	Тусгай хамгаалал ттай газар нутгийн	Аймгийн нутаг дэвсгэрт амьдарч буй уулын туруутан	Тусгай хамгаалал тад авсан	га	2022	32,7	35	Аймгийн хэмжээнд өвөлжилт хүндэрч зэрлэг ан амьтан идэш тэжээлийн хомсдолд орж зүй бус хорогдолд гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга	100%

	нутгийн хэмжээг 9 хувиар нэмэгдүүлнэ.	хамгаалал хөтөлбөр	амьтдын тархац нутгийг хамгаалах, амьдрах орчныг тэтгэх	газрын хэмжээ					хэмжээний 30.0 сая төгрөгийн санхүүжилтээр 1681 боодол өвс худалдан авч өвөлжилт хүндэрсэн Даланжаргалан суманд 400 боодол өвс, Иххэт суманд 270 боодол, Өргөн суманд 200 боодол, Сайншанд суманд 350 боодол, Сайхандулаан суманд 200 боодол өвсийг олгож, уулын туруутан болон хээрийн туруутан амьтдын тархац нэр бүхий 9 байршилд, агнуурын бүс нутгийн менежмент хариуцагч "Маунтэйн хантинг" ХХК Эрдэнэ, Мандах сумдын агнуурын бүс нутагт 300 боодол өвс, "Монгол сафари" ХХК Хатанбулаг сумын агнуурын бүс нутагт 300 боодол өвсийг худалдан авснаар нийт 2020 боодол өвсийг 12 байршил газарт тавьж зэрлэг амьтдын тархац нутагт биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлсэн. Мандах сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024.09.25-ны өдрийн шийдвэрээр Агуйт нэртэй 9148.62 га газрыг байгалийн нөөц газрын ангиллаар орон нутгийн тусгай хамгаалалтад авч Ашигт малтмал, Газрын тосны газарт бүртгүүлснээр тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 0,08 хувиар нэмэгдүүлснээр нийт нутаг дэвсгэрийн 32.7 хувийг тусгай хамгаалалтад хүргэж биологийн төрөл зүйлүүдийн тархац нутгийг хамгаалсан.	
210			Биологийн төрөл зүйлийг хамгаалах чиглэлээр сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээ	тоо	2022	2	2	Жил бүрийн 05-р сарын 22-ны өдрийг Нэгдсэн үндэсний байгууллагаас олон улсын биологийн олон янз байдлын өдөр болгон зарласан бөгөөд "Биологийн төрөл зүйлийг хамгаалах өдөр"-ийг Эрдэнэ, Өргөн сумдад "Тогтвортой зэрэгцэн оршихуй", "Биологийн олон янз байдлыг хамгаалах, хулгайн антай тэмцэх" сэдэвт гэрэл зургийн үзэсгэлэн гаргаж, Ерөнхий боловсролын сургуулийн 121 сурагч, 360 иргэдэд сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж мэдээлэл өгсөн. Мөн "Амьтны экологи эдийн засгийн үнэлгээ", зарим туруутан амьтдын танилцуулга зэрэг цахим мэдээллийг Байгаль орчны газраас бэлтгэн цахим сүлжээнд байршуулж 780 хүн үзэж сонирхсон. "Биологийн олон янз байдлын ирээдүй сан"," Их нартын хамгаалалтын захиргаа", хамтран "Байгаль	100%

									программ", "Зэрлэг амьтдын судалгааны арга зүй" сэдэвт сургалтад 56 албан хаагч, "Байгаль зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг Монгол дах төлөөлөгчийн газар"-аас "Зэрлэг амьтдын хууль бус ан, тэдгээрийн газартай түүхий эд эрхтэн, бүтээгдэхүүний хууль бус худалдаатай тэмцэх төсөл"-ийн хүрээнд хөдөлгөөнт баг буюу Хатанбулаг, Хөвсгөл, Мандах, Улаанбадрах, Өргөн, Эрдэнэ сумдын Засаг даргын орлогч, цагдаагийн төлөөлөгч, байгаль орчны мэргэжилтэн, Сайншанд суманд байрлах хамтарсан багийн гишүүд зэрэг 24 албан хаагчдад хууль эрх зүй, эргүүл хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулах арга зүйн зөвлөгөө өгч чадавхжуулах сургалтыг зохион байгуулж, 2024 оны 11, 12 дугаар сард гүйцэтгэх эргүүл хяналт шалгалтын төсөв 18,2 сая төгрөгийг шийдвэрлэж, хөдөлгөөнт багуудад зардлыг шилжүүлэх ажлыг хийж байна. Мөн 10 дугаар сарын 25-ны өдөр "Хулан хамгаалах өдөр"-ийг Байгаль, зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг (WCS) хамтран анх удаа тэмдэглэн Хатанбулаг суманд "Хулангийн хил хязгааргүй нүүдэл" гар зургийн уралдаан, хулангийн тухай танин мэдэх сургалтыг зохион байгуулж 40 сурагч 6 багш хамрагдаж биологийн төрөл зүйлийг хамгаалах нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлсэн. Даланжаргалан сумын ЕБС-н эко клубийн хүүхдүүд Айраг сумын эко клубийн хүүхдүүдэд Их нартын байгалийн нөөц газрын амьтдын төрөл зүйлийг таниулах сургалтыг Ховор амьтан хамгаалах эвслийн судлаач нартай хамтран зохион байгуулж сургалтад 2 сумын 37 хүүхэд, 4 багш хамрагдснаар Биологийн төрөл зүйлийг хамгаалах чиглэлээр нийт 5 удаагийн арга хэмжээг зохион байгуулагдсан байна.	
Салбарын үр дүн 6.3: Нийт усны хэрэглээнд эзлэх цэнгэг усны хэрэглээг 9.6 хувиас хэтрүүлэхгүй.										
211	Ус хэрэглээн ий үр ашигт байдлыг 3	Усны нөөцийн зохистой ашиглалт хөтөлбөр	Усны ашиглалт, хамгаалалт, хэмнэлтийн чиглэлээр	Зохион байгуулсан сургалт	тоо	2022	2	3	"Дэлхийн усны өдөр"-ийг жил бүрийн 3 дугаар сарын 22-ний өдөр уламжлал болгон усны мэргэжлийн байгууллагууд хамтран тэмдэглэн өнгөрүүлж усны тухай хууль, танин мэдэхүйн чиглэлээр давхардсан тоогоор нийт 15 удаагийн	100%

	хувиар нэмэгдүүл нэ.		олон нийтэд сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах						онлайн сургалт, мэдээлэл, “Усны уналт” нэртэй АХА тэмцээн, шүлэг, видео бичлэг, “Усаа хэмнээ, хайрлая” бүтээлч ажил, “Говийн ус” сэдэвт илтгэлийн уралдаан, “Ус чандмань эрдэнэ” цахим бичлэгийн уралдаан, гар зургийн уралдаан, усны сан бүхий газрууд, уст цэгүүдийн ойр орчмыг цэвэрлэх зэрэг ажлууд зохион байгуулж 800 ш гарын авлага, боршур тараагдсан байна. Ерөнхий боловсролын сургуулийн 1046 сурагч, 97 иргэн, 110 албан хаагч хамрагдаж усны сан бүхий газрын 4,7 га талбайд 14 ус хангамжийн эх үүсвэр, 18 усны сан бүхий газарт 686 малын сэг зэм устгах ажил тус тус хийгдсэн. Байгаль орчныг хамгаалах, усыг хайрлан хамгаалах, зүй зохистой ашиглах, экологийн боловсрол олгох зорилгоор Саранхөхөө театртай хамтран “Чандмань-Эрдэнэ” хүүхдийн жүжгийн уран бүтээлийг бэлтгэж ерөнхий боловсролын сургуулийн 3000 гаруй сурагчдад толилуулж, усыг хайрлан, хамгаалахад чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан.	
212			Хөв цөөрөм байгуулах	Хөв цөөрмийн тоо	тоо	2022	1	3	Даланжаргалан суманд үйл ажиллагаа явуулдаг “Ачир”ХХК, “Талст дөл” ХХК-иуд 4.0 сая төгрөгийн санхүүжилтээр Цомог багийн Аман ус нэртэй газарт 1,5 тонны багтаамжтай тус бүр 3 хөв, Элдэв багийн Чойрын богд нэртэй газарт 1,5 тонны багтаамжтай тус бүр 5 хөв, Эрдэнэ сумын Ханги нуурын даваанд ан агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлогын 2.0 сая төгрөгөөр санхүүжилтээр 2.5 тонны багтаамжтай 1 хөвийг тус тус шинээр байгуулснаар нийт 6.6 сая төгрөгийн санхүүжилтээр 11 ширхэг хөвийг байгуулж, зэрлэг амьтад ундаалах нөхцлийг бүрдүүлэхээс гадна хүрээлэн буй орчныхоо агаарын хуурайшилтыг бууруулж, хөрсний чанарыг сайжруулан ургамал ургах таатай нөхцөлийг бий болгосон. Мөн Юнител ХХК, Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамтай хамтран Монгол орон даяар нийт 80 гаруй байршилд хөв цөөрөм байгуулэх төслийн хүрээнд Даланжаргалан сумын Их нартын байгалийн нөөц газарт 2 хөв байгуулах материалын	100%

									дэмжлэгийг олгосноор хамгаалалтын захиргааны ажилтан албан хаагчид уг ажлыг гүйцэтгэсэн.	
213			Булаг шандын эхийг хамгаалж, тохижуулах	Хамгаалагдсан булгийн тоо	тоо	2022	6	9	Гадаргын усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор нийт 9 суманд 167,4 сая төгрөгийн хөрөнгөөр 18 булаг, шандын эхийг хашиж хамгаалж тохижуулснаар урсцыг нэмэгдүүлсэн. Үүнд Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 63.0 сая төгрөгийн хөрөнгөөр Алтанширээ сумын Тойг багийн "Цээлийн булаг", Даланжаргалан сумын 2 дугаар багийн "Өнгөт" булаг, Сайхандулаан сумын Жаргалант багийн Арын булаг, Хатанбулаг сумын Сулинхээр багийн Хангийн булаг, Эрдэнэ сумын Бүрдэнэ багийн "Нүдэнгийн булаг", Дөрвөлж багийн "Сэвхүүлийн цагаан булаг", Еншөөв багийн "Ар гашууны булаг", Иххэт сумын Баян багийн "Өвөр зүлэгтийн булаг", Хөвсгөл сумын Жавхлант багийн "Улаан булаг" зэрэг нийт 9 булгийг тохижуулсан. Даланжаргалан суманд "Мак цемент" ХХК-ийн 10,0 сая төгрөгийн санхүүжилтээр Далантүрүү булаг, Өргөн суманд "Монцемент билдинг материалс" ХХК-ийн 10,0 сая төгрөгийн санхүүжилтээр "Шувуун хөөвөр"-ийн булгийг тохижуулах ажлыг уул байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн байна. Мөн Мандах сум Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх хөтөлбөрийн 84,4 сая төгрөгийн хөрөнгөөр Алхантаг багт байрлах Дуутын булаг, Баруун сухайтын булаг, Баянхошуу багт байрлах Сайрын булаг, Хөөврийн булаг, Өөхий багт байрлах Хөөврийн булаг, Сэрвэнбаянхошуу багт байрлах Гэр чулууны булаг, Хөөврийн булаг зэрэг нийт 7 булгийн эхийг хашиж хамгаалан тохижуулсан.	90%
214		Суурин газрын усан хангамж хөтөлбөр	Хүн амыг эрүүл аюулгүй усаар хангах, гүний болон гадаргын усыг зүй зохистой ашиглах нөхцөлийг	Зохион байгуулсан арга хэмжээ	тоо	2022	1	2	Замын-Үүд сумын орон нутгийн төсвийн 95,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт болон "Дэээрэт" олон Улсын энэрлийн байгууллагын 66.0 сая төгрөгийн буцалтгүй тусламжаар Сүлд багт байрлах ус түгээх байр 1, 4, Хилчин багт байрлах ус түгээх байр 3, 7, 14, Жаргалант багт байрлах ус түгээх байр 8, 11, 12, 13, Борхойн багт байрлах ус түгээх байр 5, 19 зэрэг нийт 11 ус түгээх байрны гадна, дотор завсар хяналтын камерууд, иж бүрэн тоноглогдсон	100%

			бүрдүүлэх, хяналт тавих						түгээлтийн самбар, сервер, цахилгаан халаагуур, гадна гэрэлтүүлгийн ажлуудыг хийж гүйцэтгэн бүрэн автоматжиж 24 цагийн ажиллагаанд шилжүүлж иргэдэд эрүүл ахуйн шаардлага хангасан ус түгээх цэгээр үйлчлүүлж байна. Аймгийн хэмжээнд хүн амын ус хангамжийн 21 худагт шинжилгээ хийж, 8 худгийг шинээр тоолууржуулан, 67 ус ашиглуулах дүгнэлт гаргаж, ус ашиглалтын байдалд 6 удаагийн хяналт шалгалт явуулж ус ашиглагчийн үүрэг, тавигдах шаардлага биелүүлээгүй 7 аж ахуйн нэгжид Зөрчлийн тухай хуулийн дагуу 21.0 сая төгрөгөөр торгох шийтгэл оногдуулж 223.2 сая төгрөгийн нөхөн төлбөр тавьж зөрчлийг арилгуулсан.	
215			Хүн амын ундны усны эх үүсвэрийн худагт цэвэршүүлэх, зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулах	Цэвэршүүлэх, зөөлрүүлэх төхөөрөмж жийн тоо	тоо	2022	1	1	Аймгийн Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний 2023 оны 186,4 сая төгрөгийн санхүүжилтээр Сайншанд сумын 4, 8 дугаар багт автоматжуулсан цэвэр усны төвийг байгуулж 10 дугаар сард ашиглалтад оруулсан. Энэхүү ус цэвэршүүлэх систем нь усны хатуулаг бохирдлыг бүрэн арилгаж, шүлтлэг усыг гаргах бөгөөд 4 төрлийн байгалийн чулуулгаар байгалийн ус мэт болгож эрдэсжүүлдгээрээ давуу талтай бөгөөд иргэд хүссэн цагтаа картаа уншуулаад дэвшилтэд тоног төхөөрөмжөөр шүүж цэвэршүүлсэн эрүүл аюулгүй ундны усыг ашиглах боломжтой бүрдсэн. Мөн 2024 онд Дэлгэрэх суманд үйл ажиллагаа явуулдаг "Дэртийн булаг"ХХК-ийн 250,0 мянган төгрөгийн санхүүжилтээр тус сумын хүүхдийн цэцэрлэгийн 1 худагт бага оврын ус цэвэршүүлэх, зөөлрүүлэх шүүлтүүр, Улаанбадрах суманд аймаг, орон нутгийн төсвийн 240,0 сая төгрөгийн хөрөнгөөр тус сумын 2 дугаар багийн Хонгор, Цэвүүн нэртэй 2 худаг, 3 дугаар багийн Наймаа, Гүнсухайт нэртэй 2 худаг нийт нийт 4 ус хангамжийн эх үүсвэрийн худгуудад ус цэвэршүүлэх, зөөлрүүлэх, усны хатуулаг, хүнцэл бууруулах төхөөрөмж суурилуулах, худгийн барилга байгууламж барих ажлууд тус тус хийгдснээр 426.6 сая төгрөгийн санхүүжилтээр цэвэршүүлэх	100%

									төхөөрөмжтэй худгийн тоог 6-аар нэмэгдүүлснээр аймгийн хэмжээнд нийт 25 цэвэршүүлэх төхөөрөмжтэй худгаас иргэд эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усаар хангагдах боломжийг бүрдүүлсэн.	
216			Замын-Үүд суманд стандартад нийцсэн усан сан байгуулах	Шинээр байгуулсан цэвэр усны усан сангийн тоо,	тоо	2022	12	1	Сайншанд, Замын-Үүд сумдын ундны усны нөөцийн санг тус бүр 3000 м3/хоног хүчин чадалтай болгон өргөтгөх ажлыг улсын төсвийн 3,8 тэрбум төгрөгийн санхүүжилтээр "Энержи парагон" ХХК гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өгсөн.	100%
217			Аймгийн төвийн ундны усны эх үүсвэрийн хамгаалалтын ажилчдын байр барих	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Аймгийн төвийн ундны усны эх үүсвэрийн хамгаалалтын ажилчдын байр барих ажлыг 200.0 сая төгрөгийн санхүүжилтээр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан. 2024 оны 11-р сарын 10-ны байдлаар барилга угсралтын ажил 25%-тай байна. Гэрээний хугацаа 2025 онд дуусна.	30%
218			Ан амьтан услах зорилгоор нарны эрчим хүчээр ажилладаг худаг байгуулах	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Ан амьтдын тархац нутагт ундаалах боломжийг бүрдүүлэх зорилгоор "Ти Ти Си Ти" ХХК-ийн 90.0 сая төгрөгийн санхүүжилтээр Хатанбулаг сумын нутагт нарны эрчим хүчээр ажилладаг, хөдөлгөөн мэдрэгчтэй автомат төхөөрөмжтэй 1 ширхэг худгийг шинээр гаргаснаар аймгийн хэмжээнд ан амьтадыг ундаалахад зориулсан 2 худагтай болсон. Аймгийн байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлын 100.0 сая төгрөгийн санхүүжилтээр Айраг, Даланжаргалан, Сайншанд, Эрдэнэ, Өргөн сумдад хөв байгуулах боломжтой газрын судалгаа хийх, бороо цасны ус хуримтлуулах 4 ширхэг хөвийн зураг, төсөв боловсруулах ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендерийг зарлаж 11 дүгээр сарын 18-ны өдөр нээхээр хүлээгдэж байна.	100%
Салбарын үр дүн 6.4: Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг 1.07 хувьд хүргэнэ.										
219	Тарьсан модны ургалтыг 70 хувьд хүргэнэ.	Ойжуулалт хөтөлбөр	Ойн анги, мод үржүүлгийн газруудыг тогтвортой үйл ажиллагаа явуулахад	Зөвлөх үйлчилгээнд хамрагдсан иргэн, ААН	тоо	2022	120	130	Япон улсын "Жайка"-гийн төслийн түншлэлийн хөтөлбөрийн хүрээнд Нийгата мужийн Гадаадтай технологийн талаар хамтран ажиллах нийгэмлэгээс хэрэгжүүлж буй "Гүн суулган тарих аргаар Дорнын говийн цөлөрхөг бүсийн хуурай, хүйтэн газар нутгийг ургамалжуулах үйл ажиллагааг дэмжих техникийн	90%

			мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх						хамтын ажиллагааны төсөл” II шат амжилттай дууссан бөгөөд төслийн эрдэмтэд судлаачид төслийн хүрээнд хийгдсэн ажлаа танилцуулж, Дорноговь аймагт хэрхэн амжилттай мод тарьж ургуулах талаар мод үржүүлгийн газрын ажилтан албан хаагчид, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн төлөөлөл 30 гаруй зөвлөгөө, мэдээлэл өгсөн. Замын-Үүд сумын Засаг даргын Тамгын газар, ХААИС-ийн профессорын баг, НҮБ-ын ХХААБ-ын төслийн нэгж, “Борхойн Баян Бүрд” ОНӨ ААТҮГ хамтран “НОГООН ХӨГЖИЛ” сургалт, дадлагын ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдийн 30 гаруй байгууллагын 212 албан хаагчдыг хамруулан зохион байгуулж бионүүрс түүний түүхий эд гарган авах технологи, хэрэглээ, Хөрсөн бортого болон үр бүрэх техник технологи, Говийн хөрсний онцлог, хөрсөн бортогоны орцын найрлага бүтэц зэрэг сэдвээр танилцуулга, мэдээлэл, зөвлөмж өгч ажилласан. Мөн Замын-Үүд сум, БНХАУ-ын Эрээн хотын Засгийн ордонтой ногоон байгууламжийн чиглэлээр хамтран ажиллах "Санамж бичиг"-ийг байгуулж, тус ажлын хүрээнд Замын-Үүд сумын ойн ангийн 13 ажилтан алба хаагч Эрээн хотын мод үржүүлгийн компаниудад туршлага солилцох дадлага хийж, Бээжингийн Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн багш нараас туршлага судлан ажилласан. БНХАУ-ын Эрээн хотын байгаль орчны газартай хамтран “Замын-Үүд – Эрээн хотуудын экологийн судалгааны төв” байгуулахаар хамтран ажиллаж байна. Аймгийн Байгаль орчны газраас Улаанбадрах, Эрдэнэ, Иххэт, Хатанбулаг сумдад мод тарих, ургуулах арчлах, хамгаалах талаар зөвлөгөө мэдээлэл өгсөн.	
220			Ойн анги, мод үржүүлгийн газарт ажиллах мэргэжилтэй ажилтан бэлтгэх, сургах	Мэргэжил тэй ажилтан	тоо	2022	6	7	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд ойжуулалт, мод тарих заавар зөвлөмж өгөх мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх зорилгоор МУИС-ын Ой хүрээлэнгээс сургагч багш бэлтгэх танхим болон практик хосолсон сертификаттай сургалтыг 2024 оны 04 дүгээр сарын 20-ноос 24-ний хооронд зохион байгуулж нийт 42 сургагч багшийг	100%

								бэлтгэсэн. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, арчилгаа тордолгоог хийх, мод үржүүлгийн үйл ажиллагааг Замын-Үүд сумын “Борхойн Баян Бүрд” ОНӨҮГазар 20 хүний бүтэц орон тоотой, Байгаль орчны газрын дэргэдэх мод үржүүлгийн талбай 7 хүний бүтэц орон тоотойгоор мод үржүүлгийн үйл ажиллагааг явуулж, Алтанширээ, Сайншанд, Мандах, Иххэт, Эрдэнэ суманд ногоон байгууламжийн чиглэлээр түр ажлын байраар хангагдан ажилласан 97 иргэнд арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.	
221		Сайншанд суманд сум дундын ойн анги байгуулах	Ойн ангийн тоо	тоо	2022	1	2	Аймгийн Байгаль орчны газрын дэргэдэх мод үржүүлгийн газар 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр 2022 оноос хойш үйл ажиллагаа явуулж 9498м2 талбайд хөрс боловсруулалт хийж 20кг үрээр, 7310 ширхэг мөчрөөр үржүүлэг хийсэн бөгөөд хайлаас, улиас, сухай, жигд, агч, буйлс, гүйлс зэрэг 7 төрлийн 13,181 ширхэг тарьц суулгацыг ургуулан бойжуулан бэлтгэж 2051 ширхэг модыг намрын тарилтад нийлүүлсэн. Замын-Үүд сумын “Борхойн Баян Бүрд” ОНӨААТҮГ-ын мод үржүүлгийн талбайн хүлэмжид болон бойжуулах талбайд говийн ховор ургамлууд болох Одой Хайлаас, Хармаг, Улаан Сухай, Жигд зэрэг 5 төрлийн модыг 320 м² талбайд үрээр болон мөчрөөр үрслүүлж хайлаасны 3.2 кг үр, сухайн 9500 ширхэг мөчир бэлтгэж үр, суулгацын нөөцийг бүрдүүлж 1000 ширхэг модны суулгацыг тарилтад нийлүүлсэн байна.	90%
222		Мод үржүүлгийн газарт шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	Тоног төхөөрөмжийн тоо	тоо	2022	2	4	Аймгийн Байгаль орчны газрын дэргэдэх мод үржүүлгийн талбайд хүлэмж (40*8) барьж, 10 ширхэг хөрсний хучлага, 1 ширхэг мананжуулагч (8*40), 2 гад бороожуулагч усалгааны систем, 30 ширхэг туулайнаас хамгаалах (40 метр) тор авч суурьлуулан үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлсэн. Замын-Үүд сумын "Борхойн Баян Бүрд" ОНӨААТҮГ-т ойн ангийн үйл ажиллагааг дэмжиж олон үйлдэлт культиварт тоног төхөөрөмж авах ажлын тендерийг зарлаж шаардагдах санхүүжилт болох 24.0 сая	70%

									төгрөгийг аймгийн хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас гарган дэмжлэг үзүүлж үйл ажиллагааг дэмжсэн. Даланжаргалан суманд Мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг "Чойрын богд ложистик" ХХК 2 худаг шинээр гаргаж, үржүүлгийн үйл ажиллагааг нэмэгдүүлсэн.	
Салбарын үр дүн 6.5: Цөлжилтийн нэн хүчтэй, хүчтэй зэрэглэлд өртсөн газрыг 2.7 хувиар бууруулна.										
223	Бэлчээрийн даац хэтрэлтийг 1 хувиар бууруулна	Мал аж ахуй хөтөлбөр	Ангилан ялгалт хийх	Ангилалт хийсэн мал	тоо	-	0	1900 0	Мал сүргийн таваарлаг байдлыг хангах, өндөр ашиг шимт малын тоо, тархалтыг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд улсын төсвийн 15,8 сая, аймгийн орон нутгийн төсвийн 15.7 сая, нийт 31.5 сая төгрөгийн санхүүжилтээр "Сэнж сант" ХХК-тай гэрээ байгуулан малд үзлэг ангилалт хийх, цөм сүрэг бүрдүүлэх ажлыг зохион байгууллаа. Үзлэг ангилалтад Өргөн сумын 2600 толгой үхэр, Алтанширээ сумын 1200 толгой хонь, Дэлгэрэх сумын 5000 толгой ямаа, нийт 8800 толгой малыг хамруулж, үүнээс цөм сүрэгт 2328, үржлийн сүрэгт 3739, хэрэгцээний сүрэгт 2733 толгой малыг ангилан бүртгэж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд оруулсан.	100%
224			Малчдыг бэлчээрийн даацдаа тохируулан сүргийн эргэлт тооцоолол хийх талаар бүсчилсэн сургалт хийх	Бүсчилсэн сургалт	тоо	2022	0	3	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 166 тогтоолоор уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан мал аж ахуйн салбарт үүсэж болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, мал аж ахуйн үйлдвэрлэл, малчдын хоршоог дэмжих замаар тогтвортой хөгжүүлэх зорилго бүхий "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ийг орон даяар өрнүүлж эхэлсэн. Тус хөдөлгөөний нээлтийн 3 удаагийн (Улаанбаатар, Өмнөговь, Дорноговь) улс, бүсийн томоохон арга хэмжээнд Дорноговь аймгийн малчин 378, төрийн албан хаагч 57, банкны 28, нийт 463 төлөөлөл мал аж ахуйн салбарын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх арга зам, Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлого шийдвэрүүдийн талаар мэдээлэл авч, санаа бодлоо хуваалцаж, нэгдсэн ойлголт авч оролцсон. Тус хөдөлгөөний зорилго, ач холбогдолыг малчид, иргэдэд сурталчилан танилцуулах "Зөвлөн туслах баг"-ийг 14 суманд 21-30 хоногийн хугацаатай	100%

									ажиллуулж, нийт малчин өрхийн 70.3 хувь буюу 3248 өрх, нийт малчдын 83.09 хувь буюу 5881 малчин, бусад 2576 иргэнд мэдээлэл өгч, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. Дээрх ажлын үр дүнд аймгийн хэмжээнд 176 хоршоо шинээр байгуулагдаж, 1698 малчин хоршоонд бүртгүүлж, хоршооны гишүүн 404 малчин 14,6 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл авсан.	
225			Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй хортон, мэрэгч амьтдыг устгах	Хамруулсан бэлчээр нутаг	га	2022	19	20	Ургамал хамгаалал, эрдэм шинжилгээний хүрээлэнгээс 2023 онд намрын хортон мэрэгчийн тодотгох судалгааг Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт сумдад гүйцэтгэж, бэлчээр дэхь хортон, мэрэгч амьтдын тархалт хөнөөл учруулахаар түвшинд хүрээгүй тул зориудаар устгах шаардлагагүй дүгнэлт гарсан. Бусад сумдын бэлчээрт хортон, мэрэгч амьтдын бөөгнөрөл, нүлдэл, тархалт ажигдагдаагүй. Тус оны 8 дугаар сард аймгийн УЦУОШТ-өөс гүйцэтгэсэн бэлчээрийн төлөв байдал, ургац тодорхойлох судалгаагаар нийт бэлчээрийн газрын 98.7% нь хувь хүрэлцээтэй буюу нөөцтэй, 1.3% нь даац 1-5 дахин хэтэрсэн (сумдын төвийн орчимд) болохыг тогтоосон.	100%
226			Сумдад малын тэжээлийн ургамал тариалалтыг нэмэгдүүлэх	Бэлчээрийн ургамал тарьсан га хэмжээ	га	2022	20	25	Айраг, Даланжаргалан, Алтанширээ, Хатанбулаг, Өргөн, Иххэт, Дэлгэрэх, Эрдэнэ сумдын 12 иргэн, 2 аж ахуйн нэгж, 7 хоршоо нийт 116.24 га талбайд тэжээлийн ургамал тариалж, 146.6 тонн ургац хураан авч, урьд оноос талбайн хэмжээ 59 га-аар, ургацын хэмжээ 64 тонноор нэмэгдсэн. Тэжээлийн ургамал тариалах аргачлал, технологийн сургалт, зөвлөгөөг 8 сумын давхардсан тоогоор 7000 гаруй малчид, иргэдэд өгсөн. "Шинэ хоршоо" хөдөлгөөний хүрээнд Айраг, Алтанширээ, Улаанбадрах, Дэлгэрэх сумд тэжээлийн ургамал тариалах зориулалтаар 8 хоршоонд 45 га газрыг олгосон.	100%
227			Сумдын мал нядалгааны цэгийг эрүүл ахуйн	Засварласан мал нядалгааны цэг	тоо	2022	1	7	Сайншанд суманд мал төхөөрөх 1 үйлдвэр, Айраг, Алтанширээ, Дэлгэрэх, Мандах, Сайншанд, Сайхандулаан сумдад тус бүр 1, нийт 7 цэг үйл ажиллагаа явуулж байна. Үүний 10 гаруй хоршоо нь	100%

			шаардлагад нийцүүлэн засварлах						мах махан бүтээгдэхүүн, мал нядалгааны цэг байгуулах чиглэлээр төслөө бичиж боловсруулаад байна. "Шинэ хоршоо" хөдөлгөөний хүрээнд байгуулагдсан Даланжаргалан сумын "Өнгөтбаян бүрд", Дэлгэрэх сумын "Дэлгэрч дэвших дэртийн булаг" хоршоо нь нийт 610.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авч, мал нядалгааны цэг байгуулах ажил 80 гаруй хувьтай үргэлжилж байна.	
228			Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажил, отор нүүдэлд хяналт тавих	Хамрагдсан сум, тайлан	тоо	2022	14 1	14 сум 2 удаа 2 тайлан	Мал аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 28 дугаар тогтоол, ХХААХҮ-ийн сайдын 02, аймгийн Засаг даргын 03 дугаар албан даалгавар гарч, хэрэгжилт 90.5%-тай хангагдсан. Өвөл, хаврын улиралд хилийн зурваст 5 сумын 164 өрхийн 76,0 мянган толгой, улсын тусгай хамгаалалттай бүс нутагт 3 сумын 119 өрхийн 61,0 мянган толгой, нийт 8 сумын 283 өрхийн 137,0 мянган толгой малыг оторлуулахаар отор нүүдлийн зохион байгуулалтад оруулан, малын шилжилт хөдөлгөөнд тогтмол хяналтыг хэрэгжүүлж байна.	100%
229			Сумдад инженерийн хийцтэй худаг шинээр гаргах	Шинээр гаргасан худаг	тоо	2022	26	28	Бэлчээрт инженерийн хийцтэй-488, богино яндант-29, бетон хашлагат-534, энгийн уурхай -2177, нийт 3228 худгийг ашиглагдаж, бэлчээрийн 40.8% -ийг усжуулсан. Тайлант хугацаанд улсын төсвийн 94,8 сая төгрөгийн санхүүжилтээр Эрдэнэ -2, Сайхандулаан -1, сумын орон нутгийн хөгжлийн сангийн 296.0 сая төгрөгийн санхүүжилтээр Даланжаргалан-6, Улаанбадрах -2, Хатанбулаг-3, малчдын 60.0 сая төгрөгийн санхүүжилтээр Өргөн-3, Сайхандулаан -3, Сайншанд -1, нийт 21 инженерийн хийцтэй худгийг ашиглалтад оруулж, энгийн уурхайн 9 худгийг шинээр болон сэргээн засварласнаар 40 мянган га бэлчээрийг усжуулж, 98 мянган толгой мал услах боломжийг бүрдүүлсэн. Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны А/38 дугаар тушаалын хүрээнд улсын төсвийн 33,8 сая төгрөгийн санхүүжилтээр Алтанширээ, Өргөн, Мандах, Сайхандулаан, Эрдэнэ сумдын 26 цэгт усны	100%

									геофизикийн хайгуул судалгааны ажлыг “Ус амьдрал” ХХК гүйцэтгэсэн.	
230			Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт сумдын бэлчээрт хөнөөл учруулж буй үлийн цагаан оготнотой тэмцэх	Нөхөн сэргээсэн бэлчээрийн талбай	га	2022	0	42	Ургамал хамгаалал, эрдэм шинжилгээний хүрээлэнгээс 2023 онд намрын хортон мэрэгчийн тодотгох судалгааг Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Иххэт сумдад гүйцэтгэж, бэлчээр дэхь хортон, мэрэгч амьтдын тархалт хөнөөл учруулахаар түвшинд хүрээгүй тул зориудаар устгах шаардлагагүй дүгнэлт гарсан. Бусад сумдын бэлчээрт хортон, мэрэгч амьтдын бөөгнөрөл, нүлдэл, тархалт ажигдагдаагүй. Тус оны 8 дугаар сард аймгийн УЦУОШТ-өөс гүйцэтгэсэн бэлчээрийн төлөв байдал, ургац тодорхойлох судалгаагаар дээрх сумдын бэлчээрийн даац хүрэлцээтэй буюу нөөцтэй болохыг тогтоосон.	100%
231			Хур тундасны хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор үүлэнд зориудаар нөлөөлөх	Үүлэнд зориудаар нөлөөлсөн арга хэмжээ	тоо	2022	8	16	Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд зориулан 2024 онд 50 сум ашиглах нөөцийг бүрдүүлсэн. Ус цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2024 оны А/123 дугаар тушаалын дагуу 05 дугаар сарын 22-ний өдрөөс эхлүүлж 05 дугаар сарын 25-нд Айраг суманд, 05 дугаар сарын 28, 29-нд Мандах суманд цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг хийж гүйцэтгэсэн.	100%
232			Мал, амьтны халдваргүйтгэлийн ДУК автомашин худалдан авах	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Орон нутгийн төсвийн 185,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Мал эмнэлгийн байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд "Говийн төгөлдөр" ХХК 3 ширхэг “ДҮК” авто машиныг нийлүүлсэн. Тайлант хугацаанд 14 сумын 120.9 мянга м2 талбайд ариутгал халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулж, урьд оноос 61%-иар нэмэгдүүлсэн.	100%
233			“Масс мессеж” үйлчилгээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Илгээсэн мессеж	тоо	2022	151359	160000	Мал аж ахуйн салбарын цаг үеийн мэдээ, мэдээлэл, цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн богино, дунд хугацааны урьдчилсан мэдээг шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор “Масс мессеж” үйлчилгээг үзүүлж хэвшсэн. Тус үйлчилгээнд 5537 малчин бүртгүүлж, нийт малчин өрхийн 92%-ийг хамруулж, урьд оноос хэрэглэгчийн	100%

									тоо 0.9%-иар, мэдээлэл хүргэсэн малчны тоо 22%-иар тус тус өссөн. 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын хүрээнд орон нутгийн төсвийн 6.5 сая төгрөгийн санхүүжилтээр үйлчилгээний чанар, тасралтгүй найдвартай ажиллагааг хангах гэрээг үүрэн холбооны "Скайтел" ХХК-тай байгуулсан.	
234	Нөхөн сэргээлт хийсэн талбайг 30 хувиар нэмэгдүүлнэ.	Газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх хөтөлбөр	Дүйцүүлэн хамгааллын хүрээнд эзэнгүй орхигдсон газрыг нөхөн сэргээх	Нөхөн сэргээсэн талбай	га	2022	9.52	10	Аймгийн нутаг дэвсгэрт эвдэрсэн газрын тооллогын ажлыг аймгийн Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний 20,0 сая төгрөгийн санхүүжилтээр “Дорнын байгаль” ХХК-иар гүйцэтгүүлж, тооллогын урьдчилсан дүнгээр эвдрэлд орсон 77 байршилд 599.2 га талбайг өс.тп цахим мэдээллийн санд бүртгэсэн. Дээрх судалгааны ажлын үр дүнг үндэслэн "Түмэн айл инвест" ХХК,"Хөх жонш" ХХК, "Дунфанлунма" ХХК, "Би ти девелопмент" ХХК, "Хүдрэнт" ХХК, "Экилешия" ХХК, "Бишрэлт түшлэг" ХХК, "Фриеншип ресурсес" ХХК, "Билэгт баялаг" ХХК, "Хэрлэн импекс" ХХК, "Мегатек мануфактуринг Монголиа" ХХК, "Ачир" ХХК, "Сармай дээлт" ХХК, "Билэгт зурвас" ХХК, "Эрдэнэс цагаан суварга" ХХК, "Пауэрлэнд" ХХК зэрэг аж ахуй нэгжүүд дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд нийт 20 байршил 15.8 га талбайд нөхөн сэргээлт хийсэн.	100%
235			Уул уурхайн олборлолт болон төмөр зам, авто зам, барилга байгууламж барихтай холбоотой эвдэрсэн газруудыг нөхөн сэргээх	Нөхөн сэргээсэн талбай	га	2022	393.8	400	Хатанбулаг сумын Агаруут, Эргэл багийн нутагт Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 484.4км хүнд даацын авто зам байгуулах төслийн ажилд ашигласан түгээмэл тархацтай ашигт малтмалын 58 карьерын 311 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийгдсэнийг аймгаас томилогдсон ажлыг хэсэг газар дээр нь шалган хүлээн авах ажлыг гүйцэтгэж байна.	90%
Салбарын үр дүн 6.6: Монгол орны биологийн олон янз байдлыг 2020 оны түвшинд хадгална.										
236	Ашиглалт ад өртөмтгий	Биологийн төрөл зүйлийг	Дорноговь аймгийн нэн ховор, ховор,	Судалгаанд хамрагдс	тоо	2022	34	34.0	Хамарын хийдийн орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөг	90%

	амьтан, ургамлын ашиглалтын нөөцийг бүсчлэн бий болгоно.	хамгаалах үндэсний хөтөлбөр	ашиглалтад өртөмтгийн ургамлын судалгааны ажлыг зохион байгуулах	ан ургамлын тоо					боловсруулахад шаардагдах биологийн олон янз байдлын суурь судалгааны ажлыг "Ховор амьтан судлах нийгэмлэг", "Их нартын хамгаалалтын захиргаа"- хийсэн. Дээрх судалгааны ажлаар Хамарын хийд, Ханбаян зүрх хайрхан уул, Зоогийн хоолой, Хашаатын говь, зээгийн хөтөл орчмын 10 цэгт ургамлын төрөл зүйлийг тодорхойлох хэмжилт хийсэн. Их нартын байгалийн нөөц газарт хийгдсэн судалгаанд үндэслэн сурагчдад зориулан "Ургамлын мониторинг хийх арга зүй" гарын авлага гарган Ерөнхий боловсролын сурагчдад хүргэсэн. Дээрх сурагчдад зориулсан гарын авлагад 41 овгийн 128 төрөлд багтах 232 зүйлийн ургамлыг тодорхойлсон.	
237			Уулын туруутан амьтдын тархац нутгийн судалгааг гаргах	Судлагдсан газрын байршил, хэмжээ	тоо, га	2022	54	60	Алтанширээ 1, Айраг 3, Даланжаргалан 3, Иххэт 4, Мандах 9, Өргөн 7, Сайншанд 3, Сайхандулаан 5, Улаанбадрах 8, Хатанбулаг 6, Хөвсгөл 7, Эрдэнэ суманд 6 нийт нэр бүхий 62 газрыг хамруулан уулын туруутан амьтдын түүвэр судалгааг зохион байгуулсан. Дээрх судалгаагаар 1700 гаруй аргаль хонь, 800 гаруй янгир бүртгэгдсэн. Их нартын байгалийн нөөц газрын хамгаалалтын захиргаанаас аргаль хонь болон уулийн туруутны байршил нутагт мониторингийн судалгаа Их нартын БНГ-ын 5 байгаль хамгаалагч болон хамгаалалтын захиргааны ажилтнууд сар бүрийн 25-нд нэгдсэн тойролт хийж уулын туруутан амьтдын байршил, нутагшил, хооллолт, төллөлт зэрэгт мониторингийн судалгааг гүйцэтгэж, судалгаагаар 11 байршилд давхардсан тоогоор аргаль хонь - 461, хар сүүлтэй – 138, цагаан зээр – 654, янгир – 62 ажиглагдаж бүртгэгдэж байгаль хамгаалагчид өдөр бүр ажиглалт, эргүүл хяналтын ажлыг гүйцэтгэж байна. Нийт 73 байршил буюу нийт нутаг дэвсгэрийн 40 хувьд уулын туруутан амьтдын тархцын судалгааг хийсэн.	90%
Салбарын үр дүн 7.1: Авлигын үзүүлэлтээр 10 байр урагшилна.										
238	Авлигыг үл тэвчих соёл,	Авлигатай тэмцэх хөтөлбөр	Авлигын эсрэг хууль	Сурталчлал	тоо	2022	10	30	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар агентлаг байгууллага, сумдын Засаг даргын Тамгын	100%

	хандлагыг 20 хувиар нэмэгдүүлнэ.		тогтоомжийг сурталчлах						газарт чиглэл өгч хэрэгжилтэд хяналт тавих ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын хууль, эрх зүйн хэлтсээс хэрэгжүүлсэн ажилласан. Энэ хүрээнд Хууль, зүй дотоод хэргийн сайдтай байгуулсан гэрээ, агентлаг байгууллага, сумдын засаг дарга нартай аймгийн Засаг даргаас байгуулсан гэрээнд тусгаж тодорхой үйл ажиллагаанд зориулсан төсөв санхүүжилтийг шийдвэрлэсэн. Мөн авлигын эсрэг дараах онцлох арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан. Үүнд: 1. Авлигатай тэмцэх газрын Соён гэгээрүүлэх хэлтэс, Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран авлигын эрсдэл өндөр төрийн байгууллага болон тендерийн үнэлгээний хорооны гишүүдэд 2024 оны 8 дугаар сард сургалт зохион байгуулж чиглэл өгсөн. 2. Авлигыг мэдээлэх тусгай дугаар 110-ийг сурталчлан орон нутгийн сонинд хэвлүүлж 6000 гаруйг алслагдсан сумын малчин, хот айлд хүргэх ажлыг зохион байгуулсан. 3. Цахим орчноос мэдээлэл авах боломж хязгаарлагдмал буюу Дорноговь аймгийн нийт ахмад настанд зориулсан гарын авлага боловсруулж 3200 гаруй ахмад настанд нэг бүрлэн хүргэсэн бөгөөд иргэдэд нэн хэрэгцээ шаардлагатай төрийн байгууллагын утас болон авлигыг мэдээлэх 110 тусгай дугаарыг жагсаалтад оруулж сурталчилсан. 4. Орон нутаг дахь эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг дэмжих, сумдын ЗДТГ-аар үйлчилгээ авч буй иргэдэд авлигын эсрэг мэдээ, мэдээллийг хүргэх ажлыг нэгдсэн байдлаар зохион байгуулж байгууллагын үүд хэсэгт байршуулах хөлтэй банер хэвлүүлэн байршуулсан. 5. Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлан таниулах зорилгоор орон нутгийн хэмжээнд зохион байгуулагдаж байгаа томоохон уулзалт, зөвлөгөөний хөтөлбөрт тус хуулийг сурталчлан таниулах, авлигын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар сэдвийг тусгаж хэвшсэн бөгөөд нийт 8 удаагийн уулзалт зөвлөгөөнөөр 1200 гаруй иргэнд мэдээлэл хүргэсэн. Мөн эрх бүхий албан тушаалтнууд тайлант онд нийт 39 удаагийн сургалтаар 1560 төрийн албан хаагчдыг	
--	----------------------------------	--	------------------------	--	--	--	--	--	--	--

									хамруулсан. Түүнчлэн Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн чиглэлийн дагуу бэлтгэн гаргасан шторк, зурагт хуудас, цахим мэдээллийг тухай бүр нэгдсэн зохион байгуулалттайгаар түгээх, цахим хуудсанд байршуулах ажлыг тогтмол зохион байгуулсан. Дээрх арга хэмжээний үр дүнд төрийн албан хаагчид авлигыг мэдээлэх ойлголт, хандлага нэмэгдэж бусдад үлгэр жишээ болж авлигаас татгалзаж, авлигын талаар шуурхай мэдээлж, нийгэмд эерэг үлгэр дуурайлал үзүүлсэн.	
239			ЭБАТ-уудад сургалт зохион байгуулах	Сургалт	тоо	2022	1	3	Байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнуудыг удирдлага арга зүйгээр хангаж, тухай бүр зөвлөгөө мэдээлэл өгч хэвшсэн бөгөөд Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад эрх бүхий албан тушаалтнуудыг бүрэн хамруулсан. Мөн эрх бүхий албан тушаалтнуудыг чадавхжуулах, авлигатай тэмцэх газраас ирүүлсэн мөрдөгчийн тэмдэглэлийн хэрэгжилтийг хангах, нийтлэг гаргадаг алдаа дутагдал болон авлига өгөх, авах шалтгаан нөхцөлд анхаарч ажиллах талаар сургалтыг 3 удаа зохион байгуулж, 14 сумын Засаг даргын Тамгын газар, холбогдох агентлаг байгууллагын нийт давхардсан тоогоор 60 гаруй эрх бүхий албан хаагчдыг хамруулсан.	100%
240			Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалт зохион байгуулах	Хамрагдсан албан хаагч	тоо	2022	0	1600	Төрийн албаны зөвлөлийн Дорноговь аймаг дахь салбар зөвлөлөөс Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль батлагдсантай холбогдуулан 580 төрийн албан хаагч, цахимаар давхардсан тоогоор 620 төрийн албан хаагчдыг хамруулсан сургалт зохион байгуулсан. Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх ёс зүйн дэд хорооноос төрийн болон захиргааны байгууллагуудын 102, ёс зүйн дэд хорооны 300 гаруй албан хаагчдыг хамруулах нэгдсэн сургалтыг зохион байгуулахаар төлөвлөсөн.	100%
241			Авлигыг үл тэвчих нөлөөллийн контент бүтээх	Контент	тоо	2022	0	2	Авлигыг үл тэвчих, авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах талаар орон нутгийн онцлогт тохирсон 9 шторкийг орон нутгийн DTV-телевиз, Саранхөхөө театр, сумдын ЗДТГ-ын газартай хамтран бүтээж иргэд олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан. Тус контентыг орон	100%

									нутгийн мэргэжлийн жүжигчин, орон нутагт болсон бодит кейс дээр тулгуурлан бүтээсэн. Үүний үр дүнд төрийн албан хаагчид, иргэд авлигыг таслан зогсоох,мэдээлэх, авлигагүйгээр асуудлыг шийдвэрлэх боломжтой гэх эерэг ойлголт хандлагыг нийтэд хүргэсэн.	
242			Авлигын эсрэг "Дэвжээ-2024" тэмцээнийг зохион байгуулах	Тэмцээн	тоо	2022	1	1	Орон нутгийн хэмжээнд “Авлигатай тэмцэх” чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг эрчимжүүлэх, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлан таниулах, иргэд олон нийт, төрийн албан хаагчдад зөв хандлага төлөвшүүлэх зорилгоор "Дэвжээ-2024" тэмцээнийг 2024 оны 11 дүгээр сарын 16-наас 29-ний өдрийг хүртэл зохион байгуулсан. Тус тэмцээнд сумдын ИТХ, ЗДТГ, агентлаг, байгууллагын нийт 10 гаруй баг оролцож тэмцээнд өгөгдсөн даалгавруудын хүрээнд 2024 онд хийж хэрэгжүүлсэн ажил арга хэмжээ, авлигыг мэдээлэх тусгай дугаарыг сурталчилсан шторк бүтээх, илтгэл хэлэлцүүлэх агуулгын хүрээнд зохион байгуулагдаж нийт цахим болон танхимын хандалтаар 30,000 гаруй иргэдэд мэдээ, мэдээллийг хүргэсэн.	100%
Салбарын үр дүн 7.2: Хүний эрхийн баталгаа хангагдсан 80 орны нэг болно.										
243	Хүний эрхийн зөрчлийг 30 хувиар бууруулна.	Хүний эрхийг хангах хөтөлбөр	Хүний эрхийн талаар боловсрол олгох	Сургалт	тоо	2022	50	100	Хүний эрхийн талаар боловсрол олгох 80 гаруй удаагийн сургалтаар давхардсан тоогоор 8,000 гаруй төрийн албан хаагчийг хамруулсан. Хүний Эрхийн Үндэсний Комиссын Дорноговь аймаг дахь төлөөлөгчтэй хамтран хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах, хүний эрхийн боловсрол, соёлыг түгээн дэлгэрүүлэх хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажиллах чиг үүргийн байгууллагын албан хаагчдад харилцаа, хандлага, ёс зүйн лекц, сургалтыг 20 гаруй удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 1.2 мянга гаруй албан хаагчийг хамруулан ажилласан. Тайлант онд нийт 100 гаруй удаагийн сургалтыг зохион байгуулсан байна.	100%
244			Орон нутаг дахь хүний	Ажлын гүйцэтгэл	хувь	2022	0	1	Төрийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөө нь хүний эрхэд суурилсан	90%

			эрхийн төлөв байдлыг тодорхойлох, тайлагнах						эсэхийг үнэлэх, сайжруулах зорилгоор Хүний эрхийг хангах Үндэсний хорооны 2023 оны 01 дүгээр тогтоолоор баталсан “Орон нутаг дахь хүний эрхийн төлөв байдлыг тайлагнах, илтгэх журам”-ын 2.3-т жил бүрийн 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор аймгийн Засаг дарга орон нутаг дахь хүний эрхийн төлөв байдлыг тайлагнаахаар заасны дагуу тайланг боловсруулсан. Мөн хүний эрхийг хангах, хамгаалах хүрээнд тайлант хугацаанд Хүний Эрхийн Үндэсний Комиссоос ирүүлсэн 2 шаардлага, 1 зөвлөмжийн дагуу холбогдох төлөвлөгөөг боловсруулан хуулийн хугацаанд хэрэгжилтийг тайлагнан ажилласан.	
245			Замын-Үүдийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын өргөтгөл барих	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Аймгийн Засаг даргын 2024 оны А/160 дугаар захирамжийн дагуу ОНТ-ийн 54,2 төгрөгийн хөрөнгө оруулалтаар Замын-Үүд сумын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын барилгын өргөтгөлийн ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн.	100%
246			Хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах	Сургалт	тоо	2022	0	1	Хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах чиглэлийн хүрээнд урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулсан. Үүнд хүүхдийн эрх, хөдөлмөрлөх эрх, өмчлөх эрх, эрүүл аюулгүй орчинд амьдрах зэрэг тодорхой эрхийн хүрээнд 10 гаруй төрлийн төлөвлөгөөт арга хэмжээг хийж хэрэгжүүлсэн. Мөн эрүү шүүлтээс ангид байх эрхийн хүрээнд ШШГГ-ын цагдан хорих байранд шаарлагатай тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлж, аймгийн хэмжээнд нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулсан	100%
247	Шүүх дээр иргэний эрхийг хамгаалах тэгш эрхийн зарчмын хэрэгжилт	Өмгөөлөл хөтөлбөр	Хууль зүйн туслалцаа авах боломжийн талаар сурталчлах, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх	Өмгөөллийн үйлчилгээ авсан иргэд	тоо	2022	30	40	Хууль зүйн туслалцааны төвөөс 36 хэргийн 44 үйлчлүүлэгчид өмгөөллийн үйлчилгээ үзүүлэхээр хүлээн авсан бөгөөд 26 хэргийн 31 үйлчлүүлэгчид холбогдох хэрэг шийдвэрлэгдсэн. 10 хэргийн 13 хүнд холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцтай байгаа бөгөөд 82 иргэнд хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл өгсөн. Мөн иргэдэд мэргэжлийн зөвлөгөө, мэдээлэл үнэ төлбөргүй өгөх “ХУУЛЬЧИЙН ПРО БОНО ӨДӨРЛӨГ”-ийг 2024.05.01-ний өдөр аймгийн	100%

	ийг 10 хувиар нэмэгдүүлнэ								Шүүх, Прокурорын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Өмгөөлөгчдийн холбоо, Хууль зүйн туслалцааны төв, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Нийгмийн даатгалын газар, Төрийн цахим үйлчилгээний хурдан төв, Архивын тасаг, Хүний эрхийн үндэсний комиссын орон нутаг дахь ажилтантай хамтран зохион байгуулан 200 гаруй иргэнд хууль, эрх зүйн зөвлөгөө мэдээллийг үнэ төлбөргүй өгсөн. Түүнчлэн 14 сумын ЗДТГ-аас нийт 280 гаруй иргэнд зөвлөгөө өгч аймгийн хэмжээнд нийт 600 гаруй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлсэн.	
248	Жендерийн тэгш байдлын үзүүлэлтийг 15 хувиар сайжруулна.	Жендерийн эрх тэгш байдал хөтөлбөр	Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, салбар дундын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Хэрэгжилт	хувь	2023	30	70	Аймгийн Жендэрийн салбар хороог аймгийн Засаг даргын 2023 оны А/253 дугаар захирамжаар 16 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. "Жендэрийн бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ"-г хэрэгжүүлэхээр 2024 онд 4 зорилт, 18 заалт бүхий төлөвлөгөөг батлуулж, тэгш хүртээмжтэй тусламж үйлчилгээг жигд хүргэх бодлого барин ажиллаж байна. Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн салбарт 1087 эрүүл мэндийн ажилтан ажиллаж байгаагаас 85.6% эмэгтэй, 14.4% нь эрэгтэй, 36 буюу 3.3% нь ХБ иргэн ажиллаж байна. "Дэээрэт" ОУ-ын Энэрлийн байгууллагын 136 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгтэйгээр аймгийн Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн тасагт "Эрэгтэйчүүдийн кабинет"-ийг ЭМС-ын 2022 оны А/449 дүгээр тушаалаар батлагдсан "Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх кабинетын үлгэрчилсэн загвар, ажиллах журам"-ын дагуу 2024 оны 2-р сард шинээр нээж, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй орон нутагтаа авах боломжийг бүрдүүлэв. Тус кабинет нээснээр Урологийн эмчийн үзлэгт 22 хүн хамрагдаж, үүнээс мэс засал шаардлагатай 8 хүнд хагалгаа хийж, тусламж үйлчилгээг түргэн шуурхай үзүүлжээ. Мөн Дорноговь, Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр аймгуудын 600 гаруй эмэгтэйчүүдийг хамруулж нийгэмд тулгамдаж буй асуудал, оролцох оролцоо,	90%

									хандлага төлөвшлийг сайжруулах чиглэлээр “Дулаахан” говийн бүсийн эмэгтэйчүүдийн чуулганыг зохион байгуулсан.Монгол Улсын Засгийн Газар, Жендэрийн Үндэсний Хороо Монгол Улсын Ерөнхий сайдын 71 дүгээр захирамжаар батлагдсан “Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2027)”-г үндэсний хэмжээнд танилцуулах ажлыг зохион байгуулж тус цахим сургалтад 150 гаруй төрийн алба хаагчид хамрагдсан.	
249			Орон нутгийн төрийн захиргааны байгууллагад жендер хариуцсан орон тоог бий болгох	Батлагдсан орон тоо	тоо	2023	0	1	Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн баталх тухай 2024 оны 01 сарын 02-ны өдрийн А/02 дугаар захирамжийн дагуу Нийгмийн бодлогын хэлтсийн Жендэрийн эрх тэгш байдал, салбар дундын бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтний орон тоог батлаж, томилогдон ажиллаж байна.	100%
Салбарын үр дүн 7.3: Гадаад таатай орчныг бэхжүүлнэ.										
250	Монгол Улсын Азийн эрх мэдлийн индексэд эзлэх байрыг 3.5 хувиар нэмэгдүүлнэ.	Гадаад харилцаа бодлого, хамтын ажиллагаа хөтөлбөр	Гадаадын улс орнуудтай хамтран олон талт арга хэмжээг зохион байгуулах	Арга хэмжээ	тоо	2023	13	18	Хөрш орнууд болон өндөр хөгжилтэй орнуудын хот, муж, аймгуудтай уламжлалт найрамдалт харилцааг өргөжүүлэн хөгжүүлж БНХАУ-ын 5 хот, хошуудтай, ӨМӨЗО-ны Эрээн хот, Бугат хот, Хөх хот, Улаанцав хот, Шилийн гол, Дархан Муу мянган холбоот хошуу, Жининь хот, Дөрвөд хошуу г.м), БНСУ-ын 2 /Өмнөд Чолла, Гванжу/хоттой, Япон улсын 2 /Шизуока, Яйзү хот/ мужтай, Дорноговь аймгийн 4 сумыг ӨМӨЗО-ны хот, хошуудтай, 13 байгууллагыг холбогдох байгууллагуудтай холбоо тогтоож бүх талаар харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх хэлэлцээр байгуулсан. Хамтын ажиллагааны хүрээнд мэргэжилтэн бэлтгэх, туршлага судлуулах, суралцуулах арга хэмжээг зохион байгуулж, Япон улсын Шизуока мужид Ерөнхий боловсролын сургуулийн 62 сурагч, 9 багш, 35 төрийн албан хаагч, БНСУ-ын Сөүл хотод 12 эмч, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бугат хот, Дархан Муу Мянган Холбоот хошуунд 15 эмч, Шилийн гол, Бугат хот, Эрээн хот, Улаанцав хот, Дархан Муу Мянган Холбоот хошуу зэрэгт 60 гаруй төрийн албан хаагч,	90%

									Тайвань хотод 3, Малайз улсад 1, Сингапур 1, БНСУ-д 14 төрийн албан хаагчийг урт богино хугацааны сургалтад хамруулсан. Мөн хамтын ажиллагааны хүрээнд 7 тэрбум гаруй төгрөгийн 10 төсөл, хөтөлбөр хэрэгжиж гадаадын хөрөнгө оруулалтыг орон нутагтаа татан ажиллаж байна. БНХАУ-ын Хунан мужийн Жан жяжие хоттой хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах асуудал хэрэгжилтийн шатандаа явж байгаа бол 2024 оны байдлаар шинээр 8 санамж бичгийг байгуулсан байна.	
Салбарын үр дүн 7.4: Батлан хамгаалах чадавхыг бэхжүүлнэ.										
251	Иргэдийн эх оронч үзлийг төлөвшүүлнэ.	Зэвсэгт хүчин хөтөлбөр	Салбарын бодлого шийдвэрийг иргэдэд сурталчлан таниулж, эх оронч үзлийг төлөвшүүлэх арга хэмжээ зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээ	тоо	2022	10	15	Монгол цэргийн дайчин замнал, Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг аймаг, орон нутагт сурталчлах, иргэд, хүүхэд залууст, цэрэг Эх-оронч үзлийг төлөвшүүлэх нөлөөллийн арга хэмжээг жил бүр зохион байгуулж хэвшсэн. Зэвсэгт хүчний 336 дугаар анги, Орон нутгийн телевизүүдтэй хамтран “Цэргийн нэг өдөр” гэх мэт нэвтрүүлэг бэлтгэх, Зүүнбаян Цэргийн хүрээний Марш-тактик, тусгай бэлтгэлийн аварга тасаг шалгаруулах тэмцээн, Дорноговь аймгийн соёлын байгууллагуудтай хамтран “Цэрэг эрсийн дуулал” цэрэг Эх-орны сэдэвтэй дууны уралдаан, Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагаас бэлтгэл, чөлөөнд гарсан ахмадууд болон Ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдын дунд “Мөрдөстэй ахмадууд” арга хэмжээ, Монгол Улсын баатар Д.Данзанваанчигийн хөшөөт цогцолбор, 6 баатрын хөшөөнд цэцэг өргөх ёслолын ажиллагаа, аймгийн Ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдын дунд “Цэрэг Эх-оронч” сэдэвтэй “Гоцлол дуу”, “Хамтлаг дуу”-ны уралдаан, Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын нэгдсэн оройн тоо /туяа тоо/, спортын цогцолбор тэмцээн, “Мөрдөстэй үдэш” үдшийн цэнгүүн зэрэг арга хэмжээг тус тус зохион байгуулсан. Дээрх нөлөөллийн арга хэмжээгээр дамжуулан Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг жил бүр дунджаар 2000 гаруй ард иргэнд шууд	90%

									байдлаар, 5000 гаруй иргэнд цахим болон мэдээллийн сувгуудаар мэдээлэл хүргэж ажилласан.	
252			Оюутан цэрэг сургалт зохион байгуулах	Сургалта д хамрагдсан оюутан	тоо	2022	14	20	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 111 дүгээр тогтоол, Батлан хамгаалахын сайдын 2023 оны А/103 дугаар тушаал, Дорноговь аймгийн Засаг даргын 2023 оны А/266 дугаар захирамжаар 2023 онд 14 оюутан, 2024 оны А/266 дугаар захирамжийн дагуу 20 оюутан нийт 34 оюутныг "Оюутан цэрэг" сургалтад хамруулсан. Сургалтын сонгон шалгаруулалт, эрүүл мэндийн үзлэг, биеийн тамирын шалгуур үзүүлэлтээр зохион байгуулсан. Хүсэлт гаргаж сонгон шалгаруулалтад тэнцсэн Дорноговь аймаг дахь Анагаахын шинжлэх ухааны салбар сургуулийнн, Политехникийн коллежийн оюутнуудад "Цэргийн ерөнхий бэлтгэл" шатны сургалтыг 04, 05, 06 саруудад зохион байгуулсан. "Цэргийн ерөнхий бэлтгэл" шатны сургалтад амжилттай хамрагдсан нийт 20 оюутныг Дорноговь, Сайншандаас Өмнөговь аймгийн Даланзадгад сумын Зэвсэгт хүчний 167 дугаар ангид 06, 07, 08 дугаар сард зохион байгуулагдсан "Мэргэжлийн бэлтгэл" шатны сургалтад хамруулсан.	100%
253			Хилийн цэргийн болон зэвсэгт хүчний анги салбаруудын орчин нөхцөлийг сайжруулах	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	ОНТ-ийн 330,0 сая төгрөгөөр Зэвсэгт хүчний 336, 065 дугаар цэргийн анги, байгууллага, бие бүрэлдэхүүний албан үүргээ гүйцэтгэх нөхцөлийг хангахад дэмжлэг үзүүлсэн байна.	100%
254			Орон нутгийн хамгаалалт томилгоот нэгжийн сургалт зохион байгуулах	Сургалт зохион байгуулсан тоо	тоо	2022	1	3	Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн 6.3, 7.2-4 дахь заалт, 11.1, 11.2, 11.3.2, 11.3.3, 11.4.2 дахь заалтууд, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалтаар, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалт, Батлан хамгаалахын сайдын 2024 оны А/110 дугаар тушаал, Засгийн газрын батлан хамгаалах зарим чиг үүргийг Дорноговь аймагт төлөөлөн 2024 онд хэрэгжүүлэх	100%

									гэрээний 3.2, 4.2, 4.4 дахь заалтууд, аймгийн Засаг даргын А/770 дугаар захирамжийн дагуу Орон нутгийн хамгаалалтын хээрийн сургуулийг 2024 оны 11 дугаар сарын 10-аас 17 -өдрүүдэд Зэвсэгт хүчний 336 дугаар анги, Тусгай хүчний командлалын 335 дугаар ангийн сургалтын бүлэгтэй хамтран 14 сумын орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн 100 иргэнийг хамруулан зохион байгуулсан.	
Салбарын үр дүн 7.5: Төрийн бүтээмжийн сэргэлт										
255	Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангана	Үндэсний аюулгүй байдал хөтөлбөр	Орон нутаг дахь Үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх нөхцөл байдлыг тодорхойлж, түүнд чиглэсэн арга хэмжээ авах	Авсан арга хэмжээ	Тоо	2022	0	2	Жил бүрийн аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөг Үндэсний аюулгүй байдлыг хангах орон нутгийн бодлогын баримт бичигтэй уялдуулан боловсруулж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан “Орон нутаг дахь Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын удирдах бүрэлдэхүүн, удирдах ажилтны зөвлөгөөн”-д “Дорноговь аймгийг хөгжүүлэхэд тулгарч буй болон цаашид учирч болох эрсдэлүүд”-ийг тодорхойлж, илтгэл, мэдээлэл бэлтгэн ажилласан. Тус эрсдэлүүдийг шийдвэрлэх арга замыг тодорхойлж, хариу арга хэмжээ авах ажлыг тогтмол зохион байгуулж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ мэдээллээр хангах орон нутаг дахь ажлын хэсгийн бүрэлдэхүүнд харьяа чиглэлдээ тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлж түүнд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн 2024 оны орон нутаг дахь Үндэсний аюулгүй байдлыг хангах тайланг боловсруулсан.	70%
256			Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын талаар иргэдэд мэдээлэл, сургалт зохион байгуулах	Мэдээлэл, сургалт	Тоо	2022	2	4	Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын талаар иргэдэд мэдээлэл, сургалт зохион байгуулах салбар бүрийн уялдаатайгаар зохион байгуулж хүн амын удмын сангийн аюулгүй байдал, оршин тогтнохуйн аюулгүй байдал, хүнсний аюулгүй байдал зэрэг хууль тогтоомжид заасан үндсэн чиг үүргийн хүрээнд сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж эх оронч үзэл төлөвшүүлэх, эрүүл монгол хүн байх, угийн бичиг хөтлөлт, хүний эрхийг хүндэтгэх, түүх өв соёлоо хадгалан хамгаалах талаар нийт 42,000 гаруй	100%

									иргэнийг хамруулсан. Тус сургалтыг тогтмол зохион байгуулснаар үндэсний аюулгүй байдлын талаар иргэдийн ойлголт, хандлага нэмэгдэж судлах иргэдийг тоо нэмэгдсэн.	
257	Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашгийг 20 хувиар нэмэгдүүлнэ.	Төрийн өмчийн бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөр	ОНӨААТҮГ, ХХК-уудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, үр ашгийг нэмэгдүүлэх	Арга хэмжээ	Тоо	2022	1	6	Орон нутгийн өмчит компаниудын төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаанд орон нутгийн өмчит 6 компанид хяналт шалгалтыг зохион байгуулсан. Шалгалтаар төлөөлөн удирдах зөвлөлийн материалтай танилцаж сургалтанд хамрагдаагүй гишүүдийн судалгааг гаргасан. Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компаниудын үйл ажиллагаа, өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдал, компаниудын удирдлага, хүний нөөц, сайн засаглалд тулгамдаж буй асуудалд мониторинг хийхэд Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд улс төрийн албан тушаалтан томилсон байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 5.3 дах заалттай зөрчилдөж байгааг тухайн компанийн хувьцаа эзэмшигч болон удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд танилцуулан заавар зөвлөмж өгч ажилласан. Төлөөлөн удирдах зөвлөл гүйцэтгэх захирал хоорондын уялдаа холбоо дутмаг гэх нийтлэг зөрчил дутагдал илэрсэн учраас Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай хамтран 2024 оны 10 дугаар сарын 29-ны өдөр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн удирдлага, арга зүй, Компанийн засаглалын олон улсын сайн засаглал ба Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, компаниудын өмчлөл, засаглал, үр өгөөжийг сайжруулах, Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагааг сайжруулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.	70%
258	Чадахуйн зарчмыг хангаж буй төрийн алба	Төрийн албаны ерөнхий удирдлага хөтөлбөр	Төрийн албан хаагчийн мэргэшсэн байдлын үнэлгээг нэмэгдүүлэх	Төрийн албан хаагчийн мэргэшсэн	Хувь	2022	80	100	Төрийн албан хаагчдыг ажлын байранд нь сургах, мэргэшүүлэх чиглэлээр Удирдлагын академитай хамтран богино болон мэргэшүүлэх багц сургалтуудад албан хаагчдыг шат дараатай хамруулж ажиллалаа. Удирдлагын академийн эрхэлсэн болон ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц	100%

	хаагчдын нийт төрийн албан хаагчдад эзлэх хувийг 20 хувиар нэмэгдүүл нэ			байдлын үнэлгээ					сургалтад 9, мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 23, мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 13, шинээр томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх сургалтад 28 албан хаагчийг тус тус хамруулан мэдлэг ур чадварыг дээшлүүлсэн. УА-ийн сургагч багшийн сургалтад 4 албан хаагч, нийт 77 төрийн захиргааны албан хаагч мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байна. Мөн тайлант онд хувийн зардлаар сурах иргэдийн судалгааг УА-д хүргүүлж, мэргэшүүлэх сургалтад нийт 27 албан хаагчын суралцах хүсэлтийг илгээж нэмэлт элсэлтэд хамрагдсан байна.	
259			ХШҮ-ний чиглэлээр албан хаагчдыг мэргэшүүлэх, сургах	Албан хаагчид	Тоо	2022	10	100	Хяналт-шинжилгээ, үнэлгээний талаарх ойлголтыг нэмэгдүүлэх төрийн болон нутгийн бодлогын баримт бичгийг хяналтад авах, хэрэгжилтийг эрчимжүүлэх, тайлагнах болон үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ хийх арга зүйд сургах зорилгоор сум, агентлагийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан болон тухайн чиг үүргийг хэрэгжүүлдэг нийт 50 албан хаагчдад "Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ" сэдэвт сургалтыг 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдөр зохион байгууллаа. Сургалтаар "Хяналт-шинжилгээ, үнэлгээний үндсэн ойлголт", "Бодлогын баримт бичгийг төлөвлөх арга зүй", "Тайлан бичих арга зүй, анхаарах асуудал", "Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд ХШҮ хийх арга зүй" зэрэг 8 сэдвээр мэдээлэл хүргэж, дадлага ажил зохион байгуулан үр дүнг тооцон ажиллалаа. Мөн давхардсан тоогоор 18 байгууллагын 41 гаруй албан хаагчид хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлангийн талаар болон ХШҮ-ний цахим сангийн хэрэглээний талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.	100%
260		Төрийн албаны ерөнхий удирдлага хөтөлбөр	Зарим төрийн байгууллагууд ад автомашины парк шинэчлэлт хийх	Парк шинэчлэ лт хийсэн авто машин	тоо	2023	0	4	Айраг, Даланжаргалан, Хатанбулаг, Мандах, Улаанбадрах, Сайншанд сумын Захирагчийн ажлын албанд, Ахмадын сувилал, Хүүхдийн зуслан Эрүүл мэндийн газар, Зүүнбаян багийн Ажлын албанд, Прокурорын газарт, Цагдаагийн газар, Мал эмнэлэгийн газруудад нийт 1.5 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 18 автомашиныг нийлүүлсэн.	100%

261			Онцгой байдлын газрын барилгын их засварын ажил	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 6/15 дугаар тогтоолоор Онцгой байдлын газрын коридорын барилгын их засварын ажлыг гүйцэтгэхэд 81,5 сая төсвийг баталсан. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам, худалдан авах ажиллагааны 2024 оны төлөвлөгөөний дагуу тус оны 02 дугаар сард Онцгой байдлын газрын барилгын засварын ажлын тендер шалгаруулалтын төсөл арга хэмжээг Засгийн газрын худалдан авах ажиллагааны tender.gov.mn цахим системээр зарлаж “Дэнжийн цамхаг” ХХК шалгарч, ажил гүйцэтгэх гэрээ байгуулан, тайлант оны 03-04 дүгээр сард ажлыг гүйцэтгэсэн. Онцгой байдлын газрын коридорын барилгын их засварын ажлыг 04 дүгээр сарын 05-ны өдөр барилга байгууламжийг Улсын комисс ашиглалтад хүлээн авсан.	100%
262			Онцгой байдлын газарт Нисдэг тэрэгний шатахуун тээврийн тусгай зориулалтын тоноглол бүхий автомашин худалдан авах ажил	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Агаараас эрэн хайх, аврах 111 дүгээр ангид агаараас эрэн хайх аврах ажиллагааны-1, иргэдийн амь насыг аврах, яаралтай тусламж үзүүлэх чиглэлээр-3 удаагийн дуудлага өгч, аврах ажиллагааг амжилттай зохион байгуулсан. Цаашид энэ төрлийн дуудлага мэдээлэл ихсэх хандлагатай тул тус ангиас нэгэн зэрэг 2 нэгж техникээр аврах ажиллагааг зохион байгуулах боломжтой, нисдэг тэрэгний шатахуун цэнэглэх, тээвэрлэх асуудлыг орон нутагтай хамтран шийдвэрлэхээр Онцгой байдлын газрын 2023 оны 25/272 дугаар албан бичгийг аймгийн Засаг даргад тусгай зориулалтын шатахуун тээврийн автомашины хүсэлтийг судалгааны хамт хүргүүлсэн. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн 2023 оны 15 дугаар хуралдаанаар агаараас эрэн хайх, аврах ажиллагааны зориулалттай нисдэг тэрэгний шатахууны тээвэрлэх, нөөц бүрдүүлэх, шатахуун тээврийн автомашинд 90,0 сая төгрөгийг 2024 оны орон нутгийн төсөвт суулган, АИТХ-ын 2023 оны 6/15 дугаар тогтоолоор батлуулсан. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ	30%

									худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Онцгой байдлын газарт Нисдэг тэрэгний шатахуун тээврийн тусгай зориулалтын тоноглол бүхий автомашин худалдан авах тендер шалгаруулалтын төсөл арга хэмжээг Засгийн газрын худалдан авах ажиллагааны tender.gov.mn цахим системээр тайлант хагас жилийн байдлаар 2 удаа зарлахад тендер нээх товлосон хугацаанд оролцогч ирээгүй тул тендер шалгаруулалт хүчингүй болсон.	
263			Хатанбулаг Бүх сум-ын барилгын дээврийн болон гадна засвар хийх	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Хатанбулаг сумын ЗДТГ-ын барилгын дээврийн болон гадна засвар хийх ажлыг Орон нутгийн төсвийн 285,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Эргэл хийц" ХХК гүйцэтгэж бүрэн ашиглалтад оруулсан.	100%
264			Төрийн албан хаагчдын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжих	Эрдэм шинжилгээний ажил	тоо	2022	3	4	2024 онд Говийн ноён хутагт Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жилийн ойд зориулсан “Ноён хутагтын өв, өнгөрсөн, одоо, ирээдүй” олон улсын эрдэм шинжилгээний VI их хурлын илтгэлүүдийн эмхтгэлийг 500 хувийг 5 сая төгрөгөөр хэвлүүлсэн.	30%
265			Замын-Үүд, Иххэт, Дэлгэрэх, Улаанбадрах сумдын төрийн албан хаагчдын орон сууц худалдан авах, засварлах, барих	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Иххэт суманд орон нутгийн төсвийн 190,0 сая төгрөгийн хөрөнгө 2024 онд 2 өрөө орон сууц 2, 3 өрөө орон сууц 1 тус тус худалдан авсан. Улаанбадрах суманд төрийн албан хаагчийн 6 айлын орон сууц барих ажлыг орон нутгийн төсвийн 467,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Зэс орд" ХХК ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан, ажлын явц 15%. Дэлгэрэх суманд орон нутгийн төсвийн 608,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар төрийн албан хаагчийн 6 айлын орон сууц барих ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах тендер 2 удаа зарлагдаж амжилтгүй болсон ба 3 дахь удаагийн тендер шалгаруулалт 2024 оны 10 дугаар сарын 31-нд нээгдэж "Дэлгэр цамхаг өргөө" ХХК шалгарсан.	50%
266			Аймгийн төвийн зарим төрийн байгууллагын	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Аймгийн Засаг даргын Тамгын газарт арга хэмжээ, үйл ажиллагаа зохион байгуулахад шаардлагатай иж бүрэн техник хэрэгслийг 350 сая төгрөгийн төсөвт өртгөөр худалдан авч ажилласан.	100%

			үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай техник тоног, төхөөрөмж худалдан авах						Саран хөхөө театрын шинэ барилгад шаардалгатай байгаа хөгжим, гэрэлтүүлэг, лед дэлгэц болон бусад тоног төхөөрөмжийг 700,0 сая төгрөгийн төсөвт өртгөөр худалдан авах ажлыг зохион байгуулсан. Цахим шилжилт, цахим засаглалыг эрчимжүүлэхээр 14 сумд, 20 сургууль, 65 багийн Засаг дарга нарт компьютер, техник хэрэгслийн шинэчлэлт хийж орон нутгийн төсвийн 1,2 тэрбум 51,9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Хатанбулаг 51.2 сая төгрөг, 57.7 сая төгрөг, Хөвсгөл 63.0 сая төгрөг, Улаанбадрах суманд 56.7 сая төгрөгөөр тус тус техник хэрэгсэл, лед дэлгэцийг худалдан авч, нийт 4 сумын Соёлын төвийн техник хэрэгслийг сайжруулахаар орон нутгийн 228.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар тохижуулсан. ЕБ-ын 1-р сургуульд 121.0 сая төгрөгийн “Дижитал анги” шинээр нээж, хүүхдүүдийн хичээлийг “VR” төхөөрөмжөөр виртуал орчинд үзэх боломжийг бүрдүүлж, нийт 2.0 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлснээр төрийн үйл ажиллагаа хэвийн явагдаж, ажлын бүтээмж нэмэгдсэн байна.	
267			Сайхандулаан сумын Цохио багийн төвийн барилгад засвар хийх	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Орон нутгийн төсвийн 120,0 сая төгрөгийн хөрнгө оруулалтаар Сайхандулаан сумын Цохио багийн засварын ажлыг "Хүрэл Соёмбо" ХХК гүйцэтгэж, бүрэн ашиглалтад оруулсан боловч улсын комисс тодорхойгүй шалтгааны улмаас ажиллаагүй.	90%
268			Хөрөнгө оруулалтын ажлын зураг төсөв гүйцэтгэх	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Хөрөнгө оруулалтын ажлын зураг төсөв гүйцэтгэх Багц-1 ажилд Криетив монголиа ХХК шалгарч ажлын гүйцэтгэл 80%, Багц-2 ажилд Гидродизайн инноваци ХХК шалгарч ажлын гүйцэтгэл 50%-тай явагдаж байна.	70%
269	Төрийн худалдан авалтын үр ашгийг 5 хувиар нэмэгдүүлнэ.	Төрийн худалдан авалт хөтөлбөр	Аймгийн 2024 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Төлөвлөгөөний хэрэгжилт	хувь	2022	98	100	Дорноговь аймгийн 2024 оны төсөв батлах тухай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор 138 төсөл арга хэмжээний 101.0 тэрбум төгрөг батлагдсаны дагуу аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах 2024 оны төлөвлөгөөг төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулсан. Үүнээс аймгийн Засаг даргын захирамжаар 27.4 тэрбум төгрөгний 77 төсөл арга хэмжээг захиалагчийн эрхийг шилжүүлж цахим системээр	90%

									илгээсэн. Аймгийн Засаг даргын Тамгын газраас 465.0 сая төгрөгний 2 төсөл арга хэмжээ нэмэгдэж ирсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар яамдуудаас 11 төсөл арга хэмжээний 49.8 тэрбум төгрөгний эрх шилжиж ирсэн. Нийт худалдан авах ажиллагааны газрын цахим системээр зарлагдах 63 төсөл арга хэмжээнээс 60 төсөл арга хэмжээг tender.gov.mn сайтад нээлттэй ил тод байдлаар зарласан. Үүнээс: 51 төсөл арга хэмжээнийг гэрээ байгуулсан. Ажлын тоо хэмжээ ирээгүй байгаа 3 төсөл арга хэмжээ, 6 төсөл арга хэмжээ хүчингүй болсон. Гүйцэтгэл 95.2 хувьтай байна.	
270	Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн найдвартай байдлын түвшинг 5 хувиар нэмэгдүүлнэ	Төрийн архив, албан хэрэг хөтлөлт хөтөлбөр	Төрийн архивын ажилтнуудын ажлын өрөө, уншлагын танхимд их засварын ажил хийх	Засварын ажлын гүйцэтгэл	хувь	2022	0	100	Архиваар үйлчлүүлэгчдийн ая тухтай байдлыг хангах, ажилтнуудын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны А/67 дугаар тушаалаар 19,9 сая төгрөгийн төсвийг баталсан. Их засварын ажилтай холбогдуулан аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны А/73 дугаар тушаалаар "Төрийн архивын ажилтнуудын өрөө, уншлагын танхимын их засварын ажлыг гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулах ажлын хэсэг" байгуулагдаж "Эйбол" ХХК-ийг шалгаруулан, 19,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар архивын өрөө болон уншлагын танхимын өрөөнүүдэд их засварын ажлыг бүрэн хийсэн.	100%
271			Төрийн архивт дохиолол хяналтын систем суурилуулах	Суурилуулсан хяналтын камер	тоо	2022	0	10	Төрийн архивын аюулгүй байдлыг хангах зорилгоор Архивын тасагт дохиолол хяналтын камерын систем суурилуулах зардлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны төсөвт тусгасан. Төрийн архивт дохиолол хяналтын камерын систем суурилуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг 2024 оны 10 дугаар сард явуулсан ба "Сор-Уул" ХХК шалгарсан. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасаг нь "Сор-Уул" ХХК-тай гэрээ байгуулан, дээрх ажлыг гүйцэтгүүлсэн. Архивын сан хөмрөгийн болон ажилчдын өрөө, уншлагын танхимд нийт 5,0 сая төгрөгөөр 10 ширхэг хяналтын камер, 5ш утаа	100%

									мэдрэгч суурилуулан холболтын ажлууд бүрэн хийгдсэн.	
272		Төрийн архив, албан хэрэг хөтлөлт хөтөлбөр	Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн үзлэг зохион байгуулах	Үзлэгт хамрагдсан байгууллага	тоо	2019	71	100	Аймгийн Засаг даргын 2024 оны А/211 дүгээр захирамжаар “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн Засаг даргын нэрэмжит үзлэг зохион байгуулах” комиссын бүрэлдэхүүн, ажлын удирдамж, шаардагдах зардлын төсвийг баталсан. Үзлэг зохион байгуулах комиссын хурлыг 2024 оны 04 сарын 04-ний өдөр хуралдаж, үзлэгийн шалгуур үзүүлэлт, үзлэгт хамрагдах байгууллагын жагсаалт, үзлэгийн хуваарийг хэлэлцэн баталсан.	30%
273				Үзлэгийн дундаж үнэлгээ	хувь	2019	79	83	Үзлэгийн шалгуур үзүүлэлт, хуваарийг үзлэгт хамрагдах төрийн байгууллагуудад аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаас албан бичгээр хүргүүлсэн. Үзлэг 2024 оны 05 дугаар сард явуулах байсан боловч цаг үеийн ажлаас болж хойшлогдсон.	30%
274	Бүртгэлийн зөрчлийн тоог 10 хувиар бууруулна	Улсын бүртгэл хөтөлбөр	Бүртгэлийн нотлох баримтын бүрэн гүйцэд байдалд хяналт шалгалт хийх	Хяналт шалгалт	тоо	2022	20	30	Улсын бүртгэлийн хэлтсээс төлөвлөгөөт хяналт шалгалт 5, өргөдөл, санал гомдлын мөрөөр 49 шалгалтыг хийсэн. Иргэний бүртгэлийн чиглэлээр 1571, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 657, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 76, архивын чиглэлээр 241 бүртгэл шалгаж, нийт 330 зөрчил илрүүлэн, 441 зөрчил шийдвэрлэж 8,5 сая төгрөгийн торгууль оногдуулсан.	100%
275	Хил хамгаалах чадавхыг 20 хувиар нэмэгдүүлнэ	Улсын хил хамгаалал хөтөлбөр	Хилийн ангиудад орчин үеийн техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, хилчдийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх	Дэмжлэг	тоо	2022	3	6	Хилийн цэргийн ангийн орчин нөхцөлийг сайжруулах, хилчдийн ажиллах, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 0108, 0129 дүгээр ангид тус тус 80,0 сая төгрөг, 0168 дугаар ангид 180,0 сая төгрөг нийт 340,0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн. Тус дэмжлэгийн хүрээнд 1.Хилийн цэргийн 0108 дугаар анги - 2 салбарын хилчдийн байрыг засварлах 2. Хилийн цэргийн 0168 дугаар анги- алба хаагчдын 8 айлын орон сууцанд урсгал засвар хийж, Улсын хил хамгаалалтыг удирдах “Удирдлагын төв”-ийг шинээр тохижуулах 3. Хилийн цэргийн 0168 дугаар анги – шуурхай удирдлагын төв, номын сан, алжаал тайлах өрөө, соёл амралтын танхим, хүүхэд хөгжлийн өрөө,	100%

									хилийн цэргийн салбаруудын 54 айлын орон сууцны засварын ажил болон 0143 дугаар салбарын хариуцсан хэсгийн 10 км газарт инженерийн торон саадыг хийх зэрэг ажлуудыг тус тус хийж гүйцэтгэсэн байна.	
276			Хилийн өргөст торон саадыг үе шаттай засварлахад дэмжлэг үзүүлэх	Дэмжлэг	тоо	2023	0	3	Хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг ханган хилийн цэргийн байгуулалтыг хөгжүүлж, хил хамгаалалтын чадавхыг дээшлүүлэх хүрээнд тайлант онд олгосон дэмжлэгийн хүрээнд хилийн торон саадыг үе шаттай засварлах ажлыг хийж гүйцэтгэж байна. Хилийн цэргийн 3 ангид нийтдээ 340.0 сая төгрөгөөр засвар, тохижилт ажил мөн 0143 дугаар салбарт 10 км газарт инженерийн торон саадыг шинэчлэх зэрэг дэмжлэг үзүүлсэн. Хилчдийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулах хүрээнд тайлант онд нийт 652,0 сая төгрөгийн дэмжлэгийг хилийн цэргийн ангиудад олгосон. Хилийн 0129 дүгээр ангийн Таван толгой хилийн харуулын байрыг шинээр барих, 10 кВт -ын ЦДАШ татах, хилийн 0168 дугаар ангийн мөр хянах зурвас татах, гүний худаг гаргах, ус цэвэршүүлэгч тавих алба орон сууцанд урсгал засвар хийх, улсын хил хамгаалалтыг удирдах “Удирдлагын төв”-ийг шинээр тохижуулах, шуурхай удирдлагын төв, номын сан, алжаал тайлах өрөө, соёл амралтын танхим, хүүхэд хөгжлийн өрөөг засварлах, хилийн цэргийн салбаруудын орон сууцны засварын ажил болон 0143 дугаар салбарын хариуцсан хэсгийн 10 км газарт инженерийн торон саадыг хийх, хилийн 0108 дугаар ангийн орон сууцны барилгын их засвар хийх, 2 салбарын хилчдийн байрыг засварлах, инженерийн байгууламж, өргөст утсан хашааг сэргээн засварлах, эргэлтийн цэг тэмдэгжүүлэх зэрэг ажлуудыг тус тус хийж гүйцэтгэсэн байна.	100%
277	Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хувийг 3 хувиар	Шүүхийн шийдвэр гүйцэтгэл хөтөлбөр	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын албан хаагчдыг мэргэшүүлэх	Сургалтад хамрагдсан албан хаагч	тоо	2022	1	2	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь алба хаагчдыг чадавхжуулах сургалтыг зохион явуулах төлөвлөгөөнд нийт 5 агуулгын хүрээнд 32 сэдвээр сургалт зохион явуулахаар төлөвлөсний дагуу 150 цагийн сургалтыг зохион байгуулж сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлсэн. Мөн Шүүхийн шийдвэр	100%

	нэмэгдүүл нэ.		сургалтад хамруулах						гүйцэтгэх ерөнхий газраас ирүүлсэн чиглэлийн дагуу алба хаагчдыг чиглэл тус бүрээр мэргэшүүлэх сургалтыг төлөвлөгөөний дагуу зохион явуулан ажиллаж байна. Үүнд: 1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2. Цэргийн нийтлэг дүрэм, 3. Шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ, 4. Үл хөдлөх хөрөнгийн албан дуудлага худалдаа зэрэг сэдвүүдээр 7 хоногт 2-с багагүй цагаар сургалтыг зохион байгуулсан.	
Салбарын үр дүн 8.1: Орон нутагт амьдарч буй хүн амын тоог 4 хувиар нэмэгдүүлнэ.										
278	Улаанбаа тар хотоос шилжин ирэгчдийн аймгийн нийт хүн амд эзлэх хувийг 2 хувьд хүргэнэ.	Хөгжлийн бодлого хөтөлбөр	Түрээсийн орон сууц хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Ашиглалта д орсон орон сууцны айл	тоо	2022	0	144	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023.07.04-ний өдрийн 12/02 дугаартай тогтоолоор "Дорноговь аймгийн зорилтот бүлгийн иргэдийг түрээслээд өмчлөх орон сууцад хамруулах журам"-ыг батласан. 2023 онд зарласан Түрээсийн орон сууц худалдан авах Багц-1 ажлын тендерт 13.5 тэрбум төгрөгийн өртөгөөр "Гантулга трейд" ХХК шалгарч, Сайншанд сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт Мандах наран-5 хороололд 72 айлын 2 блок, нийт 144 айлын орон сууцыг орон нутагт хүлээлгэн өгсөн. Тус ажлын 2-р багцад "Энержи парагон" ХХК шалгарч 30 айлын орон сууцыг 3.3 тэрбум төгрөгийн өртөгөөр нийлүүлэх гэрээ байгуулсан. Сайншанд сумын 3-р багт "Энержи парагон" ХХК нь гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийг хэрэгжүүлж, үйлчилгээтэй 144 айлын 2 блок орон сууц барьж, дээрх орон сууцны 1-р блокноос түрээсийн 30 айлын орон сууцыг гэрээний дагуу нийлүүлсэн. 2024 онд орон нутгийн хөгжлийн сангийн 15.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Замын-Үүд суманд Түрээсийн орон сууц хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг "Гантулга трейд" ХХК гүйцэтгэхээр шалгарч гэрээ байгуулсан. Тус компани нь Замын-Үүд сумын 1-р багийн нутаг дэвсгэрт 288 айл /72 айл*4 блок/-ын орон сууцны төсөл хэрэгжүүлж, угсралтын ажлын явц 70%-тай байна. Уг орон сууцнаас 1 м2 нь 2.4 сая төгрөгийн өртөг бүхий 129 айлын орон сууцыг гэрээний дагуу нийлүүлнэ.	90%

279			Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд шилжин суурьшигчдад зориулсан газар төлөвлөх	Тухайн жилийн газар төлөвлөлт өөс шилжин суурьшигчдад зориулсан газар	хувь	2022	20	20	Газрын тухай хуульд 2023 оны 12 дугаар сарын 07-ний өдөр орсон нэмэлт өөрчлөлтөөр газартай холбоотой аливаа хүсэлтийг зөвхөн egazar.gov.mn цахим системээр хүлээн авах, өргөдлийн бүртгэлийн мэдээллийн санд бүртгэгдсэн дарааллын дагуу шийдвэрлэхээрх хуульчилсан тул шилжин суурьшигчдад зориулсан газрыг шийдвэрлэх боломжгүй болсон. Дээрх тулгарч буй асуудлыг шийдвэрлэх талаарх санал хүсэлтийг ГЗБГЗЗЕГазарт уламжилсан.	30%
280			Шилжин суурьшигчдад чиглэсэн цахим системийн баяжилтыг тогтмол хийх	Баяжилт хийсэн тоо Хандалтын тоо	тоо	2022	0	10 20000	Нээлттэй аймгийн хүрээнд huduu.mn цахим хуудсанд аймгийн талаарх 133 мэдээ мэдээллийг байршуулсан. Аймгийн талаарх мэдээ мэдээлэл, аймгийн онцлог, бүтээн байгуулалт, амьдрах таатай орчин, аялал жуулчлал, бизнес эрхлэх боломж, газар зохион байгуулалт, ажлын байрны зар мэдээг авах боломжийг бүрдүүлсэн гар утасны "Нээлттэй Дорноговь" аппликейшныг бүтээж 4200 гаруй татагдан ашиглагдаж байна.	70%
281			Шилжин суурьшигчдад чиглэсэн санхүүгийн боломжийг орон нутагт бий болгох	Шилжин суурьшигчдад үзүүлж буй санхүүгийн дэмжлэг	төгрөг	2022	60	70	"Алсын хараа-2050" Монгол улсын Засгийн газрын урт хугацааны хөгжлийн бодлогын "Шинэ сэргэлтийн бодлого"-ын үзэл санаа, зорилго, зорилт, үйл ажиллагааны хүрээнд тайлант хугацаанд орон нутагт шилжин суурьшсан 49 иргэнд нийт 4,2 тэрбум төгрөгийн ипотекийн зээл олгосон.	100%
282	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн бэлэн байдлыг 15 хувиар нэмэгдүүлнэ	Албан ёсны статистик хөтөлбөр	Аймгийн эдийн засаг, нийгмийн үзүүлэлтийг судлан, товхимол гаргах	Товхимол	тоо	2022	1	2	Аймгийн нийгэм, эдийн засгийн танилцуулга: Албан ёсны статистикийн 39 нэр төрлийн мэдээ, захиргааны статистикийн 54 төрлийн мэдээ болон хуульд заасан тооллого, түүвэр судалгааг холбогдох төрийн байгууллага, иргэн, аж ахуйн нэгжээс сар, улирал, жилийн давтамжтайгаар цуглуулж, нэгтгэн аймгийн нийгэм, эдийн засгийн 2023 оны жилийн эцсийн эмхтгэлийг боловсруулж, хэлтсийн албан ёсны вэб сайтад байршуулж, хэвлэмэл болон цахим хэлбэрээр давхардсан тоогоор 6600 гаруй хэрэглэгчдэд тархааж, мэдээ мэдээллээр хангаж ажиллав. Салбаруудын сэдэвчилсэн "Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга-2023", "Хүн ам, өрхийн үндсэн үзүүлэлт-2023", "Амьдарч буй орчин,	100%

									нийгмийн үзүүлэлтүүд-2023", "Аж үйлдвэр, барилгын салбарын танилцуулга-2023" судалгааг боловсруулан статистикийн хэлтсийн цахим сайтад байршуулж, 4 удаагийн давтамжтай хэвлэмэл болон цахим хэлбэрээр давхардсан тоогоор 6600 гаруй хэрэглэгчдэд тараасан.	
283			Аймгийн эдийн засаг, нийгмийн үзүүлэлтийг судлан, статистикийн мэдээллийн санг баяжуулах	Нэмэгдсэн мэдээлэл	тоо	2022	360	380	www.1212.mn сан дахь статистикийн мэдээллийн нэгдсэн сан гийн үндсэн 6 бүлэг, 54 дэд бүлгийн 363 үзүүлэлтийг жил бүр шинэчилж байна. Азийн Хөгжлийн Банкны техникийн туслалцааны дэмжлэгтэйгээр "Төрийн нэгдсэн мэдээллийн сангийн хөгжүүлэлт, удирдлага" төслийг 2023 оноос эхлэн хэрэгжүүлсний үр дүнд "Төрийн нэгдсэн өгөгдлийн сан", "Төрийн мета өгөгдлийн нэгдсэн сан" системүүдийг 2024 онд нэвтрүүлсэн. Энэхүү системүүд нь нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтын тогтолцоог бүрдүүлэхээс гадна өгөгдөл, мэдээллийн хэрэглээг нэмэгдүүлэх, өгөгдлийн үнэ цэнэ, ач холбогдлыг таниулах зорилготой. Мөн их хэмжээний өгөгдлийг хадгалах, боловсруулах, дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүлсэн. Төрийн нэгдсэн өгөгдлийн сан нь төрийн байгууллагуудын өгөгдөл, мэдээлэлд үнэлгээ хийж, мэдээллийн зөрүүтэй байдлыг арилгах, өгөгдлийн чанарыг сайжруулахаас гадна мэдээллийн эрэлт хэрэгцээг хангах, олон нийтэд ил тод, хүртээмжтэй байдлыг бий болгох ач холбогдолтой. Төрийн нэгдсэн өгөгдлийн сангаас нийгэм, эдийн засгийн 36 үзүүлэлтийг тоо, график дүрслэл болон дүн шинжилгээ хийсэн байдлаар аймаг, сумын түвшинд мэдээлэл гаргаж авах боломж бүрдсэн.	100%
Салбарын үр дүн 9.1: Өмчийн эрхийн хамгааллаар 20 байр ахина.										
284	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн тоог 5 хувиар	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн хэсэгчилсэн арга хэмжээг	Арга хэмжээний тоо	тоо	2022	5	8	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр "Шаргын овоо", "Гэрэл", "Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх", "Цахим", "Сүм хийд-2024", "ШТС-2024", "Цахим залилан шийдвэр", "Мөнгөө эрсдэлээс хамгаалж, ирээдүйгээ баталгаажуулъя" зэрэг 8 арга хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулсан. Арга хэмжээнүүдийн хүрээнд өмчлөх эрхийн эсрэг гэмт	90%

	бууруулна. а.		зохион байгуулах						хэргийн талаар иргэд олон нийтэд сургалт мэдээллийг хүргэх чиглэлээр хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор иргэн 40.000 гаруй иргэдэд мэдээлэл хүргүүлж ажилласан. 2024 кны 10 дугаар сарын байдлаар өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 14.7%-аар буурсан эерэг өөрчлөлттэй байна.	
285			Байр, орон сууц, орц камержуулах аян зохион байгуулах	Аяны тоо	тоо	2022	0	1	Байр, орон сууц, орц камержуулах хүрээнд "Нэг баг, нэг хороо, нэг сум" аяныг зохион байгуулж аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж 1196 аж ахуй нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын камерын талаарх судалгааг гаргасан. Аяны хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагууд стандартад нийцсэн камерын системээр тоноглогдож, барилга байгууламжийн гадна гэрэлтүүлэг нь ойр орчимд байгаа эд зүйл харагдах, камерын бичлэгт орж байхаар гадаад орчны аюулгүй байдлыг хангаж ажилласан.	100%
286			Хөршийн холбоог сайжруулахад чиглэсэн контент хийх	Контентийн тоо	тоо	2022	0	1	Хөршийн холбоог сайжруулах чиглэлээр Цагдаагийн ерөнхий газрын урьдчилан сэргийлэх газраас бэлтгэн ирүүлсэн 6 видео контентыг Дорноговь аймгийн цагдаагийн газар болон Дорноговь цагдаа, Замын-Үүд цагдаа цахим хаягт байршуулан иргэдэд түгээх ажлыг зохион байгуулж, 11552 хүнд хүрч 13518 хандалтыг авсан.	90%
Салбарын үр дүн 10.1: Хариуцлагатай уул уурхайн нийт үйлдвэрлэлийг 57.2 хувиар нэмэгдүүлнэ.										
287	Уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтын хэмжээг 50 хувь нэмэгдүүлнэ	Олборлолт, уул уурхайн хөтөлбөр	Уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн улмаас байгаль орчинд учрах сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор авто болон төмөр зам байгуулах, өргөтгөхөд	Үзүүлсэн дэмжлэг	тоо	2022	0	1	Айраг, Даланжаргалан, Сайхандулаан, Мандах, Хөвсгөл сумдын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа 11 компанид 581.1 км тусгай зориулалтын авто замын чиглэлийг батлан үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлсэн. Тавантолгой-Ханги чиглэлийн хатуу хучилттай авто замын ажлыг хэвийг явуулахад орон нутгаас түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах зөвшөөрлийг олгож дэмжлэг үзүүлсэн нийт 58 байршил карьерын 311 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийснийг аймгаас томилогдсон ажлыг хэсэг газар дээр нь шалгах ажлыг гүйцэтгэж байна.	100%

			дэмжлэг үзүүлэх							
288			Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтэд тулгуурлан сөрөг нөлөөллийг бууруулах	Биелэлтийн хувь	хувь	2022	86	93	2024 онд аймгийн хэмжээнд 58 аж ахуй нэгжийн төсөл хөтөлбөрүүд байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлуулан хэрэгжүүлэн ажилласан. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 тушаалаар батлагдсан журмын дагуу ажлын хэсэг 2024 оны 12-р сарын 31-ний дотор биелэлтийг дүгнэнэ. "Түмэн айл инвест" ХХК, "Хөх жонш" ХХК, "Дунфанлунма" ХХК, "Би ти девелопмент" ХХК, "Хүдрэнт" ХХК, "Экилешия" ХХК, "Бишрэлт түшлэг" ХХК, "Фриеншип ресурсес" ХХК, "Билэгт баялаг" ХХК, "Хэрлэн импекс" ХХК, "Мегатек мануфактуринг Монголиа" ХХК, "Ачир" ХХК, "Сармай дээлт" ХХК, "Билэгт зурвас" ХХК, "Эрдэнэс цагаан суварга" ХХК, "Пауэрлэнд" ХХК зэрэг аж ахуй нэгжүүд дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд нийт 20 байршил 15.8 га талбайд нөхөн сэргээлт хийсэн.	70%
289			Уул уурхайн баяжуулах, боловсруулах үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлэх	Үзүүлсэн дэмжлэг	тоо	2022	2	3	"Алтанширээ сумын нутаг дэвсгэрт баригдаж буй Газрын тос боловсруулах үйлдвэрийн Технологийн бус барилга байгууламжийн ажлыг "JMC projects India" компани гүйцэтгэж ажлын явц 100 хувийн гүйцэтгэлтэй, Улсын комисс ажиллуулах бэлтгэл ажил хангагдаж байна. Анхдагч процессын болон дагалдах байгууламж болон үйлдвэрийн цахилгаан станцын суурийн ажлууд хийгдэж байна. "Монголиан транс ложистик" ХХК-ийн "Алтанширээт" үйлдвэрлэл технологийн паркийн барилгын ажил 45 хувийн гүйцэтгэлтэй, Айраг сумын нутаг дэвсгэрт "Алтраг ахас" ХХК-ийн манган боловсруулах үйлдвэрийн барилгын ажил 95 хувийн гүйцэтгэлтэй, Цагаан суваргын зэс молбидены үйлдвэрийн хөвүүлэн баяжуулах үйлдвэр, бутлуурын хэсэг, тээрмийн барилгын суурийн цутгалт 85 хувь, краказ угсралтын ажлууд 30 хувийн гүйцэтгэлтэй, нийт төслийн ажил 55 хувьтай, Хөвсгөл сумын нутагт баригдаж буй "Гэрэлт говь" үйлдвэрлэл технологийн паркийн угаах үйлдвэрийн барилгын ажил 95 хувьтай, коксын үйлдвэрийн барилгын ажил 20 хувьтай, төмөр замын далан, гүүрэн байгууламжийн	90%

									ажил 100 хувьтай нийт төслийн ажил 40 хувийн гүйцэтгэлтэйгээр ажлаа үргэлжлүүлж байна. Монгол Улсын Засгийн газраас үйлдвэрлэл технологийн паркаар зарлагдсан Алтанширээ сумын нутаг дэвсгэрт байрлах "Алтанширээт" үйлдвэрлэл технологийн паркийн 674.4 га, Хөвсгөл сумын нутаг дэвсгэрт байрлах "Гэрэлт говь" үйлдвэрлэл технологийн паркийн 264.38 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авах саналыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэсэн. Сайншанд сумын 3 дугаар багийн нутагт хаягдал тосноос дизель түлш гаргах үйлдвэрийг "Саус ресурс" ХХК барьж ашиглалтад оруулахаар барилгын ажил хийгдэж байна. Тус үйлдвэрийн барилгын ажлыг хэвийн явуулахад дэмжлэг үзүүлэх талаар Санамж бичиг байгуулахаар хүлээгдэж байна. Төрийн байгууллагуудаас үйл ажиллагааг хэвийн явуулахад чиглэсэн 5 удаагийн дэмжлэг үзүүлсэн.	
290		Эрчим хүчний түүхий эдийг хангах хөтөлбөр	Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг нүүрсний уурхайг түшиглэн дулааны үйлвэрлэлийг дэмжих	Үзүүлсэн дэмжлэг	тоо	2022	1	1	Дорноговь аймгийн хэмжээнд 11 сумдын нутагт 49 ашиглалтын талбайд уул уурхайн үйл ажиллагаа явагдаж байна. "Түмэн айл инвест" ХХК-иас Мандах сумын төсвийн 5 байгууллага, айл өрхийн хэрэгцээнд 600 тонн нүүрс, Хатанбулаг суманд 400 тн нүүрс, "Сора интернэшнл" ХХК Хөвсгөл сумын төвлөрсөн уурын зуухны түлшийг 100 хувь бэлтгэн нөөцөлж, иргэн ААНБ-н байгууллагыг дулаанаар тасралтгүй хангахад дэмжлэг үзүүлсэн байна. Улсын төсвийн 5.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн төвийн дулааны станцыг орчин үеийн дэвшилтэт техник технологиор өргөтгөн шинэчилж дулааны үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлж нүүрс зарцуулалтыг бууруулж, хэрэглэгчдийг тасралтгүй дулаанаар хангах нөхцөлийг бүрдүүлэхээр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарласан. Орон нутгийн төсвийн 600.0 сая төгрөгийн хөрөнгөөр Сайншанд сумын ашиглалтын шаардлага хангахгүй болсон дулааны шугам сүлжээний засвар шинэчлэлтийн ажлын гүйцэтгэгчээр "Энгүүмэл оргил" ХХК шалгарч гэрээ байгуулж ажлаа эхлүүлсэн.	90%

Салбарын үр дүн 10.2: Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг 6 хувиар нэмэгдүүлнэ.

291	Эрчимжсэн аж ахуйн эрхлэгчийн тоог 15 хувиар нэмэгдүүлнэ.	Мал аж ахуйн хөтөлбөр	Эрчимжсэн аж ахуйн чиглэлээр зээл авсан иргэн ААН-ийн үйл ажиллагаанд хяналт тавих, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх	Хийгдсэн хяналт, хүргүүлсэн зөвлөмж	тоо	2022	0	4, 10-с дээш	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан удирдамжийн хүрээнд Даланжаргалан, Өргөн, Эрдэнэ, Замын-Үүд сумдын 2 аж ахуйн нэгж, 4 иргэний эрчимжсэн аж ахуйг хяналт шалгалтад хамруулсан. 2024 оны төлөвлөгөөт хяналт шалгалтад Сайншанд, Өргөн, Эрдэнэ, Замын-Үүд сумдын 4 иргэн, 2 аж ахуйн нэгжийн 8 объектыг хамруулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг 80%-тай хангасан. Хяналт шалгалтын явцад илэрсэн 71 зөрчлийг арилгуулж, 6 иргэн, 1 аж ахуйн нэгжид улсын байцаагчийн 71 заалт бүхий 7 албан шаардлагыг хүргүүлж, 1 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа түр хугацаагаар зогсоох арга хэмжээ авсан.	90%
292			Малчид, иргэдийн захиалгын дагуу бод, бог малын зохиомол хээлтүүлэг хийх	Зохиомол хээлтүүлэгт хамрагдсан мал	тоо	2022	1137	484	Биотехнологийн дэвшилтэт технологийг орон нутагт нэвтрүүлэх ажлын хүрээнд иргэн, аж ахуйн нэгж болон малчдаас бод, бог малд зохиомол хээлтүүлэг хийлгэх захиалга авч Алатау, Хар тарлан үүлдрийн 50 толгой үхэрт, 434 толгой Дэлгэрэхийн улаан омгийн ямаа, Нутгийн монгол хонь, ямаа нийт 484 толгой малд шингэлсэн үр болон гардан хээлтүүлэг хийхээр төлөвлөсөн. Тайлант хугацаанд Өргөн сумын 4 малчны алатау, монгол үүлдрийн 30 үхэрт шингэлсэн үрээр, "Цагаан сүүний буян" ХХК-ий 35 толгой хар тарлан үүлдрийн үхэрт гардан хээлтүүлэг, Дэлгэрэхийн улаан омгийн ямаа, монгол үүлдрийн 434 толгой хонь, ямаанд шингэлсэн үр болон гардан хээлтүүлэг, нийт 499 толгой малд зохиомол хээлтүүлэг хийсэн. Төлөвлөгөөт зохиомол хээлтүүлгийн ажлыг 100 хувь гүйцэтгэсэн.	100%
293			Өндөр ашиг шимт малын дуудлага худалдаа, үзэсгэлэн зохион байгуулах	Үзэсгэлэн худалдаа	тоо	2022	1	1	Нутгийн гойд ашиг шимт үржлийн мал шалгаруулах, өндөр ашиг шимтэй малыг олон нийтэд сурталчлан таниулах, малчид, үйлдвэрлэгчдийг харилцан туршлага судлуулах зорилгоор "Шилмэл мал-2024" үзэсгэлэн худалдааг Сайншанд суманд зохион байгуулсан. Үзэсгэлэнд 14 сумын малчид 156 толгой нутгийн шилмэл малыг оролцуулж, 5 төрөлд 6 гол үзүүлэлтээр шалгаруулж,	100%

									Дэлгэрэх, Замын-Үүд, Сайхандулаан, Өргөн, Эрдэнэ, Сайншанд сумдын 24 толгой малыг "Шилмэл мал"-аар шалгаруулсан.	
Салбарын үр дүн: 10.3: Стандартын шаардлага хангасан хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нийлүүлэлтийг 10 хувиар нэмэгдүүлнэ.										
294	Стандартын шаардлага хангасан хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлэгчдийн тоог 10 хувиар нэмэгдүүлнэ	Мал аж ахуйн хөтөлбөр	Малын эмч мэргэжлээр суралцах элсэгчдийг тоог нэмэгдүүлэх хүрээнд тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах	Элсэгчид	тоо	2022	3	5	Малын эмч, мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх орон нутаг дахь 11 удаагийн сургалтад давхардсан тоогоор 798 албан хаагч, эмч, мэргэжилтэн, улс, бүсийн чанартай 68 удаагийн сургалт, хуралд давхардсан тоогоор 230 албан хаагч, эмч, мэргэжилтэн тус тус хамруулсан. Дорноговь аймгийн нутгийн Улаанбаатар хот дахь нутгийн зөвлөлийн тэтгэлэгт хөтөлбөрт орон нутгаас 2 малын эмч мэргэжлээр оюутан хамрагдаж суралцах хугацааны /5 жил/ сургалтын төлбөрийг бүрэн төлүүлэхээр гэрээ байгуулан суралцаж байна.	100%
295			Малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд хяналт тавих	Хяналт	тоо	2022	6	8	Аймгийн хэмжээнд мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд "Мал эмнэлгийн нэгдсэн систем"-ээр хяналт тавин бүртгэлжүүлж байна. Тайлант хугацаанд 2343813 тн мах, 385 кг сүү, 63.2 тн дайвар бүтээгдэхүүн, 15.1 тн арьс, шир тн ноос, 49.6 тн ноолуурыг 25.8 тн хянан ширхэг гарал үүслийн гэрчилгээ олгосон. Малын шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг тогтмолжуулж, 70,994 толгой малд үзлэг тандал хийж, гадагшаа чиглэсэн 1387 толгой малд гэрчилгээ олгон, урьд оноос малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний хэмжээ 0.9 %-иар, олгосон гэрчилгээний тоо 3863 ширхэгээр тус тус өссөн. Аймгийн мал эмнэлгийн лаборатори сүүний 1.6 тн дээж, махны 64.1 тн дээж, хүлээн авч шинжлэн, 12 төрлийн өвчин оношлон хариу арга хэмжээ авч ажилласан.	90%
296			Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, малчдын хамтын ажиллагааг сайжруулах нөлөөллийн ажлыг зохион байгуулах	Арга хэмжээ	тоо	2022	23	35	Тайлант хугацаанд 14 суманд мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч 9, тархвар зүйч 3, мал эмнэлгийн нэгжийн эмч 29, нийт 36 малын эмч, мэргэжилтэн 8,130 дуудлага хүлээн авч, малчин, мал бүхий иргэний хотонд хүрч үйлчилгээ үзүүлсэн. Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, мал эмнэлгийн үйлчилгээ авах заавар, зөвлөмж бүхий 8 төрлийн 8700 гаруй гарын авлага материалыг 14 сумын 5643	90%

									малчид, иргэдэд хүргэж, цахим орчинд давхардсан тоогоор 25 төрлийн постер, 4 төрлийн богино хэмжээний видео мэдээлэлийг байршуулж, 1300 үзэгчээс хандалт авсан. Сумдын мал эмнэлэгийн үйлчилгээний 29 нэгж, нийт 5856 малчинтай хамтран ажиллах гэрээ байгуулж, үйлчилгээ үзүүлж байна. Урьд онтой харьцуулахад дуудлага үйлчилгээний тоо 0.2%-иар, малчид, иргэдэд хүргэсэн мэдээлэл 0.5%-иар, үйлчилгээний хүртээмж 10%-иар тус тус өссөн.	
297			Мал амьтны шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд төлөвлөсөн малыг бүрэн хамруулах	Хамрагдсан мал	тоо (сая)	2022	1.3	1.1	Аймгийн хэмжээнд шимэгчтэх өвчнөөс эмчлэх, мал эмнэлгийн халдваргүйтгэлийн арга хэмжээг Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2024 оны А/26 дугаар тушаал, аймгийн Засаг даргын А/529 дүгээр захирамжийн хүрээнд мал амьтны шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд нийт 621.8 мянган толгой мал хамруулахаар төлөвлөж, угаалгад 43.4 мянган толгой, туулгалтад 169.1 мянган толгой, боловсруулалтад 143.7 мянган толгой, нийт 356.2 мянган толгой мал хамруулж, гүйцэтгэл 57.4%-тай, урьд оноос хамруулсан малын тоо 48%-иар өссөн.	50%
298			Мал амьтны гоц халдварт өвчний гаралтыг бууруулах	Бууралт	хувь	2022	25	10	Мал, амьтны гоц халдварт 2 төрлийн өвчин давхардсан тоогоор 11 суманд оншлогдож, нийт 14577 толгой малч өвчилсөнөөс 10 толгой мал хорогдож, 127 толгой малын шинж тэмдэг арилж, 14440 толгой малыг зориудын аргаар устгаж, 6 устгалын цэгт холбогдох заавар, зөвлөмжийн дагуу булшилж, халдваргүйтгэлийг 820 м2 талбайд гүйцэтгэсэн. Гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 3 төрлийн дархлаажуулалтад 630619 толгой хонь, 73489 толгой үхэр, 46055 толгой хонь, ямааг хамруулж, төлөвлөгөө 72.9%-тай хэрэгжсэн. Дархлаажуулалтад хамруулсан малын тоо урьд оноос 44%-иар буурсан, гоц халдварт өвчний гаралт 20%-иар өссөн.	30%
299			Мал амьтны халдварт өвчний	Бууралт	хувь	2022	40	50	Тус аймагт оншлогдож байсан 5 нэр төрлийн малын халдварт өвнөөс урьдчилан сэргийлэх 7 төрлийн дархлаажуулалтад 421126 толгой мал хамруулахаар төлөвлөж, 353,324 толгой мал	70%

			гаралтыг бууруулах						хамруулж, гүйцэтгэл 83.9%-тай хангагдсан. Тайлант хугацаанд халдварт өвчний гаралт 25%-иар буурч, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдалт урьд оноос 1.1%-иар өссөн.	
300			Мал амьтны халдварт өвчний тандалт, шинжилгээний ажлыг зохион байгуулах	Мал	тоо	2022	41000	48000	Шүлхий, бог малын мялзан өвчний халдварын хүрээг тодорхойлох тандалт шинжилгээнд 14 сумын 30 өрхийн 480 малаас цусны дээжийг цуглуулан шинжилгээг хийж гүйцэтгэн УМЭАЦТЛ-д хүргүүлэн ажилласан. Тандалт шинжилгээнд УТ-н 4,9 сая төгрөгийн санхүүжилтээр хийж гүйцэтгэсэн. Бруцеллёзын хээлтүүлэгчийн тандалт 2024 тандалт шинжилгээнд нийт 14 сумын 1030 хээлтүүлэгч малаас ийлдсийн дээж цуглуулан розбенгалын урвалаар эерэг дүнтэй 10 дээж илэрсэн. Эерэг дээжийг ХХУ-н шинжилгээг хийн баталгаажуулан тайлан мэдээг нэгтгэн УМЭАЦТЛ-д хүргүүлэн ажилласан. Тандалт шинжилгээнд УТ-н 13,8 сая төгрөгийн санхүүжилтээр хийж гүйцэтгэсэн. Адууны халдварт цус багадах өвчин, адууны африк мялзан, ям, нийлүүлгийн өвчний тандалт шинжилгээнд 14 сумын 70 өрхийн 140 цусны дээжийг цуглуулан ийлдсийг ялган УМЭАЦТЛ-д хүргүүлэн ажилласан. Тандалт шинжилгээнд УТ-н 4,0 сая төгрөгийн санхүүжилтээр хийж гүйцэтгэсэн. Мал амьтны гоц халдварт Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын дараах мониторинг хийх тандалт шинжилгээнд 14 сумын 42 малчин өрхийн 126 толгой үхэрээс цусны дээж аван ийлдсийн ялган УМЭАЦТЛ-д хүргүүлэн ажилласан. Уг тандалт шинжилгээнд УТ-н 4,7 сая төгрөгийн санхүүжилтээр хийж гүйцэтгэсэн.	70%
301		Газар тариалан	Амтат гуа, сонгины шинэ сортын үрийг үржүүлэн үрийн хангамжийг нэмэгдүүлэх	Үрийн хангамжийн өсөлт	хувь	2022	2,2	8,0	Сорт сорилтын ажлын хүрээнд "Мөнх ашиг" хоршоо эртийн байцааны 1, сонгино 1, тарвасны 1, сармис 1, бууцай 1, гүзээлзгэнэ 1, чавганы 40 ширхэг суулгац, нийт 7 төрлийн сортын үрийг шинэчилж, амтат гуаны 2 сортыг ирээдүйтэй сортоор батлуулахаар туршилтын ажлыг 4 дахь жилдээ үргэлжлүүлж байна. Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас 75,0 сая төгрөгийн өртөг бүхий 11 нэр төрлийн хүнсний ногооны элит үрийг 14 сумын 198 тариалан эрхлэгчид, орон нутгаас 3,8	90%

									төгрөгийн үнэ бүхий 3 тн төмсний элит үрийг Сайншанд, Эрдэнэ, Сайхандулаан Даланжаргалан сумдын 23 тариаланчид тус тус 80%-ийн хөнгөлөлттэй үнээр нийлүүлж, аймгийн хэмжээнд үрийн хангамжийг урьд оноос 10.3%-иар нэмэгдүүлсэн. Мөн орон нутгийн хөрсөнд амтатгуа, гүзээлзгэнэ, улаан лоолийн үр, үрслэг тариалах туршилтын ажлыг Монгол Улсын гавьяат агрономч Т.Баярхүүгийн удирдлага дор туршилтаар, Сайншанд сумын 15 тариаланчийн 5 га талбайд төмсний супер элит үрийг эрчимжсэн технологиор тариалж га-аас авах ургацыг 100 цн-ээр нэмэгдүүлсэн.	
302			Шинэ хөдөө төсөл хэрэгжүүлэх	Төлөвлөгдсөн ажлын гүйцэтгэл	хувь	2022	0	100	Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, иргэдийг амьжиргааг дэмжих замаар ажлын байр бий болгох "Шинэ хөдөө" төсөл аймагт 3 дахь удаагаа улсын төсвийн 1.8 тэрбум төгрөгийн хөрөнгөөр хэрэгжиж, Сайншанд сумын 7 дугаар багийн нутагт мах, ногооны механикжсан 2 зоорийн байгууламжийг барих ажлын гүйцэтгэгчээр "Хөх оноо" ХХК шалгарч ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан.	70%
Салбарын үр дүн 10.4: Гадаад жуулчдын тоог 0.003 саяд хүргэнэ.										
303	Жилийн 4 улиралд аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн хүчин чадлыг 2 дахин нэмэгдүүлнэ	Аялал жуулчлал хөтөлбөр	Орон нутагт ирэх гадаад, дотоодын жуулчдыг нэмэгдүүлэх чиглэлээр багц арга хэмжээ зохион байгуулах	Хийгдсэн арга хэмжээ	тоо	2022	2	4	БНХАУ-аас Замын-Үүдэд суугаа Ерөнхий консулын газар, Япон улсын Шизуока муж, хөрш зэргэлдээ орших муж, хошууд болон хамтын ажиллагаатай төсөл хөтөлбөрийн төлөөллүүд Дорноговь аймагт айлчилсантай холбогдуулан 4 удаагийн 20 гаруй гадаадын, зочид төлөөлөгчидтэй хийсэн уулзалтыг зохион байгуулсан.	70%
304			Орон нутгийн онцлог, давуу талд түшиглэн орон нутгийн бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлэх	Аялал жуулчлалын бүтээгдэхүүн	тоо	2022	2	4	"Солид Партнерс групп" ХХК нь төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Дорноговь аймагтай хамтран "Монгол тэмээ Дорноговь" төслийг хэрэгжүүлэн ингэний сүүг боловсруулан хуурай сүү, молоко зэрэг эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортлох үйлдвэрийг Замын-Үүд суманд, үйлдвэрт шаардагдах ингэний сүүг цуглуулах эрчимжсэн фермерийг Мандах, Хатанбулаг, Улаанбадрах,	70%

									Хөвсгөл, Сайншанд сумдад байгуулахаар малчид, иргэдэд танилцуулга мэдээллийг хүргэж эхэлсэн.	
305			Эвент арга хэмжээнүүдийг зохион байгуулах	Зохион байгуулсан эвент арга хэмжээ	тоо	2022	0	1	Хамарын хийдийн тусгай хамгаалалттай газрын захиргаанаас жил бүрийн 4 дүгээр сарын сүүлийн долоо хоногийн хагассайн өдрийг "Сакура цэцэглэх баяр" эвент арга хэмжээг уламжлал болгон зохион байгуулахаар шийдвэрлэн 04 дүгээр сарын 26-ний өдрөөс 14 хоногийн хугацаанд зохион байгуулж 500 гаруй иргэнд танилцуулга мэдээлэл өгч худалдаа эрхлэгч 15 иргэн худалдаа эрхэлсэн. Мөн Өвөрбаясгалант Хамарын хийдээс Лусын тамга арилгах зан үйл, галын тахилга, Шамбалын баяр зэрэг тогтмол зохион байгуулдаг арга хэмжээнд 15000 гаруй хүн оролцсон.	50%
306			Хил орчмын болон хил дамнасан аялал жуулчлалын бүс нутгуудын хамтын ажиллагааг өргөжүүлж, жуулчид авто машинтайгаа аялах боломжийг бүрдүүлэх	Аялал жуулчлалд хамрагдсан хүн	тоо	2023	100	200	Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны төлөөлөгчид хилийн бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэх уулзалт зөвлөгөөнийг 05 дугаар сарын 28-ны өдөр Замын-үүд суманд аялал жуулчлалын бизнес эрхлэгч, Дорноговь аймгийн аялал жуулчлалын холбооны гишүүдтэй уулзалт хийж, аялал жуулчлалын мэргэжлийн салбар холбоог байгуулах ажлыг зохион байгуулж, хилийн бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, хоёр улсын жуулчдыг аялуулах хүлээн авах талаарх хэлэлцүүлгийг зохион байгуулсан. БНХАУ-ын жуулчдыг хүлээн авах талаар 2 тал нэгдсэн шийдвэрт хүрсэн нь Дорноговь аймгийг зорин ирэх гадаадын жуулчдын тоо, түүнийг дагасан эдийн засаг нэмэгдэх боломжтой юм. Энэ оны байдлаар "Хамарын хийд", "Ханбаян зүрх хайрхан уул"-ын орон нутгийн тусгай хамгаалалттай газарт нэвтэрсэн тасалбарын мэдээгээр дотоод 88400 гадаадын 1661 "Их нарт"-ын тусгай хамгаалалттай газарт нэвтэрсэн тасалбарын тоогоор гадаадын 116, дотоодын 165 аялагч, нийт 90342 аялагч аяласан. Өмнөх онтой харьцуулахад 11.2 хувиар өссөн.	30%
307			Аялал жуулчлалын бүс нутагт үйлчилгээ	Сургалтад хамрагдсан	тоо	2022	0	80	Энергийн төвд худалдаа үйлчилгээ эрхэлж байгаа 6 иргэн, Ханбаянзүрх хайрханд худалдаа үйлчилгээ эрхэлж байгаа 6 иргэн, гэр буудлын үйлчилгээ эрхлэгч 11 иргэн, жуулчны баазын үйл	100%

			эрхлэгчдийг зочлох үйлчилгээний чиглэлээр мэргэшүүлэх, давтан сургах, ажилтан бэлтгэх	үйлчилгээ эрхлэгч					ажиллагаа эрхлэгч 2 аж ахуйн нэгж, хоол үйлдвэрлэл эрхлэгч 11 иргэн буюу нийт худалдаа үйлчилгээ эрхлэгч 34 иргэн, 2 аж ахуйн нэгжтэй 1 жилийн хугацаанд "Хамтран ажиллах гэрээ"-г байгуулсан. Аймгийн бизнес эрхлэгчдийг дэмжин хөгжүүлэх зорилтот хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, бизнес эрхлэгчдэд үүсэж буй боломжуудын талаар танилцуулах, харилцан санал солилцох 6 удаагийн уулзалт хэлэлцүүлгийг цахим болон танхимын хэлбэрээр зохион байгуулж давхардсан тоогоор 1400 гаруй иргэн, бизнес эрхлэгчийг хамруулсан. "Эерэг давлагаа" ТББ-тай хамтран аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй зочид буудал, зоогийн газар, аялал жуулчлалын бүс нутгийн худалдаа, үйлчилгээ эрхлэгчид, тэдний ажиллагсдад ажлын байрны 2 өдрийн дадлага сургалтыг зохион байгуулж, 120 гаруй төлөөллийг хамруулан харилцааны ёс зүй, зочлох үйлчилгээний мэдлэг, ур чадварыг дээшлүүлж, 4 сургагч багшийг бэлтгэсэн. 2023-2025 оны "Монголд зочлох" жил болгох тухай Засгийн газрын 2023 оны 158 дугаар тогтоолын хүрээнд Сайншанд сумын нутаг дэвсгэрт зочлох үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч аж ахуй нэгж, байгууллагуудад "Аялал жуулчлал ба хамтын ажиллагаа" сургалтыг 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр онол, практик гэсэн 2 үе шаттай зохион байгуулсан. Сургалтад төрийн байгуулалтын 11 албан хаагч, гэр буудлын үйлчилгээ эрхлэгч 13 иргэн, аж ахуй нэгж, 4 жуулчны бааз, 5 зочид буудал, 4 ресторан, 18 гар урлал хийдэг иргэн хамрагдаж зочлох үйлчилгээний стандарт, чанарын мэдлэг мэдээлэлтэй болсон.	
Салбарын үр дүн 10.5: Худалдааны салбарын нэмүү өртгийг 20.8 хувиар нэмэгдүүлнэ.										
308	Нийт худалдааны эргэлтэд цахим худалдааны эзлэх	Худалдааны салбарын хөгжил хөтөлбөр	Орон нутгийн үйлдвэрлэл худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн цахим	Хамрагдсан бизнес эрхлэгчид	тоо	2022	0	1000	"Хөгжлийн шийдэл" ТББ-ын "Best" хөтөлбөртэй хамран аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй худалдаа, үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн судалгааг гаргасан. Бизнес эрхлэгчдэд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замыг тодорхойлох судалгаанд орон нутгийн 1000 бизнес	100%

	хувийн жинг 20 хувиар нэмэгдүүлн э		флатформ бий болгох						эрхлэгчийг хамруулсан ба амжилттай хэрэгжиж буй бизнес эрхлэгчдийн дэлгэрэнгүй мэдээлэл бүхий цахим каталоги https://online.fliphtml5.com/fhdql/fuxx/ бий болгосон. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 15/06 дугаар тогтоолоор батлагдсан "Түншлэл ба хөгжил" аймгийн бизнес эрхлэгчдийг дэмжих зорилтот хөтөлбөрийн хүрээнд 3 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатай хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулалтыг зарлаж, 69 төсөл хүлээн авч сонгон шалгаруулалтын шат үргэлжилж байна.	
309			Бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд цахим худалдааг нэвтрүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах	Хамрагдсан бизнес эрхлэгчид	тоо	2022	180	250	Төр, хувийн хэвшлийн хамтарсан 5 удаагийн томоохон сургалт, арга хэмжээнд давхардсан тоогоор 524 бизнес эрхлэгч оролцож худалдаа, үйлчилгээний салбарын олон улсын чиг хандлага болон зах зээлээ тэлэх боломж, эрэлтэд нийцсэн нийлүүлэлтийг бий болгох зэрэг сэдвүүдийн хүрээнд туршлага судалсан. Орон нутгийн бизнес эрхлэгчдийн 80 гаруй хувь нь цахим хэрэглээг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, үйлчилгээний цар хүрээгээ өргөжүүлсэн байна. Аймгийн бизнес эрхлэгчдийг дэмжин хөгжүүлэх зорилтот хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, бизнес эрхлэгчдэд үүсэж буй боломжуудын талаар танилцуулах, харилцан санал солилцох 6 удаагийн уулзалт, хэлэлцүүлгийг цахим болон танхимын хэлбэрээр зохион байгуулж давхардсан тоогоор 1400 гаруй иргэн, бизнес эрхлэгчийг хамруулсан. "Эерэг давллага" ТББ-тай хамтран аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй зочид буудал, зоогийн газар, аялал жуулчлалын бүс нутгийн худалдаа, үйлчилгээ эрхлэгчид, тэдний ажиллагсдад ажлын байрны 2 өрийн дадлага сургалтыг зохион байгуулж, 120 гаруй төлөөллийг хамруулан харилцааны ёс зүй, зочлох үйлчилгээний мэдлэг, ур чадварыг дээшлүүлж, 4 сургагч багшийг бэлтгэсэн.	100%
310		Авто тээвэр хөтөлбөр	Авто тээврийн үйл ажиллагааны	Арга хэмжээ	тоо	2022	6	8	Авто тээврийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хяналтыг сайжруулах зорилгоор	100%

			тасралтгүй байдлыг хангах, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хяналт тавих						дараах арга хэмжээг авч ажилласан. Үүнд ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГИЙН ЧИГЛЭЛЭЭР 14474 тээврийн хэрэгсэл, явуулын тоног төхөөрөмжөөр 13618, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР 6488 шилжилт хөдөлгөөн, АВТО ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР үйл ажиллагаа эрхлэж буй нийт 11 иргэн, хуулийн эдгээдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 6 иргэн, хуулийн эдгээдэд ангилал тогтоосон. Мөн НИЙТИЙН ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН ЧИГЛЭЛЭЭР 6 чиглэлд, 10 жолоочтой, Сайншанд-Улаанбаатар-Сайншанд хот хоорондын чиглэлд “Автобус тав” ХХК, “Хүслэнт ажнай ХХК”-тай аймгийн Авто тээврийн төв зорчигч нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ үзүүлж байна. 2024 оны 11-р сарын 11-ний өдрийн байдлаар орон нутгийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг 404 иргэнд, хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг 16477 иргэнд тус тус үзүүлсэн. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР Аймгийн Цагдаагийн газар, Автотээврийн төвтэй хамтран "Ачаа тээврийн жин даац", "Хууль бус тээвэр", "Цагаан сар-2024", "Оюутан тээвэр-1", "Аюулгүй тээвэр-Сайн жолооч", "Намар-2024", зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж давхардсан тоогоор 1500 гаруй жолооч, иргэдэд тус тус мэдээлэл өгч ажилласан. Шалгалтаар нийт 432 тээврийн хэрэгслийг шалгаж 56 зөрчил илрүүлж 7,6 сая төгрөгийн арга хэмжээг тооцож ажилласан. АВТО ЗАМ АШИГЛАСНЫ ХУРААМЖ ТӨВЛӨРҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР 2024 онд авто зам ашигласны 70,0 сая төгрөгийг орон нутгийн замын санд төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 81.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн.	
311			Автотээврийн төвд явуулын автопүү худалдан авах	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Аймгийн авто тээврийн төвийн үйл ажиллагаанд шаардлагатай явуулын автопүү нийлүүлэх ажлыг 44.0 сая төгрөгийн санхүүжилтээр "Мэйжүрмэнт" ХХК гүйцэтгэсэн.	100%
312			Иххэт, Дэлгэрэх,	Маршрут	тоо	2022	8	12	Орон нутгийн чиглэлд буюу Мандах сум руу 2 тээврийн хэрэгсэл, Хөвсгөл, Хатанбулаг сум руу 4	90%

			Өргөн, Эрдэнэ зэрэг сумдад зорчигч тээврийн үйлчилгээг нэвтрүүлэх						тээврийн хэрэгсэл, Ханги боомт руу 3 тээврийн хэрэгсэл, Зүүнбаян баг руу 1 тээврийн хэрэгсэл нийт 6 чиглэлд, 10 жолооч аймгийн автотээврийн төвтэй орон нутгийн зорчигч тээврийн гэрээг 2024 оны 9-р сараас байгуулан 2024 оны 11-р сарын байдлаар 404 иргэд, зорчигчдод тээвэрлэлтийн үйлчилгээгээр тав тухтай аюул осолгүй үйлчилгээг үзүүлж байна. Гэрээний үүргийн биелэлтийг хангуулах зорилгоор байнгын хяналт шалгалтыг зохион байгуулж нийт 15 зөрчил илэрч зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулсан. Цаашид 2025 оны 1-р сараас Иххэт, Дэлгэрэх, Өргөн, Алтанширээ сум руу зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдийн судалгааг гаргаж, хүсэлтийг хүлээн авч байна.	
313		Төмөр зам, далайн тээвэр хөтөлбөр	Төмөр замын тээвэрлэлт, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хяналт тавих	Арга хэмжээ	тоо	2022	4	5	Сайншанд зангилаа нь 2024 онд нийт 14977 вагонд 1,7 сая тн ачаа тээврийн үйлчилгээ үзүүлсэн. Цахим тасалбар худалдаалалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Өргөн, Зүүнбаян өртөөний зорчигчийн заалны дэлгэцээр цахимаар тасалбар худалдан авах шторк явуулж, хэвлэмэл гарын авлагыг тарааж, зорчигчдын ая тухтай байдлыг хангуулах чингэлээр вокзалын зорчигчийн зааланд үнэгүй интернэтийн үйлчилгээ нэвтрүүлж, нийтийн бие засах газрыг байгуулсан.	90%
314			Төмөр замын сүлжээг өргөтгөх, шинэчлэхэд дэмжлэг үзүүлэх	Төмөр замын урт	км	2022	216	100	Мөн Галт тэрэгний нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх, хоорондын замд явах хугацааг багасгах зорилгоор Агьсүмбэт өртөөний 36-р зөрлөгийг А, Б паркттай хүлээн авч явуулах, зогсолтгүй зөрүүлэх зориулалттай болгон өргөтгөх ажлыг хийж 2024.11.15-наас ашиглалтад оруулсан.	100%
315			Төмөр замын мэргэжилтэй ажилтан бэлтгэх, сургаж, дадлагажуулах	Хамрагдсан суралцагч	тоо	2022	120	120	2023-2024 оны хичээлийн жилд аймгийн Политехникийн коллежийг төмөр замын замчин 10, өртөөний жижүүр 18, вагон үзэгч, шалгагч 13, машинч 23, илчит тэрэгний засварчин 6, нийт 6 мэргэжлийн 70 боловсон хүчнийг бэлтгэсэн. Эдгээр төгсөгчдөөс 48 буюу 68.5% нь мэргэжлээрээ ажиллаж байна. 2024-2025 оны хичээлийн жилд төмөр замын өртөөний жижүүр 25, вагон үзэгч	100%

									засварчин 27, зүтгүүрийн туслах машинч 52 мэргэжлээр нийт 104 элсэлт авч суралцуулж байна.	
Салбарын үр дүн 10.7: Мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн үзүүлэлтийг 1 хувиар нэмэгдүүлнэ.										
316	Хөдөлгөөнт холбооны 4G үйлчилгээ авдаг иргэдийн тоог 55 хувьд хүргэнэ.	Цахим засаглал хөтөлбөр	Нийтийн мэдээллийн дэд бүтцийг хөгжүүлэх	Мэдээлэл хүртэх иргэд	хувь	2023	60	80	Монгол улсын Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдааны 31 дүгээр тэмдэглэлийг үндэслэн төрийн нэгдсэн вэб сайт /www.gov.mn/-ыг таниулах, нийтийн мэдээллийг дэд бүтцийг болгохоор шийдвэрлэсэн. Тус ажлын хүрээнд аймгийн бүх төрийн болон төрийн өмчит байгууллагуудын цахим хуудас ашиглалт, олон нийтэд мэдээлэл хүргэдэг мэдээллийн хэрэгслийн талаар судалгааг авч нэгтгэн ажиллаж байна. Ажлын хүрээнд албаны цахим хуудасгүй байгууллагуудыг вэб сайттай болгох ажлыг зохион байгуулж /gov.mn/ хуудсанд 15 байгууллагыг бүртгэсэн. Аймгийн талаарх мэдээ мэдээлэл, аймгийн онцлог, бүтээн байгуулалт, амьдрах таатай орчин, аялал жуулчлал, бизнес эрхлэх боломж, газар зохион байгуулалт, ажлын байрны зар мэдээг авах боломжийг бүрдүүлсэн гар утасны "Нээлттэй Дорноговь" аппликейшныг бүтээж 4200 гаруй татагдан ашиглагдаж байна.	90%
317			Иргэдэд цахим үйлчилгээг таниулах, сурталчлах нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах	Арга хэмжээ	тоо	2023	4200	5000	"Цахимд хэвшье" уриан дор Digital first-D1 EXPO өдөрлөгийг аж ахуйн нэгж байгууллагуудад цахимжуулалтын талаар мэдлэг мэдээлэл өгч, мэдээллийн технологийн чиглэлээр суралцаж байгаа оюутан, залуучуудад сургалтын дэмжлэг үзүүлж, орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор, программ, техник хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 15 байгууллагыг хамруулан өөрсдийн бүтээгдэхүүнээ сурталчлан танилцуулах зорилгоор Цахим хөгжил харилцаа холбооны яам, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, Мэдээлэл технологийн газар, МОСА-тай хамтран 2024 оны 03 дугаар сарын 13-ний өдөр зохион байгуулж ажилласан. Тус өдөрлөгт нийт Төрийн байгууллагын 166 албан хаагч, ЖДҮ бизнес эрхлэгчид 43, ЕБС-ийн ахлах ангийн 285 сурагч, 10 багш нарыг хамруулж нийт 504 иргэн оролцсон байна. Төрийн	100%

								үйлчилгээний нэгдсэн "E-Mongolia", "E-business" системийг ашиглах, цахим ур чадварыг дээшлүүлэх, төрийн цахим үйлчилгээг сурталчлан таниулах сургалтыг 25 удаа зохион байгуулж нийт 1102 иргэн, 12 байгууллагын 181 албан хаагч хамруулсан. Нийт 458 төрлийн лавлагаа, мэдээллийг 51000 удаа гаргаж үйлчилсэн. "E-Mongolia" системээр 1 дүгээр ангид элсэх 1415 хүүхдийг бүртгэж, анги хуваарилалтыг эцэг эхэд цахимаар хүргэн, esis.edu.mn-д бүртгэлийг баталгаажуулсан. "ХурДан" төв, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, татварын хэлтэс, газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, нийгмийн даатгалын газар, улсын бүртгэлийн газрууд цахимаар дамжуулан төрийн үйлчилгээг "e-mongolia.mn", "e-halamj.mn", "etax.mn", "e-gazar.gov.mn," "nd-daatagal.mn", "burtgel.gov.mn", "e-job.gov.mn" системүүдээр 3,105 үйлчилгээг давхардсан тоогоор нийт 97658 иргэн, аж ахуй нэгжид үзүүлж, заавар зөвлөмжийг өгч ажилласан. Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх "Цахимд зөв байя" сарын аян Дорноговь аймагт амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Аяны хүрээнд аймаг сумдын Төрийн албан хаагч, иргэд, Анагаахын шинжлэх ухааны их сургуулийн оюутнууд, Сайншанд сумын 12 жилийн сургуулийн сурагчдад батлагдсан сэдвийн хүрээнд хичээл сургалтыг нийт 1012 иргэн оролцсон.	
318		Байгууллага, сумдын цахим хуудасны мэдээллийг тогтмол шинэчлэх	Цахим хуудсанд оруулсан мэдээлэл	тоо	2023	1200	2000	Монгол улсын Засгийн газрын 2024 оны 31 дүгээр тэмдэглэлийг үндэслэн төрийн нэгдсэн вэб сайт /www.gov.mn/-ыг таниулах, нийтийн мэдээллийг дэд бүтцийг болгохоор шийдвэрлэсэн. Тус ажлын хүрээнд аймгийн бүх төрийн болон төрийн өмчит байгууллагуудын цахим хуудас ашиглалт, олон нийтэд мэдээлэл хүргэдэг мэдээллийн хэрэгслийн талаар судалгааг авч нэгтгэн ажиллаж байна. Ажлын хүрээнд албаны цахим хуудасгүй байгууллагуудыг вэб сайттай болгох ажлыг зохион байгуулж /gov.mn/ хуудсанд 15 байгууллагыг бүртгэсэн. Аймгийн хэмжээнд төрийн болон төрийн өмчит нийт 57 байгууллага албан ёсны цахим хуудас ажиллуулж	90%

									байгаа бөгөөд мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байршуулан чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаягийг тогтмол шинэчлэн олон нийтэд мэдээлсэн. ЦХИХХЯ-ны харьяа Төрийн цахим үйлчилгээний газартай хамтран шилэн ажиллагааны хүрээнд ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж төрийн байгууллагын нээлттэй мэдээллийг shilen.gov.mn цахим хуудсанд байршуулах талаар аймгийн хэмжээнд төрийн болон төрийн өмчит байгууллагуудын 120 албан хаагчдыг хамруулан сургалт зохион байгуулсан.	
319				Хандалт			17000	30000	Аймгийн 15 төрийн байгууллагын 83 үйлчилгээг төрийн цахим үйлчилгээний нэгдсэн (e-mongolia.mn) системд нэвтрүүлж цахимаар дамжуулан 7 газар төрийн үйлчилгээг 7 системээр 32,052 үйлчилгээг давхардсан тоогоор нийт 195,316 иргэн, аж ахуй нэгжид үзүүлж, заавар зөвлөмжийг өгч ажилласан.	90%
320			"Цахим Дорноговь" хөтөлбөр хэрэгжүүлэх	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0	100	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12/01 дүгээр тогтоолоор батлагдсан "Цахим Дорноговь" аймгийн зорилтот хөтөлбөрийг 4 зорилт 22 арга хэмжээг сумдын Засаг даргын Тамгын газар, холбогдох агентлагууд хэрэгжүүлсэн. 1. "Төрийн байгууллагын дотоод удирдлагын нэгдсэн "ERP" системийг 32 байгууллагад шинээр нэвтрүүлж нийт төрийн байгууллагын 98 хувь буюу 177 байгууллагад бүрэн нэвтрүүлсэн. Шинээр 41 байгууллага, 300 албан хаагч тоон гарын үсэг ашиглаж эхлэсэн нь өмнөх оноос 2 дахин нэмэгдэж аймгийн талаарх мэдээ мэдээлэл, аймгийн онцлог, бүтээн байгуулалт, амьдрах таатай орчин, аялал жуулчлал, бизнес эрхлэх боломж, газар зохион байгуулалт, ажлын байрны зар мэдээг авах боломжийг бүрдүүлсэн гар утасны "Нээлттэй Дорноговь" аппликейшнийг бүтээж 4200 гаруй хүн татаж ашигласан. Мөн 2024 оны байдлаар 102 цэгт 263 чиглэлийн камер ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд цахим аймаг болох суурь дэд бүтэц,	70%

									программ хангамжуудыг бий болгохоор аймгийн хэмжээний судалгааг МОСА мэргэжлийн байгууллагатай хамтран хийсэн.	
321			Зарим төрийн байгууллагуудыг лицензтэй программтай болгох асуудлыг судлан шийдвэрлэх	Санал	тоо	2022	0	1.0	Төрийн байгууллагуудын кибер аюулгүй байдлын эрдслийн үнэлгээг аймгийн Тагнуулын хэлтэстэй хамтран зохион байгуулахаар төрийн болон төрийн өмчит 100 байгууллагыг хамруулан ашиглаж буй систем, хүний нөөц, лог бүртгэл, мэдээллийн аюулгүй байдлын журмыг мөрдүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулж ажилласан.	30%
322			Мэдээллийн аюулгүй байдлын журам боловсруулан батлуулах	Журмын хэрэгжилт	хувь	2023	0	80	Цахим хөгжил харилцаа холбооны яам, И-Монгол академи, Мэдээлэл технологийн үндэсний парк УТҮГ-тай хамтран хамтран “Кибер аюулгүй байдлын тухай хууль”, “Хувь хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль” хэрэгжилтийг хангах, цахим ур чадвар, төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр танхим болон цахимаар дамжуулан 10 удаагийн сургалтыг зохион байгуулан нийт давхардсан тоогоор 1100 албан хаагчийг хамруулсан. Сум, орон нутгийн телевизүүдтэй хамтран нөлөөллийн аяны хүрээнд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 5 төрлийн тоон контент үйлдвэрлэж цахим орчинд түгээж хүүхдийн эрхийн сайн дурын ажилтан, идэвхтэн багш, “Монголын аюулгүй байдлын академи НҮТББ”-тай хамтран 14 сумд, Сайншанд сумын ерөнхий боловсролын 5 сургуулиудад 113 удаагийн сургалтаар 13,234 сурагч, эцэг, эхийг хамруулж, сургагч багш бэлтгэх, мэдээ мэдээлэл өгөх сургалтыг зохион байгуулсан. Мөн “Сурагчийн аюулгүй байдал” цахим номыг 1500 ширхэгийг тарааж ажилласан.	70%
323				Журам баталсан байгууллага	тоо		0	40	Төрийн болон төрийн өмчит 96 байгууллага кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж дотооддоо дагаж мөрдөх байгууллагын кибер аюулгүй байдлын журмыг батлан мөрдөн ажиллаж байна.	100%

324			Төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, иргэдийг тоон гарын үсэгтэй болгох	Шинээр тоо гарын үсэг	тоо	2023	152	200	Улсын бүртгэлийн хэлтсээс иргэдэд тоон гарын үсгийг иргэний үнэмлэхэд суулгах ажлыг зохион байгуулж нийт 15167 иргэнийг тоон гарын үсэгтэй болгосон. Тоон бичиг үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, мэдлэг ур чадварыг дээшлүүлэхээр “Цахим гарын үсгийн тухай хууль”-ийг сурталчлах ажлыг 52 аж ахуйн нэгж, байгууллага болон нийт 1024 иргэнийг хамруулан зохион байгуулсан. Тоон бичиг үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, мэдлэг ур чадварыг дээшлүүлэхээр “И-Монгол академи”-ийн УТҮГ-ын газар, Улсын бүртгэлийн газартай хамтран “Цахим гарын үсгийн тухай хууль”-ийг сурталчлах ажлыг төрийн 1600 албан хаагч, 52 аж ахуйн нэгж, байгууллага болон нийт 13331 иргэнийг хамруулан зохион байгуулсан. Тус арга хэмжээг холбогдох байгууллагууд, бүх сум, орон нутгийн телевизүүдтэй хамтран нөлөөллийн аяны хүрээнд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 5 төрлийн тоон контент үйлдвэрлэж цахим орчинд түгээж хүүхдийн эрхийн сайн дурын ажилтан, идэвхтэн багш, “Монголын аюулгүй байдлын академи НҮТББ”-тай хамтран 14 сумд, Сайншанд сумын ерөнхий боловсролын 5 сургуулиудад 113 удаагийн сургалтаар 13,234 сурагч, эцэг, эхийг хамруулж, сургагч багш бэлтгэх, мэдээ мэдээлэл өгөх сургалтыг зохион байгуулсан. Мөн “Сурагчийн аюулгүй байдал” цахим номыг 1500 ширхгийг тарааж ажилласан.	100%
Салбарын үр дүн 10.8: Эрчим хүчний сэргэлт										
325	Импортоор авдаг эрчим хүчний хэмжээг 20 хувиар бууруулна.	Эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалт хөтөлбөр	Хатанбулаг - Ханги чиглэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам татах ажлыг судлах	Ажлын гүйцэтгэл	хувь	2022	0	40	Ханги хилийн боомтыг эрчим хүчээр хангаж буй 10кВ-ын ЦДАШ-ын хүчин чадлыг 110кВ-ын ЦДАШ, 110/10кВ-ын 2х10000 кВА дэд станцтай болгон өргөтгөх хүсэлтийг БНХАУ-ын ӨМӨЗО-ны цахилгаан хангамжийн компанид хүргүүлсний дагуу дэмжлэг үзүүлж ажиллахаа мэдэгдсэн. Уг ажлын барилга угсралтын ажлыг эхлүүлэхэд шаардлагатай зөвшөөрлийг БНХАУ-ын Өвөр монголын өөртөө засах орны Засгийн ордноос авахаар аймгийн Засаг даргын албан хүсэлтийг хүргүүлсэн.	90%

326			Даланжаргалан сумын Их нартын байгалийн нөөц газрын тусгай хамгаалалттай захиргааны гадна цахилгаан хангамжийн угсралтын ажил хийх	Ажлын гүйцэтгэл	хувь	2022	0	100	Даланжаргалан сумын Их нартын байгалийн нөөц газрын тусгай хамгаалалттай захиргааны гадна 0.8 км 0.4кВ-ын ЦДАШ угсралтын ажлыг 53,1 сая төгрөгийн санхүүжилтээр "Уртын-Уул" ХХК гүйцэтгэж ашиглалтад оруулсан.	100%
327			Иххэт сумын шинэ суурьшлын бүсэд цахилгаан хангамжийн угсралтын ажил хийх	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	80	100	Иххэт сумын шинэ суурьшлын бүсэд 0.4 кВ-ын 5км ЦДАШ барих ажлыг 344,8 сая төгрөгийн санхүүжилтээр "Эрчим" ХХК гүйцэтгэж ашиглалтад оруулсан.	100%
328		Дулаан хангамжийн хөтөлбөр	Аймаг, сумдын дулааны станц, халаалт, цэвэр, бохир усны шугам сүлжээний үйл ажиллагааг сайжруулах	Ажлын гүйцэтгэл	хувь	2023	0.00	100	Улаанбадрах сумын Төрийн албан хаагчдын байрыг дулааны шугамд холбох ажлыг 61,0 сая төгрөгийн санхүүжилтээр "Түрүү гарав" ХХК, Хөвсгөл сумын Эмнэлгийн барилгын цэвэр, бохир шугамыг шинэчлэх ажлыг 73,6 сая төгрөгийн санхүүжилтээр "Эрхэм бадрах" ХХК, Сайншанд сумын 1-р багийн 9,10-р гудамжинд 235м цэвэр усны шугам татах ажлыг 60,0 төгрөгийн санхүүжилтээр "Ингүүмэл Оргил" ХХК, Сайншанд сумын Алтанговь-1 гудамж 102-р байрны (хуучнаар 3 дугаар 58 айл) подвалын инженерийн шугам сүлжээний засвар шинэчлэлийн ажлыг 67,0 сая төгрөгийн санхүүжилтээр "Ивээлт баян буурал" ХХК тус тус гүйцэтгэж ашиглалтад оруулсан. Аймгийн төвийн дулааны станцын өргөтгөлийн ажлыг "Энерготех сервис" ХХК 5,9 тэрбум төгрөгийн санхүүжилтээр гүйцэтгэхээр гэрээний байгуулсан. Ажлын гүйцэтгэл 10%-тай. Гэрээний хугацаа 2025.10.10 дуусна. Улаанбадрах суманд 2 зуух, тоног төхөөрөмж	90%

								худалдан авах ажлыг 565,3 сая төгрөгийн санхүүжилтээр "Ингүүмэл-Оргил" ХХК, Айраг сумын Дулааны станцын 3-р зуухыг шинэчлэх ажлыг 134,9 сая төгрөг, Өргөн сумын уурын зууханд өргөтгөл шинэчлэлт хийх ажлыг 178,0 сая төгрөг, Зүүнбаян багийн халаалтын зуухыг шинэчлэх ажлыг 239,6 сая төгрөгийн санхүүжилтээр "Бэсүжин констракшн" ХХК тус тус гүйцэтгэж 2024-2025 оны халаалтын улиралд үйл ажиллагааг хэвийн явуулахыг нөхцлийг хангасан.	
Дундаж үнэлгээ:									86,0%

ТАНИЛЦСАН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

ХЯНАСАН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА

НЭГТГЭСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН



Н.ХОНГОРЗУЛ

У.ШИНЭЧИМЭГ

А.БАДРАЛ